

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(3)

УЛААНБААТАР ХОТ
2025 он



НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(3)

(Тайлангийн эмхэтгэл)

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ННА 78
DDC 020
Н 615

Нийтийн номын сангуудын тайлан 2024(3)

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

ISBN 978-9919-9114-7-8

ГАРЧИГ

ГАРЧИГ.....	04
ӨМНӨХ ҮГ	05
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН Д.СҮРЬЕЭГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	06
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН.....	25
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	26
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	95
ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	121
ДОРНОД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	143
ЗАВХАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	181
ХАВСРАЛТ.....	197
ДҮГНЭЛТ.....	214

ӨМНӨХ ҮГ

Технологийн хөгжилт, мэдээллийн хязгааргүй өсөлтийн энэ үед ард иргэдийг соён гэгээрүүлэгч, номын сан, мэдээллийн байгууллагын хэрэгцээ шаардлага улам ихээр бий болж байна. Дээрх өсөлтүүд нь номын сангуудыг соёл, боловсролын шинэлэг хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Энэ шаардлагад нийцэх, хүрч ажиллахын тулд аймаг, нийслэлийн номын сангууд бүхий л талаараа хичээнгүйлэн ажиллаж ирсний илрэл, ул мөрийг энэхүү тайлангаас үзэх болно. Өмнөх жилүүдэд тус тайлан 300-600 хуудас болдог байсан бол энэ жил 800 гаруй хуудастай болж байгаа нь үүнийг илтгэх нэгэн сэжиг болно. Өдий хэмжээний хуудастай номыг цахим файлд хөрвүүлэн уншихад ачаалал өгөх тул 200 хуудсаар нь салган 4 боть болгон нийтлүүлээ.

Өнгөрөгч 2024 он Монголын номын сангийн салбарт олон чухал, түүхэн үйл явдал болж өнгөрсний нэг нь Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар шинэ салбар ашиглалтад орж, номын санч- мэдээллийн ажилтнуудын сүүлийн 30 гаруй жилийн мөрөөдөл биелж, Монгол Улсын Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран номын сангийн нэгдсэн системийг хөгжүүлэн, ашиглалтад хүлээн авснаар, аймаг орон нутгийн номын сангуудыг нэгдсэн системд холбон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймгийн 216 номын санч мэдээллийн ажилтнуудад зохион байгууллаа. Энэ нь ном зүйн мэдээллийг автоматжуулж, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, электрон мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хүртээмж нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрийг оруулсан явдал мөн.

Эмхэтгэлийн төгсгөлд уламжлал ёсоор аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудыг үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн lavlagaanomzui@gmail.com хаягаар болон 70188882 утсаар ирүүлнэ үү.

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АХМАД ЗОХИОЛЧ Д. СҮРЬЯАГИЙН НЭРЭМЖИТ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЖАНГАР НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Эрхэм зорилго. Орон нутгийн хүн амын боловсрол, соёл, мэдээлэл чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн номын сан-ном зүйн үйлчилгээг үзүүлж, оюуны өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2024 онд дараах бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан үйл ажиллагаагаа иргэдэд хүргэлээ.

- Алсын хараа 2050 “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”
- Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Соёлын сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ
- Жангар нийтийн номын сангийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Ахмад зохиолч Д. Сүрьяагийн нэрэмжит нийтийн номын сан нь 2023 оны 12 дугаар сарын 28-ны А707 дугаар Аймгийн Засаг даргын захирамжаар Говь-Алтай аймгийн Жангар нийтийн номын сан болон өөрчлөгдсөн.

Жангар нийтийн номын сан нь Удирдах-1, Гүйцэтгэх-10, Үйлчилгээний-5 Гэрээт-1 нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

ХОЁР. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Аймгийн номын сан нь сан хөмрөгтөө нийт 48602 номтой бөгөөд монгол хэл дээрх 45602, орос хэл дээрх 2043, бусад хэл дээрх 957 ширхэг номтой. Үүнээс танхимуудын ойрын фондуудад 4080 ширхэг ном эргэлтээр уншигдаж байна. 2024 онд байгууллагын төсөвт ном авах зардалд 5,0 сая төгрөг батлагдаж, 49 нэр төрлийн 6,274,500 төгрөгийн 245 ш номоор баяжилт хийлээ. Үүнээс худалдан авсан 96ш ном, хандив 149ш номоор сан хөмрөгийн бүрдүүлэлт хийсэн байна.

Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа “Ховор хуучин номын” судалгааг гаргаж, “Ховор судар сурталчлах” цахим контент цувралаар хүргэлээ.

Үндсэн фондын ном хадгалалт нь өдрийн 4 цагийн зайтай агаар сэлгэлт хийж, чийгшүүлэлтийн саванд ус хийж, тасалгааны температурыг 14 хоногт нэг удаа шалган тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Ном сэлбэн засалт: 2024 онд нийт ГНОТ-аас 207 ширхэг ном, Үндсэн фонд 130 ширхэг ном, ГХУТ-аас 20 ширхэг ном, ХУТ-аас 100 ширхэг ном нийт 457 ширхэг ном сэлбэн засаж, уншлага үйлчилгээнд гаргасан.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Говь-Алтай аймгийн Жангар нийтийн номын сан нь аймгийн хэмжээнд 5 танхимаар, 999 хүнд шинээр карт нээж, , 8765 ирэгсдэд, 9481 ном олгож үйлчилсэн байна. Сэтгэл ханамжийн судалгаа болон үйлчлүүлсэн иргэдийн судалгаанаас үндэслэхэд нийт ирэгсдийн 76% нь 18 нас хүртэлх хүүхдүүд үйлчлүүлсэн байна.

Номын сангийн танхимын үйлчилгээнээс гадна лавлагаа ном зүйн үйлчилгээг 108 удаа, номын татгалзал 117 удаа өгсөн байна. Сургалт семинар удаа, уншигчдын дунд соёл олон нийтийн ажил удаа, номын сэдэвчилсэн үзэсгэлэн удаа зохион байгуулсан байна. 2024 оны 07 дугаар сард интернэт хурдыг 2 дахин

нэмэгдүүлж, мэдээллийн танхимын үйл ажиллагааг сайжрууллаа. Ингэснээр мэдээ мэдээллийг түргэн шуурхай авах боломжоор хангагдаж байна.

Соёл олон нийтийн ажил:


2024 онд Жангар нийтийн номын сан нь уншигч үйлчлүүлэгч иргэд, албан байгууллагын ажиллагсдын дунд 30 удаагийн соёл олон нийтийн ажлыг 14.956.800 төгрөгийн төсөв хөрөнгөөр зохион байгууллаа. Үүнд:

Есөнбулаг сумын 3-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд 03 дугаар сарын 01-нд “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтыг цэцэрлэгийн захиргаатай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 6 бүлгийн 107 хүүхэд багачууд оролцож, 180 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нар үзэж сонирхлоо.

Жангар нийтийн номын сангаас тэргүүн, дэд байруудад өргөмжлөл, номын богцоор шагнаж урамшуулан хамтран ажиллалаа.

1-р байр эзэлсэн Бэлтгэл “А” бүлэг
орос ардын үлгэр “Тэнэг хулгана”

2-р байр эзэлсэн Бэлтгэл
“Б” бүлэг “Чоно ба долоон ишиг”



Ахлах бүлэг “Цасан гоо ба долоон одой”



Дэлхийн номын өдрийг тохиолдуулан 2024 оны 04 дүгээр 23-нд шүлэг, яруу найраг сонирхогч, уншигч, хүүхэд багачуудын дунд УНШИГЧ ЗОХИОЛЧДЫН УУЛЗАЛТ-ыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд МЗЭ-ийн гишүүн, Утга зохиолын төлөөх шагналт, яруу найрагч Т.Мөнх-Амар, Сэтгүүлчдийн эвлэл, зохиолчдын эвлэлийн гишүүн Гомбын Сэр-Од болон утга зохиолын төлөөх шагналт яруу найрагч Г.Хосбаяр нар уригдаж хүүхэд багачуудад ном уншихын ач холбогдлын талаар харилцан ярилцаж, зохиолын дээжээсээ өргөн барилаа.



Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024 арга хэмжээг угтан Есөнбулаг сумын 11 цэцэрлэгийн дунд бүлгийн 193 хүүхэд багачуудад “Өнхрүүш” үлгэрээр “Үлгэрээс үлгэрлээ” чанга уншлагын аяныг зохион байгууллаа.



“Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024” арга хэмжээг угтан “Уран бийр” уран бичлэгийн уралдаан, “Шидэт урлал” бүтээлийн уралдаан, “Номтой зочин” цуврал контент, “Үндэсний бичгээ өвлөн бахархъя” уралдаануудыг зохион байгуулж, мэдээ мэдээллийг цахим хаягуудад байршуулан иргэд олон нийтэд сурталчиллаа.

“Үлгэрийн баатруудыг хэн сайн амилуулсан бэ?” уралдаанд:
Тэргүүн байр 3-р цэцэрлэг М.Энхтуяа багштай бэлтгэл бүлэг
Дэд байр 2-р цэцэрлэг Д.Гэрэлсүрэн багштай бэлтгэл бүлэг
Гутгаар байр 10-р цэцэрлэг З.Хатанбаатар багштай бэлтгэл бүлэг шалгарлаа.



“Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024” арга хэмжээг угтан “Номтой зочин” цуврал контентыг “Алтай ТВ”-тэй хамтран Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын хамт олны дунд зохион байгууллаа.



“Номтой зочин” цуврал контентыг волейболын багш Б.Шинэхүүгийн гэр бүлийг урьж, “Алтай ТВ”-тэй хамтран зохион байгууллаа.



“Урнаар уншихуй” шүлгийн уралдааныг 2024 оны 5 дугаар сарын 16-нд Жангар нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимд зохион байгууллаа. Тус уралдаанд 27 сурагчид оролцсоноос,

- 1- р байр: 4-р сургуулийн 9-а ангийн сурагч А.Цэвэлмаа,
- 2- р байр: 5-в ангийн сурагч С. Булгансор нар эзэллээ.



“Уран бийр” уралдааныг ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

- 1-р байранд 1-р сургуулийн 12в ангийн сурагч Д.Ням-Өлзий,
- 2-р байранд 1-р сургуулийн 11в ангийн сурагч З.Хулан,
- 3-р байранд Баян-Уул сумын 12 жилийн сургуулийн 12б ангийн сурагч Э.Анхбаяр, тусгай байранд ХЭЦ-ийн 11а ангийн Т.Эрдэнэсүвд нар тус тус шалгарлаа.





Төгсөх ангийн сурагчдыг мэргэжлээ зөв сонгоход нь туслах, номын сан судлалтай холбоотой мэргэжлүүдийг сурталчлах, давуу болон онцлог талуудыг нь таниулах, хэрхэн элсэх, зэрэг мэдээллүүдийг “Номын өргөөний ид шид” цуврал лекцээр дамжуулан аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын I, II, III, IV, V сургуулийн нийт 250 гаруй төгсөх ангийн сурагчид хамрагдаж, санал бодлоо хуваалцан, харилцан үр дүнтэйгээр амжилттай зохион байгууллаа.



“Шидэт урлал” бүтээлийн уралдааныг 05 дугаар сарын 06-ны өдрөөс 05 дугаар сарын 16-ны өдөр хүртэл хүлээн авч, үзэсгэлэн гаргаж, амжилттай



зохион байгууллаа. Тус бүтээлийн уралдааны хүүхдийн ангилалд Тэргүүн байр 1-р сургуулийн 8а ангийн сурагч У.Нямжаргал, Дэд байр 8а ангийн 3.Цэцэнбилэг, гутгаар байр 3-р сургуулийн 6б ангийн хамт олон шалгарлаа. Насанд хүрэгчдийн төрөлд тэргүүн байр Б.Булганжав, дэд байр Б.Оюун, гутгаар байр А.Бурмаа нар тус тус шалгарлаа.

“Үндэсний бичгээ өвлөн бахархъя” уралдааныг төрийн 11 байгууллагын 45 албан хаагчдын дунд зохион байгууллаа.

Тэргүүн байр ерөнхий боловсролын 2-р сургуулийн “Алтан бийр” баг
Дэд байр Мэргэжид сургалт үйлдвэрлэлийн төвийн “Сэцэн бийр” баг
Гутгаар байр сургуулийн өмнөх боловсролын 3-р цэцэрлэгийн “Титэм” багууд шалгарлаа.

“Ухаалаг утаснаас – уншлагын цаг руу” анхдугаар чуулганыг 2024 оны 12



дугаар сарын 11-нд ХГБХХГ-ын Мазаалай театрт зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь “Ухаалаг утасны зөв зохистой хэрэглээ, хор уршиг, өсвөр насны хүүхдүүдийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилгоор зохион байгууллаа. “Ухаалаг утаснаас – уншлагын цаг руу” анхдугаар чуулганы зочин илтгэгчээр:

- О.Мөнхжаргал “Тэгш зохицол” ТББ-ын тэргүүн, Сэтгэл судлалын ухааны доктор /Ph.D/ ментор, сэтгэл зүйч “АМЖИЛТЫГ ӨДӨР ӨДРӨӨР”
- Л.Наранжаргал Улсын тэргүүний 1-р сургуулийн Монгол хэлний зөвлөх зэрэгтэй багш “ЭХ ХЭЛНИЙ ЭЗЭН НЬ БАЙЯ”
- Н.Мягмарсүрэн Хантайшир сургалтын төвийн зохион байгуулагч хүчний багш, дасгалжуулагч “ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНД”
- Э.Сарантуяа Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч “ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ОРОЛЦОО”
- Б.Баднаанямбуу ЕБ-ын 1-р сургуулийн 11г ангийн сурагч Говь-Алтай аймгийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн “ ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭЭ” сэдвүүдээр сургалт зохион байгуулж 280 гаруй өсвөр үе, ахлах ангийн сурагчдын төлөөлөл хамрагдан 2.326.000 төгрөгийн төсөв хөрөнгө зарцуулагдлаа.



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь Засгийн газрын 2022 оны 314 тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийн хүрээнд, Монголын зохиолчдын эвлэлтэй хамтран Утга зохиол ном хэвлэлийн салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Монголын орчин үеийн утга зохиолын өнөө үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэхэд уран зохиолын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 12-р сарын 17-нд орон даяар зарласан "УТГА ЗОХИОЛЫН ДОЛОО ХОНОГ"-ийн хүрээнд 12 сарын 19-26-ны хугацаанд Говь-Алтай аймгийн хэмжээнд хүүхэд залуус, уншигч зохиолчид, иргэдийн дунд хоёр насны ангилалаар “ЭХ ХЭЛ СОЁЛ, ЭХ ҮНДЭС ОРШИХУЙ” эсээ бичлэг, нийтлэлийн уралдааныг зарлалаа.

Тус уралдааны насанд хүрэгчдийн ангилалд: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын иргэн Г.Ганбагана

11-18 насны ангилалд: ЕБ-ын 1 сургуулийн 12а ангийн сурагч Б.Сувдаа нар шалгарлаа.



“СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР 2024” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Олуулаа илүү их уншъя” сарын аяныг сургуулийн өмнөх боловсролын 144 хүүхэд багачууд, ерөнхий боловсролын бага, дунд ангийн 350 сурагчдад монгол ардын үлгэр болон дэлхийн сонгодог үлгэрүүдээр чанга уншлага хийж, номын тэмдэглэл хөтлөх аргуудаас хуваалцлаа.



Соёлын бүтээлч сар-2024 аяны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 07-нд түүхэн суут хүмүүнээс суралцахуй уриатай "ӨНГӨЛӨГ ӨГЛӨӨ" арга хэмжээг зохион байгуулж, зочин илтгэгчээр Ерөнхий боловсролын 3-р сургуулийн түүх, нийгмийн багш н.Эрдэнэсүвд, 4-р сургуулийн түүх, нийгмийн багш зохиолч, яруу найрагч



Г.Хосбаяр нар "Монголын нууц товчоо"-ны түүхэн судалгааны баримтуудын тухай Ерөнхий боловсролын 11 дүгээр ангийн 300 гаруй сурагчдад илтгэл тавьж, мэдээлэл хүргэлээ.

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Ч.Лодойдамбын нэрэмжит шагналт ахмад зохиолч, Жангар, Гэсэр судлаач, түүхч Соён гэгээрүүлэгч, Д.Сүрьяагийн бүтээлийг сурталчлах алдаршуулах зорилгоор МЗЭ-ийн гишүүн Ч.Лодойдамбын шагналт зохиолч, яруу найрагч Г.Чардаг "Чингисийн гурвалжин" судалгааны бүтээлээр Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын хэв журмын тасаг, Алтай нисэх буудал, Дотоодын цэргийн 825 дугаар тусгай салбарын нийт 200 гаруй алба хаагчдад илтгэл мэдээллийг хүргэж, тус байгууллагуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлж, шинэ номын үзэсгэлэн дэлгэн хамтран ажиллалаа.

"Соёлын бүтээлч сар 2024" аяны хүрээнд "Номын ертөнц" подкастын онцлох дугаарт Жангар нийтийн номын сангийн 2023 оны "Шилдэг уншигч байгууллага"-аар шалгарсан Говь-Алтай аймгийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх газрын хамт олон оролцлоо.

"Номын ертөнц" подкастын яруу найрагчийг онцлох дугаарт Гомбын Сэр-Одын нэрэмжит шагналт, Хуурын эгшиг яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт Х.Чимэдрэгзэн, МЗЭ-н гишүүн Мишигийн Цэдэндоржийн шагналт, Хуурын эгшиг яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт зохиолч Н.Бямбасүрэн нар оролцлоо.

"Номын ертөнц" подкастын онцлох дугаарт Ч. Дорждагвын гэр бүл оролцлоо.

"Номын ертөнц" цуврал подкастын хандалтын тоо 17852.

"Номын ертөнц" цуврал подкастыг бэлтгэн хүргэхэд 200 мянган төгрөгийн төсөв зарцууллаа.



"Соёлын бүтээлч сар 2024" аяны хүрээнд "Охидоо хайрлая" өдөрлөг арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны 15:00 цагт ХГБХХГ-н Мазаалай театрт зохион байгууллаа. Тус арга хэмжээний зочин илтгэгчээр "Өсвөр насны охидын тулгамдаж буй асуудал, сэтгэл зүй, эрүүл мэнд, цахим орчинд өөрийгөө хамгаалах нь" сэдвээр ХЭҮК-ын Говь-Алтай аймаг дахь референт Б.Золжаргал, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн эрүүл мэндийн багш Б.Доржханд, эмч Д.Дахинбаяр, МЭХ-ний Говь-Алтай аймаг дахь салбарын сургагч багш, сэтгэл зүйч Б.Байгалмаа нар илтгэл тавьж, мэдээлэл хүргэлээ. Тус өдөрлөгт өсвөр насны 250 гаруй охид хамрагдан тулгамдаж буй асуудал, хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцлаа.



“Соёлын бүтээлч сар 2024” аяны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 18-нд монголын түүх, соёл, зан заншил, үндэсний өв уламжлалаараа бахархах, түгээн дэлгэрүүлэх, ардын аман зохиолыг сурталчлан таниулах, төрөлх хэлээрээ зөв унших чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Тусгай хэрэгцээт хөгжлийн төв”-д харъяалагдаж байгаа хүүхдүүдийн дунд “Түүх соёлоороо бахархъя” арга хэмжээг зохион байгууллаа.



“Соёлын бүтээлч сар-2024” аяны хүрээнд Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан “Өв соёлоо дээдэлъе” шагайн наадгайн тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны 15:00 цагт Ерөнхий боловсролын I, II, III, IV, V сургуулиуд болон АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны лицей сургуулийн багууд оролцлоо. Тэмцээнд багийн мэндчилгээ, шагайгаар морь уралдуулах, алаг мэлхий өрөх, шагай шүүрэх, монгол ардын оньсого таавар таах 5 төрлөөр оролцож

- 1-р байрт 1-р сургуулийн “Домгийн тав” баг
- 2-р байрт 4-р сургуулийн “Таван нүдэн” баг
- 3-р байрт 3-р сургуулийн “Таван шагай” баг
- Тусгай байрт “Таван эрдэнэ” баг тус тус шалгарлаа.



“Соёлын бүтээлч сар 2024” аяны хүрээнд 2024 оны 11 сарын 01-29-ний өдрүүдэд “Өвлөгддөг өв” гэрийн номын сангаа танилцуулах видео бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Арга хэмжээний цахим хандалтын тоо 53900.

“Соёлын бүтээлч сар 2024” аяны хүрээнд 2024 оны 11 сарын 01-29-ний өдрүүдэд “Номын амт” тикток видео бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Арга хэмжээний цахим хандалтын тоо 13.000.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР
Олон дүүргийн олон хуртал

“Өвлөгддөг өв”
ГЭРИЙН НОМЫН САНГАА ТАНИЛЦУУЛАХ ВИДЕО БИЧЛЭГИЙН УРАЛДААН

БҮХ ОРОЛЦОГЧДЫН БҮТЭЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН СУЛЖЭЭНД БАЙРШУУЛНА.

Шалгаруулалт:
Оролцогчдын гэрийн номын сангийн баяжилт, сурталчлалааг үндэслэн олон нийтээс хамгийн их дэмжлэг авсан like, share, үзэлтийн тоогоор видео бичлэгийг тодруулна.

Хугацаа:
2024 оны 11 сарын 01-29 хүртэл

70483313, 91491141, 99010316 | jangarnomiinsan@gmail.com

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР
Олон дүүргийн олон хуртал

“Номын амт”
ТИКТОК, REEL БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Хугацаа: 2024 оны 11 сарын 07-25 хүртэл
Насны ангилал: 09-18 нас, 19-25 нас, 26-35 нас

Шалгаруулалт: 1. Бичлэг чанарын шаардлага хангасан байна.
2. Олон нийтийн хандалтаар тодруулан дүгнэнэ.

Шагнал: Ангилал тус бүрд ТЭРГҮҮН байр шалгаруулж Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

99083507, 90942169 | jangarnomiinsan@gmail.com

“Соёлын бүтээлч сар 2024 аяны хүрээнд “Ховор Эрдэнэ” арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийн гар дээрх ховор судрыг хүлээн авч, Дашпэлжээлин хийдийн хамба ламаар судрын түүхийг ард иргэдэд сурталчлах 2 удаагийн видео

контент бэлтгэн байгууллагын албан ёсны page хаягт байршуулан ажиллаа. Арга хэмжээний цахим хандалтын тоо 4500



Жангар нийтийн номын сан нь “Соёлын бүтээлч сар 2024” аяны хүрээнд 12 удаагийн хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээнүүдэд 2-18 насны 1364 хүүхэд багачууд, 1563 насанд хүрэгчид, тусгай хэрэгцээт 31 хүүхэд, цахим хаягаар 165.284, нийт 168.242 уншигчдад хүрч үйлчлэн 2.244.000 төгрөг төсөв хөрөнгийг зарцуулан ажиллаа.

Соёлын бүтээлч сар

Соёл гэгээрэл, номын сангийн чиглэлээр хийсэн ажил /дэс дарааллаар эмх цэгцтэй бичих/				
№	Хийсэн ажлын нэр	Үзсэн хамрагдсан хүний тоо	Үүнээс хүүхдийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо
1	“Алтайн хөх салхи” Алтайн зохиолчдын 220 номын үзэсгэлэн	150	120	0
2	“Олуулаа илүү их уншъя” хүүхдийн уншлагын сарын аян	494	494	31
3	Түүхэн суут хүмүүнээс суралцахуй уриатай “Өнгөлөг өглөө” уншигч зохиолчдын уулзалт	337	202	0
4	“Эрдэнийн толь” түүхийн эх сурвалж, үндсэн фондод хадгалагдаж байгаа ганц хувьтай ховор 120 ном,	80	54	0
5	“Номын ертөнц” зочинтой ярилцлага подкаст	Хамрагдсан-10 Үзсэн-17852 /цахим/	2	0
6	“Монгол эмэгтэй” монголын эмэгтэй зохиолчдын 130 ном	93	93	0
7	“Охидоо хайрлая” өдөрлөг	Хамрагдсан-294 Үзсэн-64613 /цахим/	294	0

8	“Огторгуйн чимээ” яруу найргийн 126 ном	80	80	0
9	“Өв соёлоо дээдлье” шагайн наадгайн уралдаан	25	25	0
10	“Номын амт” тик ток видео бичлэгийн уралдаан	24419 /цахим/	-	-
11	“Өвлөгддөг өв” гэрийн номын сангаа танилцуулах видео бичлэгийн уралдаан	53900 /цахим/	-	-
12	“Ховор-Эрдэнэ” ард иргэдийн гар дээрх ховор өв судрыг сурталчлах контент	4500 /цахим/	-	-
13	Нийт	Танхимаар-1563 Цахимаар- 165284	1364	31

СУРГАЛТ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ:

“Алтайн соёлын сэргэлт” Соёл, урлагийн салбарын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалтууд төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулагдлаа. Аймгийн Соёл, урлагийн газраас Нийтийн номын сантай хамтран “Номын санчдын чадавхжуулах сургалт”-ыг зохион байгуулж сумдын Соёлын төвийн болон Нийтийн номын сангийн нийт 28 албан хаагч хамрагдлаа. Уг сургалтаар: “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа, мэдээллийн цахим сан”, “Утга зохиол, ном хэвлэлийн салбарын хамтын ажиллагаа, орон нутгийн соён гэгээрэл”, сэдвүүдээр тус тус илтгэл мэдээллийг номын санчдад хүргэлээ. Ном сэлбэн засалтын дадлага ажлыг зохион байгууллаа.



Монгол Улсын Засгийн газар Жендэрийн үндэсний хорооны ажлын албанаас санаачлан, 2024 оноос эхлэн сар бүрийг улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаан дахь тодорхой нэг асуудлаар эерэг хандлага, дадлыг бий болгож буй сайн туршлагауудыг танилцуулж, сурталчилан түгээх, уриалан дэмжих сар болгон ажиллаж байгаатай холбогдуулан “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ыг боловсруулан иргэдэд сурталчилан ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 15-наас 2024 оны 02 дугаар сарын 15-ныг дуустал нэг сарын хугацаанд байгууллагын цахим хаягаар жендэрийн тэгш болон ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх талаар постер бэлтгэж иргэдэд сурталчиллаа. 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагын хэлтсийн референт Б. Золжаргал “Хүний эрхийн үндэсний байгууллага”, “Хүний эрхийн ойлголт”, “Жендэр ба хүний эрх” сэдвүүдээр номын сангийн 14 ажилтанд сургалт орлоо. Тус сургалтын зорилго нь сургалтад оролцогч нарт Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг, хүний эрх, жендэрийн талаар ойлголт мэдлэг олгоход оршлоо.



НҮБ-ын Ерөнхий ассамблей 2007 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/RES/62/10 дугаартай тусгай тогтоолоор “Нийгмийн шударга ёсыг хамгаалах дэлхийн өдөр”-ийг бий болгосон. Энэ өдрийг жил бүрийн 2 дугаар сарын 20-нд тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Говь-Алтай аймгийн Нийтийн номын сан хамтран “Хүний эрх, бидний мэдлэг” төрөлжсөн булан нээж, каталогжуулах ажлыг эхлүүллээ. Тус ажлын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Б.Золжаргал нь 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Нийтийн номын санд 28 нэр төрлийн 116 ширхэг хүний эрх, хууль эрх зүйн холбогдолтой ном, гарын авлагыг хүлээлгэн өглөө.

Жендэрийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан 2024 оны 03 дугаар сарын 1-ээс 04 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл үндэсний хэмжээнд “Харилцан хүндэтгэе” нэг сарын аяныг эхлүүлж байна. Энэ жил “Харилцан хүндэтгэе” аяныг “Харилцан хүндэтгэж тэгш оролцоог хангая” уриатайгаар зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд өсвөр насны охид, хөвгүүдэд жендэрийн хэвшмэл буруу ойлголтоос ангид байх, жендэрийн мэдрэмжтэй иргэн болгон төлөвшүүлэх, цахим орчин дахь ялгаварлан гадуурхалтыг багасгах, эмэгтэй эрэгтэй хүмүүс нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын тэргүүний I сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа.



“Нерпо Кидс” хэвлэлийн газар нь Оксфордын Их сургуулийн хэвлэлийн газрын уншлагын хөтөлбөрийг Монголд нутагшуулж, хүүхдүүдийг номод дурлуулах, ном унших зуршилтай болгох, унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн “1000 ном уншлагын хөтөлбөр”-ийн нээлтэд оролцож, энэ үеэр сумдын номын санч нарт “Дижитал контент бэлтгэх арга зүй” сэдвээр сургалт зохион байгууллаа.




Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ барилгын нээлтийн үйл ажиллагаа, Монгол улсын цахим номын сангийн нэгдсэн цахим системийн сургалтад Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн захирал С.Алтайбаатар, мэдээллийн ажилтан Э.Оюунсүвд нар оролцлоо.



Монгол Улсын Засгийн газар, Соёлын яамнаас хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийн дагуу Номын сангийн нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлж байгаатай холбогдуулан аймаг, орон нутгийн номын санчдад КОХА программын сургалтыг 2024 оны 06 сарын 17,18-ны өдрүүдэд Жангар нийтийн номын санд зохион байгууллаа.



Аймгийн Засаг даргын санаачлагаар хэрэгжүүлж буй “Угийн бичиг-Удмын хэлхээ” хөдөлгөөнд нэгдэж 01 дүгээр албан даалгаврын дагуу 2 удаагийн багц сургалтыг Соёл урлагийн газрын мэргэжилтэн, сургагч багш Д. Элбэгзаяатай хамтран зохион байгууллаа. Соёлын үнэт өв болох угийн бичгийг үеэс үед уламжлан хөтөлдөг Монгол зан үйлийг сэргээж, өрх гэр бүлийн уг гарвал, ураг удмын холбоо, элгэн садны хэлхээгээ бэхжүүлэхэд дэмжих, монгол хүний удмын санд учирч болзошгүй цус ойртолтын эрсдэлээс сэргийлэх зорилгоор “Угийн бичиг-Удмын хэлхээ” хөдөлгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний хооронд өрнүүлэх үүрэг чиглэлийн дагуу 2 удаагийн 6 багц цагийн хичээлийг байгууллагын 14 ажилтанд давтан сургалтаар орлоо. Сургалтын үеэр байгууллагын ажилтан, албан хаагчид өөрийн гэр бүлийн угийн бичгийг хөтөлж, цаашид мэдээлэл цуглуулах, судалгаа хийх шаардлагатайг онцоллоо.



ДӨРӨВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уншигч үйлчлүүлэгчдийн цахим хэрэгцээг хангах зорилгоор номын сангийн интернет хурдыг 2 дахин нэмэгдүүлж, 5 танхимын үйл ажиллагаанд FREE WIFI орчин бүрдүүлэн ажиллаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага дахь хяналтын камеруудын тоог нэмэгдүүлэн ажиллаа.

Соёл спорт аялал жуулчлал залуучуудын яамнаас олон үйлдэлт принтер 1 болон Notebook 1 дагалдах хэрэгслийн хамт хандивлаж, цаашид номын сангийн албан хаагчдын техник технологийг стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах судалгаа гарган ажиллаа.

ТАВ.НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

Жангар нийтийн номын сан нь 2024 оны байдлаар сэдэвчилсэн 55 удаагийн номын үзэсгэлэн гаргаж 3500 гаруй хүүхэд багачууд, иргэдэд үйлчилсэн байна.

- Үндсэн хуулийн өдөрт зориулсан сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 58, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 70/
- “Монгол ардын аман зохиол” сэдэвчилсэн үзэсгэлэн/Үзэсгэлэн гаргасан номын тоо- 94, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 108/
- Соёлын урлагийн ажилтны зөвлөгөөнд зориулсан номын сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 63, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 175/
- Монголын уламжлалт сар шинийн баярын “Монголын уламжлалт ёс заншил” номын сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 120, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 200/
- Хүний эрх, жендэрийн ойлголт номын үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 76, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 90/
- Аймгийн Жангар музейтэй хамтран 2024 оны 03 дугаар сарын 04-07-нд үзэсгэлэнгийн танхимд Лодонгийн Түдэвийн сэдэвчилсэн номын үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 76, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 80/
- “Эх оронч эрчүүд” сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 120, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 86/
- Монгол хүн сансарт ниссэний баярын өдөрт зориулсан номын сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 38, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 60/
- Казах ард түмний ёс уламжлал сэдэвт “Наурыз” номын үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо-45, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 54/
- “04 сарын 01” сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 28, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 90/
- Дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 158, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 200/
- Үндсэн фондод хадгалагдаж байгаа ганц хувьтай ховор номын сэдэвчилсэн үзэсгэлэн /Үзэсгэлэн гаргасан номын тоо- 58, Үзэсгэлэнд хамрагдсан уншигчийн тоо- 150/

- Сумдын 100 жилийн ойн баярт зориулан гаргасан “100 жил” үзэсгэлэн
- Алтайн хөгжил сонины үзэсгэлэн
- Хүүхдийн танин мэдэхүй, үлгэрийн шинэ номын үзэсгэлэн
- Жижиг, том номын үзэсгэлэн
- Уншигч хүүхдүүдийн номын тэмдэглэлийн үзэсгэлэн,
- Мэргэжил бүхэн сайхан номын үзэсгэлэн

Багш нарын баярын өдөрт зориулан “Багшийн алдар” номын үзэсгэлэнгүүд дэлгэгдлээ. Номын сэдэвчилсэн үзэсгэлэнгүүдийн мэдээллийг байгууллагын цахим хаяг болон Алтай телевиз, Алтай мэдээ агентлагийн цахим хаягаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллаа.

ЗУРГАА. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэр, Соёл спорт аялал жуулчлал, залуучуудын яам, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, санхүү бүртгэлийн тайланг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээллэж ажилласан. 2024 онд батлагдсан улсын төсвийн санхүүжилт 528.450.900 төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 123.823.900 төгрөг, үүнээс үндсэн цалин 241.245.000 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 47.540.300 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 225.583.100 төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Байгууллагын хагас жил болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг ажилтан албан хаагч нарын эд хөрөнгийг гар карттай тулган нэг бүрчлэн тоолж, өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж ашиглах боломжгүй болсон бараа материалыг эд хөрөнгийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэв.

ДОЛОО. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Аймгийн ЗДТГ, ССАЖЗГ-с зохион байгуулсан нийт соёлын ажилчдын “Бэсрэг наадам”-д “Ганган тогос” төрөлд тэргүүн байр, Шагайн уралдаанд 2 байрт шалгаран амжилттай оролцлоо.
- Байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, уншигч үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор “Ном ариутгагч” төхөөрөмжийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаа.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг дэмжих зорилгоор байгууллагын гадна орчинд 4 төрлийн модны суулгацыг тарьж, Естийн амны хуваарьт газарт 200 гаруй мод тариалж, усалгаа арчилгаа хийж ажиллаа.
- Өвлийн улиралд цас орж, халтиргаа гулгаа үүсэх нөхцөл бүрдсэн үед байгууллагын ойр орчмын 50 метр газрын цас, мөсийг тогтмол цэвэрлэж, иргэдийн аюулгүй үйлчлүүлэх, зорчих нөхцөл боломжоор ханган ажиллаа.
- Жил бүрийн хавар, намрын номын баярыг угтан “Шилдэг уншигч” байгууллага, сурагч, иргэдийг тодруулан номын сангийн үйл ажиллагааг дэмжих шагнал урамшууллуудыг олгон ажиллаа.
- Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтан албан хаагч нараа Говь-Алтай аймгийн ИТХ-ын тогтоол төрийн албан хаагчдыг орон

сууцжуулах хөтөлбөрт хүүхдийн уншлагын танхимын номын санч Ч.Бямбадоржийг 10 сая төгрөгийн дэмжлэгт хамрууллаа.

- Тус номын сан нь бүтцийн өөрчлөлтөд орж “Чимээтэй номын сан” болж, шинэ үйлчилгээг хөдөө орон нутгийн ард иргэдэд хүргэх зорилгоор 16 сая төгрөгийн зураг төслийн ажил хийгдэж, 2025 онд гүйцэтгэх ажил эхэлхэд бэлэн болоод байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн Нийтийн Номын сангаас шинээр 1132 уншигчид карт нээж 7117 ирэгсдэд 18847 ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ. Гэрээр 299 уншигчид 515 ширхэг ном, зөөврөөр 175 уншигчид 368 ширхэг ном, Тусгай бүлгийн 39 уншигчид 260 ном тус тус олгосон. Фондын сан хөмрөгийг бэлэг хандиваар 218 ширхэг төсвөөр 289 ширхэг Нийт 507 ширхэг ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлсэн.

Лавлагаа ном зүйн үйлчилгээний хүрээнд 216 уншигчид 820 лавлагаа өгсөн. Шинэ ирсэн номын мэдээн тухай бүр гаргаж иргэд, уншигчдад мэдээллийг хүргэсэн. “Үндэсний Номын баяр”-ийн арга хэмжээний ажлын хүрээнд:

Ном уншлагын 2 сарын, 14 хоногийн аян тус тус зохион байгуулсан. Аянд Нийт 5126 уншигч хамрагдсан. Ерөнхий боловсролын 5-р сургуулийн төгсөх ангийн хүүхдүүдэд номын санч мэргэжлийг сонгох, мэргэжлийн ач холбогдол, онцлогийн талаарх мэдээллийг 25 сурагч хамруулсан.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн арга хэмжээний хүрээнд:

Монгол бичгээр номын хавчуурга-350 ширхэг, оюуны чихэр 320 ширхэг хийсэн.

“Үлгэрээс үлгэрлэе” арга хэмжээний хүрээнд 1,2,6-р цэцэрлэгийн 372 хүүхдэд багачууд хамрагдсан.

Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх ажлын хүрээнд:

Байгууллага-1, ангийн номын булан-3, хувийн номын сантай иргэн-1 сайн туршлагыг байгууллагын цахим хуудсанд байршуулж нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээний зохион байгуулсан.

Нийт 5 байгууллага, анги хамт олон -3, иргэн-2 хамрагдсан.

“Боржигидай сэцэн” салбартай хамтран “Зохиолч уншигчдын уулзалт”-д 35 уншигч хамрагдсан.

“Номын кафе” үйлчилгээ: Уншигч хүүхэд багачууд, иргэддээ зориулан “Номын кафе” ажиллуулж шинэ номын үзэсгэлэнг 60 ширхэг номоор гаргаж 135 уншигч хамрагдсан. Шинээр 17 уншигчид карт нээж үйлчилсэн.

Хөдөөгийн 4,5,6 дугаар багын иргэдэд 2024 оны 05 дугаар сарын 10, 11, 12, 9-р сарын 06-ны өдрүүдэд нүүдлийн номын сангийн үйлчилгээг 2 удаа хүргэсэн. 415 иргэн хамрагдсан.

Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл хүргэж, 215 ширхэг брүшур гарын авлага тараасан. Шинэ номын үзэсгэлэнг 150 ширхэг номоор гаргаж 85 иргэн хамрагдсан. Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчилсан Монгол бичгийн номын үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 03 - 06-ний өдрүүдэд зохион байгуулсан. “Эх хэлний өдөр”-т зориулан Монгол хэл бичгийн хосолсон номоор үзэсгэлэн гаргаж иргэдэд сурталчилсан. Нийт 172 уншигч хамрагдсан. Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчилан түгээх ажлын хүрээнд: Үндэсний бичиг үсгийн ховор номын үзэсгэлэнг 7 номыг 58 уншигч сонирхсон. Соёл урлагийн газартай хамтран “Боржигин соёл урлаг” сэтгүүлийг кирилл, монгол бичгээр гаргаж аймгийн 30 жилийн ойг угтаж зохион байгуулсан хандивлагчдын уулзалтын үеэр иргэдэд түгээсэн.

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 542 номоор гаргаж 744 уншигч хамрагдсан.

Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд МУСТА Ц.Дуламжав агсны нэрэмжит “Боржигидайн яргуй” хүүхдийн яруу найргийн анхдугаар наадмыг яруу найраг сонирхогч дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Нийт 125 сурагч оролцсон. Монголын Зохиолчдын Эвлэлийн болон Монголын Зохиолчдын Эвлэлийн шагналт, Гомбын Сэр-Одын шагналт, Оросын холбооны улсын утга зохиолын салбарын Лермонтовын нэрэмжит шагналт, яруу найрагч хүүхдийн зохиолч Баатарын Энхтөрийн “Анхбаярын ангийнхан” номоор “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг Сүмбэр сумын 1,2,5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулиудын 12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Нийт 250 уншигч хүүхдүүд хамрагдсан.

Нийгмийн харилцааны соёлыш төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд иргэд, уншигчиддаа зориулан байгууллагын цахим хуудсаар ном уншихын ач тус, ном унших арга, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ? Номын үзэсгэлэн, гарын авлага боршур, шторк хийж номын булантай анги хамт олон, гэр бүлийн номын сантай айл өрх албан байгууллагын туршлагыг сурталчлан иргэдэд мэдээллийг хүргэсэн. Байгууллагын танилцуулга, гарын авлагуудад QR код байршуулан иргэдэд электрон катаолги хэрхэн ашиглах талаар мэдээлэл хүргэсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО ЗОРИЛТ

Алсын хараа: Мэдлэгийг түгээж, соёлыг өвлүүлнэ

Эрхэм зорилго: Соёлын үйлчилгээ - Хөгжлийн баталгаа

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, соёл танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж, оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэх, ажил үйлчилгээгээ танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулж, номын сангийн таатай орчинг бүрдүүлэх, иргэд уншигчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэрээр номын сангийн үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.

ХОЁР. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БОДИТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь:

- Уншигчдад номын сангийн үйлчилгээг үзүүлэх
- Бүх нийтийн соёлын боловсрол олгох түүгээр дамжуулан номын сангийн боловсролын хөтөлбөрүүдийг бий болгож уншигч, иргэдэд хүргэх
- Сан хөмрөгийг байнгын эргэлтэд оруулах
- Номын сангийн үйлчилгээг цахим болгох
- Орон нутгийн нийт номын санчдыг арга зүй мэдээллээр хангах
- Төр хувийн хэвшил, ТББ, ОУБ-уудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг олон талт хэлбэрээр үйл ажиллагааг иргэдэд хүргэхээр зорин ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар манай аймагт Төв номын сангийн төв болон салбар-2, Төр болон хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын сургуулийн номын сан - 31, номын сан болон номын сангийн булантай цэцэрлэг -15, Их дээд сургууль, МСҮТ зэрэг сургуулийн номын сан - 9, Орхон, Хонгор, Шарын гол сумын Соёлын төвийн номын сан - 3, Хүүхдийн номын ордон-1, төрийн байгууллагын номын сан -4, багийн төв- 2 нийт аймгийн хэмжээнд 67 номын сан ажиллаж үйл ажиллагааны чиглэл болон уншигчийн бүтэц, үйлчилгээ үзүүлж буй салбарын иргэдийн нас насны онцлогт нийцүүлэн соён гэгээрүүлэх ажлыг явуулж байна.

Мөн Дархан-Уул аймагт номын клуб - 6; ангийн номын сан ажиллуулдаг сургууль, цэцэрлэгийн бүлэг - 680 гаруй байна. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа номын сангуудын хамтын ажиллагаа, үйлчилгээ, соёл олон нийтийн ажлуудын оролцоо, иргэдийн унших идэвхийг дэмжих нөлөөллийн ажлуудад оролцогчдын тоо өссөн нь номын сангийн үйлчилгээний хүртээмж сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгааг харуулж байна.

Номын санч: Аймгийн ЕБСургуулийн - 22, Их дээд сургууль, коллежийн 12, сумдын соёлын төвийн -3, Хүүхдийн номын ордны -9, Төв номын сангийн -11, нийт **57** номын санчийн судалгааг хүснэгтээр харуулав.

Аймгийн номын санчдын судалгаа:

д/д	Байгууллагууд	Насны ангилал			Мэргэжлийн номын санч	Мэргэжлийн бус номын санчид	Нийт н/санч тоо
		18-35	36-55	55аас дээш			
1	Төв номын сан	1	10		8	3	11
2	Хүүхдийн номын ордон	8	1		7	2	9
3	Сумдын Соёлын төв		3		1	2	3
4	Их дээд сургууль, коллеж	2	7	3	6	6	12
5	ЕБСургуулиуд	2	15	5	7	15	22
	Нийт						57

Боловсон хүчнийг тогтмол сургаж, чадавхижуулах зардал, сан хөмрөгийг баяжуулах нөөц боломж, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, зориулалтын барилга байгууламжгүй байх, олон нийтийн идэвхгүй байдал зэрэг нь номын сангийн үйл ажиллагааг тогтмол, эрчимтэй явуулахад хүндрэл үүсгэдэг. Иймд дээрх асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд дотоод нөөц боломжийн хэмжээнд шийдвэрлэсэн зарим ажлуудаас тоймлон оруулав.

Жил бүр төсөв дээр номын сангийн программын төсөв батлагдаж ирдэггүй тул төрийн санд байгууллагын захирлын 2024.11.19-ны 126 тоот албан хүсэлтийг хүргүүлсэнээр, өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, 2023 оны darkhan.Lib4U.net номын сангийн программын 1 жилийн лицензийн төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний 210801 зардал дээр тавиулж, оны эцэст өр авлагагүй гарлаа.

2024 онд нийтдээ санхүүжилт хүссэн **8 удаагийн албан тоотыг** холбогдох газруудад хүргүүлж, **6 удаагийн** үйл үйл ажиллагаанд **73,115,000 төгрөгийг** улсын болон орон нутгийн, төсөл хөтөлбөрийн зэрэг гадны санхүүжилтээр олсон байна. Тодруулбал:

- ✓ Тушаал 02-А/98 "Оюунлаг дарханчууд-II" Номын баярын үйл ажиллагааны зардал - 3,547,500 төгрөг
- ✓ Тушаал 02-А/109 ОУХЭХӨ-ийн үйл ажиллагааны зардал /Номын сан/ 750,000 төгрөг
- ✓ Тушаал 02-А/150 Номын баяр өдөрлөг зохион байгуулах үйл ажиллагааны зардал - 2,850,000 төгрөг
- ✓ Соёлын бүтээлч сар-2024 олон талт үйл ажиллагааны зардал- 1,000,000 төгрөг
- ✓ Боловсролын хөтөлбөр - 1.543.500 төгрөг
- ✓ Уншигчийн орлого - 3424.000 төгрөг
- ✓ "Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь" төслийн 60,000,000 / Жаран сая / төгрөг


Нийт 73,115,000 төгрөг

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь төрийн болон ТББ, олон нийтийн байгууллага, ОУБ-уудтай байнгын хамтран ажиллаж үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн асуудалд дэмжлэг авах, харилцан туслалцах зарчмаар тулгарч буй асуудлуудад шийдэл олж, ажилласаар байна.

Эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, уншигчдын бага хурал: Төв номын сангийн хэмжээнд соёл олон нийтийн ажлыг Соёлын сайд, Засаг даргатай байгуулсан гэрээ, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллав.

✓ Ахмад номын санч Ч.Бадамцэцэгийн “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” номзүйн 4 боть номыг хэвлэн гаргав.

✓ “Дархан хот, Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа ном зүйн бүртгэл 1961-2011” I-IV боть номыг хэвлэлд бэлтгэж боловсруулсан Ахмад номын санч МУСТАжилтан Ч.Бадамцэцэгтэй 2 удаа уулзалт зохион байгуулж, сэтгүүл зүйн салбарын 120 төлөөлөгч оролцлоо.



Зөвлөгөөн: Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын анхдугаар зөвлөгөөн



Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 60 жилийн ойн хүрээнд Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын зөвлөгөөнийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Дархан-Уул аймгийн төв номын сан, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран 2024 оны 10 сарын 18-ны өдөр Дархан хотноо зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Орхон аймгийн нийтийн номын сан, Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан, Булган аймгийн нийтийн номын сан, Төв аймгийн Нийтийн номын сангийн 100 гаруй номын санч- мэдээллийн ажилтнууд оролцож, ном хэвлэлийн салбарт тулгамдаж асуудлыг хэлэлцэж, санал зөвлөмж гаргалаа.



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САЙД Ч.НОМИН ТАНАА

“Төв болон Хойд бүсийн аймгуудын номын санч-мэдээллийн ажилтны сургалт, зөвлөгөөн-2024”-т оролцогч Дархан-Уул Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Орхон аймаг, Булган аймаг, Сэлэнгэ аймаг, Төв аймгийн нийтийн номын сангуудын номын санч-мэдээллийн ажилтнуудаас гарсан саналыг хүргүүлж байна.

Хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчний асуудлыг бодлогын түвшинд авч үзэж, үнэ төлбөргүй суралцуулах талаарх саналыг Засгийн газарт уламжилж шийдвэрлүүлэх

Номын санч- Мэдээллийн ажилтнуудад зориулсан мэргэжлийн шаталсан сургалтыг бий болгох, тэднийг идэвхжүүлэх хүрээнд мэргэжлийн уралдаан зохион байгуулж байх, хүний нөөцийг хөгжүүлэх, туршлага судлах зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг байх.

Номын сангийн анхан шатны бүртгэлийн маягтуудыг яаралтай шинэчлэх.

Гадаадын номын сангуудаас туршлага судлах, номын санчдыг солилцон ажиллуулах талаарх хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх.

Номын сангийн сан хөмрөгийн баяжилт хийх төсвийг тогтмол нэмэгдүүлэх.

Номын санчдын зэргийн нэмэгдлийг батлуулах.

Боловсролын тухай хуулинд бүх шатны боловсролын байгууллагуудыг “Ном унших цаг”-тай болох талаар заалт оруулж, номын сан, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Бүсчилсэн хөгжилд номын сангийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх талаар бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНД:

Номын сангуудад зориулсан нэгдсэн арга зүйн удирдамж, гарын авлагаар хангах, Номын санчдыг мэргэшүүлэх сургалтыг системтэй зохион байгуулах
АЙМГИЙН НОМЫН САНГУУДАД:

Номын санг дэмжих лоббиг бүлэг байгуулахад хамтарч ажиллах Орон нутгийн хөгжилд номын сангуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх үүднээс суудлаач номын санчдыг дэмжих “Номын санч” сэтгүүлд орон нутгийн судалгаа, тэргүүн туршлага зэрэг мэдээллүүдийг нийтлүүлдэг байх, Төрөөс баримталж байгаа бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийтийн номын сангууд хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн бэхжүүлэх.



Хэлэлцүүлэг: Төв номын сангаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Дархан сумын ЗДТГ, Дархан сумын ИТХ, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар, Дархан Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газар, Ахмадын хөгжлийн төв, Хүний эрхийн Үндэсний Комиссын Дархан-Уул аймаг дахь салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг, эхийн холбоо болон бусад холбоод, иргэдийн төлөөлөл 25 хүн оролцов.





✓ “Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт 60,000,000 /Жаран сая төгрөг/ төгрөгийн төслийг боловсруулан, Дархан сумын Засаг дарга болон ЗДТГ-т хүргүүлснээр тэндэр зарлагдан NEGM ELECTRONICS ХК шалгарч ХБИ-ийн явган хүний зам, тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгөөд байна.

Эрдэм шинжилгээний хурал:

- 1.) “Үндэсний бичиг соёл номын өдрүүд -2024” үйл ажиллагааны хүрээнд аймгийн Монгол хэл бичиг, уран зохиолын багш нарын дунд “ХОС БИЧИГТЭН-2025” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 50 гаруй багш, номын санчид оролцов.





ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2024

ХОС БИЧИГТЭН-2025

Эрдэм шинжилгээний хурал

ХАМРАХ ХҮРЭЭ:
Дархан-Уул аймгийн Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын төлөөлөл

ХЭЗЭЭ:
2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 11:00 цагт Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд болно.

ИЛТГЭГЧ БАГШ НАР:

- “Үндэсний бичгээр эх хэлний сэтгэлгээг хөгжүүлэх нь” (МУ-ын зөвлөх багш, Үндэсний бичиг соёлоо дэлгэрүүлэгч, АБТАжилтан багш Д.Оюунбилэг)
- “Үндэсний бичгийн бодлого хэрэгжүүлэлт, хууль тогтоомж” (Хэл шинжлэлийн магистр Г.Нямзаяа)
- “Үндэсний бичгийн сургалт, судалгаа” (АБТАжилтан Тэргүүлэх зэрэгтэй багш Х.Одхүү)
- “Үндэсний бичгийн уран бичгийн үүсэл хөгжил, өнөө ба ирээдүй” (Тэргүүлэх зэрэгтэй багш С.Бавсанхүү)



ХОЛБОГДОХ УТАС: 70377937, 99227092

2.) Дархан-Уул аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд "ХҮҮХДИЙН УНШЛАГЫГ ДЭМЖИХҮЙ" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, хурлын илтгэл хэлэлцүүлэгт Зочин илтгэгчээр: Улаанбаатар хотын Хүүхдийн Төв номын сангийн Мэдээлэл технологи арга зүйн Хэлтсийн дарга С.Тунгалаг "Хүүхдийн уншлагыг удирдахуй" сэдвээр,

- ✓ Дархан-Уул аймгаас: 4-р цэцэрлэгийн багш Н.Оюунцэцэг "Явуулын номын сангаар бага насны хүүхдийг хөгжүүлэх нь" сэдвээр,
- ✓ Од цогцолбор сургуулийн багш Н.Оюунчимэг "Хүүхдийн уншлагыг зургаар удирдахуй" сэдвээр,
- ✓ Шарын гол сумын 2-р сургуулийн багш Ч.Туяа "Уран уншлагаар дамжуулан хүүхдийг номонд дуртай болгох" сэдвээр,



- ✓ 1-р сургуулийн багш Ч.Нансалмаа 4-р сургуулийн багш Б.Марал-эрдэнэ “Уншигч бүлгээр дамжуулж суралцагчдын уншихуйд дэмжлэг үзүүлэх нь” сэдвээр,
- ✓ Од цогцолбор сургуулийн багш М.Саруулзаяа, А.Пүрэвсүрэн, Д.Жавхлантагс “Уншигч–од” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Анги удирдсан багш нарын оролцоо” сэдвүүдээр сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлж, өөрсдийн үзэл бодлоо хуваалцлаа.

3) “Үр дүнтэй уншлага” хэлэлцүүлгийг ЕБС-ийн 70 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр:

- Од цогцолбор сургуулийн 10-4 ангийн сурагч н.Хүсэл “Ном уншихын ач тус”
- Од цогцолбор сургуулийн 10-4 ангийн сурагч Т.Мянганбаяр “Номын клубыг яаж удирдах вэ?”
- Монгол-Оюу сургуулийн 10-1 ангийн сурагч Э.Өнө-ундрал, Х.Аминбилэг нар “Миний мөрөөдлийн номын сан”
- Дөрөвдүгээр сургуулийн 11б ангийн сурагч Ж.Болорзаяа “Илүү их уншъя”
- Нэгдүгээр сургуулийн 10б ангийн сурагч С.Дэлгэрцэцэг “Ном бол мэдлэгт хүрэх гүүр”
- ОИЦ сургуулийн 12-8 ангийн сурагч М.Даваамаа “Номын эгшиг”
- Есдүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Идэржаргал “Номыг унших арга” сэдэвт илтгэлүүдийг хэлэлцүүлж, өөрсдийн үзэл бодлоо хуваалцав.



4). Соёлын бүтээлч сар аяны хүрээнд аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Дархан Залуучуудын хөгжлийн төв, Дархан-Уул аймгийн ТӨВ НОМЫН САН хамтран ЕБ-ын 15, 18, ОИЦС-иудын ахлах ангийн 60 гаруй сурагчдын

дунд “ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ, ЦОГТЫН ХАДНЫ БИЧЭЭС”-ийн түүх, бичиг соёлыг сурталчлан таниулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.








СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Агуулга:
 - Чингисийн чулууны бичиг
 - Цогтын хадны бичиг
 - Дундын гар чулууны бичгээ

Хэзээ:
 2024.11.15-ны
 15:00 цагаас

Илтгэгч багш:
 Ой сургуулийн Төр Чингисийн Улааны багш
 Д.Амартүвшин,
 МУИС-ын Проф. Дотор Ю.Цэдэнбалын сургуулийн
 Монгол хэлний багш, орлогчийн мастер
 Ц.Элжаргал

Хамрах хүрээ: ЕБСургуулийн ахлах
 ангийн сурагчдын дунд
Хаана: Залуучууд хөгжлийн төв
Холбоо барих утас: 70377937, 99409812



5). Төр нийгмийн нэрт зүтгэлтэн ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ-ын улс эх орныхоо бүтээн байгуулалт, хөгжлийн төлөө хийсэн ажлын нэгээхэн хэсэг болох Дархан хотын бүтээн байгуулалтын талаар "Ю.ЦЭДЭНБАЛ ДАРХАНЫ ЦОГЦ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" номыг МУ-ын Гавьяат багш, МУИС-ын Проф, Доктор, Ю.Цэдэнбалын Академийн Эрдмийн зөвлөлийн дарга Цэен-Норовын Жамбалсүрэн, Ю.Цэдэнбалын Академийн дэд Ерөнхийлөгч, Академич Тавхийн Жаргалсайхан нар эмхэтгэн бүтээсэн номын нээлт, судалгааны ажлын танилцуулга боллоо.





Нээлтэнд УИХ гишүүн, Ёс зүй Сахилга, хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХурлын дарга Я.Бат-Очир, Соёл Урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, төрсөн дүү Юмжаагийн Жавзан, Увс аймгийн Дархан-Уул аймаг дахь нутгийн зөвлөл, Монголын зохиолчдын эвлэлийн холбооны Дархан дахь салбарын зохиолчид зэрэг нийт 50 хүн оролцов. Түүнчлэн Төв номын сангаас “ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ” сэдэвт 33 боть номоор үзэсгэлэн гарган үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Үр дүн: 5 удаагийн эрдэм судлал, түүх, соёл судлалын ажлыг зохион байгуулж 320 мэргэжлийн номын санчид, багш, сурагчид оролцов.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,

ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР

3.1. Номын сангийн сан хөмрөг

Ном бүрдүүлэлтийг “Номын сангийн тухай хууль” болон ном худалдан авах журмын дагуу татгалзлал, уншигчийн судалгаанд үндэслэн номын худалдаа, зохиолч, ард иргэдийн хандив, тусламжаар фондоо бүрдүүлж ирлээ. [\(10\) Facebook](#)

2024 онд нийт **15,746,064 төгрөгийн 1984 нэр төрлийн 2349 боть** номоор сан хөмрөгөө баяжууллаа. Үүнээс :

-Хандиваар 1899 нэр төрлийн 2203 боть 10,693,007 төгрөг

-Худалдаагаар 85 нэр төрлийн 146 боть 5,053,057 төгрөг



“Нэг уншигч – Нэг ном” аян



Байгууллага ААН, иргэн, анги хамт олны номын хандив



Татгалзалд үндэслэн худалдаагаар сан хөмрөгийн баяжилтыг хийж байна.



Уншлага үйлчилгээний нэгжийн дарга Н.Норжмаа УБ хот Интерном-д/

Сан хөмрөгийн баяжилтыг сүүлийн 3 жилээр харуулбал:

№	Номын фондын үзүүлэлт	2022 он		2023 он		2024 он	
		тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
1	НИЙТ ДҮН	1751	15,818,450	1152	23,598,580	2349	15,746,064
2	Худалдаагаар	555	9,306,260	734	17,404,660	146	5,053,057
3	Хандиваар	1196	6,512,190	418	6,193,920	2203	10,693,007

Номын сангийн фонд бүрдүүлэлтийн худалдаагаар авсан номын тоог сүүлийн 3 жилээр харуулбал:

№	Номын фондын үзүүлэлт	2022 он		2023		2024 он	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
1	Худалдаагаар	555	9,306,260	734	17,404,660	146	5,053,057

Тогтмол хэвлэл: Өдөр тутмын “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Хүмүүн бичиг”, “Төрийн мэдээлэл”, “Боловсрол судлал”, “Өрхийн үйлдвэрлэл” зэрэг тогтмол хэвлэлүүдийг захиалан уншигчийн хэрэгцээг ханган ажиллаж байна.

• “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Хүмүүн бичиг” сонины 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 1, 2, 3 дугаар сарын дугааруудыг дарааллын дагуу **9 нэгж** болгон нааж үдэж, хавтаслан тогтмол хэвлэлийн дансанд бүртгэж авав.

Сан хөмрөгийн бүтэц зохион байгуулалт: Нийт 29 279 нэр төрлийн 57 253 боть 222 626 194 төгрөг 69 мөнгө. Үүнээс :

- ✓ Монгол номын фонд- 19785 нэр төрлийн 47644 боть 208 560 077 төгрөг 69 мөнгө
- ✓ Орос номын фонд- 7986 нэр төрлийн 8230 боть 6 501 237 төгрөг
- ✓ Англи номын фонд - 1110 нэр төрлийн 1346 боть 8 794 525 төгрөг
- ✓ Тогтмол хэвлэлийн фонд-1561 боть ном

Фондны нэгдсэн бүртгэл тооцоо бүрэн гүйцэд хийгдсэн байна.

2024 онд нийт 22,033,250 төгрөгийн 755 нэр төрлийн 1097 боть номонд техник ажиллагаа хийж уншигчдын гар дээр хүргээд байна. Үүнээс:

- ✓ Худалдаагаар 14,915,670 төгрөгийн 373 нэр төрлийн 592 боть ном
- ✓ Бэлэг хандиваар 7,117,580 төгрөгийн 382 нэр төрлийн 505 боть ном

Номын сан хоорондын солилцоо:

- Орхон сумын Соёлын төвд 17 боть
- Хонгор сумын соёлын төвд 12 боть
- АШУҮИС-ийн Дархан салбар сургуульд 37 боть
- Дархан дээд сургуульд 58 боть

Үр дүн: Нийт 127 боть номоор 4 удаагийн ном солилцоо хийсэн.

Иргэд хоорондын солилцоо:

- Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор сар бүрийн 17-нд “Ном солилцох өдөр” болгон зарласантай холбогдуулан 1, 3, 4, 5, 6, 7, 9, 10-р дугаар сарын 17-ны өдрүүд, Дэлхийн номын өдөр, 35 дахь удаагийн Үндэсний Номын

баярын арга хэмжээний үеэр солилцох нийт 320 боть ном гарган тус арга хэмжээг зохион байгууллаа.

- Дэлхийн номын өдрөөр 2 ангийн 50 сурагчийг асран хамгаалагчдын хамтдаар цагийг хөгжилтэй өнгөрүүлж, номтой нөхөрлүүлэн, номын худалдаа, ном солилцоо буюу гэр бүлийн номын худалдааг Олон улсын худалдааны төв, Оргил худалдааны төв, Дархан зах зэрэг худалдааны томоохон төвүүдэд зохион байгуулж 500 гаруй номыг сольж, худалдав.

Үр дүн: Нийт өөрийн номоо бусадтай солилцохоор 11 удаа, 810 боть номоор 800 уншигч иргэд оролцож, бие биедээ зарах буюу солилцоо хийлээ.

Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:

✓ 2024 оны 1 дүгээр сарын 08-наас 2 дугаар сарын 28-ны дотор Гадаад хэлний уншлагын танхимын Англи ном, Гэрээр ном олгох тасгийн Монгол ном, Архивын фондны Орос ном нийтдээ 17732691.10 төгрөгийн 9473 нэр төрлийн 10048 боть номыг тоолж, 7068168 төгрөг 60 мөнгөний 832 нэр төрлийн 943 боть номыг гадаад уншлагын танхим болон гэрээр ном олгох танхим руу шилжүүлж бар код, формулярыг номонд байрлууллаа.

✓ Байгууллагын захирлын “Эд хөрөнгийн тооллого хийх тухай” 2024 оны 01-р сарын 05-ны А/03 тоот тушаалын хэрэгжилт амжилттай хэрэгжсэн.

Үр дүн: Жилд 2 удаа тооллого хийж байгууллагын эд хөрөнгийн тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ашиглалтын хугацааг хянаж байна.

3.2. Номын сангийн үйлчилгээ

Аймгийн Төв номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын жагсаалт гаргах, ном хэвлэлийн тойм хийх, уншигчдад хэрэгцээтэй материалуудыг хувилах, цахим хэлбэрт байршуулах, мэдээллийг түгээх зэргээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2024 оны жилийн эцэст 5380 уншигч, 55508 ирцэд, 76842 боть ном олгож, үйлчлэн жилийн төлөвлөгөөг 100% биелүүллээ. Уншигчийн төлөвлөгөөг нэмэгдүүлэхийн тулд дараахь ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- ✓ СОНА-ын тоог нэмэгдүүлэв.
- ✓ Албан газар, ААНБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллав.
- ✓ Зөөврийн номын сангийн номын фондын тоог өсгөх зэрэг ажлуудыг хийв.

Үр дүн: Уншигч өнгөрсөн жилийнхээс 2%, ном олголт-28%-иар өссөн үзүүлэлттэй байна. /Гүйцэтгэл- 102%/

Үйлчилгээг сүүлийн 3 жилээр харуулбал:

№	Төлөвлөгөөт ажил	2022	2023	2024
1	Уншигч	5,102	5,235	5456
2	Ирц	55,053	56,202	56950
3	Ном олголт	70,937	71,443	76862

✓ Тайлангийн хугацаанд нийт 5380 уншигчдыг номын сангийн программд бүртгэснээс сунгасан 1553 уншигч, шинээр бүртгүүлсэн 3827 уншигчийн зургийг нь авч, үнэмлэх хэвлэн гаргаж тарааж өглөө.

✓ Номын сангаар үйлчлүүлсэн нийт 55508 уншигчдын захиалгын дагуу олгосон 76842 боть номыг буцаан авч ном ариутгалын төхөөрөмжинд хийж ариутган, номын сангийн DDC ангиллын дагуу тавиурт байрлуулав.

3.2.1. Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээний талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд Төв номын сан нь 2023 оноос эхлэн номын сангийн боловсролын хөтөлбөрийг бий болгож үйлчилгээндээ нэвтрүүлсэн. Түүнчлэн номын сангийн боловсролын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажилласанаар одоогоор 5 төрлийн хөтөлбөрийг уншигчдад хүргээд байна. Үүнд:

- "Монгол бахархал" хөтөлбөрт-18 удаа 630 хүүхэд
- "Би Монгол хүүхэд" хөтөлбөрт 1 удаа 23 хүүхэд
- "Хайрлахуйн ухаан" хөтөлбөрт 8 удаа 236 хүүхэд
- "Хөгжөөнт тоглоом"-оор 4 удаа 98
- Монгол соёмбо хөтөлбөрт 1 удаа 19 хүүхэд
- Эсгий урлал 1 удаа 15 хүнийг хамруулж, бүтээл хийж сургасан байна.

Түүнчлэн уншигч иргэдэд боловсролын хөтөлбөр зааж сургахын зэрэгцээ номын санчид өөрсдөө чадавхжиж байна. Үүнд:

- ✓ "Монгол бахархал" хөтөлбөрийг сан хөмрөгч И.Пүрэвбат, О.Дунжидмаа,
- ✓ "Би Монгол хүүхэд" хөтөлбөрийг номын санч Н.Дэлгэрмаа, О.Мөнхцэцэг
- ✓ "Хайрлахуйн ухаан" хөтөлбөрийг номзүйч Х.Отгонбаяр
- ✓ “Монгол соёмбо” хөтөлбөрийг Уншлага үйлчилгээний нэгжийн дарга Н.Норжмаа
- ✓ “Эсгий урлал” хөтөлбөрийг сан хөмрөгч О.Дунжидмаа
- ✓ “Эсгий үнэгний дом” хөтөлбөрийг сан хөмрөгч И.Пүрэвбат
- ✓ “Хөгжөөнт тоглоом” хөтөлбөрийг Н.Норжмаа, О.Дунжидмаа нар

боловсруулан хэрэгжүүлээд байна.

Үр дүн: Төв номын сангийн соёлын боловсролын хөтөлбөрт нийт 36 удаа 1036 хүүхдийг хамруулаад байна.

УБТЗ-ын Аялал жуулчлалын төвийн тусгай хөтөлбөрт аялалд хамтран ажиллаж байна.

№	Он сар өдөр	Боловсролын хөтөлбөрийн нэр	Хамрагдсан байгууллага	Хэдэн удаа	Хүний тоо	Хаана
1	2024.03.20	Монгол бахархал	ШШГГ-ын хорих 435-р ангийн хүмүүжигчид	1	58	ШШГГ-ын хорих 435-р анги
2	2024.03.30	Монгол бахархал	УБТЗ. Оюунлаг. 9д	1	29	Төв номын санд
3	2024.04.04	Монгол бахархал	ХБ-тэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо “Урам төв” эцэг эх	1	6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо

						“Урам төв”
4	2024.04.04	Монгол соёмбо	ХБ-тэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо “Урам төв” хүүхдүүд	1	16	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо “Урам төв”
5	2024.04.06	Би Монгол хүүхэд	УБТЗ-ын Тусгай хөтөлбөр, УБТЗ-ын ажилтнуудын хүүхэд	1	23	Төв номын санд
6	2024.04.11	Монгол бахархал	ЕБ-ын 9-р сургуулийн 9а анги	1	18	ЕБ-ын 9-р сургуульд
7	2024.04.20	Хайрлахуйн ухаан	Нийслэлийн Багануур дүүргийн 66-р сургуулийн 9-7 ангийн сурагчид	1	36	Төв номын санд
8	2024.04.27	Монгол бахархал	УБТЗ-ын албан хаагчдын хүүхдүүд	1	32	Төв номын санд
9	2024.05.01	Эсгий урлал	Төв номын сангийн ажилтан, албан хаагчид	1	15	Төв номын санд
10	2024.05.04	Хайрлахуйн ухаан,	УБ. Оюунлаг сургуулийн 9в анги,	1	26	Төв номын санд
11	2024.05.04	Монгол Соёмбо	Орос 3-р сургуулийн сурагчид	1	3	Төв номын санд
12	2024.05.04	Монгол бахархал, Монгол соёмбо	УБ. Оюунлаг сургуулийн 9г анги, Бага ангийн сурагчид	1	28	Төв номын санд
13	2024.05.08	Хайрлахуйн ухаан	Төв номын сангийн ажилтан албан хаагчид	1	15	Төв номын санд
14	2024.05.10	Хайрлахуйн ухаан	Дархан. Союз сургуулийн 6а анги	1	20	Дархан. ШУТИС
15	2024.05.11	Монгол бахархал	УБ. Сант сургуулийн 10б анги	1	21	Төв номын санд
16	2024.05.11	Монгол бахархал	УБ. 93-р сургуулийн 9б анги	1	29	Төв номын санд
17	2024.05.18	Хөгжөөнт тоглоом	УБ. Орос 3-р сургуулийн 4-3 анги	1	20	Төв номын санд
18	2024.05.18	Хөгжөөнт тоглоом	УБ. 64-р сургуулийн 5-4 анги	1	32	Төв номын санд
19	2024.05.25	Хөгжөөнт тоглоом	УБ. Плехановын нэрэмжит сургууль 4-1 анги	1	22	Төв номын санд
20	2024.05.25	Монгол бахархал	УБ. Оюунлаг сургуулийн 9а, 9б анги	1	45	Төв номын санд
21	2024.06.08	Хайрлахуйн ухаан	Оюунлаг сургуулийн 8а анги	1	25	ТНС-ийн уншлагын танхимд
22	2024.06.08	Хайрлахуйн ухаан	Оюунлаг сургуулийн 8г анги	1	25	ТНС-ийн уншлагын танхимд
23	2024.06.24	Монгол Соёмбо	УБ. Аутизмын онцлогтой хүүхдүүд	1	19	ТНС-ийн уншлагын танхимд
24	2024.08.09	Монгол бахархал	Зулзагын гол амралтын амрагч хүүхдүүд	1	130	ТНС-ийн уншлагын танхимд
25	2024.08.14	Монгол бахархал	Нүүдлийн соёлын зуслангийн амрагч хүүхдүүд	1	30	ТНС-ийн уншлагын танхимд
26	2024.09.24	Хайрлахуйн	Багахангай	1	28	ТНС-ийн уншлагын

		ухаан	дүүргийн Хангай сургуулийн 6-8р анги			танхимд
27	2024.09.24	Монгол бахархал	Смарт сургуулийн 10 анги	1	25	ТНС-ийн уншлагын танхимд
28	2024.10.12	Монгол бахархал	Баянзүрх дүүргийн Тусгай хэрэгцээт 55р сургуулийн 8-10р анги	1	23	ТНС-ийн уншлагын танхимд
29	2024.10.16	Монгол бахархал	16р сургуулийн 7б анги	1	37	Салбарт
30	2024.10.19	Монгол бахархал	Г.В.Плехановын нэрэмжит сургуулийн 8д анги	1	28	ТНС-ийн уншлагын танхимд
31	2024.10.19	Монгол бахархал	Г.В.Плехановын нэрэмжит сургуулийн 8а, 9в анги	1	36	ТНС-ийн уншлагын танхимд
32	2024.11.02	Монгол бахархал	Г.В.Плехановын нэрэмжит сургуулийн 9р анги	1	27	ТНС-ийн уншлагын танхимд
33	2024.11.06	Хайрлахуйн ухаан	Монгол-Оюу сургуулийн 7-2 анги	1	38	ТНС-ийн уншлагын танхимд
34	2024.11.09	Монгол бахархал	9р сургуулийн 7г анги	1	18	ТНС-ийн уншлагын танхимд
35	2024.11.10	Хөгжөөнт тоглоом	Төв номын сангийн уншигч хүүхдүүд	1	24	ТНС-ийн уншлагын танхимд
36	2024.11.12	Хайрлахуйн ухаан	15р сургуулийн 12р ангийн сурагчид	1	35	15р сургуульд
		Нийт		36	1036	



Номын сангийн Соёлын боловсролын хөтөлбөрийн “ХАЙРЛАХУЙН УХААН” сургалтыг УБТЗ-ын тусгай хөтөлбөрийн аялагчид 6, бусад 3 нийт 9 удаа 223 насанд хүрэгчдэд болон сурагчдад номын сангийн танилцуулга, электрон каталоогоос хайлт хийх талаар мэдээлэл, сургалтыг номзүйч Х.Отгонбаяр хүргэн ажилласан байна.



"ӨВЛӨН БҮТЭЭХ, ӨНӨӨ ИРЭЭДҮЙ" уриатайгаар зохион байгуулагдаж буй Соёлын бүтээлч сарын ажлын хүрээнд 1-р сургуулийн Ш.Бүрэнжаргал багштай 5г ангийн сурагчдад Номын сангийн боловсролын "МОНГОЛ БАХАРХАЛ" хөтөлбөрийн "ЭСГИЙ ҮНЭГНИЙ ДОМ" сургалтыг сан хөмрөгч-Мэдээллийн ажилтан И.Пүрэвбат зохион байгууллаа.



Нүүдэл” номын богц аян: 19 удаа 1006 боть номоор үйлчиллээ.

- ✓ Соёлын бүтээлч сарын хүрээнд санаачлан эхлүүлсэн “Нүүдэл” номын богц маань аялалаа үргэлжлүүлсээр байгаа бөгөөд өнөөдөр Х.Отгонтуяа эрхлэгчтэй 30-р цэцэрлэгийн багш ажилчид хоёр дахь номын богц 25 боть

номоо сольж авлаа. “Нүүдэл” номын богц аяны хүрээнд 30 дугаар цэцэрлэгийн 28 багш сар гарны хугацаанд 77 боть ном уншиж, тэмдэглэл хөтөлжээ.

- ✓ ШШГГ-ын хорих 435 дугаар ангийн номын санч Ж.Уранчимэгт захиалгын дагуу 22 боть номыг олгов.
- ✓ Дархан-Уул аймгийн 30-р сургуулиас санаачлан зохион байгуулсан "Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ? танин мэдэхүйн АХА тэмцээнд зориулан Төв номын сангаас 50 боть номыг зөөвөрлөн үзэсгэлэн гаргаж оролцлоо.
- ✓ Оюуны-Ирээдүй” цогцолбор сургуулийн Англи хэлний тэнхимээс санаачлан Төв номын сантай хамтран “Green world- Our future” тэмцээнд зориулан Төв номын сангаас 50 гаруй англи номоор "ХЭЛТЭЙ БОЛ ХӨЛТЭЙ" тус сургуульд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргалаа.
- ✓ ШШГГ-ын харъяа хаалттай 435 дугаар хорих ангид “Бүтээлч Дархан” өдөрлөгийн хүрээнд Монгол үндэсний уран зураг, хээ угалз, оёдол эсгүүрийн талаарх 50 гаруй боть номын үзэсгэлэнг хүргэн ажиллалаа.
- ✓ Дэлхийн Монгол иргэн Олон улсын боловсролын өдөрлөг Залуучууд театрт зохион байгуулж Төв номын сангаас мэргэжил сонголт, гадаад хэл, интерьер дизайн, гэх мэт нийт 100 гаруй боть номоор "МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН" сэдэвчилсэн номын үзэсгэлэн Залуучууд театрт гаргасан байна.
- ✓ Өсөх Ирээдүй цэцэрлэгт 70 гаруй хүүхдэд "Үлгэрийн ертөнц" сэдэвт 69 боть номоор үзэсгэлэн гаргав.
- ✓ 19 дүгээр сургуулийн 3 дугаар ангид Зөөврийн номын сангийн үйлчилгээ: 66 боть номоор
- ✓ 1-р цэцэрлэгт 65 боть номоор 65 хүүхдэд
- ✓ Зулзагын голын хүүхдийн зусланд амарч буй 130 гаруй хүүхдэд 87 боть номоор
- ✓ Нүүдлийн соёлын боловсрол олгох тус зусланд амарч буй 30 гаруй хүүхдэд 95 боть номоор
- ✓ "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн нийт ажилтан албан хаагчдад 36 боть номоор
- ✓ “Монгол-Оюу” сургуультай хамтран Уйгаржин монгол бичгээр хэвлэгдэн гарсан 22 номоор
- ✓ 18 цэцэрлэгийн 6 бүлгийн 150 гаруй хүүхдүүдэд 78 боть номоор
- ✓ 16 дугаар сургуулийн 1-р ангийн 6 бүлгийн нийт 217 сурагчдад 70 боть номыг
- ✓ Дархан Дулааны Сүлжээ ТӨХК-д 150 боть номыг
- ✓ Дархан Сумын ЗДТГ-т 110 боть номыг
- ✓ Дархан Цагдаагийн Газарт 157 боть номыг
- ✓ 1-р сургуульд 70 боть номыг тус тус зөөвөрлөн зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Нийтийн уншлага: Дэлхийн номын өдөр дархан хотод

✓ Дэлхийн номын өдрийн үйл ажиллагаанд ОД цогцолбор сургуулийн Д.Энхтунгалаг багштай 5-6 анги, Шинэ алхам сургуулийн н.Янжин багштай 5а анги, 1-р сургуулийн Д.Цэндбазар багштай 5в анги, ОИ сургуулийн С.Наранцэцэг багштай 3-9 ангийн хамт олон урилгаар оролцов.

✓ "Дэлхийн уран зохиол" 73 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж мөн Дионис драмын дугуйлангийн сурагчдын жүжигчилсэн тоглолт, номын худалдаа, ном солилцоог Олон улсын худалдааны төв, Оргил худалдааны төв, Дархан зах зэрэг худалдааны томоохон төвүүдийн үйлчлүүлэгчдэд хүргэн ажиллав. Тус өдөрлөгөөр Дархан-Уул аймгийн Соёлын салбарын залуучуудын зөвлөл "АХА"танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг иргэдийн дунд амжилттай зохион байгууллаа.

“Оюунлаг уншигч” өдөрлөг 44 удаа 1205 боть номыг 11541 хүнд сурталчилсан байна.

- Соёлын байгууллагууд хамтран “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгийг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж урлагийн тоглолт, лекц илтгэл, сэдэвчилсэн номын үзэсгэлэн зэрэг нийт 6 арга хэмжээнд 435 хүүхэд, багачуудыг оролцууллаа.

- “Оюунлаг Дархан” хөтөлбөрийн хүрээнд Оюунлаг Дарханчууд өдөрлөгийг 9 удаа зохион явуулж 632 хүүхдийг хамруулсан.

- "Угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ?" сэдвээр 4 удаа сургалт зохион байгуулж 158 иргэн оролцов.

-“Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага, тойм яриаг бага насны хүүхдүүдийн дунд 8 удаа зохион байгуулж, 332 хүүхэд хамрагдлаа.

-“Дөрвөн бэрх урлъя” эсгий урлалын сургалтад 18 албан хаагч хамрагдав.

- -"Зохиолч, яруу найрагчдын уулзалт"-ыг 4 удаа зохион байгуулагдаж, 310 хүүхэд хамрагдсан байна.

- “Уран жиргээ 2024” уран уншлагын уралдаанд 32 хүүхэд, “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгөөр “АХА” тэмцээнийг ахлах ангийн 123 сурагчдын дунд зохион байгуулав.

- “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгийн үеэр сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 6 удаа 555 боть номоор гаргасан.

-“Хэл бичгээ өвлөн бахархъя” эсээ бичлэгийн уралдаанд нийт 63 иргэн хамрагдсан.

- Дүрийн тоглолт бүтээх уралдааныг СӨББ болон ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж 36 хүүхдийг хамруулав.

- "1000 ном уншлагын хөтөлбөр"-ийн сургалтад соёлын байгууллагууд болон ЕБС, СӨББ-ийн 60 гаруй багш нарыг хамруулсан.

3.2.2. Номын санд шаардлагатай төсөл - хөтөлбөр боловсруулсан талаар

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд Аймгийн Төв номын сангаас **НОМЫН САНГИЙН Боловсролын хөтөлбөр**-ийг бий болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

2024 онд номын сангийн боловсролын хөтөлбөрийг 5 удаа шинээр боловсруулан 36 удаа зохион байгуулж, 1036 уншигч иргэдийг хамруулан **3 331 000** төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: УБТЗ-ын Тусгай хөтөлбөрийн аялалын хүүхдүүд болон Төв номын сангийн соёлын боловсролын хөтөлбөрт хамруулснаас, "Монгол бахархал" хөтөлбөрт-18 удаа 630 хүүхэд, "Би Монгол хүүхэд" хөтөлбөрт 1 удаа 23 хүүхэд, "Хайрлахуйн ухаан" хөтөлбөрт 8 удаа 236 хүүхэд, "Хөгжөөнт

тоглоом"-оор 4 удаа 98, Монгол соёмбо хөтөлбөрт 1 удаа 19 хүүхэд, Эсгий урлал 1 удаа 15 хүнийг хамруулжээ.

2. Төв номын сан нь үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хангах хүрээнд **“Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх”** 60.0 сая төгрөгийн өртөг бүхий төслийг орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэв.

3.2.3. Соёл олон нийтийн ажил зохион байгуулсан талаар:

Зохиолч, уншигчдын уулзалт:

- МЗЭ-ийн Дархан-уул аймаг дахь салбарын 60 жил-ийн ойн хүрээнд Дархан нутгийн үе үеийн зохиолчдын намтар, уран бүтээл, "ГАЛ ӨД" наадмын цуврал бүтээл 2004-2024 он, Зохиолчдын гар бичмэл, "Найрамдлын Дархан" сонины 1964-2000 оны дугааруудаар үзэсгэлэн гаргаж, уншигч иргэддээ толилуулав.
- Хаврын номын баяр-2024 арга хэмжээний хүрээнд "ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"-ыг ЕБ-ын XV сургуулийн 11 дүгээр ангийн 5 бүлгийн 150 гаруй сурагчийн дунд зохион байгууллаа. Зохиолч, уншигчдын уулзалтад:
 - МЗЭ-ийн гишүүн, МЗЭ-ийн болон "Утга зохиолын төлөө" шагналт, зохиолч яруу найрагч Норжмаагийн Төмөртоогоо
 - МЗЭ-ийн гишүүн, МУСТА, яруу найрагч Дашдондогийн Мөнххишиг
 - МЗЭ-ийн болон Монголын шог зураачдын "Шогч бийр" холбооны УЗ-ийн гишүүн, шог зураач, "Утга зохиолын төлөө" шагналт, шог зохиолч, МУСТА Дашнямын Мянганзам
 - МЗЭ-ийн гишүүн, МУСТА, ая зохиогч, яруу найрагч Цэвэгсүрэнгийн Ичинхорлоо нар уригдан оролцож яруу найргийн ертөнцөөр аялуулан, өөрсдийн уран бүтээлийн дээжээс толилуулсан бол авьяас чадвараараа алдартай МУСТА Д.Мянганзам гитар даран дуу дуулж, элэглэл хэлэн сурагчдын сонирхлыг үлүү ихээр өрнүүлсэн уулзалт боллоо.

Мөн "НОМ" сэдэвт 4 мөрт шүлгийн уралдаан зарлан нийт 29 сурагчид оролцсон ба Төв номын сангаас "ОРОН НУТГИЙН ЗОХИОЛЧДЫН БҮТЭЭЛЭЭС" сэдэвт 26 боть номоор үзэсгэлэн гарган үйлчилгээ үзүүлэн ажиллав.

Шинэ номын нээлт:

Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, эрхэм хүмүүн ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ-ын улс эх орныхоо бүтээн байгуулалт, хөгжлийн төлөө хийсэн ажлын нэгээхэн хэсэг болох Дархан хотын бүтээн байгуулалтын талаар "Ю.ЦЭДЭНБАЛ ДАРХАНЫ ЦОГЦ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" номыг МУ-ын Гавьяат багш, МУИС-ын Проф, Доктор, Ю.Цэдэнбалын Академийн Эрдмийн зөвлөлийн дарга Цэен-Норовын Жамбалсүрэн, Ю.Цэдэнбалын Академийн дэд Ерөнхийлөгч, Академич Тавхийн Жаргалсайхан нар эмхэтгэн бүтээсэн номын нээлт боллоо.

Тус номын нээлтийг аймгийн Төв номын сан 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан бөгөөд номын нээлтэнд УИХ гишүүн, Ёс зүй Сахилга, хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХурлын дарга Я.Бат-Очир, Соёл Урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, төрсөн дүү Юмжаагийн Жавзан, Увс аймгийн Дархан-Уул аймаг дахь нутгийн

зөвлөл, Монголын зохиолчдын эвлэлийн холбооны Дархан дахь салбарын зохиолчид болон уншигчид оролцсон юм. Мөн Төв номын сангаас “ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ” сэдэвт 33 боть номоор үзэсгэлэн гарган үйлчилгээ үзүүлэн ажиллав.

"Мэргэжил сонголт ба ирээдүй" сургалт

Дархан-Уул аймгийн ОИ сургуулийн 1994 оны 10А ангийн төгсөгчдийн 30 жилийн ой ойн хүрээнд хамтран ЕБС-ийн сурагчдад зориулсан Улаанбаатар хотын "КАРЬЕР ХӨГЖЛИЙН" төвийн Ц.Булган захирлын "МЭРГЭЖИЛ СОНГОЛТ БА ИРЭЭДҮЙ" сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 60 гаруй сурагч хамрагдан ирээдүйн мэргэжлээ сонгоход юуг анхаарах, ирээдүйд ямар мэргэжил илүү ирэлт хэрэгцээтэй байх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авав.

Зуслангийн зугаатай уншлага

- Төв номын сангаас Дархан-Уул аймгийн Зулзагын голын хүүхдийн зусланд амарч буй 130 гаруй хүүхдэд номын сангийн боловсролын хөтөлбөр "МОНГОЛ БАХАРХАЛ" дээлийн сампин зангидах сургалт болон "Номын сан хүүхдийн зусланд", "Зуслангийн зугаатай уншлага" сэдэвт 87 боть номоор үзэсгэлэн гарган ажиллалаа.
- Монгол түмний нүүдэлчин ахуйн соёлын онцлог, аж байдал, амьдрах ухааныг өвлүүлэн тээн үлдээх зорилготой "НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЗУСЛАН" -гийн V ээлжинд амарч буй 30 гаруй хүүхдэд номын сангийн танилцуулга мөн боловсролын хөтөлбөр "МОНГОЛ БАХАРХАЛ" дээлийн сампин зангидах сургалт, "Номын сан хүүхдийн зусланд", "Зуслангийн зугаатай уншлага" сэдэвт Англи, Монгол хэл дээр нийт 95 боть номоор үзэсгэлэн гарган ажиллав.

Сургалтад идэвхтэй хамрагдсан сурагчдыг урамшуулдаг бөгөөд захиалгын дагуу олгосон 33 боть номыг хүүхэд тус бүр долоо хоногийн турш нэг ном уншиж хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай.

“Эх хэлний өдөр”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлигийн дагуу “Эх хэлний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, “Оюунлаг Дарханчууд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Оюунлаг хүүхдийн төлөө” уриан дор үндэсний хэл соёлоо түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын оюуны чадамжийг хөгжүүлэх, тэднийг тасралтгүй бүтээлчээр суралцах, хүнлэг оюунлаг иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор "ЭХ ХЭЛ - ЗӨВ УНШЛАГА" АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 26 сурагч оролцсон бөгөөд:

I байр: Од цогцолбор сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Б.Анунгоо

II байр: Од цогцолбор сургуулийн 9 дүгээр ангийн сурагч П.Сарангэрэл

III байр: 4 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч У.Эгиймаа

Тусгай байр: 9 сургуулийн 12 дугаар ангийн сурагч Б.Амин-Эрдэнэ нар тус тус шалгарч ӨРГӨМЖЛӨЛ мөнгөн шагналаар шагнуулав.

Номын санчийн “Хишиг өдөр”

Монгол Улсын Соёл, урлагийн ажилтны 31 дэх өдрийг угтан Төв номын сангаас номын санчийн “ХИШИГ ӨДӨР”-ийг 3 дахь жилдээ зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд урилгаар Од цогцолбор сургуулийн 12-2 ангийн сурагч О.Анар,

салбар номын санд 16 дугаар сургуулийн 7б ангийн сурагч Ш.Мөнх-Учрал уригдан ирж

Номын санч мэргэжлийг хаана сурч эзэмшдэг
Номын сангийн программ
Уншигчийн бүртгэл хийх
Номын татгалзал
Ном ангилах, данслах
Номын сангийн стандарт
Номын хадгалалт хамгаалалт
Сонин сэтгүүл бүртгэх гэх мэт номын сангийн үйл ажиллагаатай нэг бүрчлэн танилцаж, уншигчдад үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.



Од сургуулийн 12-2 ангийн сурагч О.Анар, Номын санч-Мэдээллийн ажилтан Н.Дэлгэрмаа



Сан хөмрөгч О.Дунжидмаа, зочин номын санчаар ОИЦ сургуулийн Б.Хандмаа, У.Төрболд

Зочин номын санчийг Уншлага, үйлчилгээний нэгжийн дарга Н.Норжмаа, Номын санч-Мэдээллийн ажилтан Н.Дэлгэрмаа, Сан хөмрөгч Мэдээллийн ажилтан П.Булгамаа нар чиглүүлэн ажилласан ба номын санчаар ажилласан сурагчдадаа талархал, 2 цагийн хөдөлмөрийн үнэлэмж болох 15600 төгрөгийг тус тус гардуулан өглөө.

"Уншихад урам" монголын уран зохиолын дүрийн тоглолтын уралдаан

Намрын номын баярыг тохиолдуулан Монголын уран зохиолоос сэдэвлэсэн "УНШИХАД УРАМ" дүрийн тоглолтын уралдааныг ахмадуудын зохион байгууллаа.

Дархан сумын Ахмадын хороотой хамтарсан тус уралдаанд 7 багийн 60 гаруй ахмадууд авьяас билгээ уралдуулан 2-3 минутын багийн мэндчилгээ болон 10-15 минутын уран зохиолын дүрийн тоглолтыг толилуулж, 270 гаруй ахмад үзэж сонирхов.

Шүүгчээр Залуучууд театрын жүжигчин МУСТА М.Буджав, МУСТА Ч.Дунгаамаа, МУСТА Б.Баттуяа нар ажилласан бөгөөд онооны дүнгээр:

- ✓ 1 байр: 14 дүгээр багийн ахмадын баг
- ✓ 2 байр: 16 дугаар багийн ахмадын баг
- ✓ 3 байр: Малчин багийн ахмадын баг тус тус байр эзлэв.

“Эх хэлний дархлаа” өдөрлөг

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд – 2024” намрын номын баярын үйл ажиллагааны хүрээнд Ерөнхий боловсролын “Монгол-Оюу” сургуультай хамтран “Эх хэлний дархлаа” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөөр Уйгаржин монгол бичгээр хэвлэгдэн гарсан 22 номоор “Эх хэл мину” үзэсгэлэн гаргаж, Уйгаржин Монгол бичгээр “Алдаагүй цэвэр бичих”, “Минутын уншлага”, “Зөв уншлага” АХА зэрэг тэмцээн уралдаануудыг дунд болон ахлах ангийнхны дунд зохион байгуулав.

“Миний шинэ ном” комик ном бүтээх уралдаан

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” намрын номын баярын хүрээнд комик ном бүтээх уралдааныг зохион байгуулж, тус уралдаанд 9 сургуулийн 56 хүүхдийн 79 бүтээл ирлээ. Үүнээс:

- 1 байр: 16 дугаар сургуулийн 9д ангийн сурагч Б.Бат-Амгалангийн "Нууц шид" комик ном
- 2 байр: 16 дугаар сургуулийн 5в ангийн сурагч М.Төгс-Ирээдүйгийн "Компьютер" комик ном
- 3 байр: Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 12в ангийн сурагч А.Айтолкыны "Цэцэгхэн охины адал явдал" комик ном шалгарлаа.

Номын хавчуурга бүтээх уралдаан

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” намрын номын баярын хүрээнд хүүхэд залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шинэ санаа, бүтээлч байдлыг шингээсэн гарын доорхи материал ашиглан “Гоёхон номын хавчуурга” бүтээх уралдааныг зарлав. Тус уралдаанд ШШГГ-ын 435 дугаар ангиас-2, оюутан-4, Ерөнхий боловсролын 9 сургуулийн 297 сурагчийн 711 бүтээл ирсэн бөгөөд үүнээс:

1 байр: ШШГГ-ын 435 дугаар ангийн хүмүүжигч О.Энхбат /Чулуугаар хийсэн бүтээл/

2 байр: 16-р сургууль 5б ангийн сурагч н.Батзориг /Соронзтой бүтээл/

3 байр: Од сургуулийн багш Ж.Ариунзаяа /Цавуугаар цутгаж хийсэн бүтээл/

Тусгай байр:

12-р сургууль 3б ангийн сурагч Ө.Хандмаа /Дүрэмтэй бүтээл/

16-р сургууль 5б анги Т.Анужин /Онч мэргэн үгтэй, цацагтай бүтээл/

12-р сургуулийн Тусгай бүлгийн 10б анги Б.Энхжаргал /Нэр бичиж хийсэн бүтээл/

16-р сургуулийн 7б ангийн сурагчид /Арьсан бүтээл/

15-р сургууль 12д ангийн сурагч /Ургамал нааж хийсэн бүтээл/ нар шалгарлаа.

“Монгол ардын ерөөл магтаал” видео бичлэгийн уралдаан

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024" намрын номын баярын хүрээнд Дархан-Уул аймгийн нийт иргэд, хүүхэд залуучуудын дунд 9-р сарын 20-ны өдрийг хүртэл “Монгол Ардын Ерөөл, магтаал, өв уламжлал”-ыг сэргээх, таниулах зорилго бүхий видео бичлэгийн уралдаан зарлаж тухайн уралдаанд 6-17 насны 118 хүүхэд бичлэг ирүүлснээс:

- * 1-р байр- Т.Эрхэмбаяр. Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 8а ангийн сурагч /Айргийн ерөөл/
- * 2-р байр- Л.Бүрэнтөгс. Шарын гол сумын 2 дугаар сургууль 7а ангийн сурагч /Хурдан морины Ойрад магтаал/
- * 3-р байр- О.Уранзаяа. 9 дүгээр сургуулийн 16 ангийн сурагч /Сэвлэг үргээх ерөөлийн үг/ тус тус байр эзэлжээ.

Төв номын сангийн хэмжээнд соёл олон нийтийн ажлыг Соёлын сайд, Засаг даргатай байгуулсан гэрээ, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллав.

Үр дүн: 2024 онд соёл олон нийтийн 24 нэр төрлийн ажлыг 407 удаа зохион байгуулж, 83487 хүнд хүргэж, 17876 боть номыг сурталчилсан байна.

ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭ

д/д	Зохион байгуулагдах ажлууд	2024 он		
		Хэдэн удаа	Хүний тоо	Номын тоо
	<i>Сургалт семинар</i>	62	7,862	1,205
1	Зөвлөн туслах үйлчилгээ	10	10	
2	Номын санчид зориулсан сургалтууд	11	377	
3	Иргэдэд зориулсан сургалт, уулзалт			
4	Оюунлаг Дарханчууд өдөрлөг	29	6851	1205
5	Лекц	12	624	
6	Дугуйлан	4	24	1000
	Уралдаан, тэмцээн, наадам	10	673	0
7	Уралдаан	10	673	
	Хурал зөвлөгөөн	16	1345	0
8	Шинэ номын нээлт	3	260	
9	Зохиолч уншигчдын уулзалт	6	620	
10	Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг	6	365	
11	Бүсийн зөвлөгөөн	1	100	
	Үзэсгэлэн худалдаа	103	10091	3840

11	Номын үзэсгэлэн	72	8625	3030
12	Номын сантай танилцах аялал	20	666	
13	Номын худалдаа, ном солилцоо	11	800	810
	Зохион байгуулсан эвент /арга хэмжээ	212	63492	11831
14	Боловсролын хөтөлбөр	36	1036	
15	Чанга уншлага	18	957	34
16	Номын хандив	1	64	868
17	Мэргэжил сурталчлах ажлууд	2	180	220
18	Эх хэлний өдөр, номын баяр, соёл урлагийн ажилтны өдөр	4	5765	
19	Тэргүүний уншигч	2	146	
20	Номзүйн ажлууд	7	480	351
21	Зочинтой өдөр	23	414	
22	Номонд дурлагсад	7	12877	
23	Соёлын бүтээлч сар	45	11209	
24	Хавар, намрын "Номын баяр"	67	30364	10358
	НИЙТ ДҮН	407	83,487	17,876

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн: Уншлага үйлчилгээ нь түүхт ой болон тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан номын сангийн фондод байгаа ном хэвлэлээр үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчилдаг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажилладаг. 2024 онд 103 удаа номын үзэсгэлэн гаргаж 3840 хүн үзэж сонирхжээ.

№	Зохион байгуулах ажлын нэр	Хэдэн удаа	Хүний тоо	Номын тоо
1	Номын үзэсгэлэн	72	8625	3030
2	Номын сантай танилцах аялал	20	666	
3	Номын худалдаа, ном солилцоо	11	800	810
	ДҮН	103	10,091	3,840

3.2.4. Ном уншлагыг сайжруулах, уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг зохицуулах ажлын талаар

Байгууллагын зүгээс уншлагыг сайжруулах олон талт үйл ажиллагааг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулж ирлээ. Үүнд:

“**Үр дүнтэй уншлага**” хэлэлцүүлгийг Мэргэжил арга зүйн нэгжээс зохион байгуулж, ЕБС-ийн 70 гаруй сурагчид оролцов. Тус хэлэлцүүлгээр:

- Од цогцолбор сургуулийн 10-4 ангийн сурагч н.Хүсэл “Ном уншихын ач тус”
- Од цогцолбор сургуулийн 10-4 ангийн сурагч Т.Мянганбаяр “Номын клубыг яаж удирдах вэ?”
- Монгол-Оюу сургуулийн 10-1 ангийн сурагч Э.Өнө-ундрал, Х.Аминбилэг нар “Миний мөрөөдлийн номын сан”
- Дөрөвдүгээр сургуулийн 11б ангийн сурагч Ж.Болорзаяа “Илүү их уншъя”
- Нэгдүгээр сургуулийн 10б ангийн сурагч С.Дэлгэрцэцэг “Ном бол мэдлэгт хүрэх гүүр”
- Оюуны Ирээдүй Цогцолбор сургуулийн 12-8 ангийн сурагч М.Даваамаа “Номын эгшиг”
- Есдүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Идэржаргал “Номыг унших арга” сэдэвт илтгэлүүдийг хэлэлцүүлж, өөрсдийн үзэл бодлоо хуваалцлаа.

Бүтээлч уншлага: “Оюунлаг уншигч” өдөрлөгийг 44 удаа зохион байгуулж 15 минутын бүтээлч уншлагад 4800 гаруй хүн хамрагдав.

1000 ном хөтөлбөр: Nerko Kids хэвлэлийн газраас Оксфордын Их сургуулийн уншлагын хөтөлбөрийг Монголд нутагшуулж, хүүхдийг номонд дурлуулах, ном унших хэвшилтэй болгох, унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн “1000 ном уншлагын хөтөлбөр”-ийг санаачлан 3-18 нас хүртэл унших 1000 номын агуулгыг боловсруулан сургалт, мэдээлэл өгч байгаа бөгөөд тус төслийн багтай хамтран /2024.04.04/ Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, Соёл, урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Хүүхдийн номын ордны удирдлагууд болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй СӨББ, ЕБС-ийн удирдлага, номын санчидтай уулзалт танилцуулгыг өглөө. Хүүхдийг номонд дуртай болгох, зөв иргэн байх төлөвшүүлэх зорилгоор "1000 ном уншлагын хөтөлбөр"-ийн төслийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Чанга уншлага: /18 удаа 34 өгүүллэг болон үлгэрээр 957 хүүхдэд/

№	Хаана / хэнд	Үлгэрийн нэр	Хэдэн удаа	Хамрагдсан хүүхэд
1	30-р цэцэрлэгийн н.Сарангуа багштай "Бэлтгэл Б"	"Туулайн уруул яагаад сэтэрхий болсон бэ"	1	32
2	30-р цэцэрлэгийн н.Мөнхцэцэг багштай бэлтгэл бүлгийн	"Тэнгэрийн охин" үлгэр	1	34
3	16-р сургуулийн Ч.Оюунгэрэл багштай 6/б ангийн сурагчдад	Д.Энхтуяагийн "Хотын сүнс" өгүүллэг	1	37
4	30-р цэцэрлэгийн "Бэлтгэл" бүлгийн	"Сарны үлгэр", "Бамбаруушууд шударга ёсонд суралцсан нь"	2	28
5	30-р цэцэрлэгийн Б.Сарангуа, Ш.Мөнхцэцэг багштай "Бэлтгэл" бүлэг	"Хөхөө Намжил" Монгол ардын үлгэрээр	1	18
6	ОД цогцолбор сургуулийн О.Цасчимэг багштай 1г анги	"ТЭМЭЭ ЭВРЭЭ АЛДСАН НЬ" Монгол ардын үлгэрээр	1	35
7	1-р сургуулийн Д.Цэндбазар багштай 5в анги	"ЭГЧ ДҮҮ ХОЁР" Орос ардын үлгэрээр	1	36
8	12-р цэцэрлэгийн н.Номин-Эрдэнэ багштай бэлтгэл А бүлгийн	"ГУТАЛТ МУУР" үлгэрээр	1	28
9	12-р цэцэрлэгийн У.Анхбаяр багштай бэлтгэл В бүлгийн	"ЦУУТЫН ЦАГААГЧ ГҮҮ" Монгол ардын үлгэрээр	1	28
10	19-р сургуулийн Д.Баярсайхан багштай 3б анги	"Гоё үлгэр", "Дэлхийн сонгодог үлгэрүүд"-ээр	2	29
11	Өсөх-Ирээдүй цэцэрлэгийн 3 бүлгийн	Монгол ардын үлгэрээр	3	60
12	19-р сургуулийн Б.Баттамир багштай 3а, Б.Баярсайхан багштай 3б анги	"ЗААН ОГТОНО ХОЁР" үлгэрээр	2	60
13	XV сургуулийн А.Ариунжаргал багштай 1б анги	"Мэргэн хүү Өгөдэй" ач тусын үлгэрээр	1	38
14	1-р цэцэрлэгийн н.Мядагмаа багштай ахлах "А", "Б" бүлгийн	"Цэцэн туулай", "Тэнгэрийн охин" Монгол ардын үлгэрээр	2	65
15	Шинэ алхам сургуулийн н.Нарангэрэл багштай 4б анги	"ХАРААЦАЙ ХЭДГЭНЭ ХОЁР" Монгол ардын үлгэрээр	1	28

16	18 цэцэрлэгийн 6 бүлгийн	Монгол ардын үлгэрээр	6	150
17	16 дугаар сургуулийн 1-р ангийн 6 бүлгийн	"Багваахай цэцгийн хүрээлэн", "Шүдэнз худалдагч охин", "Шинэ хааны хувцас", "Арван хоёр сар" зэрэг сонгодог үлгэрүүдээр	6	217
18	30 дугаар цэцэрлэгийн Б.Бадамсүрэн, Б. Мөнхцэцэг багштай бэлтгэл "Б" бүлгийн	"Гоё Үлгэр" номын "Нар Сар хоёр муудалцсан" үлгэрээр	1	34
			34	957

3.2.5. Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

Зуслангийн зугаатай уншлага:

- Төв номын сангаас Дархан-Уул аймгийн Зулзагын голын хүүхдийн зусланд амарч буй 130 гаруй хүүхдэд номын сангийн боловсролын хөтөлбөр "МОНГОЛ БАХАРХАЛ" дээлийн сампин зангидах сургалт болон "Номын сан хүүхдийн зусланд", "Зуслангийн зугаатай уншлага" сэдэвт 87 боть номоор үзэсгэлэн гарган ажиллалаа.
- Монгол түмний нүүдэлчин ахуйн соёлын онцлог, аж байдал, амьдрах ухааныг өвлүүлэн тээн үлдээх зорилготой "НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЗУСЛАН" -гийн V ээлжинд амарч буй 30 гаруй хүүхдэд номын сангийн танилцуулга мөн боловсролын хөтөлбөр "МОНГОЛ БАХАРХАЛ" дээлийн сампин зангидах сургалт, "Номын сан хүүхдийн зусланд", "Зуслангийн зугаатай уншлага" сэдэвт Англи, Монгол хэл дээр нийт 95 боть номоор үзэсгэлэн гарган ажиллалаа.
Сургалтад идэвхтэй хамрагдсан сурагчдыг урамшуулдаг бөгөөд захиалгын дагуу олгосон 33 боть номыг хүүхэд тус бүр долоо хоногийн турш нэг ном уншиж хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай болсон байна.

3.2.6 Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх:

- **Нүүдэл зөөврийн үйлчилгээ:** Номын сангийн тухай хууль болон БСШУ-ны сайдын 2010 оны 570 дугаар буюу "Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал" тушаалын дагуу 45 удаа **1140 уншигчдад 9455 боть** номоор Зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ.
- **Ном гэрээр олгох:** Номын санд удаан хугацаагаар суух боломжгүй өндөр настан болон тусгай хэрэгцээт иргэд, бусад шалтгаантай нийт 1163 уншигчид 2178 номыг гэрээр олгож үйлчиллээ.

3.2.7 Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Номын сантай танилцах аялал: 20 удаа 20 бүлгийн 666 хүүхэд хамрагдав.

Дүрийн тоглолттой" уншигчдын бага хурал

ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР-2024" үйл ажиллагааны хүрээнд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрдэм номыг түгээн дэлгэрүүлэх, номтой нөхөрлөх хүсэл сонирхлыг дэмжих зорилгоор "ДҮРИЙН ТОГЛОЛТТОЙ УНШИГЧДЫН БАГА ХУРАЛ"-ыг зохион байгууллаа. Уншигчдын бага хурлыг "Зөв хүүхэд гэж хэн бэ?" сэдвээр IX-р сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Э.Уянга, "Дүрийн онцлогийг илэрхийлэх нь" сэдвийн хүрээнд бг ангийн сурагч Б.Эгшиглэн, Г.Намуунаа, Э.Энхзаяа, Д.Нармандах, Н.Цэлмэг нар илтгэл тавин, харилцан ярилцаж санал бодлоо солилцлоо. Мөн сурагчид "ЛАГШМИЙН СОЁРХОЛ" Энэтхэг ардын үлгэрээс сэдэвлэн анги хамт олноороо дүрийн тоглолт

тоглож үзүүлэв. Зохион байгуулагчдын зүгээс үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдсан багш, сурагчдад батламж, дурсгалын зүйлс гардуулан өглөө.

"Ном" уран илтгэлийн уралдаан зохион байгууллаа

"ХАВРЫН НОМЫН БАЯР-2024" үйл ажиллагааг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймгийн Төв номын сангаас бага насны хүүхдийн дунд "НОМ" илтгэлийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд нийт 28 СӨБ болон ЕБС-ийн нийт 38 хүүхэд оролцов.

"Монгол ардын ерөөл магтаал" видео бичлэгийн уралдаан

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024" намрын номын баярын хүрээнд Дархан-Уул аймгийн нийт иргэд, хүүхэд залуучуудын дунд Монгол Ардын Ерөөл, магтаал, өв уламжлалыг сэргээх, таниулах зорилго бүхий видео бичлэгийн уралдаан зарлаж 6-17 насны 118 хүүхэд оролцов.

"Миний шинэ ном" комик ном бүтээх уралдаан

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024" намрын номын баярын хүрээнд хэн хүний бодож олоогүй сонин содон, гайхамшигтай адал явдлуудыг цаасанд буулгаж, зургаар амилуулан комик ном бүтээх уралдааныг зарласан билээ. Тус уралдаанд 9 сургуулийн 56 хүүхдийн 79 бүтээл ирэв.

Номын сантай танилцах аялал: Номын сан, ном соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор номын сантай танилцах аялалыг албан байгууллага, сургууль, цэцэрлэгүүдэд **23** удаа зохион байгуулж **878** хүнд **380** боть номыг сурталчилав.

Хүүхэд хамгаалал:

- "Хүүхэд хамгааллын жил", Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Төв номын сан уншигч, үйлчлүүлэгчдэдээ зориулан эрүүл мэндийн "АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ"-ийг байршуулан ажиллуулж байна.
- "Хүүхэд хамгааллын жил", "Эрсдэлгүй Дархан" аяны хүрээнд Дархан-Уул аймгийн Төв номын сан бүрэн камержлаа. Ингэснээр номын сангийн орчинд ном дэвтэр, цүнх хувцас зэрэг хаяж гээсэн зүйлээ олж авах, уншигчдын дэг журам сайжрах зэргээр үр дүнгээ өгч байна.
- Дэлхийн хүүхдийн өдрөөр аймгийн Төв номын сангаас нийт ажилтан албан хаагчдын 6-16 насны 9 хүүхдэд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. "ИРЭЭДҮЙГЭЭ СОНСЪЁ" уриатайгаар зохион байгуулагдаж буй тус өдөрлөгт Төв номын сангийн хамт олон цэнхэр өнгийн хувцсаар ижилсэж, хүүхдүүдээ ажлын байрандаа урин тэдний дуу хоолойг сонсож, хүлээн авч уулзлаа. Хүүхдүүд хөтөлбөрийн дагуу Канвас зургийн гайхамшигийг мэдрэн өөрсдийн дуртай зургаа урлан, эцэг, эхийн хамтаар аймгийн Музей, Эмэгтэйчүүдийн ордны үйл ажиллагаатай танилцан, уран зураг үзэж сонирхов.

Үр дүн: Хүүхэд хамгааллын ажлын хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах, гэр бүл, хүүхдүүдийн харилцаа холбоог бэхжүүлэх хүрээнд 3 ажлыг зохион байгуулж 35 хүүхэд хамрагдав.

3.2.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооны “Урам” төвийн 16 сурагчид Монгол бахархал”, “Монгол соёмбо” номын сангийн боловсролын хөтөлбөрийг зааж сургаж.
2. Тусгай болон зорилтот бүлгийн 141 иргэнд үнэ төлбөргүй үйлчлэв.
3. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх" сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж 25 хүн оролцлоо. Номын сангийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ялгаваргүйгээр тэгш хүргэх, уншигчдад тохирсон дэд бүтэц, орчин нөхцөлийг бүрдүүлэх, номын баяжилт, техник хэрэгслээр хангаж хүртээмжийг сайжруулах зорилгоор хийсэн тус хэлэлцүүлгийг зохион байгуулсны үр дүнд Төв номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан техник тоног төхөөрөмжийн төслийг орон нутгийн 60 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр болов.
4. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор зам наалт, өвлийн улиралд хальтиргаанаас хамгаалсан наалтуудыг тус тус нааж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
5. Төв номын сан СББӨ-ийг өвлөн уламжлагчид тус аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо” ТББ-тай хамтран 2024 оны 03 дугаар сараас эхлэн 18 хүртэлх насны 129 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд 6 удаа соёлын боловсролын хөтөлбөрөөр үйлчилсэн.

Үр дүн: Салбар номын сан дээр тусгай болон зорилтот бүлгийн иргэдэд зориулсан шатыг шинээр хийж, Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчин үеийн иж бүрэн техник хэрэгсэл зэрэг 60,0 сая төгрөгийн өртөг бүхий компьютер, брайл хэвлэх принтер, аудио унших программ, сургалтын хэрэгсэлүүдийг авч аймгийн онцгой хэрэгцээт иргэдэд үйлчлэх боломжоор хангагдсан.

3.2.9. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх

Номын сангийн сан хөмрөгийг 3 төрлөөр бүрдүүлэн ажиллаж ирлээ. Үүнд:

- 1-рт худалдаагаар
- 2-рт хандиваар
- 3-рт солилцоогоор
- Худалдан авалтаар номын фондыг бүрдүүлэхэд уншигчдын татгалзлал дээр үндэслэн авдаг учраас чанарын шаардлага хангасан шинжлэх ухааны болон хэрэгцээт ном хэвлэлээ фондоо бүрдүүлж байна.
- Харин хандиваар номын фондыг бүрдүүлэхэд хэрэгцээ шаардлага муу, урагдаж гэмтсэн, дийлэнхи хувь нь уран зохиолын номууд ирдэг байсан бол 2024 онд “НЭГ УНШИГЧ – НЭГ НОМ” хандивын аяны журамыг шинэчилэн гаргаснаар иргэдийн гар дээрээс шинэ номноор фоноор бүрдүүлж байна.
- Улаанбаатар болон бусад байгууллагуудын номын сан хоорондын солилцоогоор ном хэвлэлийг авч уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.

- Төв номын сангаас зохион байгуулсан “Нэг уншигч- Нэг ном” хандивын аянд идэвхтэй оролцсон 31 байгууллага, хамт олон, 33 иргэнийг цахим орчинд алдаршуулж, талархал хадгалуулав.
- “Байгууллагаараа уншигч болцгооё” аянд 5 байгууллагын 323 ажилтан, албан хаагч хамрагдсаныг цахим орчинд алдаршуулж, бусад байгууллагуудыг уриалах ажлуудыг хийв.

Үр дүн: “Оюунлаг уншигч”, “Байгууллагаараа уншигч болцгооё”, “Нэг нэг-ном уншигч” аяны хүрээнд байгууллага, анги хамт олон, аж ахуйн нэгж иргэдийг алдаршуулах ажлыг цахим орчинд хийж 33 байгууллага, 279 иргэнд талархал хадгалуулав.

Сан хөмрөгийн баяжилтыг сүүлийн 3 жилээр харуулбал:

№	Номын фондын үзүүлэлт	2022 он		2023 он		2024 он	
		тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
1	НИЙТ ДҮН	1751	15,818,450	1152	23,598,580	2349	15,746,064
2	Худалдаагаар	555	9,306,260	734	17,404,660	146	5,053,057
3	Хандиваар	1196	6,512,190	418	6,193,920	2203	10,693,007

Аймгийн хүн ам, ард иргэдийн дунд соёлын олон талт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлснээр уншлага үйлчилгээний хүртээмж нь жилээс жилд өсөж байна. Үйлчилгээг өмнөх жилтэй харьцуулахад уншигч 2,6%, ирц 2%, ном олголт 0,7% өсөлттэй байна.

№	Төлөвлөгөөт ажил	2022	2023	2024
1	Уншигч	5,102	5,235	5456
2	Ирц	55,053	56,202	56950
3	Ном олголт	70,937	71443	76862

Номын сангийн үйлчилгээ, ном уншлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нэлээдгүй ажлыг төлөвлөн ажиллаж байна. Сүүлийн онтой харьцуулахад соёл олон нийтийн ажлын нэр төрөл 12,5%, оролцогчдын тоо 100%, ном хэвлэлийн сурталчилгаа 20,4%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

№	Зохион байгуулсан ажлын нэр төрөл	2022 он	2023 он	2024 он
1	Нэр төрөл	18	21	24
2	Арга хэмжээний тоо	41	415	407
3	Оролцогчдын тоо	12973	26739	83487
4	Ном хэвлэлийн сурталчилгаа	3489	24166	30,364

3.3 Лавлагаа номзүй, каталоги зохион байгуулалт

Манай номын сан нь 1964 онд байгуулагдсан бөгөөд номзүйн бүртгэлийг хэд хэдэн удаа хэвлэн гаргасан байдаг. Үүнд:

- ✓ 1986 онд номзүйч МУСТА Д.Гансүх “Дархан хот хэвлэлийн хуудаснаа” гар бичмэл,
- ✓ Номын санчдын хамтарсан бүтээл “Орон нутгийн номзүй” 2004 он,
- ✓ Эмхэтгэн боловсруулсан номзүйч МУСТА Н.Солонго “Орон нутгийн номзүйн бүртгэл” 2019 он 382Х.

2024 онд:

1. Эмхэтгэн боловсруулсан номзүйч Ч.Бадамцэцэг “Дархан хот, Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа номзүйн бүртгэл” (1961-2011) 2 боть, зураг түүх өгүүлнэ лавлагааны 2 боть бүрэн хэмжээний **4 боть** номуудыг хэвлэн гаргахаас гадна зохиолчдын намтар номзүйнүүдийг тухайн ондоо хэвлэн гаргаж, зохиолч, уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж ирлээ. Уг бүтээлийг “Мөнгөн мод-2024” оны улсын уралдаанд материалыг нь хүргүүлэв.
2. Хүмүүн бичиг сонинд сүүлийн 5 жилд нийтлэгдсэн Дархан-Уул аймгийн тухай мэдээ, мэдээллүүдийг Монгол бичиг болон крилл үсгээр хослуулан сэдэвчилсэн ном зүйн гарын авлагыг хэвлэн гаргав.
3. Шинэ номын мэдээг цаасан болон цахимаар улирал бүр бэлтгэн гаргаж байна.
4. 2024 онд 1594 лавлагааг амаар болон бичгээр, 1275 хүнд цахимаар өгсөн байна.
5. Zotero программд Найрамдлын Дархан сонины 1966-1996 оны нийт 130 мэдээллийг номзүйн бичилтээр оруулав.

Цахимаар мэдээлэл 20 удаа:

- ✓ WE LOVE BOOK
- ✓ Бяцхан уншигч нар манайд зочиллоо
- ✓ “Мэдлэгээ хуваалцъя” уулзалт, ярилцлага хийлээ
- ✓ Соёлын биет бус өвийн мэдлэг олгох сургалт болов
- ✓ “Ном бол цаг хугацааны далайгаар аялах хөлөг онгоц юм” фрэнсис бэкон
- ✓ “НЕПКО” компаниас хэрэгжүүлдэг “Ном түгээе” төслөөс аймгийн Төв номын сан болон сумдын соёлын төвийн номын сангуудад өөрсдийн эрхлэн гаргасан номын дээжсээс ирүүлжээ.
- ✓ Гараар урлахуй Монгол соёл
- ✓ “ОД” цогцолбор сургуулийн Н.Оюунчимэг багштай 3-2 ангийн сурагчид номын сангийн уншигчийн карт нээлгэн, ном уншиж номын тэмдэглэл хөтөллөө
- ✓ “Монголын нууц товчоог” хэн сайн мэдэх вэ? танин мэдэхүйн аха тэмцээн боллоо.
- ✓ Монголчуудын тавгийн идээ засах ёсон
- ✓ Аймгийн төв номын сан ахмадуудаа хүлээж авлаа
- ✓ “Сүбээдэй баатар” 2-р боть MNC television Туулай жилийн шилдэг номоор шалгарчээ.
- ✓ Соёлын байгууллагууддаа талархал гардууллаа.
- ✓ Дархан сумын “соёл, урлагийн салбарын онцлох ажилтан” – аар төв номын сангийн захирал Батаагийн Цэцэгсүрэн тодорлоо
- ✓ Битүүлэх ёс
- ✓ Хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд луу жилийн луу өдөр тохиож байгаа.
- ✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэн
- ✓ Цагаан сар хариуцлага аянд нэгдэцгээе.
- ✓ Сар шинэдээ сайхан шинэлээрэй

3.3.1. Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар:

МУСТА, Ахмад номын санч Ч.Бадамцэцэгийн “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” номзүйн 4 боть номыг хэвлэн гаргахад санхүүгийн туслалцаа үзүүлэн, олон нийтэд сурталчилах, уулзалт зохион байгуулах, цаашид цахим номзүйг бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Номын сангийн үйлчилгээг танхимаар авч буй уншигчдад цахим лавлагааг шуурхай олгох зорилгоор киоск машиныг байршуулан номын сангийн электрон каталог, шинэ номын мэдээ, номын сангийн үйл ажиллагаа, боловсролын хөтөлбөрүүдийн танилцуулгыг бэлтгэн үзүүлж байна.

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн электрон каталогийн нийт 16497 хайлт хийсэн байна.

3.3.2. Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл номзүйн үйлчилгээгээр хангасан байдал:

Номзүйн үйлчилгээг 1275 удаа үзүүлж, 1275 уншигчийн эрэлт хэрэгцээг ханган ажилласан байна.

- ✓ Номын сангийн цахим хаягаар нийт 20 удаа ном зүйн мэдээ мэдээлэл дамжуулав.
- ✓ Цахим лавлагаа нийт 105 удаа
- ✓ Сэдэвчилсэн лавлагаа 300 удаа
- ✓ Номзүйн лавлагаа 803 удаа
- ✓ Тодотгосон лавлагаа 34 удаа

Татгалзал: Тайлангийн хугацаанд номын сан нийт 538 боть номыг татгалзалд бүртгэсэнээс судалгаанд үндэслэн татгалзалын номыг 100% барагдууллаа.

3.3.3. Хэрэглэгчийг мэдээллийн соёлтой болгоход чиглэгдсэн ажлууд

Уралдаан, тэмцээн: Төв номын сангаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажлууд тэр дундаа ардын аман зохиол, үлгэр ярих, гэр бүлээрээ уншигч болох зэрэг уралдаануудыг цахим хэлбэрээр зохион байгуулж нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, уриалах, цахим орчны зөв хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг тогтмол хийж байна.

Мэдээ мэдээлэл: Иргэд уншигчдад мэдээ мэдээллийг үнэн зөв, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор номын сангийн “Дархан-Уул аймгийн Төв номын сан” пэйж хуудсыг тогтмол ажиллуулж өдөр тутамд 1-5 мэдээ мэдээлэл орж байна. Мэдээ мэдээллийг оруулахдаа мэдээллэх чанараас гадна бичиг үсэг, найруулгын өнгө аяс, зураг бичлэгийн чанар, мэдээний агуулгыг анхаарч оруулдаг. Ингэсэнээр 6000 гаруй уншигчид номын сангийн мэдээллийг нэг эх сурвалжаас бодитой авч, бичгийн болон гоо зүйн мэдрэмж, нөлөөлөл харилцаа хандлагын соёлд суралцаж байна. Байгууллагын пэйж хуудасны дагагчдаас 18-24 насныхан 14.6%, 25-34 насныхан 33,2%, 35-44 насныхан 34.2%, 45-54 насныхан 12,5%, мөн

76,7% эмэгтэй, 23,3% эрэгтэй байна. Үүнээс үзэхэд номын сангийн үйл ажиллагааны мэдээллийг 18-44 насныхан түлхүү хүлээн авч байна.

Электрон каталог: Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим үйлчилгээг нэвтрүүлж, үйлчилгээний соёлд суралцах хүрээнд электрон каталогийн байнгын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлуудыг тогтмол хийж байна. Мөн 2024 онд E-Mongolia системд тулгуурлан номын сангийн 4 төрлийн үйлчилгээг цахимжуулахаар санал хүргүүлээд байна.

3.3.4. Каталог, картын сан, санамж өгөх ном зүйг номзүйн бичилтийн стандартын дагуу хийсэн тухай

Төв номын сан нь зохиолч уншигчийн уулзалт зохион байгуулахдаа намтар номзүй болон санамж өгөх номзүйг тогтмол хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байна.

- Шинэ номын мэдээнүүдийг тогтмол гаргаж олны хүртээл болгож байна.
- Хүмүүн бичиг сониноос орон нутгийн ном зүйн жагсаалтыг сүүлийн 5 жилийн дугааруудаас түүвэрлэж бэлтгэв.
- МУСТА, Ахмад номын санч Ч.Бадамцэцэгийн “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” номзүйн 4 боть номыг хэвлэн гаргаж, номын санчдын гарын авлага болгон лавлагаа мэдээлэлд тогтмол ашиглаж байна.

3.4 Номын сангийн автоматжуулалт:


- Дархан-Уул аймгийн Төв номын сан нь 2010 онд LIB-4U программд номоо оруулж эхэлснээс хойш эдүгээ электрон каталогт 28,243 төрлийн, 61509 боть номын мэдээлэл бүртгэгдээд байна. Волвос ХХК-тай хамтран ажиллах 10 гаруй жилийн хугацаанд монгол номын фонд, орос номын фонд, англи номын фондуудыг программд 100% оруулж дуусгаад байна.
- Номын сангийн электрон каталогт тогтмол хэвлэлийн өргөтгөл хийлгэж 2024 оноос тогтмол хэвлэлүүдийг цахим каталогт оруулахаар болсонтой холбогдуулан “Төрийн мэдээлэл” хууль зүйн сэтгүүлийн энэ онд ирсэн №01-20 хүртэлх дугааруудыг цахим бүртгэлд бүртгэж оруулаад байна.
- Монгол Улсын нийт номын санг нэгдсэн системтэй болгох ажлын хэсэг гаран ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд МУҮНС-ийн арга зүйч В.Түвшинтогтох, Ном зүйч Т.Түвшинтунгалаг нар Дархан-Уул аймгийн нийт номын санч, мэдээллийн ажилтнуудад зориулан "НОМЫН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМ" сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалт 2 өдрийн турш Төв номын санд явагдах юм.

3.5 Мэргэжил арга зүйн үйл ажиллагаа

3.5.1. Аймгийн нийт Их дээд болон ЕБС-ийн номын санчдад арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, чадавхижуулах сургалтуудад хамруулна.

Зөвлөн туслах ажил: 17 байгууллагын 22 номын санчид хийв.

- ✓ Төв номын сангийн Мэргэжил арга зүйн нэгж, арга зүйчийн ажил үүргийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 26, ЕБС, 9 их дээд, МСҮТөв, сумдын соёлын төв зэрэг 13 байгууллагын номын санчдад жилийн төлөвлөгөөний дагуу болон өөрсдийн хүсэлтээр нь зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх ажлуудыг хийв.
- ✓ Ахмадын хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Хүүхдийн номын ордон зэрэг байгууллагын номын санчдад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэж, үүний дагуу номын санчид номондоо техник ажиллагаа хийн, ангилах, данслах, бүртгэх, байрлуулах ажлуудыг хийж байна.
- ✓ Орхон сумын Соёлын төвийн номын сангийн номын санч Мягмарсүрэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд
 - Номын сангийн фондын номыг тоолсон тухай акт, Фондын номыг хүлээлцсэн тухай акт, Фондын номын тавиурын цэвэрлэгээ үйлчилгээ,
 - Номтой хэрхэн ажиллах талаар, Номын сангийн анхан шатны бүртгэлүүд хөтлөх, Номын сангийн программтай болох
- ✓ 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Шарын гол Соёлын төвийн номын сангийн номын санч Б.Тамирт номын сангийн стандарт, бүртгэлжүүлэлт, каталог ашиглалтыг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн номын санд ард иргэдийн хандиваар орж ирсэн 500 гаруй нэр төрлийн боть номыг он болон утга агуулагаар нь ялгаж номын санч Долгорсүрэнд номонд техник ажиллагаа хэрхэн хийх яаж номыг ангилах данслах талаар зөвлөгөө өгч ажиллалаа.
- ✓ 4 сарын 1 нд Орхон сумын Соёлын төвийн номын сангийн номын санч Мягмарсүрэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:
 - Номын сангийн фондын номыг тоолсон тухай акт
 - Фондын номыг хүлээлцсэн тухай акт
 - Фондын номын тавиурын цэвэрлэгээ үйлчилгээ
 - Номтой хэрхэн ажиллах талаар
 - Номын сангийн анхан шатны бүртгэлүүд хөтлөх
 - Номын сангийн программтай болох
- ✓ 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Шарын гол Соёлын төвийн номын сангийн номын санч Б.Тамирт номын сангийн стандарт, бүртгэлжүүлэлт, каталог ашиглалтыг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.



Номын санчдын сургалт: 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 120 номын санч хамрагдав.

Төв номын сангийн Мэргэжил арга зүйн нэгжээс мэргэжлийн бус номын санчдыг бакалавр болон чадамжийн гэрчилгээ олгох сургалтуудад суулгахаас гадна нийт номын санчдад зориулсан мэргэжлийн сургалт, судалгаа хийх аргачлал, чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулж байна.

1) 2024 оны 4 сарын 10,11,17-ны өдрүүдэд Орон нутгийн номын санчдын дунд "Номын сангийн арга зүй" чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Ерөнхий боловсролын сургууль, коллежийн 25 байгууллагын 25 номын санч оролцсон ба сургалтад хамрагдсан номын санчдад "БАТЛАМЖ" олгож сургалтын дараах чөлөөт ярилцлагад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа. Сургалтаар:

- ✓ Төв номын сангийн ахлах арга зүйч С.Нэргүй "Номын сангийн номтой ажиллах стандарт, номын санд хөтлөгдөх маягтууд",
- ✓ Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд "Номын сангийн хууль эрх зүйн тухай",
- ✓ Мэдээллийн ажилтан, ном зүйч Х.Отгонбаяр "Номын сангийн электрон каталог, Номын сангийн Lib4u программын хэрэглээ" сэдвээр тус тус мэдээлэл өгөв.




✓

- 2) Дархан-Уул аймаг 2024 оныг нийтийн биеийн тамирыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан зохион байгуулж буй эмгүйгээр эрүүлжих шугаман бүжгийн сургалтад хамт олны төлөөлөл хамрагдлаа.
- 3) Төв номын сангийн хамт олон "Соёлын ажилтнуудын манлайлал, ёс зүй, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь" сургалтад хамрагдав.





- 4) Аймгийн Төв номын сан нь жилдээ 11 нэр төрлийн сэтгүүл, тогтмол хэвлэлийг захиалан уншигчдад хүргэн ажилладаг багөөд 2024 оноос тогтмол хэвлэлүүдийг цахим каталогт оруулахаар зорьж байна. Тус ажлын хүрээнд ВОЛВЕС ХХК-ийн менежер Б.Гантулгыг урьж ирүүлэн “Тогтмол хэвлэлийг цахимд оруулах нь” сургалтыг нийт номын санчид маань авч, номын сангийн электрон каталогт тогтмол хэвлэлийн өргөтгөл хийлгэв.



- 5) Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын нийт номын санг нэгдсэн системтэй болгох ажлын хэсэг гаран ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 6 сарын 12,13-ны өдрүүдэд Монгол Улсын Соёлын яам Монгол Улсын Үндэсний номын сангаас Дархан-Уул аймгийн Нийтийн номын сангийн номын санч, мэдээллийн ажилтнуудад номын сангийн “КОХА” программын улсын нэгдсэн системийн сургалтыг Төв номын сантай хамтран зохион байгууллаа. Сургалтанд нийт 25 номын санч идэвхтэй оролцлоо. Сургалтын багшаар Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч В.Түвшинтогтох, ном зүйч Т.Түвшинтунгалаг нар ажиллалав.





6) Соёл урлагийн ажилтны өдөр, Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024 намрын номын баярын үйл ажиллагааг угтан Төв номын сангийн зүгээс аймгийн хэмжээнд ажиллаж байгаа нийт номын санчдын төлөөлөлтэй уулзаж мэдээлэл өгөв.

Номын баярын үйл ажиллагааг энэ жил Аймгийн Засаг дарга болон ЗДТГ, Соёл урлаг, Аялал жуулчлал, Залуучуудын газар, Боловсролын газрын дэмжлэгтэйгээр аймгийн хэмжээнд тэр дундаа бүх шатны боловсролын байгууллагууд өөр өөрийн өнгө аястайгаар тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлийг хүргүүлж байгаа юм. Мөн уулзалтын үеэр номын санчдын ажлын нөхцөл байдал, шинэ санал санаачилга, төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны чиглэлээр ярилцаж санал солилцлов.



7) Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтуудаас соёл олон нийт, төрийн албан хаагчийн эрх зүйн хүрээнд судлах сургалтаас 5 удаагийн сургалтад бүрэн хамрагдав.

Зочин: Д.Цэцэгсүрэн
Төрийн албаны зөвлөлийн дарга

Сургалтын сэдэв: "7:4:10" арга зүйн сургалтын замны хэлэлцүүлгын сургалт

Зочин: С.Лхагвадорж
Нийслэлийн даргын газрын Ерөнхий ажилтан

Сургалтын сэдэв: Нийслэлийн даргын газрын Ерөнхий ажилтангийн үйл ажиллагааны талаар

Зочин: Ц.Амарсүх
Төрийн албаны зөвлөлийн гишүүн

Сургалтын сэдэв: Төрийн албаны зөвлөлийн гишүүн (БС зүйл ба бооллох, үйл ажиллагаа)

Зочин: Д.БААТАРСАЙХАН
Төрийн албаны зөвлөлийн гишүүн

Сургалтын сэдэв: "Төрийн албаны зөвлөлийн гишүүн" (БС зүйл ба бооллох, үйл ажиллагаа)

✓ 8) ССАЖЗЯАм болон МУУНС-аас зохион байгуулсан 3 удаагийн сургалт, 2 зөвлөгөөнд цахимаар давхардсан тоогоор 34 номын санч хамрагдав.

3.6. Хүний нөөцийн асуудал:

Хүний нөөцийн өнөөгийн байдал:

2024 онд хүний нөөцийн орон тоог 1 хүнээр нэмэгдүүлж, Архив бичиг хэргийн эрхлэгчийн ажлын байранд сонгон шалгаруулалтаар нэг хүнийг авч, ажлын байраар хангаад байна.

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь 16 ажилтан албан хаагчтай. Үүнээс: ТҮ-4, ТҮСБ – 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Мэргэжлийн буюу номын санч мэргэжлээр төгссөн 8 номын санч ажиллаж байна. Цаашид мэргэжлийн баг бүрдүүлэх, тогтвор сууршилтай ажиллуулах, мэргэжлийн ур чадвартай болгох зорилгоор 2 ажилтанг СУИС-ийн Соёлын сургуулийн номын сангийн эчнээ ангид суралцуулж байгаа бөгөөд, Төв номын сангийн нэг ажилтан, ЕБС-ийн нэг номын санчийг мэргэжлийн чадавхижуулах богино хугацааны сургалтад тус тус суралцуулав.

Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, СУАЖЗГазраас зөвлөмж, чиглэл өгсөний дагуу Төрийн албаны шинэтгэл, шинэчилсэн хууль тогтоомжууд, төрийн үйлчилгээний байгууллагын стандарт зэрэгт нийцүүлэн Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж СУАЖЗ-ын газарт батлуулахаар хүргүүлээд байна.

Одоогоор манай номын сан боловсон хүчний дутагдалд ороогүй байгаа боловч 2025 оноос 3 номын санч тэтгэвэрт гарах, номын сангийн шинэ барилга ашиглалтанд ороход мэргэжлийн боловсон хүчин дутмаг болох эрсдэл үүсээд байна.

Хүний нөөцийг чадавхижуулсан байдал: Мэргэжлийн бус номын санчдыг бакалавр болон чадамжийн гэрчилгээ олгох сургалтуудад суулгахаас гадна нийт номын санчдад мэргэжлийн сургалт, судалгаа хийх аргачлал, чадавхижуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 60 жилийн ойн хүрээнд Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын зөвлөгөөнийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Дархан-Уул аймгийн төв номын сан, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран 2024 оны 10 сарын 18-ны өдөр Дархан хотноо зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Орхон аймгийн нийтийн номын сан, Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан, Булган аймгийн нийтийн номын сан, Төв аймгийн Нийтийн номын сангийн 100 гаруй номын санч- мэдээллийн ажилтнууд оролцож, ном хэвлэлийн салбарт тулгамдаж асуудлыг хэлэлцэж, санал зөвлөмж гаргалаа.



Автобустай аялал-сургалт: Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 60 жилийн ой, Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан аймгийн Төв номын сангаас өнөөдөр /2024.09.16/ тус аймагт үйл ажиллагаа явуулж буй номын санчдыг томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн номын сангуудтай танилцуулж туршлага судлуулав.

ШШГГазрын Нээлттэй 445-р ангийн номын сан



Аймгийн Ахмадын Хөгжлийн төвийн номын сан



Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн төв



1-р сургуулийн номын сан



Ажил мэргэжлийн туршлага солилцох, шинэ санаа санаачилга олж харах, номын санчдын уялдаа холбоог сайжруулах, номын сангийн шинэ техник төхөөрөмжүүдийг үзэж судлах зорилготой тус арга хэмжээнд Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Сумдын Соёлын төв, ЕБС, Их дээд сургууль, коллежийн 25 номын санч, Монголын зохиолчдын эвлэлийн Дархан салбарын төлөөлөл зэрэг нийт 28 гаруй хүн оролцлоо

Үр дүн: 11 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 377 номын санч хамрагдаж, хойд бүсийн номын санчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан нь онцлог ажил боллоо.

Шагнал урамшуулал: 2024 онд ажил үүргээ хариуцлагатай, үр дүнтэй, тогтвор суурьшилтай, манлайлан ажилласан 11 хүнийг тодорхойлолж, 5 хүний шагнал шийдвэрлэгдэн ирэв.

2024 онд:

- ✓ Монгол Улсын Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн Гавъяаны Улаан тугийн одонгоор ахмад номын санч Д.Лида
- ✓ Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат,
- ✓ МУСТА тэмдгээр Санхөмрөгч Т.Тамир
- ✓ 2023 оны сумын Хөдөлмөрийн аваргаар захирал Б.Цэцэгсүрэн
- ✓ Дархан-Уул аймгийн Хүндэт иргэнээр Ахмад номын санч Д.Лида нар тус тус шагнагдаад байна.

Мөн Төв номын сангийн номын санчдаас гадна Аймгийн Их дээд, ЕБС-ийн номын санчдыг шагналд тодорхойлж уламжилдаг бөгөөд

- ✓ 18-р сургуулийн номын санч А.Алтанцэцэг-МУСТА,
- ✓ Энэрэл цогцолбор сургуулийн номын санч П.Одгэрэл МУСТА тэмдгээр тус тус шагнагдсан байна.

Үр дүнд суурилсан санхүүжилтийн журмын дагуу нийт ажилтнууд 6,2 сая төгрөгийн урамшуулал, 2023 оны ажлаа дүгнэж Төв номын сангийн 2 номын санч, ЕБС-ийн 1 номын санч, Хүүхдийн номын ордонь номын санчдыг мөнгөн урамшууллаар урамшуулав.

Тулгарч буй бэрхшээл:

Асуудал	Цаашид ...
Мэргэжлийн боловсон хүчин дутагдах эрсдэл	Шинээр ажилд орсон ажилтнуудыг мэргэжүүлэх болон мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулах, дэмжих
Мэргэжлээс шалтгаалсан харшил, харааны бэрхшээл зэрэг эрүүл мэндийн шалтгаан үүсэх	Урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах Харшлын нарийн мэргэжлийн үзлэгт хамруулах
Номын сангуудад сургалтын зардалтай болох	Ингэсэнээр орон нутгийн түвшинд болон УБ хот бусад газруудаас сургагч багш, мэргэжлийн хүмүүсийг урьж сургалт авах, тогтмол хөгжих, чадвахижих боломж бүрдэнэ
Номын сангийн LIB-4U програмын зардлын төсөв байхгүй	-
Номын санчдын зэрэг дэвийн журам одоо хүртэл батлагдаагүй.	-

3.7. Захиргаа удирдлагын зохион байгуулалт, төсөв санхүүгийн асуудал:

Аймгийн Төв номын сан нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Соёлын Яам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж, Соёлын яам, Үндэсний номын сангийн чиглэл, арга зүйн хүрээнд номын сангуудын консерциум болон орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаваруудад хариуцлага, санаачлагатай хандан хамтран ажиллаж ирэв.

Төв номын сан нь 2024 онд:

- Орон тоо бүтцээ шинэчлэн Архив бичиг хэргийн эрхлэгчийн нэг орон тоогоор нэмэгдүүлэн 16 орон тоотой болов. Номын сангийн тухай хууль болон стандартын дагуу /орон тоо бага учир/ Захиргаа, аж ахуйн нэгжийг хасч Мэргэжил арга зүйн нэгж, Уншлага үйлчилгээний нэгжтэйгээр ажиллав.
- Ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн батлуулахаар Төрийн албаны салбар зөвлөл, СУАЖЗГазарт хүргүүлэв.
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлав.

- Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж СУАЖЗГазарт хүргүүлэв.

Мөн Захиргаа, удирдлагын зүгээс байгууллагын үйл ажиллагааг хүртээмтэй байлгах, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд аймаг, сумын ЗДТГ, төрийн байгууллагууд, шат шатны боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж номын сангийн үйлчилгээг хүргэж байна.

Төв номын сан нь 16 ажилтантай, 2 салбар номын сантайгаар орон нутгийн уншигч иргэдэд төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар төсөв 429,820,300 төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 429,820,300 төгрөг байна.

Утга	Төсөв	Гүйцэтгэл
Цалин хөлс	429,820,300	429,820,300
Нийгмийн даатгал	53,727,500	53,727,500
Байр ашиглалт	17,075,000	17,075,000
Хангамж бараа	11,897,400	11,897,400
Ном хэвлэл	5,400,000	5,400,000
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	22,337,000	22,337,000

2024 онд 11 нэр төрлийн 12 ширхэг, 28,357,400 төгрөгийн тоног төхөөрөмжийг Соёлын Яамны санхүүжилтээр:

1. Суурин компьютер -1 ш
2. Зөөврийн компьютер -1 ш
3. Принтер Lazer HP – 1 ш
4. Өсгөгч -1 ш гэх мэт

Мөн үр дүнд суурилсан санхүүжилтын журмын дагуу албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд DELL брэндийн Corei7 13-р үеийн 16 GB 3.64bit үзүүлэлттэй компьютер, Epson DS-570WII сканнер, хурдан хэвлэгч техник хэрэгслийг худалдан авч албан хэрэгцээнд ашиглаж байна.

Түүнчлэн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс “Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал” самбарыг цаасан болон цахим хэлбэрээр сар бүр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн нээлттэй байдлыг ханган ажиллав.

ДӨРӨВ. ШИНЭЛЭГ САНАА, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ОЛОЛТ АМЖИЛТ

- Номын санчийн Хишиг өдөр зохион байгуулав.
- “Үр дүнтэй уншлага” хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- Төв номын сангийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.
- Үндэсний бичиг соёл- Манай хамт олны өв соёл” цахим контентын уралдаанд оролцож тусгай байр эзлэв.
- “Хос бичигтэн-2025” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

- Номонд дурлагсад контентийг 9 удаа бэлтгэж, цахимд байршуулан нийт 455 лайк, 33 коммент, 94 шейр хийж 12877 хүн үзсэн байна.
- Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын Анхдугаар зөвлөгөөнийг 6 аймгийн 100 номын санчдын оролцоотойгоор зохион байгуулав.
- Үр дүнд суурилсан санхүүжилтийн журмын дагуу 2023 оны үйл ажиллагааны үр дүнд Соёлын яамнаас 22,0 сая төгрөгийн санхүүжилт авч, журмын дагуу зарцуулан, тайлагнав.
- Онцлог хэрэгцээт иргэдэд зориулсан Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж 60.0 сая төгрөгийн тусгай тоног төхөөрөмжөөр номын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэв.
- “Нэг уншигч- Ном ном” хандивын аян, “Байгууллагаараа уншигч болцгооё”, 1:3:5 Зочинтой өдөр Нийт 24 удаа, 464 хүнийг хамруулан зохион байгуулсан байна.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай номын сан нь 1964 онд байгуулагдсан бөгөөд орон нутгийн картын санг 1980-иад оноос эхлэн бичгийн машинаар каталогоо бичиж, шинжлэх ухааны салбараар нь байрлуулж байв.

- ✓ 1964-1980 оны хооронд хэвлэгдсэн ороннутгийн картын санг салбарын эрхлэгч Д.Гансүх эмхтгэн хэвлүүлж байсан бөгөөд номын сангийн 40 жилийн ойгоор хамтын бүтээл (1964-2004) хоёр дахь хэвлэлийг Сэргэлэн ХК-аар 150% хэвлүүлж олны хүртээл болгосон. Үүнийг үргэлжлүүлэн номын санч Н.Солонго дахин засварлаж, 500 шахам зохиолч, уран бүтээлчдийн зураг хөрөг, ном, уран бүтээлийн цуглуулга хийж, цагаан толгойн үсгийн дараалалд оруулан ажиллахдаа нэгээр нь дамжуулж, нөгөө нэгний нь зураг намтар түүх, уран бүтээлүүдийг нь олж цуглуулан тэдний сан хөмрөгийг бүртгэн авч Дархан хот, Дархан-Уул аймаг, зохиолч, уран бүтээлчдийн орон нутгийн номзүйн (1965-2018) бүртгэлийг Үндэсний номын сангийн мэдээлэл аргазүйн эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, Үндэсний номын сангийн номзүйч Х.Ундрах, аргазүйч Б.Цогжаргал, аргазүйч Сарандэлгэр, номзүйч Ж.Ганхөлөг нараар хянуулан 350% хэвлэн гаргаж, 21 аймгийн нийтийн номын сангуудад хүргүүлсэн.
- ✓ 2024 онд “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” (1964-2014) 4 боть номзүйн бүтээл хэвлэгдэн гарлаа. Энэхүү номзүйн бүртгэлийг бэлтгэхдээ Монгол Улсын Үндэсний номын сан, Монгол Улсын Хүүхдийн номын ордон, Дархан-Уул аймгийн Төв номын санд хадгалагдаж буй ном хэвлэл, цуврал, эмхтгэл сонин сэтгүүлээс түүвэрлэн авч нэгтгэсэн. Номзүйн бүртгэлд хамрагдсан бүтээлүүд нь гурван хэсгээс бүрдэж байгаа бөгөөд 1-р хэсэгт Дарханы тухай бие даасан ном, 2-р хэсэгт Дарханд байгуулагдсан үйл ажиллагаа явуулж байсан нийгмийн хөгжлийн бүхий л салбарууд тэдгээрт ажиллаж амьдарч хүмүүсийн тухай, 3,4-р боть нэрсийн хэлхээс, лавлах хэсгүүдээс бүрдсэн. Номын сангийнхаа 60 жилийн ойдоо барьсан бидний том бэлэг байлаа. Цаашид энэ номзүйн бүтээлээ цахим болгох зорилт тавин ажиллаж байна.

**ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК ТООН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД
/хавсралтаар хүргүүлэв/**

ДОЛОО. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Музей, номын сангийн цогцолборын барилга угсралтын ажлын талаар:

Музей, номын сангийн цогцолборын 2 дугаар үе шатны ажил

- Байршил: Дархан сум, 14 дүгээр баг, Миний монгол цэцэрлэгт хүрээлэн
- Хүчин чадал: 63.5x40.9м хэмжээтэй /зөв бус хэлбэртэй/ зоорьтой 3 давхар, S=5959.7м²
- Захиалагч: Дархан-Уул аймгийн ЗДТГ
- Зураг төсөв зохиогч: "Балданс" ХХК
- Гүйцэтгэгч: "Оргил таур" ХХК
- Эх үүсвэр: УТХО
- Гэрээ дуусах хугацаа: 2025.12.31
- Ажлын гүйцэтгэлийн явц: 34%
- Гадна фасадны ажил хийгдэж байна.
- Хяналтын инженерийн зүгээс өгсөн үүрэг даалгавар: БНБД 12-03-04 мөрдөж ажиллах.



Галын сургалт: Аймгийн Төв номын сангаас Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт хүсэлт илгээн байгууллагынхаа ажилтан албан хаагчдадаа "ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ" сургалт авлаа. Тус сургалтыг ангиллын сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх, асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Ч.Лхамсүрэн "ГАМШГААС ХАМГААЛАХ ҮНДЭС" 6 боть номыг хандивлав.

НАЙМ. ХАВСРАЛТ

Сургалт: Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээ, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Ш.Дэлгэрмаа, Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Долгормаа нар "Байгууллагын тайлан, статистик мэдээ түүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлалын тухай" зөвлөн туслах сургалтыг орлоо. Тус сургалтаар цаашид тайлангийн боловсруулалтын чанар, статистик тоо баримтын үзүүлэлт, хүртээмжийг дээшлүүлэх, зөв тайлагнах зэрэг асуудлаар зөвлөлдөв.

Номын баяр: Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024 арга хэмжээ "Илүү их уншъя" уриатайгаар 2024 оны 05 болон 09 дүгээр сард улс орон даяар нэг өнгө төрх, нэгдмэл агуулгатайгаар явагдлаа. Дархан-Уул аймгийн тухайд үйл ажиллагааг Найрамдал талбай, Дархан 50 цогцолборуудад нэгдсэн байдлаар зохион байгуулсан ба Соёл урлагийн болон бүх шатны боловсролын байгууллагууд, ном хэвлэн нийтлэгчид, иргэд олон нийтийг оролцуулан зохион байгууллаа. Ингэхдээ хаврын номын баярт **24 нэр** төрлийн үйл ажиллагааг **59** удаа зохион байгуулж, **11,347** хүн оролцсон бол намрын номын баяраар **14** нэр төрлийн үйл ажиллагааг **28** удаа зохион байгуулж, **8961** хүнд соён гэгээрүүлэх үйлчилгээ үзүүлэн, **5358** ном, үзүүлэн тараах материалыг сурталчилж, цахим контентыг **6** удаа хийж, **19017** хүн үзэж сонирхсон байна.



Үр дүн нь: "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024" хавар, намрын номын баярын хүрээнд аймгийн Төв номын сан 41 арга хэмжээг 87 удаа зохион байгуулж, 10358 боть номоор үзэсгэлэн гаргаж, 30364 хүнийг хамруулсан байна

Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн:

Номын баярын өдрүүдэд хүүхэд, өсвөр үеийг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Тэргүүний уншигч -Д.Нацагдорж тэмдэгтэн"-г шалгаруулан алдаршуулдаг бөгөөд 2024 оны Хаврын номын баярын "Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн"-ий болзол хангасан сурагч, анги хамт олныг алдаршуулав.



Тэргүүний уншигч:

- 10 дугаар багийн иргэн, уншигч Жаргалсайхан Энхзул
- ОИЦ сургуулийн 3-3-р ангийн сурагч Энхтөр Төрмандах
- 18 сургуулийн 5а ангийн сурагч Бямбажав Элбэгдаваа

Тэргүүний уншигч анги хамт олноор:

- ✓ Б.Янжинлхам багштай Шинэ- Алхам сургуулийн 5А анги
- ✓ Д.Цэндбазар багштай 1-р сургуулийн 5в анги
- ✓ Д.Энхтунгалаг багштай Од цогцолбор сургуулийн 5-6-р анги

Үндэсний бичиг соёл намрын номын өдрүүд-2024 арга хэмжээний үеэр Төв болон салбар номын сангаар тогтмол үйлчлүүлэн, бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцон Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн шагналын болзол хангасан ОИ сургуулийн 7^ө ангийн сурагч Ганцоожийн НОМИНЖИН, Од цогцолбор сургуулийн М.Саруулзаяа багштай 9е анги хамт олон шагнагдлаа.



Үр дүн:Тэргүүний уншигч анги хамт олон-4 анги, Тэргүүний уншигч сурагчаар- 5 сурагч шалгарч шагнагдсан байна.

Зохиолч, уншигчдын уулзалт: Дархан-Уул аймгийн Төв номын сангийн урилгаар Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, хүүхдийн зохиолч О.Сундуй Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 5 бүлгийн нийт 150 сурагч, “Энэрэл” сургуулийн 50 гаруй сурагчидтай уулзалт зохион байгууллаа. Мөн Уран уншлагын уралдааныг сурагчдын дунд явуулав.


15 дугаар сургуульд Орон нутгийн зохиолч, уншигчдын уулзалт болж 150 сурагч оролцов. Мөн зохиолчдын бүтээлүүдээр үзэсгэлэн гаргав.

“Дархан хот, Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа ном зүйн бүртгэл 1961-2011” I-IV боть номыг хэвлэлд бэлтгэж боловсруулсан Ахмад номын санч МУСТАЖилтан Ч.Бадамцэцэгтэй 2 удаа уулзалт зохион байгуулж, сэтгүүл зүйн салбарын 120 төлөөлөгч оролцлоо.

Үр дүн: Зохиолч уншигчийн уулзалтыг 5 удаа зохион байгуулж, 470 багш, оюутан, сурагчийг хамруулав.



“Хэл бичгээ өвлөн бахархъя” эсээ бичлэгийн уралдаан: “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг тохиолдуулан Төв номын сангаас Дархан-Уул аймгийн Төрийн бүх шатны байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэгийн уралдаанд нийт 11 байгууллагын 63 албан хаагчаас бичвэр ирсэн бөгөөд уралдааны:



- ✓ 1 байранд - Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Хяналт - шинжилгээ үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн Г.Гэрэлмаа
- ✓ 2 байранд - Дархан сумын ИТХ-ын ажлын албаны ажилтан Ц.Шинэцэцэг
- ✓ 3 байранд - Хонгор сумын 14 дүгээр сургуулийн захирал М.Санжаа
- ✓ Тусгай байранд 31 дүгээр цэцэрлэгийн багшийн туслах Т.Отгонзул нар тус тус шалгарлаа.

“Ном” уран илтгэлийн уралдаан: Бага насны хүүхдийн дунд “НОМ” сэдэвт илтгэлийн уралдааныг хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулж, 18 цэцэрлэг, сургуулийн 38 хүүхэд эцэг эх, багш нарын хамт амжилттай оролцлоо. Үүнд:

Сургуулийн өмнөх насны ангилалд:

- 1-р байр Н.Алтансүвд 31--р цэцэрлэг
- 2-р байр Б.Анужин 30-р цэцэрлэг
- 3-р байр П.Наран-солонго Орхон сум 4-р цэцэрлэг

Сургуулийн бага насныханд:

- 1-р байр З.Оюун Од цогцолбор 2-2 анги
- 2-р байр Б.Хүслэн Шарын гол 2-р сургууль 4а анги
- 3-р байр Б.Төгсбаяр ОИЦогцолбор сургууль 1-7 анги



“Монгол ардын ерөөл магтаал” видео бичлэгийн уралдаан

- ✓ “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” намрын номын баярын хүрээнд Дархан-Уул аймгийн нийт иргэд, хүүхэд залуучуудын дунд 9 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл Монгол Ардын Ерөөл, магтаал, өв уламжлалыг сэргээх, таниулах зорилго бүхий видео бичлэгийн уралдаан зарласан билээ. Тус уралдаанд 6-17 насны 118 хүүхэд бичлэг ирүүлэв.
- ✓ “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” намрын номын баярын хүрээнд хүүхэд залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шинэ санаа, бүтээлч байдлыг шингээсэн гарын доорхи материал ашиглан “Гоёхон номын хавчуурга” бүтээх уралдааныг зарласан бөгөөд тус уралдаанд ШШГГ-ын 435 дугаар ангиас-2, оюутан-4, Ерөнхий боловсролын 9 сургуулийн 297 сурагчийн 711 бүтээлээр оролцсон.
- ✓ “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” намрын номын баярын хүрээнд комик ном бүтээх уралдааныг зарлаж, 9 сургуулийн 56 хүүхдийн 79 бүтээлээр оролцов.



“Эх хэлний дархлаа” өдөрлөг

- “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд – 2024” намрын номын баярын үйл ажиллагааны хүрээнд Ерөнхий боловсролын “Монгол-Оюу” сургуультай хамтран “Эх хэлний дархлаа” өдөрлөгөөр Уйгаржин монгол бичгээр хэвлэгдэн гарсан 22 номоор “Эх хэл мину” үзэсгэлэн гаргаж, Уйгаржин Монгол бичгээр “Алдаагүй цэвэр бичих”, “Минутын уншлага”, “Зөв уншлага” АХА зэрэг тэмцээн уралдаануудыг дунд болон ахлах ангийнхны дунд зохион байгуулав.
- Дархан сумын Ахмадын хороотой хамтран "УНШИХАД УРАМ" монголын уран зохиолын дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж, 7 багийн 60 гаруй ахмадууд авьяас билгээ уралдуулан 2-3 минутын багийн мэндчилгээ болон 10-15 минутын Уран зохиолын дүрийн тоглолтыг толилуулж, 270 гаруй ахмад үзэж сонирхов.

Үр дүн нь: 2024 онд нийт 11 удаагийн уралдааныг уншигч иргэд, төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан бөгөөд нийт 1364 хүн оролцов.



Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

Үндсэн хуулийн өдөрт 166 боть ном, Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт 194 боть ном, Уламжлалт цагаан сарын баяр. Бидний цагаан сар 203 боть ном, 30-р сургууль. Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ 62 боть ном, 30-р цэцэрлэг. Мэдлэгээ хуваалцъя 31 боть ном,


Эх орончдын өдөрт. Энхийн манаанд 216 боть ном, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгалах өдөрт 252 боть ном, Монгол цэргийн өдөрт. Зэвсэгт хүчний 103 жилийн ойд 326 боть ном, Дэлхийн усны өдөрт. Цэнхэр усаа хайрлая 302 боть ном, Наурызын баярт. Казах зохиолчдын бүтээлээс 197 боть ном гэх мэтчилэн 62 удаагийн үзэсгэлэнг гаргажээ.

Үр дүн: Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 62 удаа гаргаж, 3061 боть номыг 12754 хүнд сурталчилсан байна.

Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт, арга хэмжээ: Угийн бичгийн сургалт – 6 удаа, 293 хүн хамрагдсан байна.



✓ "УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ СУРЦГААЯ" сургалтыг зохион байгуулж, 30 дугаар сургуулийн менежер, Монгол бичгийн өвлөн уламжлагч ардын боловсролын тэргүүний ажилтан, магистр Ж.Эрхэмсайхан "МОНГОЛ БИЧГИЙН ТҮҮХ", "УДАМ" цахим угийн бичгийн үүсгэн байгуулагч, Старсофт ХХК-н захирал Д.Өлзий-Орших "ЦАХИМ УГИЙН БИЧИГ" сэдвээр сургалтуудыг Дархан сумын ахмадын зөвлөлийн



✓ төлөөлөл болон ард иргэдэд хийлээ. Сургалтад нийт 60 гаруй иргэд хамрагдсан бөгөөд оролцогчдод "Цахим угийн бичиг" программыг бэлэглэв.

"Угийн бичгийг хөтлөх арга" лекцийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв дээр зохион байгуулж, 15 минутын уншлага хийж, 36 боть номын үзэсгэлэн гаргаж, 25 албан хаагч оролцов.




✓ 13, 15 дугаар багийн Ахмадын зөвлөлийн хамт олонд "Угийн бичгээ хөтөлж сурцгаа" сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Сургалтаар угийн бичиг хөтлөх ач тус түүнийг цэвэр ариун байлгах, Монгол хүний чанарыг сайжруулах, айл өрх

бүрт заавал хөтөлдөг нэгэн түүхэн судраа зөв хөтлөх арга зүйд сургах зорилготой бөгөөд 15 хүн оролцов.



✓ ГБХХХГ-тай хамтран Угийн бичгийн сургалтыг зохион байгуулж, 60 гаруй иргэд оролцов. /2 удаа/

✓ Үндэсний сургагч багш, Хэл шинжлэлийн ухааны магистр Ж.Эрхэмсайхантай хамтран Хүмүүнлэгийн дээд сургуулийн 1,2-р курсийн 40 гаруй оюутнуудад “Угийн бичгээ хөтөлж сурцгаая”, “Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо дээдэлъе” сургалтыг зохион байгуулав.



Үр дүн нь: Дархан сумын 13, 15-р багийн иргэд давтан сурч, өөрсдийн ургийн хэлхээгээ судалж байгаа нь дэвшилттэй тал болж байна.

Угийн бичиг хөтөлдөг иргэд, айл өрхийг сурвалжлан олж бүртгэх, сурталчилж алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

Дархан сумын айл өрхүүдийн дунд “Угийн бичиг хэн сайн хөтөлсөн бэ” уралдааныг 2024 оны 10-р сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулж, 16 айл, өрхийн угийн бичгийн материалуудаар үзэсгэлэн гаргав. Мөн Удам АРР –ыг 20 хүнд бэлэглэв. Уралдааны үр дүнд 8,9 үеэ дуустал нь хөтөлсөн өрхийн тоо нэмэгдсэн. Нийт 6 удаагийн сургалтад 293 хүн хамрагдав.





"Үндэсний бичиг, соёлын жил-2024, "Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлж, "Хос бичигтэн аймаг" уриалгыг гаргаж, Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

Төв номын сан нь 2024 оны эхнээс албан тоот, тушаал шийдвэрийг хос бичгээр хөтөлж эхэлсэн ба одоогоор **158** албан тоотыг байгууллага, ААН-үүдэд хос бичгээр хөтлөн хүргүүлсэн байна. Ажилтан, албан хаагчид Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамрагдсан.

"Эх хэлээ эрхэмлэе" сайхан бичгийн уралдаан: Үндэсний бичиг үсгийн баярт зориулан зохион байгуулсан "Эх хэлээ эрхэмлэе" үндэсний бичгээр хэн сайхан бичих вэ? уралдаанд нийт **263** бичвэр ирж шалгаруулалтыг 3 үе шаттайгаар зохион байгууллаа.

- ✓ I шатны шалгаруулалтаас 43 материал
- ✓ II шатны шалгаруулалтаас 16 материалыг тус тус шүүн үлдээж, насны ангиллаар 2 ангилан дүнг гаргалаа.





Эх хэлний өдрөөр “Эх хэл - зөв уншлага” АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж 26 сурагч оролцов

Үндэсний бичиг соёл- манай хамт олны өв соёл цахим контентын уралдаанд Үндэсний бичиг, түүний хэрэглээ, зохион байгуулсан үйл ажиллагаануудын тухай агуулга бүхий 2 контент бэлтгэн хүргүүлж IV байранд шалгарав.



“Хэл бичгээ өвлөн бахархъя” эсээ бичлэгийн уралдаан: “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг тохиолдуулан Төв номын сангаас Дархан-Уул аймгийн Төрийн бүх шатны байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэгийн уралдаанд нийт 11 байгууллагын 63 албан хаагч оролцов.

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2024
“ХЭЛ БИЧГЭЭ ӨВЛӨН БАХАРХЪЯ”
Эсээ бичлэгийн уралдаан

ХАМРАХ ХҮРЭЭ:
 Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид


ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Хэл найруулга, бичлэгийн ур чадвар сайн байх;
- Сэдэв, зорилго, агуулга, дүгнэлт уялдаа холбоотой байх;
- Үсгийн фонд аривал 12, мөр хоорондын зай 1.5 байх;
- Үгийн тоо 350-400 үгэнд багтсан байх;
- Тогтоосон зугаацаанд ирүүлсэн байх;
- Овог нэр, албан байгууллагын нэр, холбоо барих утасны дугаар

ШАТНАЛ:
 1-р байр: Өргөмжлөл, 100,000 төгрөг
 2-р байр: Өргөмжлөл, 80,000 төгрөг
 3-р байр: Өргөмжлөл, 60,000 төгрөг
 Тусгай байр: Өргөмжлөл, 40,000 төгрөг

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:
 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл
 Төв номын санд хүлээн авна.

Холбогдох утас: 70377937, 99227092



Сэдэвчилсэн номын үзэсгэлэн: “Үндэсний бичиг, соёлын жил-2024, “Эх хэлний өдөр”-ийн хүрээнд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 4 удаа 214 хүнд 498 боть номоор гаргав.

“Монгол ардын ерөөл, магтаал” видео бичлэгийн уралдаан,
“Хүмүүн бичиг”: сонинд сүүлийн 5 жилд нийтлэгдсэн мэдээ, мэдээллүүдийг багтаасан “Дархан хэвлэлийн хуудаснаа” сэдэвчилсэн номзүйн бүртгэл бүхий гарын авлага номыг эмхэтгэн гаргалаа.

- ✓ 2018-2023 оны дугаараас Дарханы тухай өгүүлэг, алдарт хүмүүсийн тухай хөрөг нийтлэл, мэдээ мэдээллийн тухай номзүйн лавлагааг бэлтгэж, хэвлэн гаргаж, Хэлний зөвлөлөөс гаргасан уралдаанд хамт олноороо Хүмүүн бичиг сониноор оролцож тусгай байрт шалгарав.

Үр дүн: Үндэсний бичиг соёлыг өдрийг сурталчлан таниулах **10 удаагийн** ажлыг зохион байгуулж **673** хүнийг хамруулсан байна. Мөн Төв номын сангаас хос бичгээр хөтөлсөн 158 албан тоотыг байгууллага, ААН-үүдэд хүргүүлсэн байна.

Бүх нийтийн соёлын боловсрол:

- Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн Харилцааны 5 зарчим, Үндэсний үнэт зүйлээр нийгмийг соён гэгээрүүлэх нь, Тархи ба мэдрэмж сургалт, лекцүүдийг Төв номын сангийн захирал Б.Цэцэгсүрэн 6 удаа 6 байгууллагын 160 гаруй албан хаагчдад оров.
- Nerko Kids хэвлэлийн газар нь Оксфордын Их сургуулийн уншлагын хөтөлбөрийг Монголд нутагшуулж, хүүхдийг номонд дурлуулах, ном унших хэвшилтэй болгох, унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн “1000 ном уншлагын хөтөлбөр”-ийг санаачлан 3-18 нас хүртэл унших 1000 номын агуулгыг боловсруулсан бөгөөд тус төслийн баг Дархан хотод уулзалт хийв. Тус уулзалтыг Төв номын сангаас зохион байгуулж Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, Соёл, урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Төв номын сан, Хүүхдийн номын ордны удирдлагууд болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй СӨББ, ЕБС-ийн удирдлага, номын санчид зэрэг 80 гаруй хүнтэй уулзалт хийн төслийн талаарх танилцуулгыг өглөө. Хүүхдийг номонд дуртай болгох, зөв иргэн байх төлөвшүүлэх зорилгоор “1000 ном уншлагын хөтөлбөр”-ийн төслийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх асуудлыг дахин судалж хэрэгжүүлэхээр болов.

Үр дүн: 7 удаа 240 хүнд сургалт оров.



Онцлог хэрэгцээт иргэдэд соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

- ✓ Төв номын сан нь 5/1 аяны хүрээнд тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 1 өрхөд /ээж, хүү/ улиралд хүнсний болон бусад зүйлээр тусламж үзүүлж байна.

✓ Төв номын сангаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Дархан сумын ЗДТГ, Дархан сумын ИТХ, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар, Дархан Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газар, Ахмадын хөгжлийн төв, Хүний эрхийн Үндэсний Комиссын Дархан-Уул аймаг дахь салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг, эхийн холбоо болон бусад холбоод, иргэдийн төлөөлөл 25 хүн оролцов.



✓ “Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт 60,000,000 / Жаран сая / төгрөгийн төслийг Эрдэм шинжилгээний ажилтан Г.Нямцэнд боловсруулан, захирал Б.Цэцэгсүрэн Дархан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, тэндэрийн хороонд хүргүүлснээр тэндэр зарлагдан NEGM ELECTRONICS ХК шалгарч, амжилттай хэрэгжүүллээ.

Үр дүн: Харааны бэрхшээлтэй иргэдэд ном хэвлэлийн бүтээгдэхүүн хувиан олшруулах, номын сангийн үйлчилгээ авах боломжоор хангагдав.

Бүх нийтийн соёлын боловсрол:

Төв номын сан нь одоогоор "Монгол бахархал" хөтөлбөрт-18 удаа 630 хүүхэд, "Би Монгол хүүхэд" хөтөлбөрт 1 удаа 23 хүүхэд, "Хайрлахуйн ухаан" хөтөлбөрт 8 удаа 236 хүүхэд, "Хөгжөөнт тоглоом"-оор 4 удаа 98, Монгол соёмбо хөтөлбөрт 1 удаа 19 хүүхэд, Эсгий урлал 1 удаа 15 хүнийг хамруулж, бүтээл хийж сурсан байна.



Мөн уншигч иргэдэд боловсролын хөтөлбөр зааж сургахын зэрэгцээ номын санчид өөрсдөө чадавхиж байна. **Үр дүн:** Төв номын сангийн соёлын боловсролын хөтөлбөрт нийт 36 удаа 1036 хүүхдийг хамруулаад байна.

Нүүдлийн ахуй, үндэсний өв, соёл, уламжлалыг сурталчлан таниулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

✓ Зулзагын голын хүүхдийн зусланд амарч буй 130 гаруй хүүхдэд 87 боть номоор үзэсгэлэн гаргаж, бүтээлч уншлага хийв.



✓ Нүүдлийн соёлын боловсрол олгох зусланд амарч буй 30 гаруй хүүхдэд 95 боть номоор үзэсгэлэн гаргаж, 15 минутын уншлага хийв.

Үр дүн: 2 арга хэмжээг зохион байгуулж 160 хүүхдийг хамруулж 182 боть номыг олгож үйлчилсэн байна.



Оюунлаг Дарханчууд" дэд хөтөлбөр:

✓ Хаалттай 435 дугаар хорих ангийн 58 хүмүүжигчид "Монгол бахархал" номын сангийн боловсролын хөтөлбөр, "Харилцааны 5 зарчим" лекц, Монгол үндэсний уран



зураг, хээ угалз, оёдол эсгүүрийн талаарх 50 гаруй боть номын үзэсгэлэнг гаргав.

✓ "ХЭЛ ШИНЖЛЭЛ"-ийн өдрөөр "ОРОН, ОРНЫ ТҮҮХ, СОЁЛ" өдөрлөгийг зохион байгуулж 100 гаруй хүүхэд оролцов.



✓ Ерөнхий боловсролын "Монгол-Оюу" сургуультай хамтран "Эх хэлний дархлаа" өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөөр Уйгаржин монгол бичгээр хэвлэгдэн гарсан 22 номоор "Эх хэл мину" үзэсгэлэн гаргаж, "Алдаагүй цэвэр бичих", "Минутын уншлага", "Зөв уншлага" АХА зэрэг тэмцээн уралдаануудыг дунд болон ахлах ангийн 50 хүүхдийн дунд зохион байгуулах зэрэг иргэд, уншигчдад чиглэсэн өдөрлөгүүдийг зохион байгуулав.



Үр дүн: “Оюунлаг Дархан” хөтөлбөрийн хүрээнд “Оюунлаг уншигч” өдөрлөгийг 44 удаа зохион явуулж, 1205 боть номоор үзэсгэлэн гаргаж, 11541 хүнийг хамруулсан байна.

Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах
✓ “Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт”, “Цахим гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” лекцийг зохион байгуулж, 20 хүн оролцов.



✓ Дархан-Уул аймаг 2024 оныг нийтийн биеийн тамирыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан зохион байгуулж буй эмгүйгээр эрүүлжих шугаман бүжгийн сургалтад хамт олны төлөөлөл хамрагдлаа.



✓ Дархан-Уул аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын зөвлөх Б.Наранмөнх "ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР" мэдээлэл хийж, 15 хүн оролцов.



- ✓ “Харилцаа ба ёс суртахуун” сэдвээр лекцийг хийж, 90 гаруй багш, сурагч оролцов.



- ✓ 1:3:5 мэдээллийн цагаар хүүхэд багачуудад хүний эрхийн түгээмэл тунхаглал сэдвээр лекц хийж 24 хүн оролцов.



- ✓ “ЛАГШМИЙН СОЁРХОЛ” Энэтхэг ардын үлгэрээр дүрийн тоглолттой уншигчдын бага хурал хийж, “Зөв хүүхэд гэж хэн бэ?” сэдвээр IX-р сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Э.Уянга илтгэл тавьж сурагчид үе тэнгийн хүүхдүүдийн дээрлэхэлтийн талаар санал сэтгэгдлээ харилцан ярилцаж, 50 эцэг эх, багш, сурагчид оролцлоо.



Үр дүн: Аймгийн Төв номын сан нь 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрийг зочинтой өдөр болгон сонгогдсон сэдвээр уншигчдад зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, мэдээ мэдээлэл, сургалтыг 23 удаа 414 хүнийг оролцуулсан байна.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.



Хүний эрхийн Дархан-Уул аймаг дахь салбарын ажилтан, ахлах шинжээч Э.Болортуяа Төв номын санд “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол улс”, “Жендэр ба хүний эрх”, “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, “Ажлын байр бэлгийн дарамтгүй орчин”, “Эмэгтэйчүүд хүний эрхийн боловсролын төлөө” зэрэг 23 нэр төрлийн 50 гаруй боть ном, сэтгүүл, гарын авлага хүлээн авч үзэсгэлэн гаргаж, багш, асран хамгаалагчдад сурталчилав.



<https://www.facebook.com/photo/?fbid=845800164257509&set=pcb.845758634261662>



Байгууллагын эцэг, эхийн зөвлөл:

1. Ээнэгших гэж юу вэ? сэдэвт Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сэтгэл зүйч О.Бүжин багшийн лекцэнд 10 хүүхэд хамрагдсан.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооны “Урам” төвийн 16 сурагчид Монгол бахархал”, “Монгол соёмбо” номын сангийн боловсролын хөтөлбөрийг зааж сургав.
3. Дэлхийн хүүхдийн өдрөөр аймгийн Төв номын сангаас нийт ажилтан албан хаагчдын 6-16 насны 9 хүүхдэд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.
 - "ИРЭЭДҮЙГЭЭ СОНСЪЁ" уриатайгаар зохион байгуулагдаж буй тус өдөрлөгт Төв номын сангийн хамт олон цэнхэр өнгийн хувцсаар ижилсэж, хүүхдүүдээ ажлын байрандаа урин тэдний дуу хоолойг сонсож, хүлээн авч уулзлаа.
 - Хүүхдүүд хөтөлбөрийн дагуу Канвас зургийн гайхамшгийг мэдрэн өөрсдийн дуртай зургаа урлан, эцэг, эхийн хамтаар аймгийн Музей, Эмэгтэйчүүдийн ордны үйл ажиллагаатай танилцан, уран зураг үзэж сонирхов. Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг чадавжуулах, гэр бүл, хүүхдүүдийн харилцаа холбоог бэхжүүлэх хүрээнд 3 ажлыг зохион байгуулж 35 хүүхэд хамрагдав.



<https://www.facebook.com/profile/100064825985163/search/>



Ном сэлбэн засалт / 65 нэр төрлийн 88 боть /

- Номын сангийн урагдаж гэмтсэн, салсан нийт 65 нэр төрлийн 88 боть номыг нааж, үдэж сэргээн засварлаад байна.

1	Гомбосүрэн. Философи сурах бичиг	1
2	Өвгөн Хоттабыч	1
3	Баасансүрэн Түүвэр зохиол	1
4	Сургамжит өгүүллэг 1,2,3,4	4
5	Баян аав, ядуу аав-1	1
6	Сарантуяа Л. Цэнхэр романс	1
7	Жорж Оруэл. “1984”	2
8	С.Пүрэв. “Мөнх тэнгэрийн алс”	1
9	Тогтвортой хөгжил /Сурах бичиг/	1
10	Монголын соёл судлалын асуудлууд	1
11	Дүрслэх геометр	1
12	Б.Жадамбаа. Судалгааны арга зүй	1
13	Д.Намдаг. “Цаг төрийн үймээн”	1
14	Л.Пүрэвдорж. “Гилийн дадар”	1
15	Ч.Нямсүрэн. Эрх зүй төрийн ерөнхий онол	1
16	Г.Аюурзана. Сахиуст хангайн нууц	1
17	Г.Аюурзана. Шүгдэн	1
18	М.Тогмид. Хувь заяаны цадиг. Б. 1-5	5
19	Сарантуяа Л. Бөхөөгүй зул	1
20	Сарантуяа Л. Амьдралын эргүүлэг	1
21	Пүрэвдорж Б. Хувь заяаны хишиг	1
22	Пүрэвдорж Б. Могой боолт. Б. 1-2	2
23	Төрбат Д. Зул задрах цаг	1
24	Баярдаваа. Макро эдийн засгийн онол	1
25	Сонгомол эсээнүүд	1
26	Дэлгэржаргал А. Динза. Б.1,4,12	3
27	Цондоолой цүндээлэй. Б. 1,2,5	3
28	Гоё үлгэрүүд. 3,5	2
29	Охидын үлгэр 1,2	2
30	Таши 6,13	2
31	Монгол ардын үлгэр. Б.3	1
32	Монголын нууц товчоо	2
33	Сургамжит өгүүллэгүүд Б-3, 3, 4,5, 7	5
34	Дүрсгүй жаалын адрийн тэмдэглэл. Б-5, 9	2
35	Дархан нутгийн түүх соёлын дурсгалууд Б-1	1
36	Ногун-10, 11	2

37	Сарантуяа Л. Ээж	1
38	Чамд хэн итгэх юм бэ & Вангийн нулимс	1
39	Цойлогсод	1
40	Өөрийгөө судлахуйн гайхамшиг	1
41	Монгол ухааны жимээр бэдрэхүй	1
42	Өөрчлөлтийг өөрөөсөө	1
43	Итгэхүй ухаан	1
44	Стрессгүй амьдрах нууц	1
45	Ангаргаас эрчүүд сугараас бүсгүйчүүд	1
46	Амьдралын гарааны үнэт зөвлөмж	1
47	Сайн нөхөр аав болох алхмууд	1
48	Үргэлж ялан дийлэх сэтгэхүй	1
49	Сэтгэхүй цар хүрээний гайхамшиг	1
50	Зүүдний тэмдэглэл	1
51	Мөрөөдөх эрх	1
52	Дээврийн өрөөн дэх миний мөрөөдөл	1
53	Далд ухааны нууц	1
54	Бүсгүйн код	1
55	Амьдралын хичээл	1
56	Аз жаргалын набор	1
57	Амьдралын 12 дүрэм	1
58	Real эмэгтэй: Өөрийгөө хайрлахад суралцсан 1095 хоног	1
59	Цагийн менежмент	1
60	Сэтгэх урлаг	1
61	Зорилго	1
62	5 секундийн дүрэм	1
63	Бүү саад бол	1
64	Өөртөө итгэлтэй болох сэтгэлзүйн нууц	1
65	Харц хатан	1
Нийт дүн		88

СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН: /72 удаа 3030 боть, 8625 хүн/

№	Тэмдэглэлт өдрүүд ба үйл ажиллагааны нэр	Хэдэн удаа	Номын тоо	Хүний тоо
1	Үндсэн хуулийн өдөрт	1	52	166
2	Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт	2	53	194
3	Уламжлалт цагаан сарын баяр. Бидний цагаан сар	2	62	203
4	30-р сургууль. Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ	1	50	62
5	30-р цэцэрлэг. Мэдлэгээ хуваалцъя	1	42	31
6	Эх орончдын өдөрт. Энхийн манаанд	1	38	216
7	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгалах өдөрт	2	66	252
8	Монгол цэргийн өдөрт. Зэвсэгт хүчний 103 жилийн ойд	2	58	326
9	Дэлхийн усны өдөрт. Цэнхэр усаа хайрлая	1	44	302
10	Наурызын баярт. Казах зохиолчдын бүтээлээс	1	32	197
11	Дэлхийн театрын өдөрт	1	39	238
12	Монгол хүн сансарт ниссэн 43 дахь өдөр	1	38	249
13	Инээдмийн баяр. Инээд түгээцгээе	2	84	334
14	“Дэлхийн Монгол иргэн” олон улсын боловсролыг өдөрлөгт “Мэргэжил бүхэн сайхан”	1	118	1200

15	“Миний унших дуртай ном”	1	62	231
16	“Green world- Our future” тэмцээнд	1	54	150
17	“Шинэ ном ирлээ”	3	187	355
18	“Шалгалт боллоо”	1	40	210
19	ШШГГ-ын Хаалттай 435 дугаар хорих ангид “Монгол урлал”	1	52	58
20	Инээдмийн баярын цахим үзэсгэлэн	1	32	302
21	Зочинтой өдөрт “Шашин судлал”	1	38	19
22	Зочинтой өдөрт “Сэтгэл судлал”	1	32	21
23	Зочинтой өдөрт “Харилцаа ба ёс суртахуун”	1	28	172
24	Зочинтой өдөрт “Эх дэлхийн хэл”	1	112	172
25	Зочинтой өдөрт “Орон орны соёл”	1	70	172
26	СГЗ О.Сундуйтай хийсэн Зохиолч уншигчдын уулзалт. Уран бүтээлийн үзэсгэлэн	2	23	200
27	Үндэсний бичиг үсгийн баярт “Эх хэл бичиг мину”	1	42	196
28	Дэлхийн номын баярт	1	68	223
29	Эх оронч Дарханы ирээдүй өдөрлөгт “Нүүдэлчин Монголын соёл	3	38	460
30	СӨБ-ын байгууллагад Зурагт уншлагад зориулан Үлгэрийн ертөнц, Үлгэрээс үлгэрлэе	3	71	180
31	Үлгэрээс үлгэрлэе	2	69	64
32	19р сургуулийн 3а, б ангид Үлгэрээс үлгэрлэе сэдэвт	2	66	60
33	15р сургуулийн 1б ангид Үлгэрийн ертөнцөөр сэдэвт	1	40	38
34	1р цэцэрлэгийн ахлах а, б ангид миний дуртай ном сэдэвт	2	70	65
35	15р сургуульд Зохиолч уншигчдын уулзалтанд Захиолчдын бүтээлүүд сэдэвт	1	26	150
36	Төв номын санд Шинэ номын нээлтэд Ю.Цэдэнбал сэдэвт	1	33	50
37	Зулзага хүүхдийн амралтанд Номын сан хүүхдийн зусланд сэдэвт	2	87	130
38	Нүүдлийн соёлын зусланд Зуны зугаатай уншлага сэдэвт	1	95	30
39	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвд Бидний унших дуртай ном сэдэвт	1	36	2586
40	Эх хэлний дархлаа өдөрлөгт Монгол бичгээр хэвлэгдсэн Эх хэл мину сэдэвт	1	22	50
41	18р цэцэрлэгт Үлгэрийн ертөнцөөр сэдэвт	2	78	150
42	16р сургуулийн 1р ангийн 6 бүлэгт Сонгодог үлгэрээс сэдэвт	6	70	217
43	Монголын зохиолчдын эвлэлийн дархан-уул аймаг дахь салбарын 60 жилийн ойд “Найрамдлын дархан тогтмол хэвлэл” сэдэвт	1	27	100
44	“ШИНЭ НОМ ИРЛЭЭ”	1	48	123
45	Өвлөн бүтээх өнөө ирээдүй	1	26	123
46	Байгууллагаараа уншигч болцгооё аяны хүрээнд Дархан сумын ЗДТГ-т	1	100	70
47	Байгууллагаараа уншигч болцгооё аяны хүрээнд Дархан Дулааны	1	150	65

	Сүлжээ ТӨХК-д			
48	Байгууллагаараа уншигч болцгооё аяны хүрээнд Цагдаагийн газарт	1	157	200
49	Байгууллагаараа уншигч болцгооё аяны хүрээнд 1р сургуулийн багш ажилчид	1	70	60
50	Салбар номын санд танхимаар Өв соёл мину сэдэвт	1	18	72
51	Шинэ ном сэдэвт	1	17	72
		72	3030	8625

1:3:5 ЗОЧИНТОЙ ӨДӨР: /23 удаа 414 хүн/

Аймгийн Төв номын сан нь 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрийг зочинтой өдөр болгон сонгогдсон сэдвээр уншигчдад зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, мэдээ мэдээлэл, сургалтыг өгдөг болж байгаа билээ.

- Хараагийн дарь эхийн Гэцогдаржаалин хийдийн дэд хамба Ж.Мөнхсүх “Ханш нээх өдрийн тухай” болон хүн байгалийн шүтэлцээ холбоо, судар номын тайлбарын талаар сонирхолтой мэдээллийг хийлээ.
- Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Ж.Ган-Эрдэнэ."Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт", "Цахим гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдээр мэдээлэл хийлээ.
- Нэгдсэн эмнэлгийн их эмч Сэнгэрагчаагийн Оргил уригдаж "ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ" мэдээллийг хийлээ.
- Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын газрын хүүхдийн эрхийн улсын байцаагч А.МЯГМАРЖАРГАЛ “ХАРИЛЦАА БА ЁС СУРТАХУУН” сэдвээр лекц хийлээ.
- Монгол хэлний уран яруу үг хэллэг, ертөнцийн гурав, оньсого таавар, ерөөл магтаал гээд амаас ам дамжин баяжигдаж, утга төгөлдөр болж бэхэждэг өвөрмөц соёл, биет бус өв маань сүүлийн үед мартагдаж цөөрсөн тухай, үүнийг баяжуулан бэхжүүлж уламжлан авч явахын ач холбогдол, үүргийн талаар "АМАН ЗОХИОЛ -ОРЧИН ҮЕД" сэдвээр Төв номын сангийн Сан хөмрөгч О.Дунжидмаа уншигч хүүхдүүддээ мэдээлэл өглөө.
- ХААИС-ийн багш, утга зохиол судлалын докторант Б.БҮЖИНЛХАМ "МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ӨГҮҮЛЛЭГ" түүний онцлог төрөл зүйл, сэдэв, утга санааг тоймлохын сацуу зохиолч болон зохиол бүтээлүүдийн төлөөллийг дэлгэрэнгүй тайлбарлан уншигчдад мэдээлэл хүргэлээ.
- Тус үйл ажиллагааны хүрээнд “ХЭЛ ШИНЖЛЭЛ”-ийн өдрөөр “ОРОН, ОРНЫ ТҮҮХ, СОЁЛ” өдөрлөгийг зохион байгууллаа.
- Үйл ажиллагаа Төв болон салбар номын санд зохион байгуулагдсан бөгөөд уншигчдын хэл сурах сонирхлыг өрнүүлэх, улс орны түүх соёлоос суралцах, мэдлэгийг тэлэх зорилгоор 6 орны түүх, соёл, төсөлт хөтөлбөр, тэтгэлгийн талаар уншигчид болон урилгаар оролцсон ЕБС-ийн сурагчдад дараах улс орнуудын талаар мэдээллийг хийлээ. Зочин илтгэгчээр
- Монгол бичгийн түүх, соёлын талаар “Эзэн сэтгэлгээ” ТББ-ын тэргүүн Х.Одхүү
- Япон орны түүх, соёлын талаар Наран Шожи Япон хэлний сургалтын төвийн Дархан салбарын зархиал Ж.Болорцэцэг
- Америкийн нэгдсэн улсын түүх, соёлын талаар ОИ сургуулийн мэдээлэл технологийн багш Э.Энхбаяр, ОИ сургуулийн 11-3 ангийн сурагч Э.Нэйтэн

- Бүгд Найрамдах Солонгос Улсын түүх, соёлын талаар
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын түүх, соёлын талаар Дон боско шинэ үе НҮББ-ын Хятад хэл мэдээлэл зүйн багш С.Саяцэцэг
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын түүх, соёлын талаар JCI Найрамдал салбар байгууллагын Герман хэлний багш Н.Болор-ОД
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын түүх, соёлын талаар JCI Найрамдал салбар байгууллагын Хятад хэлний багш Б.Эрдэнэ-Ундрах нар уригдан мэдээлэл хийлээ.
- Хэл шинжлэлийн ухааны магистр, Үндэсний сургагч багш Ж.Эрхэмсайхан 2025 оноос хос бичигтэн болохоор бэлтгэж буй энэ цаг үед төрийн албан хаагчдад нэн чухал мэдээллийг бэлтгэн Монгол бичгийн түүх соёл, Төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэлийн судалгааг танилцуулан тайлбарлаж, "МОНГОЛЫН АЛБАН БИЧГИЙН ТӨРӨЛ" сэдвээр мэдээлэл хийлээ.
- Салбар номын сангийн сан хөмрөгч , мэдээллийн ажилтан И.Пүрэвбат Монгол орны нүүдлийн шувуу тэдгээрийн амьдрах чадварын талаар "Монгол хөхөө шувуу" сэдэвт танин мэдэхүйн мэдээллийг уншигч хүүхдүүддээ хийлээ.
- "ТАРИМАЛ УРГАМЛЫН СОРТ, ҮР ТАРИАНЫ СЕЛЕКЦИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ" сэдэвт сургалт зохион байгуулагдлаа. Солонгосын UNIVERSITY OF SUNMOON -г Молекул Биологийн чиглэлээр Магистр хамгаалсан, ШУТИС—г Биотехнологиор төгссөн УГТХ-ын Молекул биологийн лабораторийн эрхлэгч, ЭША, М.Ариунгэрэл зочин илтгэгчээр уригдан "Таримал ургамлын сорт, үр тарианы селекцийн тухай ойлголт" сэдвээр маш сонирхолтой байдлаар уншигчид болон номын сангийн хамт олонд мэдээлэл хийлээ.
- Энэ удаагийн зочинтой өдөр арга хэмжээ маань сурагчдад хүртээмжтэй байдлаар хүргэх үүднээс Дархан-Уул аймгийн Хүүхэд хөгжлийн төвийн сургалтын танхимд зохион байгуулагдлаа. Зочин илтгэгчээр: “ЭЕШ-НД БЭЛТГЭХ СЭТГЭЛ ЗҮЙ” сэдвээр Эзэн сэтгэлгээ” ТББ-ын тэргүүн Х.Одхүү, “АМРАЛТААРАА АМЕРИКТ” сэдвээр ОИ сургуулийн 11-3 ангийн сурагч Э.Нэйтэн, “ХЭЛ СУРАХ БОЛОМЖУУД” сэдвээр ОИ сургуулийн мэдээлэл технологийн багш Э.Энхбаяр, “USA СУРАГЧ СОЛИЛЦОО” сэдвээр ОИ сургуулийн 12-5 ангийн сурагч Б.Марал нар уригдан маш сонирхолтой, үр өгөөжтэй сургалт мэдээллүүдийг I, IV, XV, XVI сургуулийн төгсөх ангийн сурагчдад зориулан хийлээ.
- Аура оношлогч Б.Удвал "ЭНЕРГИ БА ГЭРЛЭН БҮРХҮҮЛ" сэдэвт мэдээллийг хийлээ.
- Зочноор Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын Дархан-Уул аймаг дахь ажилтан, ахлах шинжээч Э.Болортуяа "ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ" сэдвээр уншигч хүүхдүүдэд мэдээлэл хийлээ.
- Төв номын сангийн сан хөмрөгч- мэдээллийн ажилтан О.Дунжидмаа "ДӨРВӨН БЭРХ" эсгий урлал сургалтыг орлоо.Сургалтаар Монголчуудын эрт дээр үеэс уламжлагдан хэрэглэж ирсэн эсгийний ач холбогдол, эсгий хийх арга, эсгий урлалын талаар мэдээлэл өгч 4 бэрхийн хайрцгийг эсгийгээр оёулж, тайлбар мэдээллийг өгөв.
- Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл технологи, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Э.Дашпунцаг уригдан ирж номын сангийн

ажилтан албан хаагчид болон уншигчдад "НИЙГМИЙН ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?" сэдвээр мэдээлэл хийлээ.

- “Ээнэгших гэж юу вэ?” Зочин илтгэгчээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Сэтгэл зүйч О.Бүжин уригдан ирж Төв номын сангийн ажилтан албан хаагчид болон уншигчдад мэдээлэл хийлээ.
- Номын сангийн боловсролын хөтөлбөрт шинээр нэмэгдэж буй харах, сонсох , бодох үйлдэх сэтгэх ухаан нэмэгдүүлэх зэрэг таван мэдрэхүйн ур чадвар оролцуулсан эцэг эхийн хайрыг үгийн болон үйлдлийн оролцоотойгоор харуулахыг зорьсон “ХАЙРЛАХУЙН УХААН” сургалтыг Төв номын сангийн мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр номын сангийн нийт ажилтан албан хаагч болон уншигчдад орлоо.
- МУ-ын зөвлөх багш,Үндэсний бичиг соёлоо дэлгэрүүлэгч, Ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Оюунбилэг оролцож "Үндэсний бичиг нэр төрийн баталгаа" сэдвээр уншигч, сурагчдад мэдээлэл хийлээ.
- Нэгдсэн эмнэлэгийн арьс гоо заслын эмч Д. Удаанжаргал "УРГАМЛЫН ТООСНЫ ХАРШИЛ" сэдвээр мэдээлэл хийлээ.
- 30 дугаар сургуулийн англи хэлний багш Л.Энхтуяа "Reading club" - Англи хэлээр ном унших боломж сэдвээр мэдээлэл хийлээ.
- Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн А.Аззаяа "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт, Байгаль хамгаалал" сэдвээр мэдээлэл хийлээ. Дэлхийн дулаарал эрчимтэй явагдаж буй энэ цаг үед иргэн бид үүрэг хариуцлагаа ухамсарлан гар утсаа 1 цаг хэрэглэхгүй байх нь дэлхийн дулаарлыг саармагжуулах нэгэн алхам болдог байна.
- Дархан-Уул аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын зөвлөх Б.Наранмөнх "ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР" мэдээлэл хийлээ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тайлангийн бүтэц:

1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:

- 1.1. Холбогдох хууль, тогтоомж, тушаал, заавар судалж ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд;
- 1.2. “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд;
- 1.3. “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд;
- 1.4. Хяналт шинжилгээ үнэлгээний талаар;
- 1.5. Албан хэрэг хөтлөлтийн талаар;
- 1.6. Архивын үйл ажиллагааны талаар;
- 1.7. Хөдөлмөрийн тухай хуулийн болон бусад холбогдох хуулийн зохих заалтуудыг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээний хүрээнд;
- 1.8. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд;
- 1.9. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд;
- 1.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд;
- 1.11. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд
- 1.12. Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээний хүрээнд ;
- 1.13. Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээний хүрээнд;

2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- 2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд;
- 2.2. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд;
- 2.3. Соёлын Сайд бөгөөд Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2024 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийн хүрээнд;
- 2.4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Оюунлаг Дархан” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж дараах үйл үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах зорилтын хүрээнд;

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД

- 3.1. Үндсэн үйлчилгээ
- 3.2. Нэмэлт үйлчилгээ
- 3.3. Цахим уншлага үйлчилгээ
- 3.4. Лавлагаа, мэдээллийн талаар
- 3.5. Ном унших арга зүйд төлөвшүүдэх арга хэмжээний хүрээнд
- 3.6. Номын сангаас зохион байгуулах СОНА-ын талаар
- 3.7. Сан хөмрөгийн талаар:
- 3.8. Фонд, каталогийн талаар:

Зорилго: Ирээдүйн уншигчдыг төлөвшүүлэх;

Зорилт: Хүүхэд залуучуудын унших, суралцахыг дэмжих, мэдлэг, мэдээллийг тэгш шуурхай хүртээмтэй хүртээх, цахим орчинд уншлагыг түгээх, номын сангийн үйлчилгээнд өргөнөөр хамруулах;

1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:

1.1. Холбогдох хууль, тогтоомж, тушаал, заавар судалж ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ийг хэрэгжилтийг хангаж, хууль сурталчлах, таниулах сургалтыг тус бүр 2 удаа зохион байгуулж, нийт 17 албан хаагчдыг бүрэн хамруулсан.

1.1.1. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Авлигын тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

1.1.2. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сурталчлах ажлыг зохион байгуулж нийт албан хаагчдад 1 удаа мэдээлэл хийсэн.

1.1.3. Сард 2 удаа нийт албан хаагчын хурлыг зохион байгуулж, сар бүрийн гүйцэтгэгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилт, бусад үйл ажиллагааны талаар хэлэлцэж хэвшсэн.

1.1.4. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-иар албан хаагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулсан.

1.2. ХНО-ны 2021-2024 онд баримтлах “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд:

1.2.1. ХНО-ны “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024” –ийн хүрээнд хүний нөөцийн бодлого нь дараах зорилтыг хангахад чиглэн ажиллаж байна. Үүнд:

- Мэргэшсэн, дадлага туршлагатай албан хаагчдаар багаа бүрдүүлэх /мэргэжлийн 6 номын санч, 1 компьютерийн программист/
- Хүний нөөцийн жөндөрийн харьцаа тэгш байх; / 70:30 хэтрэхгүй байх /эмэгтэй-12, эрэгтэй-5 албан хаагч/,
- ХНО-ны албан хаагчдын 2024 оны сургалтын хөтөлбөр, ХНО-ны ажилтан албан хаагчдийн нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөг тус тус хэрэгжүүлэн ажиллаж, 31 сургалтад давхардсан тоогоор 217 албан хаагчид хамрагдаж, мэдлэг, мэдээлэл авсан.
- Нийгмийн баталгааг хангах 21 арга хэмжээний хүрээнд “Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээр олгох урамшуулал дүгнэх журам, үзүүлэлт” -ээр 17 албан хаагчдад 8-12 хувиар үнэлж урамшуулал олгох, Улиралын ажлын мөнгөн урамшууллыг 50 хүртэлх хувиар 17 ажилтан албан хаагчдад үнэлгээ, үзүүлэлтийн дагуу олгох, 2 албан хаагч Соёлын яамны жуух бичгээр шагнуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

1.3. Нийт 17 албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу бүрдүүлж бүтцийн нэгж, албан тушаалын ангилал дараалалд оруулж, албан хаагч нэг бүрээр хавтас үүсгэн битүү шүүгээнд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган эмх цэгцтэй хадгалж байна. Мөн хос бичигтэн байгууллага болох зорилтын хүрээнд бүх албан

хаагчид Зүеийн намтара монгол бичгээр бичиж хувийн хэрэгтээ бүрдүүлж, баяжуулсан.

1.4. Хяналт шинжилгээ үнэлгээний талаар:

- Хүүхдийн Номын Ордны 2022 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих зорилгоор дотоод аудит 1 удаа,
- Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2024 оны 04-р сарын 11-ний өдөр Хүүхдийн Номын Ордны соёлын ажилтанд 2023 онд олгосон тэтгэмжийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн санхүүгийн баримтад дотоод аудит 1 удаа,
- Хүүхдийн Номын Ордны 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт хийх, хэрэгжилт үр дүнг үнэлэх, санал дүгнэлт гаргах зорилгоор 2024 оны 10-р сарын 28-ний өдөр зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн санхүүгийн баримтад дотоод аудит тус тус 1 удаа хийсэн.
- Албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
- Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дотоод хяналт хэдэн 2 удаа орсон. Хяналт шалгалтын хүрээнд ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажилласан.
- Хагас жилээр ХШҮ-ЭЭР % үнэлгээ авсан.

1.5. Албан хэрэг хөтлөлтийн талаар: Байгууллагад ирсэн цаасан болон цахим баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, удирдалагад танилцуулах, явуулах баримт бичгийг ажилтнуудаас хүлээх авах, бүрдлийг шалгах, стандартын дагуу зохион бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих, удирдлагад танилцуулж баталгаажуулах, бүртгэх, илгээх ажлыг тогтмол зохион байгуулж байна. Үүнд:

- Ирсэн баримт бичиг-55
- Явуулсан баримт бичиг-62
- А тушаал-11
- Б тушаал-16

1.6. Архивын үйл ажиллагааны талаар: Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журамд заасны дагуу 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах-22, түр хадгалах-10, 70 жил хадгалах-4 б ХН хүлээн авч байна.

1.7. Хөдөлмөрийн тухай хуулийн болон бусад холбогдох хуулийн зохих заалтуудыг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээний хүрээнд:

- **Дотоод журам, Хамтын гэрээний хэрэгжилт:**
 - ✓ Хүүхдийн номын ордны Хөдөлмөрийн дотоод журмыг 2023 оны 02 дүгээр сар 01-ны А/02 тоот тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллаж байна. 2025 онд шинэчлэн боловсруулах шаардлагатай.
 - ✓ Хамтын гэрээр 2023 оны 02-р сарын 10-нд Дархан-Уул аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар бүртгэн баталгаажуулсан. 2025 онд шинэчлэн боловсруулж баталгаажуулах шаардлагатай.

1.8. Ажилтан албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хүрээнд нийт 7 удаагийн сургалтад ёс зүйн зөвлөлийн гишүүд болон 17 албан хаагч, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг сурталчлах чиглэлээр зохион байгуулсан 1 тэмцээнд 12 албан хаагч тус тус оролцсон. Үүнд:

- Байгууллагын ажилчдын дунд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-иар АХА тэмцээнийг зохион байгуулсан.

- Холбогдох байгууллагаас зохион байгуулж буй 3 удаагийн сургалт ёс зүйн зөвлөл бүрэн хамрагдсан.
- Хамрагдсан сургалтын мэдээ мэдээллийг 2 удаа байгууллагын албан хаагчдад танилцуулсан.
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сурталчлах ажлыг зохион байгуулж нийт албан хаагчдад 1 удаа мэдээлэл хийсэн.
- Дархан-Уул аймгийн Төрийн албаны Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Лхагважаргал “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-аар ХНО-ны нийт албан хаагчдад сургалт, мэдээлэл хүргэж, нийт 17 албан хаагч хамрагдсан. Мөн ХНО-ны ёс зүйн дэд хорооны гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгсөн.
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 3 мэдээлэл бэлтгэж пейждээ байршуулж, 598 хэрэглэгчдэд хүргэсэн.
- Ямар нэгэн санал гомдол зөрчил илрээгүй.

1.9. Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордны 2024 оны Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг зохион байгуулахаар тусгагдсан ба 25 арга хэмжээг зохион байгуулж, нийт 17 албан хаагчдыг бүрэн хамруулан ажилласан. Үүнд:

- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2019.10.07 10/657 тоот уриалгыг хэрэгжүүлж 5 ажилтанд хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө олгосон.
- Ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгож бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль цэцэглэгт хүргэж өгөх, авах, зам тээврийн ослоос сэргийлэх эргүүлд гарах цагийг нь зохицуулан 12 ажилтанд чөлөө олгосон.
- “ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ӨДӨР”-т зориулсан 2 арга хэмжээ зохион байгуулж, цахим хуудсан байршуулж, олон нийтэд түгээсэн. Хандалт-4507
- Хүүхдийн Номын Ордны цахим хуудсаар дамжуулан хүүхэд хамгааллын чиглэлээр 30 гаруй мэдээлэл оруулж, нийт хандалт -8569 байна. Дараах хүүхэд хамгааллын постерүүдийг бэлтгэн нийтэлж олонд хүргэсэн
- Байгууллагынхаа ажиллагсдын гэр бүлийн бүртгэлийн жагсаалтыг шинэчлэн гаргасан. Нийт 14 ажилтаны 0-18 насны хүүхэд 30 байна. /Тайланг хавсаргав/

1.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд нөлөөллийн арга хэмжээг танхмаар 1 зохион байгуулж, зам тээврийн ослоос сэргийлэх арга хэмжээг 3 удаа, цахимаар гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 мэдээлэл бэлтгэж пейждээ байршуулж, 2451 хэрэглэгчдэд хүргэсэн. Үүнд:

- Камер хянах дэлгэцийг камерийн төхөөрөмжтэй холбох, компьютерүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 21 удаа үйлдлийн систем шинэчилж 6 удаагийн шинээр үйлдлийн систем суулгасан.
- Электрон тамхины хор уршгаас сэргийлэх талаар-2, Цахим халдлагаас сэргийлэх зөвлөмж -2 бэлтгэж тус тус пейж хуудсандаа байршуулж 2451 хэрэглэгчдэд хүргэсэн.
- Хамгаалах байранд байгаа хүүхдүүдэд 1 удаа зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн.
- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар 2 зурагт хуудас бэлтгэж пейждээ байршуулж, хэрэглэгчдэд хүргэсэн.
- Байгууллагын эцэг эхчүүдийг “School police”-ээр ажиллаж боломжийг хангаж ажилласан

1.11. Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь хэсэгт заасны дагуу 3 албан хаагч ХАСХОМ-ээ Авлигатай тэмцэх газрын <https://meduuleg.iaac.mn> цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлж баталгаажуулсан

1.12. Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээний хүрээнд

- Цахимаар:
 - ✓ "Жендэрт суурилсан хүчирхийлэл" цахим мэдээлэл
 - ✓ "Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлж таслан зогсооё" Цахим мэдээлэл
 - ✓ "Жендэрт суурилсан ойлголтууд" цахим мэдээлэл
 - ✓ Жендэрийн эрх тэгш байдал "Хүүхэдтэй эерэг аргаар харилцъя" Цахим мэдээлэл
- Жендрийн эрх тэгш байдлын хуулийн талаар мэдлэг олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулсан.
- Хүүхдийн номын ордоны жендэртэй холбоотой санал асуулгаар нийт 17 ажиллагсадаас 15 хүн судалгаанд хамрагдсан байна. Судалгаанаас үзэхэд нийт ажиллагсадын жендэрийн харьцаа 70/30. Ажиллагсад жендэрийн талаарх мэдлэг, мэдээлэл сайн. Ажил дээр дарамтын шинжтэй үйлдэл гардаггүй. 14% нь жендэрийн талаар **сургалт, мэдээлэл авах хүсэлтэй гэсэн судалгаа гарсан байна.**

1.13. Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээний хүрээнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 399, 340 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохион дамжуулах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногт зохион байгуулагддаг гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад ажлын байранд байсан 12 албан хаагчид, 19 уншигч үйл оролцсон.
- Өрөө тасалгаануудын галын хорыг тогтмол сийрэгжүүлж хэвшсэн.
- Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх анхааруулах тэмдэг тэмдэглэгээг хийж байршуулсан

1.14. БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТАЛААР:

1.14.1. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

1.14.2. Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын тогтмол болон урсгал зардлын гүйлгээг тогтмол хийж, төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулсан. Үүнд:

- Батлагдсан төсөв:
 - Улсын төсөв-466,659,400.00
- Орон нутгийн төсөв-30,031,900.00
 - Гүйцэтгэл: Улсын төсөв-456,728,641.76
 - Орон нутгийн төсөв-21,121,214

1.14.3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, сайтад 151 мэдээлэл оруулсан

- 1.14.4. НББ-н анхан шатны маягтыг Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу иж бүрэн хөтөлж байна.
- 1.14.5. Мөнгөн кассын гүйлгээг 7 хоног тутам Төрийн сан банканд тушааж Сангийн сайдын 74 дүгээр тушаалын дагуу соёл олон нийтийн ажил, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангад зориулалтын дагуу зарцуулан тайлагнаж байна. Оны эхний 11 сарын байдлаар 10,213,000 төгрөгийн орлого төвлөрүүлж байна.

2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

2.1.1. “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хууль, “Номын баяр тэмдэглэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын ордны 2024 оны “Үндэсний бичиг, соёлын жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг зохион байгуулахаар боловсруулан хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Үндэсний бичиг үсгийн баяр буюу хаврын номын баярын үйл ажиллагааны хүрээнд Хүүхдийн номын ордноос 11 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулж, 1826 уншигчдыг хамруулсан. /Тайланг хавсаргав/
- “Үндэсний номын баяр” буюу намрын номын баярын үйл ажиллагааны хүрээнд Хүүхдийн номын ордноос 9 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 4885 гаруй уншигч, хүүхэд багачууд, албан хаагчид хамрагдсан. /Тайланг хавсаргав/

2.1.2. “Эх хэлний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 25-р зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийт 3 үйл ажиллагааны хүрээнд 11 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 3676 уншигчдийг хамруулан, 6 мэдээлэл бэлтгэн пейж хуудсандаа байршуулж 4689 цахим хэрэглэгчдэд хүргэж ажилласан. Үүнд:

- “Эх хэл, түүх соёлоо сурталчлах нь” үзэсгэлэн:
 - ✓ Үндэсний бичиг,соёл-номын өдрүүд болон Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан “Бийрийн бичлэг”-ийн уралдааны нийт 50 гаруй бүтээлээр 1 удаа, мөн шагналт байранд орсон бүтээлээр “Найрамдал” талбайд 1 удаа, “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 1 удаа тус тус гаргаж, нийт 1500 гаруй уншигч, хүүхэд багачуудад хүргэсэн. Мөн цахим хэлбэрээр бэлтгэж пейж хуудсандаа байршуулж, 215 хэрэглэгчдэд хүргэсэн.
 - ✓ Албан хаагчдын хичээнгүй бичгийн үзэсгэлэнг Найрамдал талбайд 1 удаа гаргаж, 1000 гаруй хүнд хүргэсэн.
 - ✓ Эх хэлний өдөр болон хичээлийн шинэ жилийг тохиолдуулан ЕБ-ийн 4-р сургууль дээр ажиллаж, 1-р ангид элсэн орж буй болон анги дэвшин суралцаж буй 6-р ангийн сурагчдад зориулан шинэ номын танилцуулга, Үндэсний бичиг-крилл бичгээр бичигдсэн номуудаар уншлага хийж, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулан нийт 160 гаруй сурагчдыг хамруулсан.
- Өөрийн сан хөмрөг дэх монгол хэл, бичгийн ном хэвлэлийг нийтэд сурталцах, номын эргэлтийг сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор сэдэвчилсэн номын үзэсгэлэнг биет болон цахим хэлбэрээр 3 удаа 75 боть номоор гаргаж уншигчид болон 465 цахим хэрэглэгчдэд хүргэсэн.

- ✓ Хос бичгээр бичигдсэн 23 боть номоор биет хэлбэрээр болон цахим хэлбэрээр;
- ✓ Үндэсний бичиг үсэг, соёлтой холбоотой сэдэвтэй 29 боть биет болон цахим хэлбэрээр;
- ✓ Эх хэлний өдрийг тохиолдуулан өөрийн сан хөмрөг дэхь эх хэлний чиглэлийн 23 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн тус тус гаргасан.
- Эх хэл, түүх соёлоо сурталчлах, эх хэлээрээ зөв ярьж, цахим орчинд зөв бичих дадал хэвшүүлэх зорилгоор
 - ✓ Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээ, пейж хуудсанд оруулж байгаа мэдээлэлд зөв бичгийн болон найруулга зүйн алдлааг тогтмол хянаж ажилласан.
 - ✓ ХНО-оор үйлчлүүлэгч 3-5-р ангийн хүүхэд багачуудын дунд “Хэн уран унших вэ” уралдаан зохион байгуулж Д.Нацагдоржийн “Миний нутаг”, Б.Ринченгийн “Монгол хэл” шүлгийг уншиж, мэдлэг оюунаа сорьсон. Арга хэмжээнд нийт 16 хүүхэд оролцсон.
 - ✓ Цахим орчинд:
 - ❖ Онч үгийг крил болон монгол бичгээр бичих;
 - ❖ Монгол бичгээр унших эх;
 - ❖ Монгол бичгийн утга ялган бичдэг үгс
 - ❖ Үндэсний бичгийн дүрс, утга ялган бичих 19 үг
 - ❖ Зарим үгсийг журамласан байдал зэрэг зурагт мэдээлэл,
 - ❖ Монгол хэлний чиглэлээр ирсэн шинэ номын мэдээ зэрийг бэлтгэн пейждээ байршуулж, 4009 хэрэглэгчдэд хүргэсэн.

2.2. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

2.2.1. “Алсын хараа-2050” 1.2.3, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр- 2.6.2.2, Соёлын сайд, Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын хамтарсан тушаал 2023 оны А/152, А/195, А/57, А/40 (**Бүх нийтийн соёлын боловсрол олгох хөтөлбөр**) хэрэгжилтийг хангах зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох “Угийн бичгээ хөтөлж сурцгаая”, “Уламжлалт тоглоом наадгай”, “Өв соёлоо мэдь”, “Даам тоглож сурцгаая” зэрэг 4 хөтөлбөр боловсруулж, баталгаажуулан мөрдөж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд тус хөтөлбөрүүдийг давхардсан тоогоор 89 удаа зохион байгуулж, 6089 уншигч, хэрэглэгчдийг хамруулсан байна. /Тайланг хавсаргав/
- Морин хуур” хөтөлбөр, “Олбог оёж сурцгаая” зэрэг 2 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна.
 - ✓ “Номтой аялал-Морин хуур” хөтөлбөр 5 удаа зохион байгуулагдаж, 249 хүүхэд хамрагдсан.
 - ✓ “Олбог оёж сурцгаая” хөтөлбөр 3 удаа зохион байгуулагдаж 32 хүүхдийн хамруулсан. /Тайланг хавсаргав/

2.2.2. “Алсын хараа-2050” 1.3.2, 1.3.3, 1.3.4, 1.3.10, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр- 2.6.2.2, **“Монгол бичгийн үндэсний бичиг-III хөтөлбөр”**-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд:

- Монгол бичгийн хэрэглээний орчин бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- ✓ Албан хаагчдын дунд “Хүмүүн бичиг” сонины шинэ дугаарын уншлагыг сар бүр зохион байгуулж хэвшсэн.
- ✓ Нийт албан хаагчдын дунд Үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Үндэсний бичгийн хурдан уншигч” уралдааныг зохион байгуулж, номын санч мэдээллийн ажилтан М.Оюунгэрэл тэргүүлсэн.
- ✓ 3 үеийн намтраа үндэсний бичгээр бичих үйл ажиллагааг зохион байгуулж нийт номын санч мэдээллийн ажилтнууд өөрийн 3 үеийн намтраа үндэсний бичгээрээ бичиж өөрсдийн хувийн хэргээ баяжуулсан.
- ✓ Монгол бичгээр алдаагүй цэвэр сайхан бичих аян зохион байгуулж, бичвэрээрээ үзэсгэлэн гаргасан.
- ✓ Салбар номын сан нь номын тавиур, номын ялгагч болон хүүхдийн чөлөөт уншлагын орчинд Монгол бичгээр хаягжуулалт хийж, Монгол бичгийн хэрэглээний орчин бүрдүүлж ажилласан.
- Монгол бичигт суралцах үйл ажиллагааг эрчимжүүлж, “Хос бичигтэн байгууллага” болох аянд нэгдэж нийт 12 удаагийн сургалт болон уралдаан зохион байгуулж 7-11 албан хаагч хамрагдсан. Үүнд:
 - ✓ “Од цогцолбор сургуулийн сурагч - Бийрийн бичгийн сургагч багш Д.Номинзултай хамтран “Бийрийн бичгийн сургалт”-ыг 2, 3, 4, 5-р саруудад хуваарийн дагуу 8 удаа зохион байгуулж, 7 албан хаагч хамрагдан анхан шатны мэдэгдэхүүнтэй болсон.
 - ✓ Монгол хэл, бичиг – Уран зохиолын танхимын номын санч-мэдээллийн ажилтан О.Даваасүрэнгийн удирдлага дор 2 удаагийн бататгах сургалтад 11 албан хаагч хамрагдсан
 - ✓ Нийт албан хаагчдыг хамруулан “Хичээнгүй цэвэр бичигтэн” шалгаруулах арга хэмжээг 1 удаа зохион байгуулж бичвэрээр үзэсгэлэн гаргасан.
 - ✓ Албан хаагчдын дунд “Монгол бичгийн хурдан уншлагын уралдаан” 1 удаа зохион байгуулж, 10 албан хаагч оролцсон.
- Албан хэргийг кирилл, монгол бичгээр хөтлөх үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээний хүрээнд явуулсан бичиг бүрийг монгол бичгээр боловсруулан илгээж хэвшсэн.
- Монгол бичгийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор уншигч хүүхэд багачуудын дунд / СОНА-Соёл Олон Нийтийн Ажил/ 5 арга хэмжээ зохион байгуулж, 703 хүүхдийг хамруулсан. 1 мэдээлэл бэлтгэж пейждээ байршуулан 506 хэрэглэгчдэд хүргэсэн. Үүнд:
 - ✓ 6-9, 10-12-р ангийн сурагчдын дунд “БИЙРИЙН БИЧЛЭГИЙН УРАЛДААН”-ыг зохион байгуулж, 50 гаруй сурагчид оролцсон.
 - ✓ “Үндэсний бичиг үсэг, номын баяр”-ын өдрийг тохиолдуулан элит-22 сургуультай хамтран “Номтой өдөр” нүүдлийн номын сангийн үйл ажиллагаа 2 өдөр зохион байгуулсан. /120 гаруй хүүхэд хамрагдсан/
 - ✓ Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Үндэсний бичиг соёл-номын баяр 2024” нэгдсэн арга хэмжээнд оролцож, 245 хүүхдийг хамруулан, номын баярт оролцогч 1000 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачуудад үйл ажиллагааг сурталчилж ажилласан.
 - ✓ Үндэсний бичиг соёл-номын өдөр-2024” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын их хурлын дарга Гомбожавын Занданшатарын санаачлагаар жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Номын сайн нөхөр” уралдааны “Шилдэг уншигч- Анги хамт олон төрөлд ХНО-оор 4 жил дараалан үйлчлүүлж буй Идэвхтэн уншигч, Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн “Од”

сургуулийн Э.Мягмаржаргал багштай 5-10 анги /37 хүүхэд/ шалгарсан.

- ✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэн, чанга уншлага, номтой аялал, танилцах аялал зэрэг арга хэмжээг зохион байгуулж, 251 хүүхдийг хамруулсан.
- ✓ Цогтын хадны бичээсийн түүхийг видео хэлбэрээр бэлтгэж, пейждээ байршуулан 506 хэрэглэгчдэд хүргэсэн

2.2.3. “Алсын хараа-2050” 1.2.10, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр- 2.6.2.4, МУ-ын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл 2.6, МУ-ын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөө 2.4.1.1, МУ-ын ЗГ-ын 2022 оны 314-р тогтоол (**Соёлын бүтээлч үйлдвэрлэл**)-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ХНО-ны брэнд бүтээгдэхүүн /бэлэг дурсгалын бүтээгдэхүүн/ бий болгох арга хэмжээний хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд 100 х 60 харьцаатай шагайн олбог ширж оёж дуусган номын сангийн үйлчилгээгдээр дамжуулан соёлын боловсролын хөтөлбөрт ашиглахад бэлэн болсон.
- Эсгийгээр “4 бэрх” багц 1 ширхэгийг хийж, АХА тэмцээнд түрүүлсэн хүүхдэд бэлэглэсэн.
- Чанга уншлага хийх “Мини театр”-т зориулан эсгийгээр шинээр хүүхэлдэй хийсэн.
- Номын үзэсгэлэн гаргахад зориулан ширээний бүтээлэг хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Үйл ажиллагаандаа ашиглах энгэрийн тэмдэг хийх машин авсан. “Найргийн даага” уралдааны 40 оролцогчдод дурсгалын тэмдэг хийж бэлэглэсэн.
- Түүх, соёл, уламжлалыг таниулахад чиглэсэн “Өв соёлын цаг” сэдвийн хүрээнд “Шагайн наадгайн төрөл”, “Шагайн наадгай” сэдвээр 2 контент, “Дээл” сэдвээр 1 видео контент тус тус бэлтгэж өөрийн пейждээ байршуулан 1474 хэрэглэгчдэд хүргэсэн.
- 16-18 насны иргэдэд үйлчлэх соёлын эрхийн бичгийн хүрээнд соёлын бүтээгдэхүүн үйлчилгээ, боловсролын хөтөлбөр, сургалт зэрэг багц үйлчилгээний саналыг Аймгийн СУГ-т хүргүүлсэн.
- Эрхийн бичгийн хүрээнд зохион байгуулагдах “Номтой аялал”, “Чанга уншлага”, “Угийн бичгийн сургалт” арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулж ажилласан. Үүнд:
 - ✓ Номтой аялал-“Номтой аялал-Морин хуур” арга хэмжээг 5 удаа зохион байгуулж 240 гаруй хүүхдийг, англи хэлний уншлага үйлчилгээний уншлагын танхимаар үйлчлүүлэгч хүүхдийн дунд 3 удаа 26, ШУТИС-ийн ахлах сургуулийн хүүхдийн дунд 1 удаа, нийт 9 удаа 286 хүүхдийг хамруулан
 - ✓ Чанга уншлага: Арга хэмжээг нийт 15 удаа, 1588 бяцхан уншигчдад
 - ✓ Угийн бичгээ хөтөлцгөөе” сургалтыг нийт 22 удаа зохион байгуулж, 1367 хүүхдийг хамруулж, Угийн бичиг гэж юу вэ?, таних тэмдэг хэрхэн ашиглах болон зурж хөтлөх аргаар ургийн модоо зурж сурах арга барилд сургаж, дадлага ажил хийлгэн анхан шатны мэдэгдэхүүн олгосон.

2.2.4. Соёлын өвийн чиглэлээр:

- ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох

чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд шавь сургалтын танхимыг 202 тоот өрөөнд нээсэн.

- ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулсан “ХОТОН” бий биелэгээний сургалтад номын санч-мэдээллийн ажилтан М.Оюунгэрэл хамрагдаж анхан шатны мэдэгдэхүүнтэй болж Батламж авсан.
- “Өв соёлын цаг” сэдвийн хүрээнд “Шагайн наадгайн төрөл”, “Шагайн наадгай” сэдвээр 2 контент, “Дээл” сэдвээр 1 видео контент тус тус бэлтгэж өөрийн пейждээ байршуулан 1474 хэрэглэгчдэд хүргэсэн.

2.2.5.

2.3. Соёлын Сайд бөгөөд Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2024 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийн хүрээнд;

2.3.1. Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулж пейж хуудсаараа дамжуулан:

- ✓ Шинэ номын мэдээлэл;
- ✓ Сэдэвчилсэн номын цахим үзэсгэлэн;
- ✓ Соёлын боловсролын хөтөлбөр;
- ✓ Ном унших арга зүйн;
- ✓ Зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээлэл;
- ✓ Уламжлалт зан заншил;
- ✓ Соёлын биет бус өв;
- ✓ Хүүхэд хамгаалал;
- ✓ Цахим орчин дахь зохистой хэрэглээ
- ✓ Эрүүл мэндийн боловсрол
- ✓ Танин мэдэхүй болон
- ✓ Бусад сэдвүүдээр тус тус мэдээлэл бэлтгэж, 8600 гаруй дагагчдад тогтмол хүргээд байна

2.3.2. Хүүхдийн зусланд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааны хүрээнд ардын уламжлалт тоглоом наадгайг илүү өргөн хүрээнд сурталчлан таниулах зорилгоор Зулзагын голын хүүхдийн зусланд амрагч хүүхдүүдэд номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох:

- ✓ Угийн бичгээ хөтөлж сурцгаая” боловсролын хөтөлбөр
- ✓ “Өв соёлоо мэдь” боловсролын хөтөлбөрийг Шагайн наадгай сэдвээр тус тус хүргэж,
- ✓ Шинэ номын үзэсгэлэн гаргаж, уншлага зохион байгуулан
- ✓ нийт 298 хүүхдийг хамруулсан.

2.3.3. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох 1 албан хаагчийг томилосон. Гэр бараа шалгаж барих буулгах, ачаа ачааллах, буулгах, ширээ болон эд хошгил цуглуулах зэрэг бэлтгэл ажилд 4 албан хаагч оролцсон. Соёлын фестивальд 3 албан хаагч гэр бүлийн хамт очиж, үзэж сонирхсон

2.3.4. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг тус бүр 1-3 удаагийн давтамжтай зохион байгуулж, 10993 уншигч, хүүхэд багачуудыг хамруулан, 37 төрлийн мэдээллийг 12469 цахим хэрэглэгчдэд хүргэсэн. Үүнд:

- ✓ Номын сангийн үйлчилгээнд 7706 уншигч,
- ✓ 6 төрлийн боловсролын хөтөлбөрийг 21 удаа зохион байгуулж, 1553 хүүхэд,
- ✓ 2 удаагийн уншигчдийн бага хуралд 221 хүүхэд
- ✓ 20 удаагийн нөлөөллийн ажилд 1513 хүүхэд тус тус хамрагдсан. Үүнд:

- ❖ Боловсролын хөтөлбөр:
 - “Угийн бичгээ хөтөлцөөе”
 - “Өв соёл”
 - “Уламжлалт тоглоом наадгай”
 - “Даам”
 - “Номтой аялал-Морин хуур”
 - “Олбог оёж сурцгаая”
- ❖ МУ-ын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог- намтар уран бүтээлийг сурталчлах арга хэмжээ,
- ❖ Хэл шинжлэлийн ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй багш Ж.Эрхэмсайхан- сурталчлах арга хэмжээ
- ❖ МЗЭ-ийн гишүүн, зохиолч, яруу найрагч Л.Мөнхбаатар-сурталчлах арга хэмжээ
- ❖ “Цогт хун тайжын хадны бичээс”-ийг цахим хэлбэрээр сурталчлан таниулах
- ❖ “Цогт хун тайжын хадны бичээс”-ийг таниулах уншлага зохион байгуулж, АХА тэмцээн зохион байгуулах
- ❖ “Алтан хонх” уралдаан
- ❖ “Найргийн даага” шилдэг шүлэг шалгаруулах уралдаан,
- ❖ Дүрийн тоглолттой уншигчдын бага хурал
- ❖ Ном унших арга зүйд төлөвшүүлэх;
 - ❖ Чанга уншлага
 - ❖ Бүтээлч уншлага
 - ❖ Лекц

2.3.5. Зохиолчдын шинэ номын нээлтийг 2 удаа зохион байгуулж 190 гаруй уншигчыг хамруулсан.

- ✓ МЗЭ-ийн шагналт яруу найрагч Л.Мөнхбаатарын бие даасан 6 дахь уран бүтээл болох “Янзын залуу минь яруу найраг зураглаач” номын нээлтийг зохион байгуулж, зохиолч, яруу найрагчид, гэр бүл, найз нөхөд, номын сайн нөхөд нийт 100 гаруй уншигч хүрэлцэн ирж оролцлоо.
- ✓ МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын гишүүн, яруу найрагч Цогломын Батгэрэлийн “Сүүн цацалтай тэнгэрийн дор”, “Аялгуу хүссэн гар бичмэлүүд” зэрэг шинэ номын нээлтийг зохион байгуулсан. Нээлтэд МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын зохиолч яруу найрагчид болон гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсад нийт 90 гаруй хүн оролцож, ХНО-ны хамт олон дэмжин ажилласан

2.3.6. Соёл, урлагийн байгууллагын орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын стандартыг хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд MNS 5742:2019 Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага стандартын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:

- ❖ Галын аюулгүй байдлыг хангах үүднээс өрөө тасалгаа бүрт байгаа 17ш галын хорыг тогтмол сэгсэрч сийрэгжүүлсэн.
- ❖ Номын сангийн гэрэлтүүлгийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж шатсан гэрлүүдийг байнга солих, засвар үйлчилгээг тухай бүр цаг алдалгүй гүйцэтгэсэн.
- ❖ Фондын чийгшилтийг хэвийн хэмжээнд хангах зорилгоор дотоод нөөц бололцоогоо ашиглан хувинтай ус тавих, өдөрт 10-20 минут агаарын солилцоо хийх арга хэмжээ авсан

- ❖ Их цэвэрлэгээг сар бүр /12 удаа/ тогтмол хийж, 0.5% хлорамины уусмалаар ном ариутгасан.
- ❖ Номын сангийн нярав, ня-бо нар шинэ ирсэн 266 нэрийн 624 боть номыг дагалдах баримтыг үндэслэн сар бүр санхүүгийн тайлан гаргаж, үндсэн хөрөнгөд бүртгэж авдаг.
- ❖ Шинээр ирсэн 624 боть номонд техник ажиллагаа хийн, ангиласны дараа “Номын нэг бүрчилсэн бүртгэл”, дагалдах баримт бичгийг үндэслэн “Нэгдсэн бүртгэл”-д бүртгэж авсан
- ❖ Номын санчид “Номын сангийн өдөр тутмын бүртгэл”-ийг холбогдох заалт, стандартын дагуу үнэн зөв хөтөлж заншсан.

2.3.7. “Цахим соёл” арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн Creativehub-т захирал Л.Мөнхбаатарыг бүртгүүлж, мэдээллийг оруулсан;

2.3.8. Орон нутгийг төсвийн хөрөнгө оруулалтаар ХНО-ны барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 1-3 давхарын бүх сантехникийн шугамыг бүрэн сольж, Дулааны удирдлагын контеллёр суурилууснаар уншигч үйлчлүүлэгчдийн сурч хөгжих болон ажилтан албан хаагчдын ажиллах таатай орчин бүрдсэн. Техник тонгог төхөөрөмжийн шинэчлэл /камерын дэлгэц шинэчлэх, киоск машин/ хийснээр ажил үйлчилгээг хэвийн явуулах боломжоор хангагдсан.

- ❖ Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 28,769,300 төгрөгийн 8 нэрийн 9ш техник тоног төхөөрөмжийг хүлээн авсан.
- ❖ Хяналтын камерын дэлгэцийн хүчин чадлыг нэмэгдүүлж шинээр 55 инчийн дэлгэц авсан.
- ❖ Хүүхдийн номын ордны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, сан хөмрөгийн номын мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй хүргэх, электрон каталогийн ашиглалтыг сайжруулах зорилгоор киоск машин 1,648,900 төгрөгөөр худалдан авч 1-р давхарт нийтэд ил байрлуулан ашиглаж байна.
- ❖ Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, уншигч хүүхэд багачуудын сурч боловсрох, ажилтан албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор дулааны удирдлагын контеллёр 4,716,400 төгрөгөөр сольж суурилуулсан.
- ❖ 1-3 давхарын бүх сантехникийн шугамыг бүрэн болон зарим өрөө тасалгааны халаалтын төхөөрөмжийг шинэчлэн сольсон.

2.4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Оюунлаг Дархан” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж дараах үйл үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан:

- Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:
 - ✓ Төрөлжсөн book & coffee танхим уртсгасан цагаар ажиллаж өдөр бүр 09,00-20,00 цагийн хооронд журмын дагуу ажиллаж байна. Тайлангийн хугацаанд /2024.10.31-ны байдлаар/ 2141 ирэгсдэд үйлчилгээ үзүүлсэн.
 - ✓ Уншигч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн шинээр 1-р давхарын Team Room уншлага үйлчилгээний танхимд анги нийтээрээ болон хэсэг бүлэг, найз нөхөд, баг хамт олноороо номын сангийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэн ажилласнаар 2145 уншигчдад үйлчилгээ үзүүлж, төрөлжсөн танхимаар үйлчилгээ авагчдын тоо 14%-иар өссөн.

- ✓ Номын сангийн үйлчилгээгээр дамжуулан Соёлын боловсрол олгох хөтөлбөрүүд эрчимжиж (Угийн бичгээ хөтөлцгөөе, Уламжлалт тоглоом наадгай, Өв соёлоо мэдье, Даам зэрэг хөтөлбөрүүдэд нийт 2270 уншигч хүүхдүүд хамрагдсан) шинээр Олбог оёж сурцгаая хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо /оны эхнээс нийт үйлчлүүлэгчдийн тоо-51423/ 4,3% нэмэгдсэн байна.
 - ✓ Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх СОНА 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10 арга хэмжээг зохион байгуулж 925 уншигч, хүүхдүүдийг хамруулсан. Үйл ажиллагааны санхүүжилт авснаар зохион байгуулж буй арга хэмжээний чанар, хүртээмж нэмэгдэж, уншигч, хүүхдүүдийн оролцоо сайжирсан.
 - ✓ Хүүхдийн номын ордны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, сан хөмрөгийн номын мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй хүргэх, уншигч үйлчлүүлэгч ая тухтай үйлчлүүлэх, ажилтан албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр ажиллаж киоск машин суурилуулсан.
- Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, чөлөөт цагийн зөв зохистой өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор шинжлэх ухаан танин мэдэхүйн уралдаан тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулж ажилласан. Үүнд:
- ✓ “Номтой өдөр” нүүдлийн номын сангийн үйлчилгээний хүрээнд “АХА” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн, “ХЭН САЙН ҮГ БҮТЭЭХ ВЭ?” ” хөгжөөнт тэмцээн зэргийн тус тус зохион байгуулж, 165 хүүхдийг хамруулсан.
 - ✓ Хүүхдийн эрхийн хамгаалах өдрийг тохиолдуулан Улс орны ирээдүй болсон хүүхэд багачуудын дотоод ертөнц, хүсэл мөрөөдлийг тэдний нүдээр харах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлэх, авьяас чадварийг нээх, урамшуулан дэмжих зорилгоор 3-10 насны хүүхэд багачуудын дунд 3 насны ангилалаар “Цардмал талбайн зургийн уралдаан” зохион байгуулж, нийт 60 гаруй хүүхдийг хамруулан шагнаж урамшууллаа.
 - ✓ Уран жиргээ” аймгийн аварга шалгаруулах уралдаан зэргийн зохион байгуулж, 60 хүүхдийг хамруулсан.
 - ✓ “Уншихад урам хайрла” видео контент 3 удаа бэлтгэж, ХНО пейжид байршуулж, 2601 хэрэглэгчдэд хүргэсэн.
 - ✓ Олон улсын ном бэлэглэх өдрийг тохиолдуулан эртэч, байнгын уншигч, шинээр карт нээлгэсэн болон төрөлжсөн танхимаар үйлчлүүлсэн 31 уншигч хүүхдүүдэд ном бэлэглэсэн.
 - ✓ ОИЦ сургуулийн бага ангийг заах аргын нэгдэлтэй хамтран тус сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Уран жиргээ” уран уншлагын уралдаан зохион байгуулсан. Уралдаанд нийт 35 хүүхэд оролцож, авьяас чадвараа сорьсон
 - ✓ “Номтой өдөр” нүүдлийн номын сангийн үйлчилгээний хүрээнд 9-р сургуулийн 6-9, 10-12-р ангийн сурагчдын дунд “ 60 хором” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, нийт 52 хүүхдийг хамруулсан.
 - ✓ Номтой өдөр арга хэмжээний хүрээнд ОИЦ сургуулийн бага ангийн 28 сурагчдын дунд “Уншсан номын баатрууд” сэдвээр танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулсан
 - ✓

- ✓ Хүүхэд багачууд, иргэд, олон нийтэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, өөрийн үндэсний түүх, соёл уламжлалыг сурталчлан таниулах “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгт “Өв соёл мэдье”, “Угийн бичиг”, “Шагайн наадгай”, “Уламжлалт тоглоом наадгай” зэрэг боловсролын хөтөлбөрөөр 3 өдөр оролцож, нийт 150 гаруй хүүхдийг хамруулсан.
- Дархан хотын 63 жилийн ойн хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” эсээ болон видео бичлэгийн уралдааныг Аймгийн Соёл урлаг аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран зохион байгуулсан. Үүнд:
 - ✓ “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” эсээ бичлэгийн уралдаанд 120 гаруй хүүхэд,
 - ✓ “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” видео контентийн уралдаан 4 сургуулийн 4 багийн 4 бичлэг тус оролцсон
- Ахлах ангийн сурагчид, ЭЕШ-д бэлтгэгчид, баг хамт олон болон насанд хүрэгчдэд зориулан Book & coffee танхимын цагийн хуваарийг 4 цагаар уртасгаж, Даваа- Ням гарагт 09.00-20.00 цагийн хооронд ажиллаж байна. Тус танхимд 2024 оны 10-р сарын 30-ны байдлаар 371 уншигч бүртгүүлж, 2141 ирэгсдэд үйлчилсэн.
- Цахимаар зохион байгуулах арга хэмжээ, хурал, зөвлөгөөн, сургалтуудыг тусгай программ /zoom, google meet г.м/ ашиглан зохион оролцох чадварт суралцаж:
 - ✓ Соёлын яам, Үндэсний номын сан зэрэг удирдах дээд байгууллагаас цахимаар зохион байгуулсан 5 удаагийн арга хэмжээ, хурал зөвлөгөөн, сургалтуудад захирал, нягтлан бодлогч, нярав, 9 номын санч- мэдээллийн ажилтнууд тусгай программ ашиглан оролцсон.
 - ✓ Удирдагын Академинаас ТАХ-д зориулсан “Хүний эрх”, “Ёс зүй”, “Авилгаас ангид төрийн алба”, “Монгол бичиг” зэрэг багц цахим сургалтад 5 номын санч- мэдээллийн ажилтнууд бие даан суралцсан.
 - ✓ Оюуны өмч, зохиолчийн эрх, ёс зүн зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим сургалтад 4 албан хаагч тус тус хамрагдсан
- “Цахим ур чадвар олгох” сургалтыг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж,
 - ✓ 5 насанд хүрэгч, ахлах ангийн сурагч-7, дунд ангийн-16, нийт 28 уншигчдад 2-5 удаагийн компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах анхан шатны ганцаарчилсан сургалт зохион байгуулсан.
 - ✓ “Team room” танхимд уншигч, хүүхэд багачуудыг бие даан компьютерийн чадвараа дээшлүүлэх боломжоор хангаж, 3 компьютерийг байнгын ашиглалтад ажиллуулж, 158 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн.
 - ✓ Программист Т.Сумандадар “Интернет орчноос мэдээлэл цуглуулах арга”, “canva программ ашиглан постер бэлтгэх арга” сэдвээр нийт албан хаагчдад сургалт 2 удаа тус тус зохион байгуулсан.
 - ✓ Гар утасны зохистой хэрэглээ, Цахим аюулгүй байдал, Дэлгэцийн донтолтоос сэргийлье, Цахим сүлжээний зохистой хэрэглээг бий болгоё зэрэг зурагт постер бэлтгэж пейж хуудсандаа байршуулж 1562 хэрэглэгчд хүргэсэн.
 - ✓ Салбар номын сангийн уншигчдад Гар утасны зохистой хэрэглээ, Цахим сүлжээн дэх хаягуудынхаа нууцлал хэрхэн хийх вэ сэдвээр

богино хэмжээний сургалтыг 3 удаа зохион байгуулж, 26 хүүхдийг хамруулсан.

- ✓ Номын сангийн сүлжээний инженер, программист Т.Сумандадар “American corner”-ын харьяа “Interact club”-тэй хамтран клубын ментороор ажиллаж 7 хоног бүрийн уулзалт, хурал зөвлөгөөнүүдийг зохион байгуулах үйл ажиллагаанд туслаж, компьютерийн анхан, дунд шатны мэдлэг олгох, олж авсан мэдлэгээ бататгах үйл ажиллагааг дэмжин туслаж, удирдан чиглүүлж ажиллаж байна.
- Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордны 2024 оны Авилга, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж мөрдөж ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд 23 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Авилгын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал илрээгүй.
- “Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөр болон бусад үйл ажиллагааны хүрээнд сар бүр хуваарийн дагуу цас мөс цэвэрлэх, орчны хог хаягдал зайлуулах /12 удаа/, Нийтийн эзэмшлийн хуваарьт талбайг цэвэрлэх /4 удаа/, Байгууллагын хашаан доторх зэрлэг ургамлыг түүж, зайлуулах / 4 удаа / тус тус гүйцэтгэж, тайлан мэдээг багийн даргад хүргүүлж ажилласан.
- Тэр бум мод хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын хашаан доторх мод бут, сөөгийг тэгшилж тайрч, арчилгаа хийх, модны үр түүх, цэцгийн мандалд үр тарих зэрэг арга хэмжээг зохион байгуулж, “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д “Зохиолчдын төгөл”-д тарьсан модны усалгаа, арилгааг тогтмол хийсэн.
- Ажилтан албан хаагчдыг биеийн тамираар хичээллэх боломжийг олгож:
 - ✓ “Цасны баяр” арга хэмжээг 1-р сард амралтын өдрүүдээр зохион байгуулж, 3 төрлийн уралдаан тэмцээнд нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.
 - ✓ Зааланд 12 удаа гар бөмбөгөөр хичээллэсэн.
 - ✓ 1 албан хаагч хөл бөмбөгийн спортоор тогтмол хичээллэж байна.
 - ✓ Нэг албан хаагч хүүхдийн болон насанд хүрэгчдийн хөлбөмбөгийн уралдаан тэмцээний шүүгчээр ажиллаж боломжийг хангасан.
 - ✓ Соёлын байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулагдсан 4 төрөлт тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцсон.
 - ✓ 1 албан хаагч “Спортын мастер” цол авсан.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД

3.1. Үндсэн үйлчилгээ: /Уншлагын танхим, салбар номын сан, Төрөлжсөн танхимаар/ 11-р сарын 25-ны байдлаар:

3.1.1. Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Монгол хэлний тухай хуулийг мөрдлөгө болгон MNS 5742:2019 Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага стандартын хэрэгжилтийг хангаж Номын сангийн үндсэн үйлчилгээг аймгийн хэмжээнд хүүхэд багачууд, оюутан залуус, насанд хүргэгчдэд номын сангийн уншлага үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг өрнүүлэн тэлэх, бие дааж сурч боловсрох, хөгжихөд нь үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2019 стандарт /F хавсралт/-ын “Номын сангийн үйлчилгээний хүрээ,

мэргэжлийн албан тушаал, орон тооны жишиг"-ын Аймаг болон УБ хотын дүүргийн нийтийн номын сангийн жишгээр үндсэн үйлчилгээ буюу уншигч, ирц, ном олголтыг бодитой төлөвлөдөг. Үүнд:


- ✓ Уншигч-3800
- ✓ Ирэгсэд-55522
- ✓ Ном олголт-65244

2024 онд /оны эхний 11 сарын байдлаар/ Хүүхдийн номын ордны хэмжээнд:

- ✓ Уншигч 4617 (Уншлагын танхим + салбар номын сан)
- ✓ Ирэгсэд 55522 (Уншлагын танхим + Салбар номын сан + Төрөлжсөн танхим)
- ✓ Ном олголт 65244 ном олгож үйлчилсэн (Уншлагын танхим + Салбар н/сан + Төрөлжсөн танхим)

Стандартын хэрэгжилт:

- ✓ Уншигч 121,5%
- ✓ Ирэгсэд 146%
- ✓ Ном олголт 118%



3.1.2. Төрөлжсөн танхимын үйлчилгээ:

Төрөлжсөн /Англи хэл, Монгол хэл, бичиг-уран зохиол, Математик, Team room, Book & Coffee/ 5 танхимаар дамжуулан хүүхэд багачуудад номтой нөхөрлөх, бие даан сурч боловсрох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, мэдээ мэдээллээр хангах, ЭЕШ болон бусад уралдаан тэмцээнд бэлтгэхэд зөвлөн туслах, хоцрогдол арилгах зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар /11-р сарын 25-ны байдлаар/ дээрх танхимуудад давхардсан тоогоор 2680 хүүхэд үйлчлүүлж, 19658 ирэгсдэд, 21022 ном хэвлэл болон хоцрогдол арилгах, бие даан суралцах, давтлага өгөх чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн.

“Од” сургуулийн гадаад хэлний заах аргын нэгдлээс англи хэл анхлан суралцагч 5-р ангиудын дунд зохион байгуулсан "Fun English" тэмцээнд манай ордны англи хэлний уншлага үйлчилгээний танхимаар үйлчлүүлэгч 51 ангийн хамт олон маань тэргүүлсэн.

3.2. Нэмэлт үйлчилгээний талаар: /гэрээр ном олгох үйлчилгээ, зөөврийн номын сангийн үйлчилгээ, нүүдлийн номын сангийн үйлчилгээ/ **Нийт 4 ажил үйлчилгээний хүрээнд 8080 ирэгсдэд, 13928 боть ном олгож үйлчилсэн. Үүнд:**

3.2.1. Гэрээр ном олгох үйлчилгээ: 436 уншигчдад, 1972 боть ном олгож үйлчилсэн.

3.2.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: СӨББ / 5, 7-р цэцэрлэг/ болон ЕБС-ийн /Од, ОИЦ, Цайхун, Монгол Оюу/ бага, дунд ангид нийт 68 удаа очиж, 2380 сурагчдад, 2785 боть ном хүргэж үйлчилсэн.

3.2.3. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ: Алслагдсан сургуулийн хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг хүргэх, номтой нөхөрлүүлэх, ном унших чиг хандлагад төлөвшүүлэх зорилгоор “Номтой өдөр” нүүдлийн номын сангийн үйлчилгээг **10** удаа зохион байгуулж, 326 уншигч бүртгэж, **4889** ирэгсдэд, 8771 ном олгож үйлчилсэн байна. Үүнд:

- 12-р сургуульд 2-р сарын 6, 3-р сарын 19
- 4-р сургуульд 2-р сарын 21, 22
- 1-р сургуульд 3-р сарын 5, 6
- 9-р сургуульд 3-р сарын 12-13
- 15-р сургуульд 3-р сарын 20-21
- 16-р сургуульд 3-р сарын 28,29
- ОИЦ сургуульд 4-р сарын 10-нд
- Элит-22-р сургуульд 5-р сарын 08,09
- Зулзагын голын хүүхдийн зуслан 07-р сарын 17
- Од цогцолбор 11-р сарын 15-нд тус тус ажиллаж:
 - ✓ Шинэ номын үзэсгэлэн гаргах /тус бүр 208-301 боть номоор/
 - ✓ Гэрээр ном олгох
 - ✓ Номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд **“Угийн бичиг хэрхэн хөтлөх вэ”** сургалт зохион байгуулах;
 - ✓ Бага ангийн сурагчдад чанга уншлага, номын тойм яриа хийх;
 - ✓ Ангиудад уншлага удирдаж ном унших арга зүйд төлөвшүүлэх, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар заавар зөвлөмж өгөх
 - ✓ Танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг явууллаа.

3.2.4. Хүүхэд багачуудын зуны амралтыг тохиолдуулан Нийт 3 төрлийн уншлага арга хэмжээг 11 өдөр зохион байгуулж, 375 уншигчдийг хамруулан 400 гаруй боть номоор үйлчилгээ үзүүлсэн.

- **Өдрийн Уншлага:** 2024.08.19-21 “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд 3 өдөр 61ш боть номоор 15 минутын уншлага зохион байгуулж, мөн Боловсрол хөтөлбөрийн хүрээнд Монголын үндэсний тоглоом наадгайн төрөл оньсон тоглоом, эв долоо, эвлүүлэх тоглоомуудыг сурталчилан таниулах арга хэмжээ зохион байгуулан 60 гаруй хүүхэд багачууд, эцэг эх, эмээ өвөө оролцож, мэдээлэл авсан,
- **Үдийн уншлага:** “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д 4 өдөр уншлага зохион байгуулж, нийт 145 хүүхэд, эцэг эхийг хамруулан 168 номоор үйлчилгээ үзүүлсэн.
- **Үдшийн уншлага:** “Дархан 50” цогцолбор дээр 17-21 цагийн хооронд “Үдшийн уншлага” арга хэмжээг 4 өдөр уншлага зохион байгуулж, нийт 219 хүүхэд, эцэг эхийг хамруулан 170 төрлийн номоор үйлчилгээ үзүүлж байна. Үйл ажиллагааны хүрээнд:
 - ✓ Хуучин номын худалдаа
 - ✓ Шинэ номын үзэсгэлэн

- ✓ Уншигчийн карт хөнгөлөлттэй нээх
- ✓ Уншлага үйлчилгээ зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

3.3. Цахим уншлага үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, уран бүтээлчийн зөвшөөрлөөр уран бүтээлийг цахим хэлбэрт хувиргах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:

- 1-р сард: Л.Цэрэн-Очир “Баатар цэрэг”
- 2-р сард: Ц.Дамдинсүрэн “Аман өгүүллэг”
- 3-р сард: Жанни Родани “100 лиртэй болсон нь” Итали үлгэр
- 4-р сард: С.Надмид “Атармаа, түүний аав,ээж, төрийн сүлд дөрвийн тухай” өгүүллэг
- 5-р сард: Х. Сампилдэндэв Ноён хутагт Д.Равжаагийн домноос цуврал-1
- 6-р сард: Х. Сампилдэндэв Ноён хутагт Д.Равжаагийн домноос цуврал-2
- 7-р сард: Ц.Дамдинсүрэн “Гэрийн ерөөл”
- 8-р сард: Д.Дорж “Бяцхан нөхөд” Номоос Авгындаа зочлов.
- 9-р сард: Д.Дорж “Бяцхан нөхөд” Номоос Томоогүй хургачин
- 10-р сард: Д.Сүрьяа “Бадарчингийн инээдэмт паян”
- 11-р сард: С.Буяннэмэх “Тайлбарлахыг эрсэн шүлэг”
- 12-р сард С.Буяннэмэх уран бүтээлээс нийт 12 бүтээлийг цахим орчинд байршуулж, 9114 цахим уншигч, хэрэглэгчдэд хүргэсэн.

3.4. Лавлагаа, мэдээллийн талаар:

- ✓ Амаар-583
 - ✓ Бичгээр-93
 - ✓ Утсаар-122
 - ✓ Пэйж хуудсаны зурвасаар-465
- Нийт 1263 лавлагааг давхардсан тоогоор 1263 уншигч, хэрэглэгчдэд өгсөн.**

3.5. Ном унших арга зүйд төлөвшүүдэх арга хэмжээний хүрээнд: Нийт 5 арга хэмжээг 45 гаруй удаагийн зохион байгуулж, 5425 уншигч, хүүхэлд багачуулыг хамруулсан. Үүнд:

3.5.1. Номын үзэсгэлэн: Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 30 удаа гаргаж, 4500 гаруй уншигч хэрэглэгчдэд, цахим үзэсгэлэнг шинэ болон сэдэвчилсэн номоор 15 удаа 485 боть номоор тус тус гаргаж, 8500 гаруй пейж хуудасны дагагчиддаа хүргэсэн. Үүнд:

Биет хэлбэрээр:

- ✓ Шинэ номын үзэсгэлэн 13 удаа 268 боть ном
- ✓ Сэдэвчилсэн-17 удаа 330 боть ном,

Цахим үзэсгэлэн:

- ✓ Шинэ номын цахим үзэсгэлэн 6 удаа 205 боть номоор гаргасан
- ✓ Сэдэвчилсэн цахим үзэсгэлэнг 9 удаа 280 боть номоор гаргасан

3.5.2. Чанга уншлага: Бага насны хүүхдүүдийг номд дуртай болгох, анхаарал төвлөрөх, сонсох чадварыг хөгжүүлэх, сонссон зүйлээ ойлгож, дүн шинжилгээ хийн үгээр илэрхийлэх арга барилд сургах, шинэ ном сурталчлах зорилгоор “Чанга уншлага” арга хэмжээг тогтмол зохион байгуулж нийт 15 удаа, 1588 бяцхан уншигчыг хамруулсан. Үүнд:

- ✓ 8 сургуулийн 1007 хүүхэд
- ✓ 3 цэцэрлэгийн 19 бүлэг 416 бяцхан багачууд
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй 120 хүүхдүүдэд 2 удаа;

- ✓ Төрөлжсөн танхимаар үйлчлүүлэгч 45 уншигчдад 2 удаа “Мини театр”, “Хормогчин үлгэр”, зурагт том ном болон үлгэрийн номоор уншлага зохион байгуулсан.
- ✓ Уншлагын танхимаар анги хамт олноороо хүрэлцэн ирж үйлчлүүлж буй шинэ уншигчдад шинэ номын тойм яриаг тогтмол хийж, 6 ангийн 210 гаруй хүүхдэд хамрагдсан

Мөн ХНО-той танилцах аялалаар ирсэн болон төрөлжсөн танхимуудаар үйлчлүүлэгч 1-р ангийн болон цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 116 хүүхдүүдэд:

- ✓ “Заан огтоно хоёр”, “Арслан хулгана хоёр”, “Ухаант туулай”, “Гурван тоорой” зэрэг үлгэрүүдээр,
- ✓ О. Сундуйн “Тэнгэрт өлгөөтэй бяслаг” номоос,
- ✓ Сургамжит өгүүллэг номоос “Хүчээр биш ухаанаар” өгүүллэгээр,
- ✓ Сургамжит өгүүллэг-6 номоос,
- ✓ “Ухаант туулай” хормогчин үлгэр болон танин мэдэхүйн бусад номоос чанга уншлага зохион байгуулсан.

3.5.3. Хуваарьт уншлагын цаг: Од цогцолбор сургуулийн 72, 67, 52, 510, 43, 45, 48, 49 ангийн 285, Цайхун сургуулийн 56 ангийн 28, нийт 2 сургуулийн 9 ангийн 313 хүүхэд хуваарьт өдрүүддээ хүрэлцэн ирж, 519 боть номоор үйлчлүүлж, номын тэмдэглэл хөтөлсөн. Үүний үр дүнд хүүхэд багачуудыг ном санд суух дадал хэвшлийг бий болгосон.

3.5.4. Зохиолч уншигчдийн уулзалт: 9 удаа зохион байгуулж, 3410 уншигч, хүүхэд багачуудыг хамруулсан. Үүнд:

1. “Номтой өдөр” арга хэмжээний хүрээнд 1-р сургуулийн дунд ангийн сурагчдад ХНО-ны захирал, яруу найрагч Л.Мөнхбаатартай “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгуулж, мөн ном унших чиг хандлагад төлөвшүүлэх чиглэлээр “Уншихад урам хайрла” сэдэвт лекц зохион байгуулж, уран бүтээлийн үзэсгэлэнг гаргаж, нийт 56 хүүхэд хамрагдсан.
2. Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төвтэй хамтран “Зохиолч уншигчдын уулзалт” арга хэмжээг 2024 оны 03-р сарын 14-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтад ХНО-ны захирал, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Л.Мөнхбаатар оролцож, уран бүтээлийн талаар товч танилцуулга хийж, уншлага зохион байгуулан мөн “Эх хэлээ хэн сайн мэдэх вэ” асуулт хариултын тэмцээн, “Хөдөлгөөн- эрүүл мэнд” шугаман бүжиг заах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж нийт 28 өндөр настан, 5 албан хаагч хамрагдсан.
3. Дэлхийн номын өдрийг угтаж Хүүхэд багачуудыг ном унших чиг хандлагад төлөвшүүлэх, амьдралын зорилгоо тодорхойлох, мөрөөдлөө биелүүлэх, өөрийгөө олж авах сэдлийг төрүүлэх зорилгоор “Зохиолч-Уншигчдын уулзалт” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 121 хүүхэд хамрагдсан. Үүнд:
 - Уулзалтад Хүүхдийн номын ордны захирал, МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Л. Мөнхбаатар, Од цогцолбор сургуулийн Б. Дэлгэрцэцэг багштай 9д ангийн 43 сурагчид, мөн оролцож, ном унших үр дүнтэй арга, хэрхэн яаж унших талаар зөвлөгөө өгч, шүлэг зохиол бичих талаар ярилцлаа. Уулзалтын үеэр “Уншихад урам хайрла” лекц хүргэж, үгийн утга зөв тайлсан эхний 3 сурагчдад номынхоо дээжээс бэлэглэсэн.

- 2024.04.15 Хонгор сумын Соёлын төвтэй хамтран Зохиолч-Уншигчдын уулзалт зохион байгуулсан. Уулзалтад Хүүхдийн номын ордны захирал, МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Л. Мөнхбаатар, Хонгор сумын ЕБ-ийн сургуулийн ахлах ангийн 78 сурагч оролцсон. Уулзалтын үеэр хүүхэд багачуудад “Уншихад урам хайрла” лекц хүргэж, сонирхсон асуултад хариулт өгч, зохиол бүтээлийн тухай ярилцсан. Мөн номын үзэсгэлэн гаргах, уншлага зохион байгуулах, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 4. Үндэсний номын баярын хүрээнд – 5 удаа /“Зохиолчийн номтой өдөр” арга хэмжээний хүрээнд Соёлын Гавьяат зүтгэлтэн, Зохиолч Б.Шүүдэрцэцэг, МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Э.Амарзаяа, Сэтгэл зүйч, сэтгэл судлаач, сэтгэл заслын докторант Д.Мөнхцэцэг Од, 16, 15, ОИ, 9-р сургуулиудад уулзалт ярилцлагуудыг зохион байгуулж, 3200 гаруй уншигчдийг хамруулсан./

3.5.5. “Номтой аялал” арга хэмжээний хүрээнд: Уншигч хүүхэд багачуудын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолыг үндэслэн тусгай аялал жуулчлалын төрлийг бий болгож хөгжүүлэх, ном унших чиг хандлагад төлөвшүүлэх, уншсан мэдсэнээ амьдрал дээр турших, хэрэгжүүлэх, бодит байдалтай харьцуулах, дурсамжтай, үр өгөөжтэй, сонирхолтой хэлбэрээр ном унших боломжийг олгох зорилгоор “Номтой аялал” арга хэмжээг нийт **5 удаа зохион байгуулж**, нийт **114** хүүхдийг хамруулсан. Үүнд:

- ✓ **2024.02 сар:** Цайхун сургуулийн Д.Мягмарсүрэн багштай 6-а ангийн 30 сурагч Хүүхдийн номын ордонтой танилцаж, "Хэрэмнээс авсан сургамж" өгүүллэгээр хэлэлцүүлэг хийсэн.
- ✓ **2024.04 сар:** “Номтой аялал” хөтөлбөрт Англи хэлний уншлага үйлчилгээний танхимаар үйлчлүүлэгч, Од сургуулийн Д.Энхтунгалаг багштай 5-6 ангийн 38 сурагчид хамрагдсан. Аялалын хүрээнд Аймгийн музейтэй танилцангаа "Мандала" боловсролын хөтөлбөрт хамрагдаж, хэлбэр дүрс, өнгө будгийн талаарх ойлголт, сэтгэн бодох чадвар, орон зайн төсөөллөө хөгжүүлэх зэрэг олон сонирхолтой мэдээлэл авч, дадлага ажил хийсэн.
- ✓ **2024.05 сар:** Од цогцолбор сургуулийн 5-1 ангийн хамт олон оролцсон “Номтой аялал” арга хэмжээг “Миний монгол” цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж 15 хүүхэд хамрагдсан.
- ✓ **2024.06 сар:** "Номтой аялал" хөтөлбөрт “Цайхун” сургуулийн Хятад хэлний Б.Батцэцэг багштай 8¹¹ ангийн 11 хүүхдүүд оролцож, өсвөр насныхны сэтгэлзүйн чиглэлээр уншлага зохион байгуулж, уншсан номын талаар хэлэлцүүлэг хийн мөн өсвөр үеийн сэтгэл зүйн талаар чөлөөт ярилцлага зохион байгуулсан.
- ✓ **12-р сарын “Номтой аялал”** хөтөлбөрт ШУТИС-ийн харьяа Дархан-Уул аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль -ийн 10-12-р ангийн 20 хүүхдүүдийг хамруулан “Science Café Darkhan”-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хүүхэд бүр шинжлэх ухааныг нүдээр үзэж, гараар барьж, Цахилгааны өртөө, Биологийн өртөө, Химийн өртөө, Соронзон орны өртөө бүхий 4 өртөөнд зочилж 40 төрлийн туршилт, шинжлэх ухааны номуудаар уншлага хийж, туршилт хийсэн сэтгэгдэлээ хуваалцаж ярилцсан.

3.6. Номын сангаас зохион байгуулах СОНА-ын талаар: Нийт 13 арга хэмжээг зохион байгуулж, 2239 уншигчдыг хамруулсан. Үүнд:

3.6.1. Дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан Үүнд:

- ❖ Салбар номын сангаас 12-р сургуулийн Л. Баяржаргал багштай 2А ангийн сурагчдад Монгол улсын төрийн шагналт соёлын гавьяат зүтгэлтэн хүүхдийн зохиолч Жамбын Дашдондогийн товч намтар уран бүтээлээс нь танилцуулж харилцан ярилцаж, “Өвдөгцөө ус” номоор уншлага зохион байгуулж, мөн “Өвдөгцөө ус” шүлгээр нь зурагт ном бүтээсэн. **/25 сурагч/**
- ❖ Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан оюуны спортоор хичээллэх, сэтгэн бодох чадвараа хөгжүүлэх зорилгоор ЕБС-ийн бага, дунд ангийн **81** сурагчдын дунд “Монгол тоглоом наадгай” боловсролын хөтөлбөрийг 3 удаа зохион байгуулж ажиллалаа.
- ❖ Андерсений бүтээлийг хүүхэд багачуудад сурталчлан таниулах зорилгоор зохиол бүтээлээс унших уншлага зохион байгуулж нийт **28** хүүхэд хамрагдсан.
- ❖ Дэлхийн хүүхдийн номын өдөрт зориулан Х.Х.Андерсений намтар, уран бүтээл, үлгэрийн дээжээс сэдэвчилсэн номын үзэсгэлэнг биет болон цахим хэлбэрээр гаргаж, 524 хэрэглэгчдэд хүргэсэн.
- ❖ Пейж хуудсандаа 7 мэдээлэл бэлтгэн байршуулж, 2109 хэрэглэгчдэд хүргэсэн

3.6.2. Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан:

- ✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг цахим болон шилэн хоргонд 52 боть номоор гаргасан.
- ✓ Монгол-Оюу сургуулийн 5а ангийн сурагчид, багш эцэг эхчүүтэй хамтран “Номч гэр бүл” **/25 сурагч/**
- ✓ Албан хаагчдын дунд “Бид нэг гэр бүл” өдөрлөг тус тус зохион байгуулсан.

3.6.3. Хүүхдийн эрхийн хамгаалах өдрийг тохиолдуулан

Улс орны ирээдүй болсон хүүхэд багачуудын дотоод ертөнц, хүсэл мөрөөдлийг тэдний нүдээр харах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлэх, авьяас чадварийг нээх, урамшуулан дэмжих зорилгоор 3-10 насны хүүхэд багачуудын дунд 3 насны ангилалаар “Цардмал талбайн зургийн уралдаан” зохион байгуулж, нийт 60 гаруй хүүхдийг хамруулан шагнаж урамшууллаа.

3.6.4. “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан анги-9, Сурагч-3 байна.

- Цайхун сургуулийн 2а, 6а,
- Од сургуулийн 34,
- 9-р сургуулийн 5б,
- ОИЦ сургуулийн 54,
- 15-р сургуулийн 5в,
- 16-р сургуулийн 5в анги
- Од сургуулийн 5-3 анги
- Од сургуулийн 5-6 ангийн сурагч Батмөнхийн Бямбабаяр

- 1-р сургуулийн 116-Х.Номин-Эрдэнэ
 - ОИ Сургуулийн 5-1 ангийн сурагч Х.Хангал
- Мөн Үндэсний бичиг соёл-номын өдөр-2024” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын их хурлын дарга Гомбожавын Занданшатарын санаачлагаар жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Номын сайн нөхөр” уралдааны “Шилдэг уншигч- Анги хамт олон төрөлд ХНО-оор 4 жил дараалан үйлчлүүлж буй Идэвхтэн уншигч, Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэгтэн “Од” сургуулийн Э.Мягмаржаргал багштай 5-10 анги /37 хүүхэд/ шалгарч Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй 35 дахь удаагийн “Номын баяр”-ын тайзнаа УИХ-ын дарга Г. Занданшатараас шагналаа гардан авсан.

3.6.5. Дархан хотын 63 жилийн ойн хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” эсээ болон видео бичлэгийн уралдааныг Аймгийн Соёл урлаг аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран зохион байгуулсан. Үүнд:

- “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” эсээ ЭСЭЭ бичлэгт нийт 120 гаруй эсээ ирсэнээс:
 - ✓ Тэргүүн байр-Цайхун сургуулийн 10а ангийн сурагч Г.Индра
 - ✓ Дэд байр-Оюуны Ирээдүй сургуулийн 11-9 ангийн сурагч У.Маргад
 - ✓ Гутгаар байр- Оюуны Ирээдүй сургуулийн 11-1 ангийн сурагч Б.Сарнайцэцэг
 - ✓ Тусгай байр- 31-р сургуулийн 10-Б ангийн сурагч Ч.Тэлмүүн
 - ✓ Тусгай байр- Оюуны Ирээдүй сургуулийн 10-2 ангийн сурагч Т.Анужин
- “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” Видео бичлэгт
 - ✓ Шилдэг бичлэгээр Од сургуулийн 9-6 анги,
 - ✓ 4-р сургуулийн 116 ангийн баг хамт олон шалгарсан.
 - ✓

3.6.6. “Гал өд” яруу найргийн наадам: Дархан хотын 63 жил, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбар байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд яруу найргийн “Гал-Өд” наадмыг МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбартай хамтран 3 шаттайгаар зохион байгуулсан. Наадмын 1-р шатны шалгаруулалт цахимаар зохион байгуулагдсан бол 2,3-р шатны шалгаруулалт 2024 оны 10-р сарын 14-нд Залуучууд театрт зохион байгуулагдаж 21 аймгаас шалгарсан 20 яруу найрагч шүлгээ уншиж өрсөлдсөн.

Наадмын

- Тэргүүн байранд МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Л.Мөнхбаатар "Соёо толгой" шүлгээр,
- Дэд байранд Говь-Алтай аймгийн МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Ганхүрэл
- Гутгаар байранд Говь-Алтай аймгийн МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Г.Сүхбаатар
- Тусгай байранд Архангай аймгийн МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч М.Амархүү
- Тусгай байранд Орхон аймгийн МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Н.Болормаа нар тус тус шалгарч шагналын эзэд болов.
- Мөн МЗЭ-ийн Дархан дахь Салбарын нэрэмжит шагналаар Булган аймгийн МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Н.Үржинбадам шагнуулсан.

Наадмын үеэр:

- Дархан нутгийн үе үеийн зохиолчдын намтар, уран бүтээл
- "ГАЛ ӨД" наадмын цуврал бүтээл 2004-2024 он
- Зохиолчдын гар бичмэлээр үзэсгэлэн гаргаж, уншигч иргэддээ толилуулсан.

Тус арга хэмжээнд нийт 250 гаруй зохиолч яруу найрагч, уран бүтээлчид болон уншигч, сонирхогчид оролцсон.

3.6.7. Бийрийн бичгийн үзэсгэлэн: "Цогт хунтайжийн хадны бичээс"-ийн 400 жилийн ойг тохиолдуулан манай ХНО-оос ЕБС-ийн сурагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах, бийрийн бичлэгийг сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, бийрийн эрдмийн гайхамшгийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор VI-IX ангийн сурагчдын дунд бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулсан."Соёлын бүтээлч сар"-ын аяны хүрээнд тус уралдааны шагналт байранд орсон сурагчдын бүтээлээр 11 сарын 1-30 хооронд үзэсгэлэн гаргаж хүүхэд багачуудад сурталчилж байна. 2024 оны 11-р сарын 06-ны өдрийн байдлаар тус үзэсгэлэнг 937 хүүхэд үзэж сонирхоод байна.

3.6.8. "Алтан хонх" тэмцээн: "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдрийг тохиолдуулан "**Би Монголын Нууц Товчоо**" Алтан хонх тэмцээнийг монголын нууц товчоогоос асуулт бэлтгэн ЕБС-ийн 10-р ангийн сурагчдын дунд зохион явууллаа. Нийт ЕБ-ын 6 сургуулийн 33 сурагч оролцлоо. Үүнээс:

- Тэргүүн байр З. Аминзул /15-р сургуулийн 10а/
- Дэд байр Г. Урансувд /15-р сургуулийн 10а/
- Гутгаар байр Д. Дэнсмаа /1-р сургуулийн 10б/ нар шалгарсан.

3.6.9. Мэтгэлцээний сургалт: Од цогцолбор сургуулийн мэтгэлцээний клубын дарга, түүх нийгмийн багш М.Туяа, ахлагч 10-4 ангийн сурагч Г.Хүслэн, Б.Оюунтүлхүүр нарын удирдлага дор дунд ангийн сурагчдад зориулсан мэтгэлцээний сургалт 3 өдрийн турш зохион байгуулагдаж, өнөөдөр мэтгэлцээний нээлттэй хэлэлцүүлэг хийлээ. Сургалтаар:

- Мэтгэлцээн гэж юу болох?
- Мэтгэлцээнээс ямар сайн чадвар олж авах тухай
- Нээлттэй хэлэлцүүлэг хэрхэн яаж, ямар журмаар хийх талаар мэдлэг олгосон.

Сургалтад 126 хүүхэд хамрагдсан байна.

3.6.10. "Найргийн даага" уралдаан: Хүүхэд багачуудын авьяас билиг, зохион бичих ур чадварыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах зорилгоор оны шилдэг шүлэгч шалгаруулах "Найргийн даага" яруу найргийн уралдааныг их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан 17 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулсан.

Уралдааны 1-р шатанд нийт 72 шүлэгчийн 206 бүтээл ирснээс, бүтээлд тавигдах шаардлагын дагуу 2-р шатны шалгаруулалтад 40 шүлэгчийг, 3-р шатанд 2 ангиллын 10 шүлэгчийг 5 минутын хугацаанд заасан сэдвийн дагуу шүлэг зохиох зэрэг шалгуураар өрсөлдүүлэн зохион байгуулж дүнгээ гаргасан.

Уралдааны VI-IX ангийн ангилалд:

- Тэргүүн байр: Оюуны ирээдүй сургуулийн 8-6 ангийн сурагч Т.Урансанаа

- Дэд байр: Шарын гол сумын 6-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ
 - Гутгаар байр: 18-р сургуулийн 9б ангийн сурагч Э.Гүнтэнбаатар
 - Тусгай байр: Монгол-Оюу сургуулийн 9-1 ангийн сурагч Б.Мишээл, Монгол-Оюу сургуулийн 8-2 ангийн сурагч О.Анунгоо
- Х-ХII ангийн ангилалд:
- Тэргүүн байр: 1-р сургуулийн 10б ангийн сурагч С.Дэлгэрцэцэг,
 - Дэд байр: Оюуны ирээдүй сургуулийн 11-1 ангийн сурагч Ж.Төрболд
 - Гутгаар байр: 18-р сургуулийн 10г ангийн сурагч О.Ариунзаяа,
 - Тусгай байр: 18-р сургуулийн 10г ангийн сурагч Б.Одням, 14-р сургуулийн 10б ангийн сурагч Б.Мөнхсарнай нар тус тус шалгарлаа.
- Мөн 9-р сургуулийн 12б ангийн сурагч А.Алсзаяа МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь зохиолчдын салбарын нэрэмжит шагналаар шагнуулав.
- Шүүгчээр МЗЭ-ийн шагналт яруу найрагч, “Гал өд-2024” яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт Л.Мөнхбаатар, МЗЭ-ийн шагналт, зохиолч, яруу найрагч Д.Мягмаржав нар ажиллав

3.6.11. “Дүрийн тоглолттой уншигчдын бага хурал: Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, номыг анхааралтай уншиж сургах, уншсан зүйлдээ дүгнэлт хийж эргэцүүлэн бодож сургах, зохиолын баатруудын сайн сайхан чанарыг дуурайх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн нууц мэдрэмж, авьяасаа нээх боломжийг олгох, дэмжин урамшуулах зорилгоор ЕБ-ын IX сургуультай хамтран VII ангийн сурагчид дунд “Дүрийн тоглолттой уншигчдын бага хурал” арга хэмжээг сонгогдсон сэдвийн хүрээнд зохион байгуулж, нийт 9 сургуулийн 9 багийн 108 хүүхэд оролцлоо. Арга хэмжээний:

- Тэрүүн байранд: ОИ сургуулийн 7-8 ангийн “Эхийн сэтгэл” өгүүллэг,
- Дэд байранд: 18-р сургуулийн 7а,в-гийн хамтарсан багийн ““Хоёр аяга ус” өгүүллэг,
- Гурав дугаар байранд: 12-р сургууль 7а ангийн “Сэтгэлийн амар амгалан” өгүүллэг,
- Тусгай байранд: 4-р сургууль 7г ангийн “Үнэ цэнэ” өгүүллэг, 12-р сургууль 7а ангийн сурагч С.Эрдэнэ-Очир ганцаарчилсан “Хааны цагаан хүлэг” өгүүллэгүүд тус тус шалгарсан

3.6.12. “Уран жиргээ” наадам: Хүүхэд багачуудын авьяас билиг, ур чадварыг дэмжих, ой тогтоолт, уран сайхны сэтгэлгээг нээж, эх хэлээрээ уран яруу тод унших чадварыг хөгжүүлэх, урамшуулах зорилгоор сургуулийн өмнөх нас /цэцэрлэг/, сургуулийн бага нас /1-5 анги/, сургуулийн дунд нас /6-9 анги/, сургуулийн ахлах нас /10-12 анги/ гэсэн 4 насны ангилалаар “Уран жиргээ” уралдааныг зохион байгуулж, нийт 50 гаруй хүүхэд авьяасаа сорьж, 16 хүүхэд шагналт байранд орсон. Ангилал тус бүрийн Тэргүүн байрт шалгарсан хүүхэд Улсын Уран жиргээ уралдаанд Дархан-Уул аймгаа төлөөлөн оролцох юм. Үүнд:

Сургуулийн өмнөх нас:

- Тэргүүн байр: 18 дугаар цэцэрлэг-Ахлах Б бүлэг - П.Зүрхи
- Дэд байр: 12 дугаар цэцэрлэг - Бэлтгэл Б бүлэг - Ц.Мөнх-Ирээдүй
- Гутгаар байр: 3 дугаар цэцэрлэг - Бэлтгэл Б бүлэг - Д.Анхзаяа
- Тусгай байр: 23 дугаар цэцэрлэг - Ахлах Б - Г.Солонгорох

Сургуулийн бага нас:

- Тэргүүн байр: Оюуны ирээдүй сургууль 5-1 анги А.Гийгүүлэн
- Дэд байр: 18 дугаар сургууль 5Д анги Б.Ану-Үжин
- Гутгаар байр: 16 дугаар сургууль 5В анги Б.Аминаа
- Тусгай байр: Од сургуулийн 3-2 анги З.Оюун

Сургуулийн дунд нас:

- Тэргүүн байр:Оюуны ирээдүй сургууль 7-1анги Б.Ганди
- Дэд байр:Шинэ алхам сургууль 9А анги П.Нандин-Эрдэнэ
- Гутгаар байр:18 дугаар сургууль 9А анги С.Маралжингоо
- Тусгай байр:Тусгай байр:1 дүгээр сургууль 7Б анги Ц.Билгүүн

Сургуулийн ахлах нас:

- Тэргүүн байр:Союз сургууль 10А анги С.Санчирмаа
- Дэд байр:18 дугаар сургууль 11Б анги Г.Ганцэцэг
- Гутгаар байр:16 дугаар сургууль 12В анги Ж.Тэмүүжин
- Тусгай байр:9 дүгээр сургууль 12Б анги А.Алсзаяа нар тус тус шалгарлаа.

3.7. Сан хөмрөгийн талаар:

- ✓ Ажил хүлээлцэх тооллого 1 удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тооллогоор урагдаж гэмтсэн номын сэлбэн засварлах арга хэмжээ авсан. Дутагдсан ном байхгүй.
- ✓ Жилийн эцсийн сан хөмрөгийн тооллого 1 удаа тус тус зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тооллогоор урагдаж гэмтсэн 59 номын сэлбэн засварлаж, ойрын сан хөмрөгийн номыг ариутгах арга хэмжээ авсан. Дутагдсан ном байхгүй.
- ✓ 1 удаагийн хандив, 16 удаагийн худалдан авалтаар нийт 15,164,038 төгрөгийн 318 нэрийн 740 боть номоор тус тус сан хөмрөгөө баяжуулсан.
- ✓ Сэлбэн засалт 165 ном сэлбэн засаж, сан хөмрөгийн номын 43%-ийг ариутгаж, картжуулан уншлага үйлчилгээнд ашиглаж байна.
- ✓ Татгалзлалаар 62 ном бүртгэж, захиалга хийсэн.
- ✓ Шинэ номын мэдээ-13
- ✓ Санамж өгөх ном зүйн бүртгэл-1 /С.Мандал/
- ✓ Санамж өгөх ном зүйн цахим мэдээлэл-9 бэлтгэн пейжээрээ дамжуулан 11324 хэрэглэгчдэд хүргэсэн.

3.8. Фонд, каталогийн талаар:

- ✓ Шинээр ирсэн 318 нэрийн 740 боть номыг электрон каталогт бүртгэж, цаасан каталогийг төрөл анги, үсэг дараалал гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан.
- ✓ 9857 нэр төрлийн 15532 боть номын фондын электрон каталогийн цахим сан хөмрөгийг Үндэсний номын санд файлаар өгч GLAM, портал сайтад системүүдэд оруулах бэлтгэл ажил хийгдээд байна. Тус шилжилтийн ажилтай холбоотойгоор шинээр ирсэн номыг электрон каталогт оруулах ажил түр зогссон.
- ✓ Ахлах, дунд ангийн 150 гаруй уншигчдад цаасан болон электрон каталоги ашиглах заавар зөвлөмж өгсөн.

4. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

4.1. ХНО-ны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааны хүрээнд:

- 4.1.1. МҮОНРТ-ийн "Эргэх дөрвөн цаг" нэвтрүүлгийн 1-р сарын 14-ний өдрийн дугаарт захирал Л.Мөнхбаатар оролцож, ХНО-ны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. /Сурвалжлагч- Монголын радиогийн Дархан дахь сэтгүүлч Б.Норовсамбуу/
- 4.1.2. 5-р сарын 27-нд Улаанбаатарт НТВ-телевизд Дархан-Уул аймгийн хүүхдүүдийн ном унших чиг хандлагын талаар захирал Л. Мөнхбаатар ярилцлага өгсөн.
- 4.1.3. Ордны пейж хуудсаар дамжуулан нийт 232 мэдээлэл нийтэлж, давхардсан тоогоор 144160 хэрэглэгчдэд хүргэсэн. Үүнд:

- ХНО-ноос зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээлэл 64,
- Соёлын боловсролын хөтөлбөрийн талаарх мэдээлэл 35
- Үндэсний бичиг, соёлтой холбоотой мэдээлэл-29
- Видео контент - 3
- Хүүхэд хамгааллын чиглэлээр-21
- Хууль эрх зүйн чиглэлээр-10
- Танин мэдэхүйн мэдээлэл-22
- Эрүүл мэндийн чиглэлээр-28
- Цахим орчноос унших ном - 6,
- Бусад-14 мэдээлэл боловсруулан нийтэлж,
- Хүүхэд хамгаалал, Хууль эрх зүй, соёл урлагийн салбарын болон танин мэдэхүйн 34 мэдээллийг пейжээрээ дамжуулан түгээж ажилласан

4.2. Аж ахуйн үйл ажиллагааны талаар:

- 4.2.1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хүрээнд байгууллагын сантехникийн засвар үйлчилгээ хийх, гадна хашаа сэлбэн завварлаж өнгө сэргээх, цахилгааны утас мантажыг нягтлан шалгаж засварлах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- 4.2.2. Сар бүр болон "Хотоо цэвэрлэе-хог хаягдлыг багасгая" тохижилтын сарын аяны хүрээнд байгууллагын гадна болон хуваарьт газарт хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг 14-р багийн даргад хүргүүлж ажиллаж байна.
- 4.2.3. Шаардлагатай сантехник, цахилгаан хэрэгсэл болон эд хөрөнгийн засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэж ажиллаж байна.
- 4.2.4. Шинээр хүлээн авсан тоног төхөөрөмжүүдийг зааврын дагуу суурилуулж, зориулалтын дагуу ашиглаж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА:

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
2. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ
3. УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭ
4. СОЁЛ, ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ
5. БУСАД АЖИЛ
6. АРГА ЗҮЙН АЖИЛ

1.1 Эрхэм зорилго:

Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалж хамгаалах, ард иргэдэд ном соёлоор үйлчлэн тэдний оюуныг хөгжүүлэх, бүтээлч санаачлагыг өрнүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тав тухтай тохилог орчинг бүрдүүлэх, номын сангийн стандартыг ханган ажиллахад оршино.

1.2 Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь **1945** онд байгуулагдсан, нийт **14** хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Номын сан нь уншлагын 2 танхим, Соёмбо салбар уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фонд, хэвлэлийн фонд, гэр бүлийн уншлагын танхим зэрэг танхимуудаар үйл ажиллагаагаа явуулдаг. Нийт 484м² талбайг номын сангийн үйлчилгээнд зориулан ашиглаж байна.

[Номын сангийн албан ёсны имэйл хаяг: dq.library@yahoo.com](mailto:dq.library@yahoo.com)

[Цагийн хуваарь:](#)

[Насанд хүрэгчдийн уншлагын танхим:](#)

[Даваа-Лхагва 8⁰⁰-20⁰⁰, Пүрэв-Ням 8⁰⁰-17⁰⁰](#)

[Бусад тасаг танхим:](#)

[Даваа-Баасан 8⁰⁰-17⁰⁰](#)

[Байгууллагын утасны дугаар: 70522706](#)

[Номын сангийн захирал: Г.Баттогтох](#)

2. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2.1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар **40321ш** 142,346269 төгрөгний номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2 Сан хөмрөгийн бүрдүүлэлт

2024 оны фондын бүрдүүлэлтийг төсвийн санхүүжилтээр шинэ ном 6302600 төгрөгийн **236** ширхэг, хандив бэлгээр 899,000 төгрөгийн **113** ширхэг номоор нийтдээ 7201,600 төгрөгний **349** ширхэг номоор сан хөмрөгийн баяжилтыг хийсэн. Мөн **8** нэр төрлийн **828** ширхэг 692,740 төгрөгний хэвлэл захиалж иргэдийг өдөр тутмын мэдээ мэлээллээр ханган ажиллав.

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ /төг/
Шинээр нэмэгдсэн нийт	349	7,201,600
Шинээр нэмэгдсэн ном	Шинэ ном-236 хандив-113	Шинэ ном – 6302600 Хандив – 899,000
Шинээр нэмэгдсэн Сонин, сэтгүүл	828	692,740

Хийгдсэн ажил	Тоо хэмжээ
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	40321
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	349
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	1836

2.3 Каталог зохион байгуулалт

Номын санд шинээр ирсэн **349** ширхэг номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд тусган электрон каталогт бүрэн оруулж тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд гарган ажиллаж байна. Нийт номын сангийн хэмжээнд 40321 ширхэг номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

3. ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Уншлага үйлчилгээ:

Жилийн эцсийн байдлаар нийт 1150 уншигч, 27812 ирцэд 20762 ном хэвлэл олгож үйлчиллээ. Энэхүү тоон үзүүлэлт зөвхөн төв номын сангийн уншигч, ирц, ном олголтын тоо юм.

Үзүүлэлт	Тоо, хэмжээ
Аймгийн төвийн иргэдийн тоо	69386
Бүртгэлтэй уншигчийн тоо	1150
Номын сангийн ирц	27812
Олгосон ном	20762

Хөдөө орон нутаг болон алслагдсан айл өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өндөр настан зэрэг номын санд ирэх боломжгүй хүмүүст номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, уншигчдын хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сан болон “ТА УНШ-БИД ХҮРГЭЭ” үйлчилгээг тогтмол ажиллуулж байна.

- Зөөврийн номын үйлчилгээгээр 42 байгууллага давхардсан тоогоор 356 удаа үйлчлүүлж **1350** ирцэд 3839 ном олгож үйлчилсэн
- “ТА УНШ-БИД ХҮРГЭЭ” үйлчилгээ **765 хүнд 1108** номыг айл өрх албан байгууллагат гэрээгээр үйлчилгээг хүргэж ажилласан.



3.2 Номын үзэсгэлэн:

- Цаг үеийн болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 154 удаа дэлгэж 3936 номыг 1170 хүнд үзүүлэн фондын ном хэвлэлээ сурталчилан таниулсан.



4. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ:

"НОМ ХОЖ" танин мэдэхүйн уралдаан

Үндэсний бичиг соёл номын баярын хүрээнд ЕБС, Политехникийн коллежийн оюутан сурагчдын дунд “Ном хож” танин мэдэхүйн асуулт, хариултын уралдааныг зохион явуулж, уралдаанд 6 багийн 18 сурагч оролцлоо.



Үр дүн: Танин мэдэхүйн уралдаанаар хүүхэд багачуудын монголын түүх болон эх хэлний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ талаарх мэдээ мэдээлэлийг өгсөн өгөөжтэй арга хэмжээ боллоо.

“БАРИМЛЫН ШАВРААР УРЛАХУЙ”

Дэлхийн номын өдрийг угтан уншсан ном зохиолоосоо ойлгож танин мэдсэн зүйлээ бүтээж урлах “Баримлын шавраар урлахуй” бүтээлийн уралдаанд Тэргүүн байранд Э.Энхтамир, Дэд байранд М.Номин, Гутгаар байранд Б.Тэлмэн, Тусгай байранд Э.Аминтуяа нар шалгарлаа.



Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний нандин эрдэнэ” бүтээлийн уралдааныг зарлаж Тэргүүн байрт ЕБ-ын 3-р сургуулийн 5а ангийн сурагч М. Энхбаясгалан Дэд байранд 1-р сургууль 5б ангийн сурагч Э.


Энхтамир, Гутгаар байр 6-р сургууль Э.Нандин-Эрдэнэ,Тусгай байрт 2-р сургууль 5а О.Нарансолонго нар шалгарлаа.



Үр дүн: Өөрийн хүндэлж хайрладаг эрхэм хүндээ сэтгэлийн бэлгийг өөрийн бүтээлээр илэрхийлж сурах мөн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан соёлын уламжлалт ажил болсон.

“МИНИЙ БАХАРХАЛ” захидлын уралдаан

Монгол цэргийн баярыг тохиолдуулан “Миний бахархал” захидлын уралдаан зарлаж дүгнэлээ. Уралдаанд нийт- 57 захидал ирсэнээс Тэргүүн байрт ЕБ-ын 6-дугаар сургуулийн 8б ангийн сурагч Б.Энхсүвд, Дэд байрт 1-дүгээр сургуулийн 7г ангийн сурагч Б.Төрмандах, Гутгаар байрт 5- дугаар сургуулийн 7в ангийн сурагч Д.Хүслэн, Б.Өнө-Эрдэнэ,Тусгай байрт 6-дугаар сургуулийн 9а ангийн сурагч Д.Анх-Учрал нар шалгарлаа.



“Үрсийн зүрхний үг” захидлын уралдаан

Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ШШГГазрын цагдан хорих байранд хүмүүжиж байгаа иргэдийн дунд хайртай ижийдээ, ханьдаа, эгчдээ хэлж чадаагүй, хэлэхийг хүсдэг сэтгэлийн нандин үгээ хэлэх, ухаарал гэгээрэл, уучлал хүссэн “Үрсийн зүрхний үг” захидал бичих

уралдааныг уламжлал болгон 10 дахь жилдээ зохион явууллаа. Уралдаанд 21 захидал ирүүлсэн байна.

“НОМЫН БАЯР-2024”



“Үндэсний бичиг соёл номын баяр-2024” арга хэмжээг өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлээ. Энэхүү номын баяр нь Ерөнхийлөгчийн ивээл дор “Үндэсний бичиг үсгээ эрхэмлэн дээдэлье” уриан дор зохион байгуулагдсан 35, 36 дахь удаагийн номын баярыг Соёл урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, СӨБ болон ЕБ-ын сургуулиуд, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв хамтран зохион байгууллаа.

- "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн", тэргүүний анги хамт олон шалгаруулах
- Сурагчдын дунд үг үсэглэлийн тэмцээн
- Үлгэр зохиох уралдаан
- Уншсан номын тэмдэглэл хөтлөх уралдаан
- Англи үг үсэглэх тэмцээн
- Номын хавчуурга урлах
- Америк улсын талаар асуулт хариулт тэмцээн
- Аха асуулт хариултын тэмцээн
- “Үлгэрээс үлгэрлэе” үлгэр уншиж өгөх
- Үндэсний хувцасны “Загварын шоу”
- Үндэсний бичгээр уран бичвэр бичих
- Ном нуух тэмцээн
- Үндэсний тоглоом, наадгай
- Флашмоб
- Шинэ болон ховор хуучин номын үзэсгэлэн

- Монгол бичгээр “Үг бүтээх” , Уншлага минутад унших, Үг эвлүүлэх тэмцээн зэрэг үйл ажиллагааг явуулж номын сангийн үйл ажиллагааг сурталчилан ажиллалаа.



Үр дүн: Хүүхэд багачуудыг ном унших сэдэл төрүүлэх зорилгоор төрөл бүрийн хэлбэрээр номын тухай өгүүлэмж, харилцан яриа өрнүүлэх зэргээр үйл ажиллагааг өргөн дэлгэр иргэд уншигчидтайгаа тэмдэглэн өнгөрүүлээ.

“ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН НОМЫН БАЯРЫН ӨДӨР”

Дэлхийн хүүхдийн номын баярын өдрийг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Яруу найрагч МЗЭ-ийн шагналт А.Байгалмаатай уншигч-зохиолчын уулзалт зохион байгуулж, АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Ч.Нандин-Эрдэнэ “Хүүхдийн харилцаа хандлага” Шүдний эмч П.Бурмаа “Шүдээ хэрхэн эрүүл байлгах”, сэдвээр мэдээллийг хүргэж, Саран хөхөө театрын жүжигчин Д.Дариймаа Х.К.Андерсений уран бүтээлээс сонирхуулж “Нугасны муухай дэгдээхэй” зохиолыг жүжиглэн уншиж толилуллаа.



“ШАГАЙН НААДГАЙ-ӨВ СОЁЛ” НААДАМ

Төв номын сан нь Сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран "ШАГАЙН НААДГАЙ-ӨВ СОЁЛ" тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү тоглоом наадгайд СӨБ-ын сайншанд сумын баруун бүс буюу 1,5,8,9,14 дүгээр цэцэрлэгүүд, монголын уламжлалт шагайн наадгай, ардын "тээг" тоглоом, монгол бичиг, сампин



зангидах, шилбэ хадах зэрэг төрлүүдээр наадлаа.

Үр дүн: Монголын өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах

“ЯРУУ НАЙРГИЙН OPEN MIC”

"МОНГОЛ ГЭР-СОЁЛЫН ОРОН ЗАЙ" соёлын хөтөлбөрийн хүрээнд “Open mic” яруу найргийн чөлөөт уншлага явагдлаа. Уг арга хэмжээнд оролцогчид өөрсдийн зохиосон болон хүндэлдэг яруу найрагчийн, унших дуртай шүлгүүдийг уншиж сонордууллаа. Сэтгэлдээ бясалгаж, дэвтэртээ нандигнасан шүлгүүдээ бусадтай хуваалцлаа.



Үр дүн: Бүх насныхан өөрийн дуртай шүлгээ уншиж, авьяасаа тодруулж танигдах боломж олгосон арга хэмжээ болсон.

“МЭТГЭЛЦЭЭН”

Үндэсний бичиг соёл, номын өдрийг угтаж ЕБ-ын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудалд ул суурьтай хандах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн олон талт асуудлыг унших, судлах, мэтгэлцэх, илтгэх ур чадварыг хөгжүүлэх зорилгоор:


1. Ном унших нь ТВ үзэхээс илүү дээр
2. Фэйсбүүкийг монгол улсад төрийн бодлогоор хязгаарлах нь зөв
3. Ухаалаг утас ирээдүйн иргэдийг ухаангүй болгож байна.

4. Сургалтын агуулгаас уран зохиолыг хичээлийг хасах нь буруу
5. Цаасан ном унших нь цахим номоос илүү дээр гэсэн шийдлүүдийн хүрээнд мэтгэлцээнийг зохион явууллаа.



“ҮЛГЭР МИНИЙ МӨРӨӨДӨЛ” ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Үлгэр хэмээх соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх өвлүүлэн үлдээх үүднээс ЕБСургуулийн дунд ангийн сурагчдын дунд өөрийн мөрөөдлөө зөгнөн орчин цагтай нийцүүлэн үлгэрээр илэрхийлж, сэтгэх чадварыг нь хөгжүүлэх зорилгоор "Үлгэр миний мөрөөдөл" зохион бичлэгийн уралдаан зарлаж 58 бүтээл ирж эхний 3 байрыг шалгаруулж урамшууллаа. Ирсэн бүтээлийг ном болгож хүүхдүүдэд ашиглуулж байна.



“НОМ БИДНИЙ ИРЭЭДҮЙ” ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Хүүхэд, өсвөр үеийхэнд ном уншихын ач тусыг таниулан сурталчилж, тэдний унших сонирхлыг төрүүлж, цаашид хүсэл тэмүүллээрээ номтой нөхөрлөхөд нь үлгэрлэх, мөн эх хэлээрээ яруу сайхан бичиж сургах зорилгоор зохион явуулсан уг уралдаанд Сайншанд болон Замын-Үүд сумын ЕБС-ийн нийт 26 сурагч оролцлоо.



“МУСГЗ ЛУВСАНГИЙН ОДОНЧИМЭДИЙН ЗОХИОЛ БҮТЭЭЛЭЭР СЭДЭВЛЭСЭН УРАН ЗУРГИЙН УРАЛДААН”

МУСГЗ Л.Одончимэд зохиолчийн уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, уншигч олонд сурталчлан таниулахад чиглэсэн зургийн уралдаанд чөлөөт уран бүтээлчдийн 10 гаруй бүтээл ирж үзэсгэлэнд тавигдлаа.



“НОМТОЙ НӨХӨРЛӨСӨН ОН ЖИЛҮҮД” СЭДЭВТ ДУРСАМЖАА ХУВААЛЦЪЯ УРАЛДААН”

Хүүхэд, өсвөр үеийхэнд ном уншихын ач тусыг таниулан сурталчилж тэдний унших сонирхлыг төрүүлж цаашид хүсэл тэмүүллээрээ номтой нөхөрлөхөд нь үлгэрлэх, мөн хүүхэд залуучууд ахмад хүний үгийг сонсож тэднээр бахархах үзлийг бий болгох зорилгоор зохион явуулсан цахим уралдаанд ахмадууд идэвхтэй оролцлоо.



“ДУРСАМЖ ҮДЭШ”

Соёлын бүтээлч сарын хүрээнд МУСГЗ яруу найрагч А.Эрдэнэ-Очирын “Дурсамж үдэш” уулзалтыг зохион явууллаа. Уг арга хэмжээнд МЗЭ-ийн шагналт яруу найрагч Н.Минжинсайхан, МЗЭ-ийн шагналт Болор цомын эзэн Н.Гантулга, МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Байгалмаа, Монголын утга зохиолын төлөөх шагналт яруу найрагч Б.Бүргэд болон Хурмаст тэнгэр төвийн яруу найрагчид, уншигч иргэдийн төлөөлөл, найрагчийн ар гэрийнхэн оролцлоо.



“Өвлөн уламжлая” боловсролын хөтөлбөр

Аймгийн номын сан нь боловсролын хөтөлбөрийг дэмжиж "Өвлөн уламжлая" хөтөлбөрийг санаачилан "Шагай тоглож сурья" Монгол ардын тоглоомыг хүүхэд багачууддаа өвлөн үлдээх зорилгоор 8 нэр төрлөөр сургалт явуулж 233 хүүхэд хамрагдаад байна.



“СУДАРТАЙ АЯЛАЛ”

Аймгийн Ахмадын хороо, Номын сан, аймгийн МАН-ын Ахмадын хороо хамтран 7 дахь жилдээ зохион явууллаа. Арга хэмжээний үеэр сан хөмрөгт хадгалагдаж буй Үнэт ховор номыг нийтэд таниулан, түгээн дэлгэрүүлж номын үзэсгэлэн дэлгэн толилуулав. Ахмадууд Зава Дамдингийн “Сүмбэн”, Ганжуур, Данжуур судруудыг барин БНМАУ-ын баатар Д.Данзанваанчигийн хөшөө хүртэл алхав. **Мөн ахмадуудын дунд** морь уралдах, 4 бэрх орхих, шагай шүүрэх, богтос гаргах зэрэг 4 төрлөөр тэмцээн явууллаа.



Үр дүн: Ахмад үе залуус хүүхдэд ном эрхэмлэх зан үйлийг сурталчилах үлгэр дуурайлал болдог.

“Цахим видео бичлэгийн” УРАЛДААН

Дорноговь аймгийн Соёл, урлаг, аялал жуучлал, залуучуудын газартай хамтран зохион байгуулсан Сумдын соёлын төвийн номын санчдын дунд ажил мэргэжлээ сурталчлах цахим видео бичлэгийн уралдаан амжилттай болж өндөрлөлөө.



“ТА УНШ-БИД ХҮРГЭЭ” зөөврийн номын үйлчилгээ

Аяныг албан байгууллага, аж ахуй нэгжийн дунд зарлаж нийт 19 байгууллагын 215 албан хаагч хамрагдаж зөвөрөөр 1508 ном олгосон байна.



“ОЛУУЛАА УНШЪЯ” аян

Их дээд сургууль, Политехник коллеж, Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зарласан “ОЛУУЛАА УНШЪЯ” аянд байгууллага болон анги хамт олон идэвхтэй оролцож номын сангаар үйлчлүүлж, тэмдэглэл хөтөлж амжилттай оролцлоо.



Үр дүн: Ном, зохиол бүтээлийг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, уншигч, ном олголт нэмэгдсэн.

“НУТГИЙН ЗОХИОЛЧДЫН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН”

Зохиолчдын Хурмаст тэнгэр төв үүсэж байгуулагдсаны түүхт 70 жилийн ой энэ онд тохиож байгаа билээ. Уг ойн ажлын хүрээнд “Дорнын говиос Монгол эхэлдэг” тоглолт Соёлын төв өргөөнд болж энэхүү арга хэмжээнд зориулан тус номын сангаас Нутгийн зохиолчдын номын үзэсгэлэнг 300 гаруй номын дээжээр дэлгэн толилууллаа.



“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ХЭВЛЭЛИЙН ХУУДАСНАА”

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Монголын нууц товчоо хэвлэлийн хуудаснаа” үзэсгэлэн гаргаж олны хүртээл болголоо. Боловсрол судлалын магистр Н.Ганхуягийн хувийн цуглуулга болох 100 гаруй материалыг тав хоногийн хугацаанд 600 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн үйл ажиллагаа

Энэ өдрөөр МССТөвийн урд талбайд хүүхдийн номын үзэсгэлэн гаргаж, талбайд олон төрлийн үйл ажиллагаа явуулж тэмдэглэн өнгөрүүлээ. Үүнд:

- Гар зургийн уралдаан
- Үг үсэглэлийн тэмцээн
- Баг өмсөж зургаа авхуулах үйлчилгээ
- Аав ээжтэйгээ тоглох, ном будах орчин бүрдүүлж хүүхдүүд гэр бүлээрээ тоглох таатай орчинг бүрдүүлэхийг зорин ажиллалаа.

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”

ЕБ-ын 12 жилийн 2-р сургуулийн 6б ангийн сурагч Б. Нинжин, 5-р сургуулийн 8в ангийн Ч.Энхриймаа, 5-р сургуулийн 10б ангийн сурагч Э.Дөлгөөнтамир, 3-12 жилийн 5б ангийн сурагч М.Мөнхин, Хатанбулаг сумын ЕБ-ын 5б ангийн сурагч Б.Намсрай, Тэргүүний анги хамт олон ЕБ-ын 12 жилийн 1-р сургуулийн Г.Амарбаясгалан багштай 4в анги, Тэргүүний уншигч хамт олон ЕБ-ын 12 жилийн 3-р сургуулийн байрны хүүхдүүд тус тус шалгарсан.



Үр дүн: Бүх нийтээр ном унших дадал хэвшилд суралцсан.

“НОМЫН САНЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ” СУРГАЛТ

Соёлын тухай хууль болон Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор соёл болон боловсролын салбарын номын санчдыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах сургалтад сумдын болон ерөнхий боловсролын



сургууль, АШУУИС, Политехникийн коллежийн нийт 50 гаруй номын санчид хамрагдлаа.

Үр дүн: ажлын байран дээрээ сурч боловсрох, мэргэжлээ дээшлүүлэх ач холбогдолтой цаг хугацаа хэмнэсэн сургалт болсон.

“Коха программын сургалт”

Монголын номын сангуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилготой "Кoһа 22.11" буюу номын сангийн нэгдсэн системийн 2 өдрийн сургалт номын санд зохион байгуулагдлаа. Сургалтыг Монгол Улсын Үндэсний номын сангийн Ном бүрдүүлэх, боловсруулалтын хэлтсийн бүртгэл мэдээллийн номын санч Н.Отгонтөгс, каталогч Э.Мянганзул нар явууллаа.



Үр дүн: Коха программд одоогийн байдлаар манай номын сангийн уншлагын танхимын 1000 гаруй ном, гэрээр ном олгох танхимын 4000 гаруй ном бүртгэгдэж бар коджуулаад байна. Программд ном оруулах үйл явц үргэлжилж байна.

“Америкийн төвийн ажилчдын сургалт

Орхон аймгийн Эрдэнэт хотод Америкийн элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албанаас зохион байгуулсан Америкийн төвийн ажилчдын сургалтанд амжилттай хамрагдлаа. Улаанбаатар, Дархан, Увс аймаг болон Эрдэнэт хотын төвийн ажилчид, номын сангийн дарга нар, мөн Америкийн элчингийн ажилчидтай туршлага солилцлоо.



МУНС болон Улаанбаатар хотын номын сантай танилцаж туршлага судлав

Аймгийн номын сан болон сумдын нийт 15 номын санчид Үндэсний номын сан болон Улаанбаатар хотын номын сантай танилцаж туршлага солилцож КОХА программын сургалтын батламжаа гардан авлаа. Мөн Америк төвийн үйл ажиллагаатай танилцаж Худал мэдээллийг хэрхэн таних вэ? сургалтанд амжилттай хамрагдлаа.



“СУМДАД АЖИЛЛАЖ МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨВ”

Номын санчид дэлгэрэх, Мандах, Улаанбадрах, Өргөн сумын Соёлын төвийн номын санд ажиллав. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд сумдын соёлын төвийн номын санд зөвлөн туслах, аргазүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Соёлын төвийн номын сангийн номыг төрөл ангийн дагуу ангилах, агуулга хуучирсан олон хувь номыг актлахаар ялгах, данс бүртгэл хөтлөх талаар мэргэжил аргазүйн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллав.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НОМЫН САНГИЙН ДЭРГЭДЭХ АМЕРИКИЙН СОЁЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Америкийн Соёл Мэдээллийн төв нь бүх нийтийн Англи хэлийг сайжруулах зорилготой хөтөлбөрүүд, Англи ном уран зохиол, сэтгүүл болон өндөр хурдны интернэт, компьютераар хангагдсан. Иргэдэд нээлттэй үнэ төлбөргүй үйл ажиллагааг явуулж байна. 2022 оны 1-2 саруудад Америкийн элчин сайдын хөрөнгө оруулалтаар барилгын засвар, тохижилтын ажлыг хийсэн бөгөөд 2022 оны 3-р сараас эхлэн мэргэжлийн Англи хэлний багш ажиллаж эхэлсэн. Тус төвд Англи хэл хөгжүүлэх хөтөлбөрөөс гадна Америк соёлыг түгээх үйл ажиллагааг тогтмол амжилттай явуулж байна.

- **Англи хэлний хөтөлбөр:**
- **ABC English** - Анхан шатны англи хэлний сургалтыг тогтмол 7 хоногт 2 удаа явуулж байна. Сурагчдын тоо улам нэмэгдэж идэвхтэй оролцож байна.
- **Тоглоомын өдөр** – Үдээс хойш хичээлтэй сурагчдад зориулж хичээлийн бус цагаар сурагчдад англи хэлийг хөгжилтэй сурах боломжийг олгож тоглоомын цагийг 7 хоног бүр явуулж байна. Карт тоглоом болон Би хэн бэ тоглоомуудыг Англи хэлээр тоглож байна.

- **Ярианы клуб** - Англи хэлний ярианы клубээр англи хэлээ сайжруулах сурагчид хамрагддаг. Бэлтгэсэн асуултанд хариулж ярилцах болон өөрсдийн бэлтгэсэн сэдвийн дагуу ярилцдаг.
- **Дууны клуб** - Англи хэлийг дуугаар дамжуулж үгийн дуудлага сайжруулах зорилготой дууны клубыг явуулж байна. Сурагчид Англи хэлний сонсголоо болон хэллэгээ сайжруулахын тулд Англи дууг суралцаж гитар тоглох сонирхолтой сурагчдад гитартай дуулах боломжийг олгож байна
- **Төслийн клуб** – Сурагчдын өөрсдийн сонирхолд тулгуурлан сар бүр хамтран бүтээлч үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь 10-р сард Төслийн клубын сурагчид гарын доорх материал ашиглан баярын чимэглэл хийсэн.
- **Үгсийн сангийн клуб** - Дунд болон ахлах ангийн сурагчид тайлбар толь бичиг ашиглан үгсийн сангаа нэмэгдүүлэхийн тулд тоглоомын аргаар үгсийн сангаа баяжуулдаг. Англи хэлний мэдлэгтэй сурагчдад Олон улсын англи хэлний шалгалтанд ирдэг үгс дээр ажиллаж үгийн нөхцөл, дагаварын даалгавар гүйцэтгэдэг.
- **“Хэлэлцүүлгийн клуб”** – АНУ-н засгийн газрын тэтгэлэгтэй FLEX ахлах ангийн сурагчдын хөтөлбөрийн 2021 оны төгсөгч Пүрэвдарь болон түүний Америк ээжтэй хамтран 7 хоног бүр хэлэлцүүлгийн клубыг өнгөрсөн 3 сараас хойш амжилттай явуулж байна.
- **Кино клуб** - Англи хэлээ кино үзэж сайжруулах зорилготой киноны клубыг явуулж байна. Бэлтгэсэн асуултын дагуу хэлэлцүүлэг хийх болон өөрсдийн сэтгэгдлээ англи хэлээр хуваалцдаг.

✓ **Хүүхдийн баярт зориулсан асуулт хариултын АХА тэмцээн**



Тус өдрийн эхлэлд хүүхдийн парадад оролцсон ба манай төвөөс “Олон улсын хүүхдийн баяр”-т зориулан “SIP” болон “JEP” хөтөлбөрийн сурагч хүүхдүүдтэй хамтран АНУ-ын 50-н мужийн талаарх сонирхолтой асуулт хариултын АХА тэмцээнийг нийт 38-н хүүхдүүдийн дунд зохион байгуулсан ба нийт 2 удаагийн тойрог өрсөлдөөний ялагчдад “Project club”-н цаасан хайчилбар болон Gobi cinema-д хүүхдийн кино үзэх тасалбараар шагнасан. Мөн үйл ажиллагааны үеэр сонирхолтой видео контентыг эрхлэн хүргэсэн.

“SIP” сурагчдын дадлагажигч хөтөлбөрийн 3 дахь удаагийн төгсөлт амжилттай болж өнгөрлөө.



Тус сарын 14-ны өдөр сурагчид 6-н сарын хугацаанд хийсэн ажлын тайлангаа бэлтгэн Дархан, Улаанбаатар, Увс аймаг нийт 4-н төвийн сурагчдад болон “АНУ-н Элчин Сайдын Яам”-ны Олон нийттэй харилцах албаны дэд сайдын өмнө тайлангаа хамгаалан хөтөлбөрөө амжилттай дүүргэлээ. Тус хөтөлбөр ирэх 9-р сараас дараачийн сурагчдаа элсүүлэн хамруулах билээ.



✓ **Десерет ОУ-ын Энэрэлийн байгууллагын багш нартай хамтран олон нийтийн англи хэлд суралцахыг дэмжсэн видео контент бэлтгэв.**

06.13-ны өдөр “Deseret Charity Mongolia”-тай хамтран нийтийн англи хэлийг сайжруулах, суралцах байдлыг идэвхжүүлэн дээшлүүлэхийн тулд цуврал видео контентийг бүтээсэн.



✓ **“JEP” буюу өсвөр насны сурагчдыг чадавхжуулах хөтөлбөрийн төгсөлт амжилттай боллоо.**



Нийт 16-н сурагчдыг шалгаруулан хамруулсан “JEP” хөтөлбөрийн төгсөлт 06.15-ны өдөр амжилттай болон өндөрлөлөө. Энэ удаагийн хөтөлбөрт нийт 6-н удаагийн ур чадварыг дээшлүүлэх илтгэх урлаг, инженерчлэл, цахим спорт зэрэг олон төрлийн сургалт явуулснаараа онцлог болсон юм.

✓ **Шинэ номын төрөл нэмэгдэж номын баяжилт хийгдэв.**

Амазон сайтаас захиалсан ном зохиолууд хүргэгдэн ирж нийт 57-н номыг хүлээн авлаа. Ингэснээр номын санд ирэх үйлчлүүлэгчдийн тоо өсөх, шинэлэг ном зохиолыг цаг алдалгүй уншиж танилцах олон давуу тал бүрдэх юм.



Сайншанд сумын ЕБ-н сургуулиудад зочилж 2023 оны FLEX хөтөлбөрийн төгсөгч 5-р сургуулийн сурагч аймгийн Боловсролын газартай хамтран мэдээлэл өгсөн. Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагаа болон АНУ-н санхүүжилттай ахлах ангийн сурагчдын FLEX тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хүсэлт гаргах болон манай төв сурагчдын эссэ бичлэгт зөвөлгөө өгөх боломжтой талаарх мэдээллийг тогтмол өгч байна.



Сурагчдын англи хэлээр өөрсдийн мэдлэгээ хуваалцах боломжийг олгох, нийт сурагчдад гадаад хэлний чадвар болон ерөнхий мэдлэгийг ахиулах зорилготойгоор Аймгийн төв номын сангийн харъяа Америкийн Соёл Мэдээллийн төвөөс Англи хэл дээр мэтгэлцээнийг амжилттай зохион байгууллаа.



АНУ-н элчин сайдын яамны зочид Америкийн Соёл мэдээллийн төвөөр тогтмол зочилж иргэдэд хэрэгцээ шаардлагатай мэдээлэл болон Америк соёл талаар мэдээлэл өгдөг. дэд сайд хадагтай Меласса зочиллоо. 10 сарын 27 ны өдөр сургуулийн сурагчдад гурван удаагийн уулзалтыг зохион байгууллаа. Оюутны визний төрөл хэрхэн виз мэдүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч сурагчдын хүссэн асуултанд хариулж ярилцлаа. Нийт 136 оюутан сурагчид хамрагдсан.



Америкийн Соёл Мэдээллийн төвөөс Англи хэл дээр мэтгэлцээнийг амжилттай зохион байгууллаа. Тэргүүн байр 2-р сургууль Өнөмөнх, Сүх-Очир, Дэд байр 1-р сургууль Тодгэрэл, Саруулгэрэл, Гутгаар байр 3-р сургууль Азжаргал, Одбаяр нар шалгарсан. Сайншанд ЕБ-ын сурагчид болон Замын Үүд сургуулийн сурагчдаас ирж оролцсон.

ҮР ДҮН:



Америкийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагааг явуулснаар англи хэлийг сурах

хүүхэд багачууд, иргэдийн тоо нэмэгдэж, гадаад орны соёлоос суралцах болон олон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах сонирхол, үр дүн харагдаж байна.

БУСАД АЖИЛ

- “ҮНДЭСНИЙ БИЧИГ” нэртэй 75ш номтой үзэсгэлэнгийн булан байгуулан иргэд үйлчлүүлэгчдэд танилцуулан сурталчилж 1500 гаруй хүн үзэж үйчилгээ аваад байна. мөн байгууллагын цахим хуудсанд үндэсний бичгийн зөв бичих дадлыг хэвшүүлэх зорилгоор мэдээ мэдээллийг тогтмол оруулж хандалтын тоо өссөөр байна. албан хаагчдыг төлбөртэй анхан шатны үндэсний бичигт сургаж компьютер дээр гарын драйв суулгаж өглөө. бичиж хэвших дадлагыг номын санчид тайлан, төлөвлөгөө болон мэдээ мэдээлэл бэлтгэхдээ ашиглаж байна.
- Аймгийн номын сан нь “Цахим соёл” арга хэмжээнд нэгдэж “Цахимаар уншицгаая” аян өрнүүлж ДОРНОГОВЬ ТӨВ НОМЫН САН фэйсбүүк групп нээснээр тогтмол хүүхэд багачууд болон ард иргэдэд Онч мэргэн сургаал үгс, монгол ардын үлгэр, танин мэдэхүй, цар тахалтай холбоотой болон бусад эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, үндэсний хэл бичиг соёлыг таниулах, шинэ номын мэдээ мэдээлэл, хүүхдийн зохиол болон домог хууч яриа зэргийг оруулан мөн англи хэлний мэдлэгт зориулан зурган постор, ан амьтдын үр төлийг ялган таних зэрэг мэдээ мэдээллийг оруулсан. Мөн 7800 гаруй хүүхдүүдийн бүтээлтийг нийтэд таниулан 16610 хандалт авсан байна.
- Соёл олон нийтийн ажлыг шинэлэг олон талт хэлбэрээр зохион байгуулан ажилласан. Соёлын яамнаас 10 сая төгрөг ба антайхолбогдуулан хийсэн ажил болон байгууллагын ажилчдын төлөвлөгөөнд тусгагдсан СОНА-ууд болон уламжлалт ажлуудаа зохион байгуулан ажиллаж нийт 285 төрлийн ажилд 9876 хүн хамрагдсан.
- Цахим каталогоос уншигчдад хэрэгцээт ном хэвлэлийг түргэн шуурхай эрэн хайх, цахим лавлагаа мэдээллийг өгөх зэрэг ажлыг өдөр тутамдаа нэвтрүүлэн ажиллаж 1352ш ном хайсан байна.
- Үүлэн серверийн зардалд 2,70 0,000төгрөгийг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж шинээр 149 ширхэг номыг данслан техник ажиллагааг хийн программд оруулж бар коджуулсан.
- МЗЭ-ийн шагналт яруу найрагч Анандын Байгалмаагийн “ГЭРЭЛ АВИА” номын нээлт, Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан яруу найрагч Монголын Зохиолчдын "Хурмаст тэнгэр" төвийн гишүүн "Утга зохиолын төлөө" хүндэт шагналт Ш.Баатарын "ШАМБАЛЫН ГЭГЭЭ" номын нээлт амжилттай болж өндөрлөлөө.
- Мэдээллийн төв байх зорилтод хүрээнд тогтмол хэвлэлийг захиалан заалаар уншигчдад түгээж ерөнхий боловсролын сурагчдад мэтгэлцээн тэмцээн зохион байгууллаа.
- Бага ангийн сурагчид, цэцэрлэгийн хүүхэд багачууд, эцэг эхчүүд бага насны хүүхэдтэйгээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж хамтдаа ном уншиж ярилцах мөн эко орчинд монголын уламжлалт тоглоом наадгайгаар тоглох зэрэг тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор нэг өрөөг тусгайлан тохижуулж “АЗ ЖАРГАЛЫН ӨРГӨӨ”-г байгуулан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар

тус өргөөгөөр албан байгууллага гэр бүл болон 14-н цэцэрлэгийн 595 хүүхэд, багш эцэг, эхчүүдэд үйлчилсэн байна.

АРГА ЗҮЙН АЖИЛ:

Аймгийн номын сангийн дэргэдэх АНУ-н соёл мэдээллийн төвөөс англи хэлтэй Дорноговь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн 2022 оны 3-р сараас эхлэн мэргэжлийн англи хэлний багш ажиллаж байна. Тус төвд англи хэл хөгжүүлэх хөтөлбөрөөс гадна Америкийн соёлыг түгээх үйл ажиллагааг тогтмол амжилттай явуулж байна. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор тогтмол явагдаж буй ABC English, Тоглоомын өдөр, Ярианы клуб, Дууны клуб, Үгсийн сангийн клуб, Хэлэлцүүлгийн клуб, Кино клуб зэрэг 176 хөтөлбөрт оролцсон иргэдийн тоо 3215, нийт ирэгсэдийн тоо 3346 иргэн англи хэлний мэдлэг ахиулах сургалтад хамрагдсан байна. Хамрагдсан иргэдийн тоо жил бүр нэмэгдэж байна.

- MNS 5271:2012 Номзүйн бичилт. Ерөнхий шаардлага стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 4:2003 Мэдээлэл ба баримт бичиг. Гарчиг үг ба ном хэвлэлийн гарчгийн товчлол стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 11799:2007 Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартыг хэрэгжүүлэх зэрэг стандартын хэрэгжилтийг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- Сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гаригт “Ном сэлбэн засах өдөр” болгон зарласантай холбогдуулан урагдаж гэмтсэн номуудад стандартын дагуу сэлбэн засалт хийж 386 ном сэлбэн зассан байна.

- Сумдын номын сангуудад арга зүйн зөвөлгөөг тогтмол өгч нийтдээ давхардсан тоогоор 32 удаа өгч үйлчилсэн.

- Мөн сар бүрийн эхний долоо хоног сүүлийн долоо хонгийн 5 дах өдөр цахимаар холбогдон харилцан туршлага солилцон ажиллаж байна.

ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Алсын хараа-2050” Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 оны “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай” 314 дүгээр тогтоол, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих” тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

“Соёлын бүтээлч сар-2024” аяны хүрээнд:

Соёл, Спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас “Өвлөн бүтээх өнөө ирээдүй” уриан дор “Соёлын бүтээлч сар” аяныг хөтөлбөр, удирдамж чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулан ажиллалаа. 11 сарын турш арга хэмжээ 7, боловсролын хөтөлбөр 2, хэлэлцүүлэг 3, лекц-1, үзэсгэлэн 17, нөлөөллийн ажил-2, нийт 10 гаруй арга хэмжээ зохион байгуулж нийт 10000 гаруй мянган иргэн соёлын үйлчилгээнд хамрагдсан.

Мөн “Өвлөн бүтээх өнөө ирээдүй...” уриан дор төрийн шагналт, эрдэмтэн Санжмятавын Гаадамба, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт Өвгөний Баасанжав болон аймаг орон нутгаас төрөн гарсан судлаач, алдарт суут хүмүүсээ сурталчлан алдаршуулахаар Барга судлаач, Түүхийн ухааны магистр Ц.Түмэнг онцлон лекц хэлэлцүүлгийг хийсэн. Мөн ойтой зохиолчдын үзэсгэлэн гарган хүүхэд залуучуудад сурталчилан таниулсан.

Үр дүн.

Аяны хүрээнд иргэд олон нийтэд чиглэсэн соёл гэгээрлийн ажлыг нэгдсэн нэг уриан дор бүтээлчээр зохион байгуулсанаар иргэд олон нийтэд хүртээмжтэйгээр хүргэсэн.

Аймгийн төрийн 18 байгууллага, боловсролын 9 сургууль, 5 сум, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг нийт 10 гаруй мянган иргэдэд ном соёлын үйлчилгээг хүргэж ажилласан.

Уншлага, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.



ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн 2024 оныг хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

Номын сангийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 2024 оныг “Үндэсний бичиг, соёлын боловсрол, цахим уншлага”-ийг нэмэгдүүлэх зорилтот жил болгон ажилтан албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн талаар

судалгааг аван, программ хангамжийн хөгжүүлэлтийг сайжруулах, баг хамт олныг бүрдүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллалаа.

Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлчилгээг хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Гэр бүлийн уншлагын танхим”-ийн засварын ажлын 40.4 сая төгрөгийг батлуулан Баян-Луу ХХК хийж гүйцэтгэсэн.



Аймгийн төсвийн хөрөнгөөр Номын сангийн барилгын гадна засварын ажлын нүүрэн хэсэгт хийгдэж байгаа бөгөөд 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжинэ.



“Дэлхийн номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Хүрэл тулга-2024” өсвөрийн яруу найрагчдын аймгийн аварга шалгаруулах уралдааныг аймгийн Гэр бүл, хүүхэд хамгааллын газартай хамтран зохион байгууллаа. Уралдаанд Дорнод аймгийн 11 сумын 66 өсвөрийн яруу найрагчид 2 насны ангилалд өрсөлдөж шилдгүүдийг шалгарууллаа. Мөн тус өдрүүдэд Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн Т.Уранчимэг, Е.Марал багштай ахлах “А”, бэлтгэл “Б” бүлгийн бяцхан хүүхэд, багачууд номын сантай танилцаж, “Цахим үлгэр”-ээр аялан номын сангийн шинэ уншигч боллоо.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

- Үндэсний бичиг, соёлын боловсрол, “Эх хэлний өдөр”, “Үндэсний бичиг үсгийн баяр”, цахим уншлагыг нэмэгдүүлэх, утга зохиол хэл соёлыг түгээн дэлгэрүүлэх соёлын олон талт ажил зохион байгуулж 80 гаруй үзэсгэлэн дэлгэгдэж 250 иргэд олон нийт үзэж сонирхсон.



Номын баярт зориулж шатар, даамны тэмцээнийг 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгууллаа. 5-6, 7-8, 9-10, 11-12 насны ангиллаар зохион байгуулан 160 гаруй хүүхэд хамрагдан шилдгүүдийг тодруулж, шагнаж урамшуулсан.



Энэ жил Номын баярыг "Хүүхэд бүр уншигч" уриатайгаар зохион байгуулсан бөгөөд "Үлгэрийн баатрууд амилсан нь" арга хэмжээнээс гадна Тэргүүний уншигч "Д.Нацагдорж" тэмдэгээр Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 11в ангийн сурагч Б.Өсөхбаяр шалгарлаа.

"Шилдэг гэрийн номын сантай өрх" шалгаруулах уралдаанд 8 дугаар сургуулийн багш Ганболдын Гантогос, 7 дугаар багийн ахмад настан Ринчингийн Лхүндэв, Шинэ хөгжил сургуулийн 8а ангийн сурагч Б.Нэмүүнжаргал, О.Чулуунбаатарын гэр бүл, 1 дүгээр сургуулийн 5а ангийн сурагч Б.Анираа нар тэргүүллээ. Мөн Дорнод аймгийн "Оёдолчдын холбоо"-ны тэргүүн Д.Ганчимэг Номын сангаар идэвхтэй үйлчлүүлдэг нэг сурагчийг жил бүр монгол үндэсний дээлээр шагнахаар болж энэ онд 12 дугаар сургуулийн 6в ангийн сурагч Б.Шижир уг шагналыг хүртлээ.

Эртний ховор ном судар, тэгш ой тохиож буй зохиолчдын намтар уран бүтээл, үндэстэн угсаатны өв соёл Буриад, Барга, Үзэмчин, Халх үндэстэн, үндэсний бичгийн бүтээлүүд, шинэ ном болон хүүхдийн уран зохиол, танин мэдэхүйн 151 номоор үзэсгэлэн гаргаж 800 гаруй иргэд, хүүхэд, залуучууд, багш сурган хүмүүжүүлэгчид үзэж сонирхсон. Мөн Ерөнхий боловсролын Хан-Уул, Шинэ хөгжил зэрэг 7 сургуулийн номын сангууд үндэсний бичгийн 117 номоор, бүтээлийн 40 гаруй үзэсгэлэнг гаргаж хамтран ажиллалаа.

Номын баярын хүрээнд соён гэгээрүүлэх 7 арга хэмжээ зохион байгуулан, гэр бүлийн уншлагын танхимын нээлт, Шилдэг номын сантай өрхийг шалгаруулсан зэрэг шинэлэг ажлуудыг зохион байгуулснаар 1350 гаруй уншигчид оролцсон.

"Алсын хараа 2050", Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй үнэт түүхэн өв сурвалж эртний судрыг хадгалж хамгаалах зорилгоор сан хөмрөгч баринтаг оёх уриалга гарган

албан хаагчид болон хувь хүмүүс 149 баринтаг оёж ном, судрыг баринтаглахаас гадна хадгалах шүүгээг хийж байрлуулсан.



“Номын богц” гэрээр хүргэх үйлчилгээг 75 удаа 231 номоор, Хөгжлийн бэрхшээлтэй гэрийн асаргаанд байдаг иргэдэд 78 иргэнд 120 номыг зөөврөөр болон танхимаар хүргэж үйлчилсэн.



Алслагдсан сум, багийн иргэдэд уншигчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан номын сангийн үндсэн үйлчилгээ болон цахим номын сангийн үйлчилгээ, шинэ номын болон орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн, соёлын арга хэмжээг зохион байгуулах зорилгоор Баянтүмэн, Булган, зэрэг 9 суманд ажиллан 2575 иргэдэд 548 ном, сэтгүүлээр үйлчилсэн. Мөн зөөврийн номын сангийн үйлчилгээг биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй алслагдсан багт оршин суугч иргэн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хилийн цэргийн 0132, ШШГГ, Зүүн бүсийн албадан эмчилгээний төв зэрэг 20 гаруй байгууллагуудын 1640 хүнд хүргэсэн.



Цахим уншлагын үйлчилгээ:

Цахим уншлагын танхимаар ЕБС-ийн сурагчид анги бүлгээрээ ирж ном уншиж үйлчлүүлэх нь нэмэгдсэн бөгөөд нийт 27 анги 1000 гаруй ирэгсдэд үйлчилсэн.

Энэ жил цахим номын санд оюуны өмчийн зөрчилгүй 322 ном, зохиол бэлтгэж цахим хэлбэрт хөрвүүлэгдсэн. Өмнө оруулсан зарим ном зохиолуудыг засварлан 50 гаруй зохиолыг нэгтгэж нэг ном болгосноор нийт цахим номын сангийн сан хөмрөг 1036 ном зохиолтой болсон.

Номын санг орчин үеийн номын сангийн чиг хандлагад ойртуулахад чиглэгдэж байна. Энэ зорилгоор “Цахим уншигч” уралдааныг 2 дахь жилдээ зохион байгуулж Хэрлэн сумын 11, Матад, Цагаан-Овоо, Чулуунхороот сумдын Ерөнхий боловсролын 33 бүлгийн 400 гаруй сурагч хамрагдсанаас 22 бүлэг 2 дугаар шатанд шалгаран мэдлэг оюунаа тэлсэн. Мөн номын санчид өөрийн хүч хөдөлмөрөөр Kindle-д 1500 гаруй зохиогчийн эрхийн зөрчилгүй номыг шүүж ялган, алдааг засаж цахимд оруулсан нь цаашид хүүхдийн уншлагыг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил болсон.

ХОЁР: СОЁЛЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу албан тушаалын цалингийн доод жишгийг батлан төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон орон нутагт ажилласны нэмэгдэл, ур чадвар, үр дүнгийн урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгож байна.

- Хүний нөөцийн сургалт хөгжлийн төлөвлөгөөг гарган, гүйцэтгэлийг үнэлэн, ажилтныг хөгжүүлэхэд анхаарч бие даан суралцах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамруулан, байгууллагын эерэг уур амьсгалыг төлөвшүүлэн нэгэн зорилгод чиглэсэн бүтээлч хандлагаар багаар ажиллаж байна.

- Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцүүлэн номын санчдыг танхимуудад сэлгэн ажиллуулж байна.

- Цаг бүртгэлийн гар аргаар бүртгэдэг уламжлалт аргыг халж, бүрэн автоматжуулсан ухаалга Timely.mn бүртгэлийн ухаалга системийг нэвтрүүлсэн. Ингэснээр байгууллага, албан хаагчдын хоорондын харилцаа үр дүнтэй, ажлын бүтээмжийг нэмэх боломж бүрдсэн.

- Долоо хоног бүрийн Лхагва гарагт мэдээллийн цагийг тогтмолжуулан албан хаагчдад сургалт мэдээллийг зохион байгуулсан. Үүнд: Аймгийн Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар болон Энх тайвны корпус зэрэг орон нутгийн болон Олон улсын байгууллагын 10 гаруй удаагийн сургалтад Номын санч, албан хаагчдын хамруулсан.

- Монгол улсын Соёлын яамнаас хэрэгжүүлж буй Цахим номын сангийн нэгдсэн систем Коха программын сургалтад 8 номын санч хамрагдсан.

- Нэгдсэн системийн хайлт зэрэг 7 бүлэг хичээл орсон.

- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн барга хошуу, Манжуур хотын номын сантай туршлага судлах арга хэмжээнд 5 албан хаагчийг оролцуулж ажлын байрны ур чадвар, эерэг хандлагыг бий болгоход нөлөө үзүүлсэн.

- “Гадна хамар ба хамрын хөндийн зонхилон тохиолдох эмгэгүүд” сэдвээр чих хамар хоолойн эмч Анхбаяр албан хаагчдад мэдээлэл хүргэсэн.






Гурав.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 Уншлага үйлчилгээ:

Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө /бүтэн жил/	Биелэлт	хувь
Шинэ уншигч	6000	6597	
Байнгын уншигч	75000	82092	
Ном олголт	110000	110185	
Гэр бүлийн богц	20	75	

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинэ уншигч 7.5%, байнгын уншигч 6,1%, ном олголт 1,5%-аар тус тус өссөн.



3.2 Гэрээр ном олголт:

Тайлант хугацаанд уншигчдад 121896 ном, хэвлэл олгож үйлчилснээс 21495 номыг гэрээр олгож үйлчилсэн байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй 78 иргэнд карт нээж 120 номоор үйлчилгээ үзүүлэн, гэр бүлийн богцоор 75 удаа үйлчилгээ үзүүлж 231 ном олгосон.

3.3 Солилцоо, зөөвөр:

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ны Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу Алслагдсан сум, баг, албан байгууллага, ЕБС, цэцэрлэг зэрэгт нийт 24 удаа 3082 номоор 3450 хүнд зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:



Зөөврийн номын сангийн үйлчилгээ авсан байгууллага	Уншигчийн тоо	Ном олголт
ЗХ-ний 327-р анги	56	60
ШШГГ	48	60
Хөдөө аж ахуйн газар	51	54
Нью-эндорфин эмнэлэг	12	45
Баянтүмэн сум	23	40
Хан-Уул цогцолбор сургууль	650	135
Шинэ хөгжил цогцолбор сургууль	250	150
Зүүн бүсийн албандан эмчилгээний төв	45	120
Хилийн цэргийн 0132 анги	85	110
Хэрлэн сумын 2 дугаар багийн ажлын алба	20	167
3 дугаар цэцэрлэг	84	36
Дорнод их сургууль	5	38
1 дүгээр сургууль	120	60
12 дугаар сургууль	160	120
8-р сургууль	200	72
5-р сургууль	200	80
Сумд /Баян-Уул, Булган, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Халхгол, Дашбалбар/	1441	1735
Нийт	3450	3082

3.4 Фонд бүрдүүлэлт:

Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг хандиваар 218 нэр төрлийн 281ш ном 2828000 төгрөгийн үнэтэй, шинээр 37 нэр төрлийн 48 ширхэг 1260000 төгрөг, нийт 255 нэр төрлийн 329 ширхэг, 4088000 төгрөгийн номоор фондоо баяжуулан, электрон каталогт оруулан дансалж бар код нааж танхимуудад хуваарилсан. 12 нэр төрлийн 512400 төгрөгийн хэвлэл захиалсан



3.5 Ном сэлбэн засалт:

Урагдаж гэмтсэн 999 номыг анхны хэлбэрийг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан. Нийт 2826 ном ариутгасан.

3.6 Лавлагаа, ном зүйн үйлчилгээ

Мэдээлэл ном зүйн үйлчилгээний хүрээнд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон тодотгосон лавлагааг нийт 1232 лавлагаахүнд өгсөн байна.



3.7 Мэргэжил арга зүй

Булган, Цагаан-Овоо, зэрэг 7 сумын соёлын төв, Хилийн цэргийн 0132 ангийн шинээр орсон номын санчдад “Анхан шатны мэдлэг олгох” сургалтыг зохион байгуулан, 3 хоног аймгийн төв Номын санд дадлага хийлгэн арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.

Цахимаар номын санчдад сан хөмрөгийн зохион байгуулалт, мэдээлэл сурталчилгааны ажлын талаар арга зүйн зөвлөгөөг өглөө.

3.8 Соёл олон нийтийн ажил:

Соёл, танин мэдэхүйн ажлуудаа аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Бүх нийтийн соёлын боловсрол, соёл гэгээрлийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Соёл, олон нийтийн болон соёлын боловсрол, Соёлын бүтээлч сарын хүрээнд дараах ажлуудыг уншигчдын дунд зохион байгуулснаар 12009 иргэд, багш, хүүхэд залуучууд хамрагдсан.

Д/Д	Соёл олон нийтийн ажил	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уралдаан тэмцээн АХА	2	87
2	Номын үзэсгэлэн	52	3529
3	Үлгэрийн цаг цахим үлгэр	51	1982
4	“Ном хожье”	9	1709
5	Хэлэлцүүлэг “Номтой өглөө”	10	446
6	Номын нээлт	1	75
7	Шагай наадгай	1	70
8	Цахим контент	3	15
9	Хүрэл тулга наадам	1	66
10	Алтан хонх тэмцээн	7	280
11	Сэтгэхүйн хурд	1	50
12	Номтой цаг	1	700
13	Лекц	1	50
14	Номын баяр	2	1600
15	Цэцэг өргөх арга хэмжээ	1	1350
	Нийт	140	12009

Хүүхэд багачуудын танин мэдэхүйг хөгжүүлэх танин мэдэхүйг хөгжүүлэх боловсрол хөтөлбөрийн хүрээнд “Би шувуу ажиглагч” арга хэмжээ зохион байгуулж

мэргэжлийн шувуу судлаач Э.Баасансүрэн, О.Булган нартай хамтран 25 хүүхэд хамрууллаа.

“Хүн болох багаасаа” төслийн хүрээнд “Дорнын анир” утга зохиолын дугуйлан байгуулж 12,8,5, Хан-Уул сургуулийн 39 хүүхэд хамрагдан 7хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагуудад хичээллэж сургалтыг МЗЭ-ийн Дорнод салбарын гишүүдтэй хамтран зохион байгуулж хүүхдийн уран зохиолыг багаасаа сонирхох, номыг бүтээлчээр уншиж оюун дүгнэлт хийх зэрэгт ихээхэн ач холбогдлоо өгсөн.



Зохиолч уншигчдын уулзалт:

Зохиолч А.Гүрбямбаагийн “Дорнодын залуучуудын түүхэн товчоон” номын нээлтийг зохион байгуулж Дорнод аймгийн Залуучуудын Эвлэлийн ахмад ажилтны зөвлөлийн тэргүүн Ц.Түмэн, болон Эвлэлийн ахмад ажилтнууд нийт 75 хүн оролцлоо.

“Халхын сэцэн хан аймгийн үйзэн засгийн хошуу ба матад сум: түүх, шашин, соёл, байгаль” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Дорнод аймгийн Матад суманд амжилттай зохион байгуулсан.

Дорнод аймгийн зохиолч, номын санчидтай уулзалт хийж ШУА, ХЗХ, хэл бичгийн ухааны доктор (Ph.D) Б.Мөнхбаяр Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн”-дэх залуу охин монгол охин мөн үү ? сэдвээр илтгэл танилцуулж, шинжлэх ухааны ном зохиолыг Дорнод аймгийн уншигчдад зориулан аймгийн төв Номын санд хандивлалаа.

"Оросын уран зохиол" соёл боловсролын үйл ажиллагаа

Халхын голын ялалтын 85 жилийн ойн хүрээнд ОХУ-ын уран зохиолын ноён оргилуудын түүхийг ирээдүй хойч үе болсон хүүхэд, залууст сурталчлан таниулах, номоор дамжуулан амьдрах чадварт суралцах арга ухааныг түгээн дэлгэрүүлж, унших чадварыг сайжруулахад зорилгоор Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах болон дунд ангийн сурагчдад зориулан 04 дүгээр сарын 22-26-ний өдрүүдэд дараах ажлуудыг СУГ болон Аймгийн Музей, Халх голын Ялалт музейтэй хамтран зохион байгууллаа.

1. Номын үзэсгэлэн
 2. "Ном уншихын ач тус" лекц
 3. "Мартахын учиргүй Халхын гол" лекц
 4. "Тэд бидний төлөө, Бид тэдний төлөө" үзэсгэлэн
 5. Музейн боловсролын хөтөлбөрийг танилцуулах
- Энэ үеэр Хэрлэн сумын 1,5,8,11,12, Хан уул, Шинэ хөгжил сургуулийн 7-11р ангийн 1500 гаруй сурагчид хамрагдлаа.

Дөрөв: САЛБАРЫН ЦАХИМ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Цахим номын сангаас уншигчдад түгээхэд зориулж books.dornod-library.mn вэбсайтаа байгуулсан. Цахим номын сангийн вэбсайт манай улсад ховор тул

гадаадын вэбсайтаас туршлага судалж бүтээгдсэн. Дээр хэлсэнчлэн бэлэн плагин, модуль байхгүй учир код бичих зэргээр цаг хугацаа ажиллагаа их шаардаж байна.

Вэбсайтын шинэчлэл, хэвийн үйл ажиллагааг байнга хянан ажиллаж байна.

- “Цахим номын эрх авч үйлчлүүлсэн 1348 уншигч байна. Эдгээр уншигч 328200 удаагийн уншилт хийсэн.
- Мөн номын сангийн автоматжуулалтын LIB4U программыг өдөр тутамдаа хэрэглэн уншигчдад цаасан ном хайх, шинэ уншигч бүртгэх үйлчлэх зэргээр ашиглаж байна.
- Цахим уншлагын танхимд ЕБС-ийн сурагчид анги бүлгээрээ ирж ном унших үйлчлүүлж байна. Нийт 1500 гаруй иргэдэд үйлчилсэн.

Тав: САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

2024 онд улс, орон нутгийн төсвийг ангилагдсан зардлын дагуу зарцуулж шилэн дансанд тогтмол байршуулж байна. Санхүүгийн үйл ажиллагааг ОУНББСтандарт, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад дүрэм журмын дагуу тайлагнасан.

Үндсэн хөрөнгөнд машин тоног төхөөрөмж 16.200.0 төгрөгийн, тавилга эд хогшил 1.470.0 төгрөгийн, номын фонд 3.882.0 төгрөгийн нийт 21.552.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч эд ашиглалтын бүртгэлд тэмдэглэн албан хаагчдад хүлээлгэн өгсөн.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг комисс томилогдон хугацаанд нь хийж гүйцэтгэн хөрөнгийг нэг бүрчлэн тулган тоолж, ашиглалтын хугацаа болон элэгдэл нь дууссан хөрөнгийг актлах, устгаж ажлыг “Өмч хамгаалах зөвлөл”-өөр хэлэлцэн тушаал шийдвэрийг гаргасан.

Байгууллагын “Өмч хамгаалах зөвлөл” нь 2024 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хурлыг 3 удаа зохион байгуулж, тооллогын комиссын гаргасан шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгө болон бараа материалын бүртгэлд байгаа ашиглах боломжгүй хөрөнгийг устгах, акт үйлдэх зэрэг ажлуудыг хийсэн. Мөн хөрөнгө тус бүрийг товъёогжуулан, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, агуулахын эмх цэгцийг ханган ажилласан.

Бараа материалын хөрөнгийн бүртгэлд байгаа 17 нэр төрлийн 23 ширхэг 2,1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг Номын сангийн захирлын тушаалаар акталсан. Мөн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13.9 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийн актлуулахаар Орон нутгийн Өмчийн газарт хүсэлтээ гаргаад байна. Актлагдсан хөрөнгийг данс бүртгэлээс хассан.

Зургаа. САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР

Номын сангийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ тайлан болон холбогдох судалгаа мэдээллийг улирал бүр хугацаанд нь гарган хүргүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Албан хэрэг хөтлөлт Able программд ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүрд нь бүртгэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын цахим шуудан болох email-ийг ашиглан мэдээлэл солилцон, мэдээ тайланг хүлээн авах, яаралтай албан тоотыг хүргүүлэх, хүлээж авах зэрэг ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2024 онд 104 албан бичиг ирсэн хариутай 27 бичгийг бүртгэлд аван, бүртгэл хяналтын карт хөтлөн холбогдох зохион байгуулалтын нэгж, ажилтанд шилжүүлэн хариуг хүргүүлсэн.

Өргөдөл гомдлын чиглэлээр:

Албан хаагчдаас бичгээр 14 өргөдөл ирснийг /цалинтай чөлөө хүссэн-7, ажилд орох хүсэлт-4, ажлаас чөлөөлөгдөх-1, эчнээ сургалтад хамрагдах-1, тэтгэвэр тэтгэмж тогтоолгох-1, /Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Байгууллагын дотоод журамд заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн. Өргөдлийн 50 хувийг цалинтай чөлөө, 28 хувийг ажилд орох хүсэлтүүд эзэлж байна.

Байгууллагын архивын чиглэлээр:

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу өмнөх оны нийт байнга хадгалах 8 хадгаламжийн нэгж, түр хадгалах 23 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивд журмын дагуу байршуулаад байна.

Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцийн ажилтан (бичиг хэргийн ажилтан) нь hr.csc.gov.mn хаягаар нэвтэрч байгууллагын албан хаагчдын, орон тоо, ажлын байр, ажиллагсдын мэдээлэл, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, цалин хөлс, нөөцийн бүртгэл зэрэг үйл ажиллагааг бүртгэн, нууцлалыг бүрэн ханган өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Албан хаагчдын нэгдсэн судалгааг шинэчлэн гаргаж, хувийн хэргийн баяжилт хийсэн. Мэргэжил дээшлүүлэхээр нийтийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан Г.Ринчин СУИС-ын салбар Соёлын сургуулийн Номын сангийн эчнээ ангид суралцаж байна.

Төрийн болон аймаг орон нутгийн шагналаар 10 албан хаагч шагнагдсан. Үүнд: “Алтангадас одон”-оор Х.Чулуунцэцэг, ахмад номын санч Ж.Уранчимэг, Салбарын “Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр Хүний нөөцийн ажилтан М.Ариунаа, жижүүр Б.Энхболд, Соёлын яамны “Жуух бичиг”-ээр жижүүр С.Бат-Эрдэнэ, Ө.Наранбаатар, Хэрлэн сумын “Тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр нягтлан бодогч Г.Түмэнжаргал, А.Шүрэнцэцэг, хотын “Жуух бичиг”-ээр арга зүйч Н.Жавхлан, ҮЭ-ийн “Хүндэт тэмдэг”-ээр сан хөмрөгч Ж.Соня нар шагнагдсан.

Долоо. БУСАД АЖЛЫН ТАЛААР

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд өөрийн байгууллагын хашаа, орчиндоо 30 ширхэг шар хуайс шинээр тарьж, цэцгийн мандалд зүлгийн үр тарьж, эргэн тойрны цэвэрлэгээ, усалгаа хийж, ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн. Байгууллагын ахмадуудад 2 удаа хүндэтгэл үзүүлэн хүлээн авахад 1000,0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Хэрлэн голын эрэг дагуух цэвэрлэгээнд болон ХАБЭА-н сарын аяны нээлтэд бүрэн хамрагдсан. Байгууллагын гэрэл цахилгаан, өрөө танхимын хаалга, гэрэлтүүлэг зэрэг ажлуудыг хийж аюулгүй байдлыг ханган ажиллахаас гадна зудад нэрвэгдсэн малчдад 180000 төгрөгийн тусламж үзүүлсэн.

ҮР ДҮН:

- “Цахим номын сан”-гийн үйлчилгээг сошиал орчинд шейрлэх, лайв хийх, Хэрлэн сумын ЕБС-ийн сургуулиудад сурталчлан таниулснаар 2000 гаруй уншигчтай болж уншлага үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.
- Албан хаагчид ажлын байрандаа сурч хөгжих боломж бүрдсэн.
- Соёл олон нийтийн ажлын хүртээмж / Ном хожъё, Үлгэрийн цаг г.м / өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн.
- Өмнөх онтой харьцуулахад цахимаар үзэх уншигчдын тоо нэмэгдсэн.
- Номын сангийн үйлчилгээг шинэлэг байдлаар ард иргэдэд ойртуулан тэдний сонирхлыг татахуйц хэлбэрээр зохион байгуулан, Номын богц гэрээр хүргэх

үйлчилгээ, Ном хожъё, Үлгэрийн цаг, Цахим номын сан зэрэг ажлууд олон нийтэд хүрч Номын сангийн үйлчилгээ илүү их нээлттэй болсон.

- Сургуулийн өмнөх боловсролын суралцагсад болон бага ангийн сурагчид анги хамт олноороо номын сангийн уншигч болон багштайгаа ирж цахим үлгэрийн ертөнцөөр аялан, Номын сантай танилцах үйл ажиллагаа өмнөх оноос эрс нэмэгдсэн.
- Уншлага үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажилласнаар Үндэсний номын сангийн шалгаруулдаг “Ном цом” шагналаар шагнуулсан.

Цаашид:

1.Номын сан нь түүхэн өв, судар номыг хадгалж хамгаалдаг онцгой объект тул дээврийн болон сантехникийн их засварын ажлыг зайлшгүй хийж гүйцэтгүүлэх, цаашид дээрх орон тоог нэмэх шаардлагатай./зураг төсөв хийгдсэн/

2.Уншлагын танхимын засвар үйлчилгээ болон ширээ сандлыг шинэчлэх, мөн ном соёлын үйлчилгээг тасралтгүй олон нийтэд хүргэх зорилгоор Номын сангийн гадна талбайд LED дэлгэц байрлуулах хийж санал хүргүүлсэн. /зураг төсөв хийгдсэн/

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. ТҮҮХЭН ТОВЧООН
- 1.2. АЛСЫН ХАРАА
- 1.3. ЭРХЭМ ЗОРИЛГО

2. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Уншлага үйлчилгээ:
- 2.2. Шинэлэг үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр:
- 2.3. Соёл олон нийтийн ажил:
- 2.4. Алслагдсан хөдөөгийн иргэдэд Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:
- 2.5. Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан байдал:
- 2.6. Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:
- 2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:
- 2.8. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх:

3. САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

4. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
5. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
7. АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
8. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
9. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

10. САНАЛ, ДҮГНЭЛТ

11. ХАВСРАЛТ, БАРИМТ

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТҮҮХЭН ТОВЧООН

1946 онд Соёлын ордны дэргэд “Уншлагын газар” нэртэй, 2000 номтой байгуулагдаж Батнягт гэж эмэгтэй эрхлэгч-номын санчаар ажиллаж байв.

2002 онд Монгол Улсын Засгийн газрын 11 дүгээр сарын 20-ны өдрийн 237 дугаар тогтоолоор Алдарт гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн 100 жилийн ойг тохиолдуулан их зохиолчийн нэрэмжит болсон. 43.0 мянга орчим номын хөмрөгтэй. Уншлагын 3 танхимтай: Уншлагын их танхим, хүүхдийн болон “Гэр бүл танин мэдэхүйн танхим”, гэрээр ном олгох танхим. Хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхимууд чөлөөт сонголтоор үйлчилдэг. “Дуудлагын номын сангийн үйлчилгээ”-г 2017 оноос ажиллуулж эхэлсэн бөгөөд танхимаар үйлчлүүлэх боломжгүй иргэдэд ном, хэвлэлийг захиалгын дагуу хүргэж өгч үйлчилдэг үйлчилгээ юм.

1.2 АЛСЫН ХАРАА

Уламжлалд суурилсан цахим үйлчилгээ, оюуныг дээдэлсэн нээлттэй номын сан байна.

1.3 ЭРХЭМ ЗОРИЛГО

Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдээллээр иргэдэд шуурхай үйлчилж, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

ХОЁР. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Уншлага үйлчилгээ:

“Номын сангийн үйлчилгээг орон нутгийн хүн амын 10-аас доошгүй хувьд хүргэж үйлчлэх” зорилт дэвшүүлж 4 чиглэлээр, уншлагыг дэмжих 33, соён гэгээрүүлэх болон нөлөөллийн 18 арга хэмжээ зохион байгууллаа.

Шинэ уншигч 3080, нийт ирэгсдийн тоо 22240, ном олголтын үйлчилгээ 43064 ба төлөвлөгөөт ажлын тоон үзүүлэлт 2023 онтой харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Дуудлагын номын сан”, “Танд ойрхон номын сан” зэрэг шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн эрчимжүүлснээр иргэдийн ном хэвлэл уншиж ашиглах хэрэгцээг хангах, баг хамт олон, гэр бүлийн уншлагыг дэмжих ажлыг өргөжүүлэн тэлж, хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаа.

2024 онд “Дуудлагын номын сангийн үйлчилгээ”-ээр 150 хүнд 400 ном олгож үйлчиллээ.

Алслагдсан хөдөөгийн иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг 5 удаа хүргэсэн ба Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Хулд, Луус, Өндөршил, Өлзийт сумын соёлын төвийн номын сан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Дундговь аймаг дахь Политехник коллеж, Мандал, Эрдмийн далай ЕБСургуулийн номын сангууд зэрэг 10 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ном солилцооны үйлчилгээг тогтмол зохион байгуулж 450 номоор үйлчлэн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажиллав.

Сүүлийн жилүүдэд анги хамт олны уншлагыг дэмжих, соён гэгээрүүлэх ажлыг өргөжүүлэх зорилгоор “Олуулаа уншъя-Номтой нөхөрлөө” нөлөөллийн аяныг зохион байгуулсан бөгөөд 2024 онд тус аяны хүрээнд ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд “Чихэртэй уншлага”, дунд болон ахлах ангийн сурагчдын дунд “Ангийн номын санч”, гэр бүлийн дунд “Гэр бүлээрээ уншъя”, дотуур байранд амьдардаг сурагчдын дунд “Ухаалаг утаснаас уншлагын цаг руу”, “Өглөөний уншлага”, “Номтой эко аялал” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаа. Тус аяны

хүрээнд зохион байгуулагдсан 6 хөтөлбөрийн хүрээнд 1875 иргэн хамрагдсан байна.

2.2. Шинэлэг үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр:

Дундговь аймгийн Засаг даргын А/01 тоот захирамжаар 2024 оныг "Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалал"-ын жил болгон зарласантай холбогдуулан "УХААЛАГ УТАСНААС - УНШЛАГЫН ЦАГ РУУ" ном унших аяныг өрнүүлж, тус аяны хүрээнд "УНШИГЧ ХҮҮХДИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ"-ыг зохион байгууллаа.

Анхдугаар чуулга уулзалтад Д.Нацагдорж тэмдэгтэн, С.Буяннэмэх тэмдэгтэн сурагчдын төлөөлөл Дундговь аймгийн 15 сумын Ерөнхий боловсролын сургууль болон Политехник коллежийн 200 сурагчид чуулж, "Төгөлдөр Буяннэмэх сан"-гийн тэргүүн Л.Амаржаргалын "Суу билигт их зохиолч Сономбалжирын Буяннэмэх", Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч В.Түвшинтогтохын "Нийгмийн орон зай-суралцахуйн орчин", "Эрдмийн далай" сургуулийн 11а ангийн сурагч Д.Бямбажаргалын "Ухаалаг утаснаас уншлагын цаг руу" илтгэлүүд тавигдав.

Тус чуулганы хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- ✚ **Хүүхдийн салбар хуралдаан, чадавхжуулах сургалтаар** Мэргэшсэн боловсролын сэтгэл зүйч Г.Отгонсүрэн "Түүх бол миний сэтгэл зүй", Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Доржготов "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", Хүүхдийн хөгжил, хамгааллын ахлах мэргэжилтэн Г.Баярсайхан "Хүүхдийн хөгжил оролцоо" сэдэвт сургалтууд
- ✚ **Номын санчдын салбар хуралдаан, чадавхжуулах сургалтаар** МҮНС-ийн арга зүйч В.Түвшинтогтох "Номын сангийн үйлчилгээний чиг хандлага", "Соёл олон нийтийн ажлын шинэлэг хэлбэрүүд", "Зөөлөн ур чадвар/Soft skill/ ба номын санч" сэдвүүдээр, арга зүйч Б.Сарандэлгэр "Үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага", "Орон нутгийн ном зүй цахим номын сан" сэдэвт сургалт
- ✚ **Алдар гавъяат уран зохиолч С.Буяннэмэхийн хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаа:** Тус ёслолын үйл ажиллагаанд Дундговь аймгийн Утга зохиолын "Замбуу тив" нэгдлийн тэргүүн, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Эрдэнэбаярын Гантулга, МЗЭ-ий Яруу найргийн үндэсний төвийн дарга Н.Минжинсайхан нар үг хэлж, яруу найргийн дээжсээсээ сонордуулж хүндэтгэл үзүүлэв. Мөн МЗЭ-ийн шагналт, яруу найрагч О.Гончигсүрэн, Залуу яруу найрагч Б.Батхүү, Ю.Оюумаа нар шүлэг уншиж иргэдийн сонорыг мялаалаа.
- ✚ **Дундговь аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын шинэ номын нээлт, Зохиолч – уншигчийн уулзалт:** МЗЭ-ийн шагналт, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Болор цомын 2 удаагийн эзэн, яруу найрагч Цэндийн Чимэддоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд Дундговь нутгаас төрсөн гарсан эрдэмтэн зохиолч, яруу найрагч, эмхэтгэн бичигч 9 хүний 13 ном уран бүтээлийн нээлт боллоо. МЗЭ-ийн Дундговь аймаг дахь Утга зохиолчийн салбар "Замбуу тив" нэгдэл, зохиолч, яруу найрагчдын хамтарсан номын нээлтийн үеэр зохиолч

уншигчдийн уулзалтыг зохион байгууллаа. Зохиолч-уншигчдын уулзалтад Д.Нацагдорж тэмдэгтэн, С.Буяннэмэх тэмдэгтэн сурагчдын төлөөлөл Дундговь аймгийн 15 сумын Ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн сурагчид, сумдын нийтийн номын сангийн болон ЕБС-ийн номын санчид, нутгийн залуу зохиолч, яруу найрагчид оролцлоо.

✚ **Чуулганаас гарсан үр дүн:** Сургууль бүр дэргэдээ номын клубуудыг байгууллаа. Нийт 20 сургуулийн номын клуб байгуулагдаж цаашид ажиллах зорилгоо тодорхойллоо.

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр:

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.5.3.7-д “Төвөд номын фондыг шинээр үүсгэн байгуулах” гэж тусгагдсаны хүрээнд “Төвөд ном судрын сан хөмрөг үүсгэн байгуулж, баяжуулах төсөл”-ийг боловсруулан орон нутгийн удирдлагуудад танилцуулж, дэмжигдэн 7,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүллээ. 2021-2023 онуудад өөрийн нөөц боломжийг ашиглан 139 номоор баяжуулж, Дашгэмпилэн хийдийн дэмжлэгээр номын тавиур, ховор судрын шогол зэргийг хийж хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Төслийн хүрээнд сан хөмрөгт зайлшгүй хадгалагдах төвөд хэл дээрх болон монгол хэл дээрх төвөд судлалын номын судалгааг төвөд судлаачдын тусламжтайгаар хийж эхэлсэн бөгөөд шашин судлаач Б.Чинбат, иргэн Б.Өлзийням нартай хамтран ажиллаж судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурлан 38 нэр төрлийн 53 ном, судрыг 7,5 сая төгрөгөөр худалдан авч төвд номын баяжилтыг хийлээ. Мөн төслийн хүрээнд 108 баринтаг, донторыг иргэн Б.Чинбат хандивлалаа.

2.3. Соёл олон нийтийн ажил:

51 удаагийн соён гэгээрүүлэх, уншлагыг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулан 5007 уншигч, иргэдийг хамрууллаа. Үр дүнтэй ажлуудаас дурьдвал: “Уншигч хүүхдийн анхдугаар чуулга уулзалт”, “Олуулаа уншъя-Номтой нөхөрлөө” аян, “Дуудлагын номын сан”-ийн үйлчилгээ, “Ухаалаг утаснаас уншлагын цаг руу” нөлөөллийн аян, “Эх хэл тусгаар тогтнол” эсээ бичлэгийн уралдаан, ТАХ-д зориулсан “Мөнх тэнгэрийн бичиг” үндэсний бичгийн “Сайхан бичигтэн” шалгаруулах уралдаан, Зохиолч, уншигчийн уулзалт, “Өглөөний уншлага”, “Ном таая” өртөөчилсөн танин мэдэхүйн уралдаан, “Номтой гэр бүлийн болзоо”, “Хамтдаа өдөрлөг”, “Номтой шинэ жил” шилдгүүдийг тодруулах ёслолын үйл ажиллагаа, “Номтой эко аялал”, “Номын сангийн хишиг өдөр”, “Миний уншсан ном дүрслэх урлагт”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”, аймгийн “Харааны бэрхшээлтэй иргэдийн холбоо”-той хамтран “Цагаан таягтны өдөр”-г тохиолдуулан харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан номын өдөрлөг, “Үлгэрийн цаг”, “Ахмад настнаа сонсьё” өдөрлөг хэлэлцүүлэг, Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн амрагч хүүхдүүдэд зориулсан “Ардын зан үйл амьдрах арга ухаан” хөтөлбөр зэрэг үйл ажиллагааг хүүхэд залуучууд, тусгай хэрэгцээт иргэд, төрийн алба хаагч, ахмадууд, малчид, сумын иргэдийн дунд зохион байгуулсан нь соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэйгээр хүргэснээрээ онцлог байсан ба оролцогчдын сэтгэл ханамжид нийцсэн ажлуудыг зохион байгуулсан нь судалгааны үр дүнд гарч ирсэн. Мөн эдгээр үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн иргэдийн ном унших дадал хэвшилд нөлөөлж, эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан байна.

2.4. Алслагдсан хөдөөгийн иргэдэд Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:

Дэрэн, Дэлгэрхангай, Хулд, Луус, Дэлгэрцогт сумдад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж, номын санд зөвлөн туслах үйл ажиллагаа явууллаа. 5 удаагийн Зөөврийн номын сангийн үйлчилгээнд 416 иргэдэд 750 номоор үйлчиллээ. Мөн хаврын “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг Дэрэн, Дэлгэрхангай сумдтай хамтран зохион байгуулсан нь хөдөөгийн иргэдэд хүрч үйлчилсэн, номын баярын цар хүрээг өргөжүүлсэн, соён гэгээрүүлэх олон талт шинэлэг үйл ажиллагаа боллоо.

2.5. Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан байдал:

Албан байгууллага, Аж ахуйн нэгж, сургууль, цэцэрлэгүүдэд “Танд ойрхон номын сан”-ийн үйлчилгээгээр хүрч үйлчиллээ. Аймгийн Цагдаагийн газрын 30, Хүнс хөдөө аж ахуйн газрын 14, Мал эмнэлэгийн 21, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв 11, Нийгмийн даатгалын хэлтсийн 33, Мандалговь хотын 1, 7 дугаар цэцэрлэгийн 15, Эрдмийн далай сургуулийн 1, 2 дугаар дотуур байрны 120 сурагч, нийт 9 байгууллагын 244 алба хаагч, сурагчдад “Танд ойрхон номын сан”-ийн үйлчилгээгээр шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж үйлчиллээ.

2.6. Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:

Хүүхдийн уншлагын танхимаар 1225 шинэ уншигч, 5901 ирэгсдэд 12703 ном олгож үйлчиллээ. Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх “Гэр бүл, танин мэдэхүйн танхим”-аар 35 гэр бүлийн гишүүдэд 450 ном олгож үйлчилсэн байна.

Мөн "Гэр бүл, танин мэдэхүйн танхим"-д гэр бүл, анги хамт олноороо мэдлэг, оюун ухаанаа хөгжүүлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх, алжаалаа тайлахад зориулсан "Монгол шагай наадгай"-н буланг байгуулж шатар, даам, оюун ухаан хөгжүүлэх тоон болон оньсон тоглоомууд, шагайн наадгай, 4 бэрх, алаг мэлхий өрөх, бөгж нийлүүлэх, таван хошуу мал зэрэг тоглоомуудыг байрлуулж хүүхдүүд үндэсний өв уламжлал ёс заншлаа мэдэх, авхаалж самбаагаа сорих боломжийг бүрдүүлсэн ба тус булангаар 89 хүүхэд үйлчлүүллээ.

2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:

“Дүүрэн билиг” ТББ-тай хамтран “Хүүхдээс хүүхдэд” төслийн хүрээнд зорилтот бүлгийн хүүхдүүдэд номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, танин мэдэхүйн уралдааныг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийг соён гэгээрүүлэх, уншлагыг дэмжих олон талт үйл ажиллагаанд 150 иргэн хамрагдлаа. Харааны болон хэл, сонсголын бэрхшээлтэй 2 насанд хүрэгч, 2 хүүхдэд тусгайлан үйлчилгээ үзүүлж, тэдний ном унших, мэдээлэл авах хэрэгцээг ханган ажиллав. Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх хүрээг өргөжүүлэх зорилгоор зориулалтын томруулдаг шил 3-ыг худалдан авч, сонин сэтгүүл унших нөхцөл бүрдүүлэн 6 иргэнд үйлчиллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ая тухтай орчин бүрдүүлж, хүртээмжтэй үйлчлэх зорилгоор байгууллагын ариун цэврийн өрөөг засварлан тохижуулж, стандартад нийцсэн зориулалтын пандус хананд суурьлуулах ажлуудыг хийлээ.

2.8. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх:

Номын сангийн уншигч, ирэгсдээс улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна.

Үр дүнд суурилсан санхүүжилтийн үр дүнд соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, урам зоригийг төрүүлэх зардлуудыг шийдвэрлэж өгснөөр сүүлийн 3 жилд иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, сэтгэл ханамжийг сайжруулан номыг тойрсон олон талт үйл ажиллагааг өргөжүүлэх нөхцөл бололцоо хангагдаж эхэллээ. Энэ нь уншигчид, оролцогсод, хамрагсдаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар нотлогдож байна.

ГУРАВ. САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

“Сан хөмрөгийн баяжилтыг чанартайгаар бүрдүүлэн жил бүр 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна” зорилтыг дэвшүүлэн 12 арга хэмжээг зохион байгууллаа. Манай номын сан Үндсэн фонд, тогтмол хэвлэлийн фонд, 3 уншлагын танхим дэргэдэх ойрын фонд гээд сан хөрөгүүдийг зохион байгуулдаг.

Эдгээрт нийт 43000 номыг хадгалан 59 хувийн эргэлттэйгээр 2024 онд уншигчдад үйлчилсэн байна. Номыг шинжлэх ухааны төрөл анги, үсэг дарааллаар стандартын дагуу байрлуулдаг ба хүүхдийн уншлагын болон гэрээр ном олгох танхимуудын сан хөмрөг чөлөөт сонголттой. Сан хөмрөгийн баяжилтыг худалдан авалт, бэлэг хандив, нөхөн бүрдүүлэлтээр хийдэг ба 2024 онд худалдаагаар 160 нэр төрлийн 176 ширхэг 4,561,100 төгрөгийн ном, бэлэг хандиваар 174 нэр төрлийн 244 ширхэг 3,214,000 төгрөгийн ном, нийт 7,775,100 төгрөгийн 334 нэр төрлийн 420 номоор сан хөмрөгийн баяжилт хийв. 10 нэр төрлийн 26 нэгж сонин, сэтгүүлийг 781,200 төгрөгөөр захиалж тогтмол хэвлэлийн сан хөмрөгөө баяжууллаа. Уншигч, иргэдээс ирүүлсэн 143 номын татгалзлыг шүүж, дүн шинжилгээ хийн, номын татгалзлыг 90 хувьтай барагдуулсан ба нэн шаардлагатай 89,700 төгрөгийн 4 номыг худалдан авч нөхөн бүрдүүллээ.

“Дундговь Ариусгал” ариутгалын байгууллагатай гэрээ байгуулан 2 удаа ариутгал хийлгэж, тоосжилтыг багасгах зорилгоор чийгшүүлэлтийг тогтмол хийн хянаж ажиллав.

Уншлагын танхимуудад төлөвлөгөөт бус 2, хяналтын тооллогыг 1 удаа хийж тооллогын акт үйлдэн үр дүнг тооцож, хэрэгжилтийг ханган ажиллаа. Байгууллагын 97 ширхэг нэг бүрчилсэн бүртгэлийг LIB4U програмтай тулган баталгаажуулж Коха системд нэвтрэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Уншигч алдаж үрэгдүүлсэн номын төлбөрийг нягтлан бодогч, номзүйч, сүлжээний инженерийн тусламжтайгаар 100% барагдуулав. Зарим дутагдсан номыг утга, агуулга дүйцүүлэн номыг номоор орлуулан төлбөр барагдуулах 3 удаагийн актын шийдвэрийг хэрэгжүүллээ.

Номын санчдын өдөр тутмын анхан шатны бүртгэл хөтөлгөө, тоон төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт хийж ажиллаа.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд тэгш ой тохиож буй Дундговь аймгаас төрж гарсан зохиолчдын жагсаалтыг боловсруулж, намтар ном зүй хийх, зохиолчийн намтар, уран бүтээлээр үзэсгэлэн гарган цахимаар болон танхимаар сурталчлан, алдаршууллаа.

Бэлтгэсэн ном зүй:

1. БНМАУ-ын анхны гавьяат жүжигчин, Зууны манлай нэрт уртын дуучин Жигзавын Дорждагвын намтар, уран бүтээлийн судалгааг ном, тогтмол хэвлэлийн материалаас шүүж, 76 бичилт бүхий намтар ном зүйн;
2. МУСГЗ зохиолч Х.Зандраабайдийн намтар, уран бүтээлийн судалгааг шүүж, 181 бичилт бүхий намтар ном зүйн;

3. МУСГЗ, МЗЭ, Д.Нацагдорж, С.Буяннэмэхийн шагналт зохиолч нийтлэлч До.Цэнджавын намтар, уран бүтээлийн судалгааг шүүж, 330 бичилт бүхий намтар ном зүйн;
4. С.Буяннэмэхийн нэрэмжит зохиолч Ц.Түмэнбаярын намтар, уран бүтээлийн судалгааг шүүж, 248 бичилт бүхий намтар ном зүйн;
5. МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, зохиолч, яруу найрагч, эмч Долгорын Нямаагийн намтар, уран бүтээлийн судалгааг шүүж, 230 бичилт бүхий намтар ном зүйг тус тус хийлээ.
6. Тогтмол хэвлэл, сонин сэтгүүлийн мэдээллээс түүвэрлэн “Орон нутаг судлах картын сан”-г 2879 картаар баяжууллаа.
7. Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн сан Зотеро программд 1956 оны “Чойлбалсанч”, 2021, 2023, 2024 оны “Дундговийн амьдрал” сониноос 859, 2020-2024 оны “Боловсрол судлал” сэтгүүлээс 272 бичилт хийж МҮНС-д мэдээ хүргүүлээ.

Сурталчлан, алдаршуулсан үйл ажиллагаа:

1. Сайхан-Овоо сумын харъяат Зууны манлай уртын дууч, МУ-ын анхны гавъяат жүжигчин Ж.Дорждагвын мэндэлсний 120 жилийн ойд зориулсан намтар уран бүтээлийн үзэсгэлэн, ОУ-ын эрдэм шинжилгээний хурал;
2. Эрдэнэдалай сумын харъяат МУСГЗ зохиолч Х.Зандраабайдийн мэндэлсний 90 насны ойд зориулан 31 нэр төрлийн 82 номоор үзэсгэлэн; МУҮНС-д “Бадмаарсан зул- 4” номын нээлт;
3. Соёлын яамнаас С.Буяннэмэхийн нэрэмжит сар болгон зарласантай холбогдуулан МҮНС-тай хамтран Их Зохиолчийг алдаршуулах 4 төрлийн уралдааныг ЕБС-ийн болон оюутан сурагчдын дунд;
4. Сайнцагаан сумын харъяат Монголын хүүхдийн уран зохиолын нэрт төлөөлөгч, МЗЭ, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, Сэтгүүлчдын холбооны шагналт сэтгүүлч С.Надмидын мэндэлсний 90 насны ойд зориулсан үзэсгэлэнг 2 удаа 86 номоор; “С.Надмидыг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн уралдаан, “Номтой эко аялал”;
5. Гурвансайхан сумын харъяат МУСГЗ, МЗЭ, Д.Нацагдорж, С.Буяннэмэхийн шагналт зохиолч нийтлэлч До.Цэнджавын мэндэлсний 70 насны ойд зориулан “Утгын чимэг-2023” богино өгүүллэгийн наадамд түрүүлсэн “ТАМГА” өгүүллэгийг цахим хэлбэрээр, мөн 26 номоор үзэсгэлэн;
6. Өндөршил сумын харъяат С.Буяннэмэхийн нэрэмжит зохиолч Ц.Түмэнбаярын мэндэлсний 65 насны ойд зориулан 16 номоор;

7. Ном солилцооны үйлчилгээгээр Өлзийт сумын соёлын төвд тус сумын харъяат МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, зохиолч, яруу найрагч, эмч Долгорын Нямаагийн 20 нэр төрлийн 50 ном, Өндөршил сумын соёлын төвд Дэлгэрхангай сумын харъяат МУАУЗ, С.Буяннэмэхийн нэрэмжит шагналт, МЗЭ-ийн шагналт зохиолч С.Дашдооровын 30 нэр төрлийн 109 номыг тус тус солилцоогоор шилжүүлэн уншигчдад үйлчилж Дундговь аймгаас төрөн гарсан зохиолчдыг аймгийн болон улсын хэмжээнд сурталчлан алдаршууллаа.

Дээрх зохиолч, яруу найрагчдын сан хөмрөгт хадгалагдаж буй нийт 141 нэр төрлийн 369 номоор үзэсгэлэн гаргаж, 750 уншигч, иргэд, хүүхэд багачуудад сурталчилсан байна.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өмнөговь аймгийн нийтийн номын сантай хамтын ажиллагааг өргөжүүлж, тус номын сангийн үйл ажиллагаатай танилцан туршлага солилцож 2 байгууллагын онцлог ажлууд сайн туршлагаас суралцах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгууллаа.

Мөн Өмнөговь аймгийн нийтийн номын сангийн хамт олон хүрэлцэн ирж манай байгууллагын үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцон “Номын сангийн цахимжуулалт” сургалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр УИХ-ын гишүүн Р.Сэддоржоос сумдын номын сангуудын сан хөмрөгийг баяжуулах зорилгоор бэлэглэсэн “Дэлхийн Монголчуудын түүх” 9 боть, 900,000 төгрөгийн номыг 14 сумын нийтийн номын сан болон Төв номын санд хүлээлгэн өглөө.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Соёлын яамнаас хэрэгжүүлж буй Цахим номын сангийн нэгдсэн систем Коха 22.11 программыг нэвтрүүлэх сургалтыг сургагч багш МУҮНСангийн Уншлага, үйлчилгээний хэлтсийн дарга С.Цоггэрэл, ном зүйч Б.Гантулга нар Төв номын сангийн хамт олон, орон нутгийн соёлын төвийн болон ЕБС-ийн номын санчдад 2 өдөр амжилттай зохион байгууллаа.

Коха 22.11 программыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж МҮНС-ийн арга зүйн хэлтэст байгууллагын номын сангийн программын нөөц, баазыг 4 талбараар хүргүүлж хөрвүүлэг хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаа.

ДОЛОО. АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орон нутгийн бүх төрлийн номын сан, номын санчдад тухай бүр арга зүйн зөвлөгөөг өгч ажилласнаас гадна Дундговь аймгийн “Ид шидийн орон” хүүхэд хөгжлийн төвийн номын санд ном зүйч Э.Биндэръяа, арга зүйч Ө.Ууганбаяр нар очиж зөвлөн туслах ажил хийлээ. Энэхүү ажлын хүрээнд ном тус бүрт техник ажиллагаа хийх, нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэх, нэгдсэн бүртгэл хөтлөх, номын санчийн анхан шатны бүртгэл хөтөлгөөг хөтлөж хэвших зэрэг мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, 2 хоногийн дадлага ажлыг тус байгууллагад хийлээ. Мөн тус төвийн номын санчийг өөрийн байгууллага дээр 3 хоногийн дадлага ажил хийлгэн зөвлөн туслаж ажиллав.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан орон нутгийн мэдээллийн төв болох зорилтын хүрээнд захирал, арга зүйч, ном зүйч-сан хөмрөгч, сүлжээний инженер, номын санч-мэдээллийн ажилтан гэсэн мэргэжлийн 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааг явуулж байна.

Ажлын байрны сэтгэл зүй, орчин үеийн чиг хандлага, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг судлах, төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн Хүүхдийн болон уншлагын их танхимын номын санч-мэдээллийн ажилтны сонгон шалгаруулалтад сэтгэл зүйч мэргэжилтэй гэсэн шалгуур үзүүлэлтийг давуу тал болгон зарласнаар сэтгэл зүйч мэргэжилтэй алба хаагчдыг авч ажиллуулж байна. Мөн тухайн алба хаагчдыг номын санчийн мэргэжлээр сургах арга хэмжээг зохион байгуулж, багц цагийн сургалтад хамруулахаар бүртгүүлээ. Алба хаагчдыг чадавхжуулах зорилго бүхий “Нэг алба хаагч-Нэг сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба энэхүү хөтөлбөрийн хүрээнд алба хаагч өөрөө болон бусад сургагч багш нарын тусламжтайгаар 14 хоногт 1 удаа төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж хэвшсэн.

ЕС. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн нэмэгдэл, түлш, хоолны хөнгөлөлтийг бүх алба хаагчдад олгож, зарим алба хаагчдад эмчилгээний болон байр сууцаа тохижуулах, засварлах, шинэ байранд орсны тусламж дэмжлэгийг үзүүлэн нийгмийн баталгааг хангаж ажиллаа. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж нийт 70,058,589.73 мөнгийг зарцуулсан байна. Үүнд:

- ✚ Ур чадварын нэмэгдэлд: 23,262,244 төгрөг
- ✚ Үр дүнгийн нэмэгдэлд: 30,571,595 төгрөг
- ✚ Унаа хоолны зардалд 16,256,000 төгрөг
- ✚ Буцалтгүй тусламжид: Давхардсан тоогоор 17 алба хаагчид 5,968,750 төгрөгийн, 50,600 төгрөгийн бензин зарцууллаа.
- ✚ Эмчилгээний зардалд 5 албан хаагчид 1,000,000 төгрөг
- ✚ Шинэ төрсөн хүүхдэд 1,400,000 төгрөгийн дэмжлэг
- ✚ Байгууллагын шилдэг 2 алба хаагчид 2,000,000 төгрөг
- ✚ Алба хаагчдын ар гэрийн гачигдалд 1,568,750
- ✚ Түлшний хөнгөлөлтөд ердийн галлагаатай орчинд амьдардаг 7 албан хаагчид 1,750,000 төгрөг

АРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Дүгнэж хэлэхэд:

1. Сүүлийн жилүүдэд хүүхэд багачууд, өсвөр үеийнхнийг аливаа хорт муу зуршлаас хамгаалах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд нийтийн номын сангуудын үүрэг их болсныг жил бүр өсөн нэмэгдэж буй уншигчийн тоо, үйлчилгээний хүртээмжээс харж болно. Иймд манай байгууллага тэдний эрэлт хэрэгцээнд зориулж баг хамт олноороо, гэр бүлээрээ унших, оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллаа.
2. Үр дүнд суурилсан санхүүжилтыг бий болгосноор номын сангийн нөлөөллийн үйл ажиллагаанууд өргөжиж, нэр хүнд нь өссөн ба цаашид санхүүжих болон үйл ажиллагааны томоохон төсөл хөтөлбөрт хамрагдаж хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна.


3. Уншигчид өөр орчин нөхцөл, шинэ үйлчилгээг шаардах болсныг харгалзан судалж дүгнэлт хийн ажил хэрэг болгохыг хичээж ажиллаа. Илүү үр дүнтэй болгохын тулд аймаг орон нутгийн удирдлагууд, бусад төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжүүдийн дэмжлэгийг авч хамтран ажиллах зайлшгүй хэрэгтэй гэж үзэж байна.


Доорх саналыг дэвшүүлж байна:

1. Орон нутгийн номын санчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, чадавхжуулахад дээд байгууллагатай хамтран ажиллах саналтай байна;
2. Сан хөмрөгийг баяжуулах төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх;
3. Монгол Улсын стандартад заагдсан шаардлагатай орон тоо бүтцээр ажиллах, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдахад бүгд хамтран санаачилгатай ажиллах, гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамруулах;
4. Номын санчдыг мэргэшүүлэх, туршлага судлуулах, улмаар ажилтан солилцоог гадаадын номын сангуудтай хийх боломжийг судалж зөвлөгөө өгөх;

АРВАН НЭГ. ХАВСРАЛТ, БАРИМТ









ЗОХИОЛ БҮТЭЭЛ. (ОН ДАРААЛЛААР)

1. Зандраабайдий Х. Хонкон дуу. Өгүүлэгүүд / УБ.: УХГ. - 1964.
2. Зандраабайдий Х. Манай нутгийнхан. Найрууллууд / Ред. С.Дашдэндэв. - УБ.: УХГ. - 1967. - 127х.
3. Зандраабайдий Х. Төрийн нууц. Д.Сүхбаатарын тухай / Ред. С.Дашдэндэв. - УБ.: УХГ. - 1969. - 110х.
4. Зандраабайдий Х. Цагаан дэлт халиун. Туужууд / Ред. Л.Түдэв. - УБ.: УХК, 1971. - 175х.
5. Зандраабайдий Х. Галтай залуу нас. Гурван тууж / Ред. Л.Чойжилсүрэн. - УБ.: УХГ, 1973. - 255х.
6. Зандраабайдий Х. Хүүхдийг малд дуртай болгодог ардын уламжлал / Ред. Б.Бор. - УБ.: УХГ, 1974. - 52х.
7. Зандраабайдий Х. Их айлын эзэгтэй. Найрууллууд / Ред. Л.Чойжилсүрэн. - УБ.: УХГ, 1974. - 165х.
8. Зандраабайдий Х. Сувд эрдэнэ. Туужууд / Ред. Б.Баасг. - УБ.: УХГ, 1977. - 238
9. Зандраабайдий Х. Хэнгэрэг хээр. Хүүхдийн өгүүлэгүүд / Ред. Д.Мягмар. - УБ.: Шинжлэх ухааны академийн, 1980. - 78х.
10. Зандраабайдий Х. Түлэнхий шарга. Хүүхдийн өгүүлэгүүд / Ред. Д.Мягмар. - УБ.: АБЯ, 1984. - 47х.
11. Зандраабайдий Х.Гул аранжин. Киноны зохиолууд / Ред. Н.Банзрагч. - УБ.: УХГ, 1982. - 281х.
12. Зандраабайдий Х. Аранга. Жүжгийн зохиолууд / Ред. Д.Жамбаажамц. - УБ.: УХГ, 1989. - 235х.
13. Зандраабайдий Х. Найман сургаж. Баримтат туужууд / Ред. С.Лочин. - УБ.: УХГ, 1986. - 133х.
14. Зандраабайдий Х. Суман хурэн. Өгүүлэгүүд / Ред. Д.Маам. - УБ.: УХГ, 1991. - 245х.







100 жилийн ойгоо баяртай!
 100 years of joy!
 100 жыл баяртай!



Монгол өв соёл - Монгол дээлээрээ гоёцгооё - Монгол дээлээ урлаж шаглахад зааж сургасан уран ээжээрээ мөнхөд бахархаж явдаг даа



Уншлагын танхимын номын санч, мэдээллийн ажилтан Ц.Оюунжаргал

Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвшье



Дунговь Төв Номын Сан
 17 January

МОНГОЛ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ БОЛСОН ӨВ СОЁЛОО ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ, СОЁЛЫН ДАРХЛАГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛГООР САР БҮРИЙН 3 ДАХЬ ДОЛОО ХОНОГИЙН ЛХАГВА ГАРАГТ ҮНДЭСНИЙ ДЭЭЛ ХУВЦСАА ӨМСӨЖ ХЭВШҮҮЛЬЕ!

Үндэсний дээл хувцсаа өмсөх өдөр
 1-р сар 20



1 comment 1 share



100 100
 100 years of joy!

"МИНИЙ ГЭР БҮЛ" УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА, ҮЭСГЭСЭЛЭН

АРДЫН ИХ ХУРЛЫН ДЕПУТАТ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН АСАН, МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭЙН СВАТМОНХ, ГАВЬЯАТ БАТЦИ З.ЯНЖМАА НАРЫН ГЭР БҮЛИЙН УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА, ҮЭСГЭСЭЛЭН



УУЛЗАЛТ: 2023 ОНЫ 11 САРЫН 24-НЫ ӨДРИЙН 10.00 ЦАГТ "ЭНГЭРИЙН ГЭМЭСЭН" ХУУДИЙН ТЕАТРТ

СОЁЛЫН БҮТЭЭ







АН РХ
ЛИН ВЕР

Энэхүү романы тухай: Яд амьдралаар өссөн Бэйя Чинэз гаралтай Самсон хоёрын тала гэхдээ хоёр хүний тэгш илүүтэйгээр нийгмийн тэгш гадна орчны харилцаа, үр хүүд ойр дотно хүмүүсийн харилцаа залуу хүмүүст тулгарч буй том эрхэн яаж даван туулж чадаж сонирхолтойгоор харуулсан. Хүмүүний амьдралын нэгдсэн зохиолын аргаар өгүүлсэн байна.

Хятадын хүүхдийн зохиол Шиси ан амьтны тухай зо бүтээлээрээ хэдийн алдартай Номын тухай: Цас цавцайн; Үүлс хошилдсон Рицкоагийн цасанд дагадан намхан бол Эцэст нь Гамазырын уужим хөндий дун цагаанаар эргэ нэлэнхүйдээ зузаан цасан ху хучигдав.

Орчуулж эмхэтгэсэн: Ж.Тэгшээ

Дэлхийн шилмэл хайрын өгүүлл Номын тухай: Гоо үзэглэл би шаарх... гоо үзэглэл бол үйл үг... үзэглэл бол ертөнцийг аварда нэг зүйл... гоо үзэглэл бол тоо, тоо... гоо үзэглэл бол миний дэчиний дур, гоо үзэглэл бол мидоторх...

Ангалан Хань өмнө буюу Улаан сухай номын зо Монгол үг бүтэл зохиолч түүний амьдралын түүх бүт Хятад орны өмнөдөр, өмнөдөр, маргаа өгүүлсэн зохиолч өөрөө ч тухайн үедээ мэдэ Эн хоёр цэрвэл ном АНУ-д эвлэлдэн гарсан, бүтэлээр болжээ.

Хятад улсад үндэсчүл нийгэм ирж, тэрчүү ертөнцийг даван туулж буй иргэдийг төлөөлө буюуны түүхийг өгүүлнэ. Хууданд нь аав эгнэч хийж, Могооныг дагал цугтуйг өгчдийг нь гадурдан зайлуулж буй нь айшигт дэглэм өөр аргачууд хүргэж буй тухай өгүүлнэ.

УЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САН


ШИНЭ НОМЫН ТАНИЛЦУУЛГА

Гэрээр ном олгох танхим 2024 он

Хятадын зохиолч: Анчи Мин (Дундунгийн) 2 Номын тухай товчоон:

Соёлын хуансгалын дараа Хятад оронд цэгт гур дараарсан ч коммунист нам барьж байгаа цагт дараагийн соёлын гараагүй гэх итгэл, эерхийн ард иргэд амархан төрсөнгүй. Энэ байдалд эгчөлөөг мэдрэхийг хүссэн хэдэн мя залуусын төлөөлөл болсон харь хэл мэд бусгүй 1984 онд хүн танихгүй, АНУ-д хал газардан, иөрөөлдөө хэрхэн хүрсэн ту туужид өгүүлэх болно.





Дундговь Төв Номын Сан

ШУУНШЛАГЫН ТАНХИМ

"Ном унших гэдэг чинь агуу юм..." гэжэр орж ирэн хөвөрлөн өвөө минь нүдний шилээ мартсан ч номын санд "ТОНУРУУДАА" шилээ байдаг гэдгийг мэдээд ээ тэгээд өдөр дутлын шилээ уржээд гарцаа гээд бөөн бээр уншисар л...

Ахмадуудаяа дуугарай!

өө Нүдний шилээ мартсан галгүй ном, сонин, сэтгүүлээ цаг алдалгүй унших боломжтой.



"Номын баяр" "Олуулаа уншъя-номтой нөхөрлөө" аяны хүрээнд

“Бид номын нөхөд “Хүүхэд бүр унших” ЭДСургуулийн 1.2 дотуур байрын суралчдын дунд зохион байгуулагдаж байгаа хөтөлбөр үргэлжилсээр...”

“Ухаалаг утаснаас уншлагын цаг руу” сургалт үр дүнгээ өгч 2 дах үйл ажиллагаа “НОМТОЙ УУЛЗАЛТ” амжилттай боллоо.



“Олуулаа уншъя- номтой нөхөрлөө” аяны хүрээнд “Ухаалаг утаснаас уншлагын цаг руу” хөтөлбөр үргэлжилсээр...

ЭДСургуулийн 1, 2-р дотуур байрын сурагчид “УХААЛАГ-УНШЪЯ-УНШСАНАА БАТАГТАЯ” уриан дор 3 дах удаагийн уулзалтаа зохион байгууллаа. Уулзалтаар Ном таах, алдартнуудын тухай, номын тухай хэлсэн ишлэлүүдийг зөв олох, Монгол ардын тоглоом шайгай, наадгай зэргээр оюун ухаанаа сорин нэг оройй хөгжил, хөөр дүрэн өнгөрүүлээ. Идэвхтэй өрсөлдсөн хүүхэд багачууддаа баярлалаа. Илүү их амжил хүсье.



С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САН, МЭЭ-ИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ УТГА ЗОХИОЛЫН САЛБАР “ЗАМБУУ ТИВ” НЭГДЭЛ

НАМРЫН БАЯР **НОМЫН НЭЭЛТ**






Монгол бичгээ мэдье" алтан хонх тэмцээн тус өрөөнд төрийн алба хаагчдын иэдэглэийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан ба 120 гаруй төрийн албан хаагчийг хамруулсан.



Мандалговь, 2024 оны тавдугаар сарын 31 /МОНЦАМЭ/. С Буяннэмэхийн нэрэмжит Дундговь аймгийн төв номын сан, Сайнцагаан сумын Эрдмийн далай сургуультай хамтран дотуур байрны сурагчдын дунд "Ухаалаг утаснаас уншлагын цаг руу" хөтөлбөр хэрэгжүүлэн үр дүнгээ хэлэлцлээ.

Тус номын сангаас хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэн ном унших хүсэл эрмэлзэлтэй болгож, тэдний өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх "Олуулаа уншъя, номтой нөхөрлөө" аянаар олон хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.





ЗАВХАН АЙМГИЙН Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛГААНЫ ТАЙЛАН

Тайлангийн бүтэц:

1. Товч танилцуулга
2. Номын сангийн сан хөмрөг
3. Номын сангийн уншлага үйлчилгээ
4. Лавлагаа номзүйн ажил
5. Номын сангийн мэдээлэл технологийн үйл ажиллагаа
6. Арга зүйн ажил
7. Хүний нөөц
8. Дүгнэлт

НЭГ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга: Завхан аймгийн номын сан нь 1946 онд Гэгээрлийн хэлтсийн даргын 65 тоот тушаалаар аймгийн бага хурлын номын сан нэртэйгээр 500 номтойгоор 1 орон тоотой анх байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болон 77 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго: Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх “Мэдээллийн нээлттэй” төв болох

ХОЁР: НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус номын сан нь 2024 оны эцсийн байдлаар 56093 ширхэг 149804233 төгрөгийн Монгол, Англи, Орос, Төвд хэл дээрх ном хэвлэлтэй бөгөөд Монгол номын фонд- 2, гадаад /орос/ номын фонд- 1, Гадаад /англи/ номын фонд -1 үйл ажиллагаагаа явуулж байна. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг худалдаа, хандиваар бүрдүүлдэг бөгөөд ном хэвлэл худалдан авах журмаар бүрдүүлэн ажиллаж байна. 2024 онд 205 нэр төрлийн 314 ширхэг 8204597 төгрөгийн ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлснээс:

- Худалдаагаар: 131 нэр төрлийн 186 ширхэг 4548497 төгрөгийн ном
- Хандиваар: 74 нэр төрлийн 128 ширхэг 3618100 төгрөгийн номоор фондоо баяжуулан үндсэн фонд болон тасаг танхимуудад хүлээлгэн өгч ажилласан байна.
- М бүүк платформоос: 58 ширхэг 1000000 төгрөгийн үнэ бүхий цахим номоор фонд баяжилт хийж цахим ном уншлагын булан байгуулан ажиллаж байна.

- Тогтмол хэвлэл: 6 нэр төрлийн 540600 төгрөгийн тогтмол хэвлэлийн захиалгыг хийж, 316 дугаар нэгжлэн үдэж, уншигчдад лавлагаа мэдээлэл өгч байна.
- Брайл ном: Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 4 боть 900000 төгрөгийн үнэтэй брайл болон кирилл бичгийн хосолмол хэвлэлтэй ярьдаг “Монголын нууц товчоо” номоор фонд баяжилт хийлээ.

Уншлага үйлчилгээнд ашиглагдах боломжгүй болсон 175 ширхэг номыг сэлбэн засах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сан хөмрөгт хадгалагдаж буй Төвд хэлээр бичигдсэн болон гар бичмэл, судруудын хадгалалт хамгаалалтыг сайжруулан баримтат өвд бүртгүүлэх цаашлаад ганц хувьтай судрыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлуудыг хийж эхлээд байна.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь Уншлага үйлчилгээний:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох тасаг
- Англи хэлний сургалтын танхимаар үйлчилгээ явуулдаг

Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2501 уншигч 6688 ирэгсдэд 8293 ном олгож үйлчиллээ.

Албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн ажилтан албан хаагчдад номын сангийн үйлчилгээнд татан оролцуулан, албан хаагч бүрээс унших дуртай номын судалгаа авч захиалсан номыг зөөврөөр хүргэн өгч, хамтран ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 15-н байгууллагын уншигчдад 1519 номыг зөөврөөр олгож үйлчиллээ. Уулын аялагч нарт зориулсан "Хүлээж суухгүй хүрч үйлчилье" уриатай Товцог хайрхны өвөрт кофетой уншлага, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллалаа. Уг үйл ажиллагаа нь уншигчдын таашаалд нийцсэн үйлчилгээ боллоо.



Номын эргэлтийн үйл ажиллагааг сайжруулах, номоор дамжуулан уншигчдад мэдээ мэдээлэл өгөх соён гэгээрүүлэх, болон төлөвлөгөөт үйлчилгээ арга хэмжээ болон тэмдэглэлт баяр ёслолоор 66 удаа 1800 ширхэг номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тасаг танхимуудад болон төрийн байгууллагуудаар гаргах ажлыг зохион байгууллаа.



Дорнын их найрагчийн мэндэлсний 95 жилийн ойн хүрээнд Би хаана төрөө вэ? шүлгээр “Шүлэгч анги” шалгаруулах уралдааныг зохион байгуулж 420 суралцагч оролцлоо. Мөн их найрагчийн 95 насны ойд зориулан “Цастын гэгээн үдэш” яруу найраг, уран бүтээлийн цэнгүүнийг аймгийн Утга зохиолын нэгдэл, СУГ-тай хамтран зохион байгууллаа.



Жил бүр Үндэсний бичиг үсгийн баярыг угтан "Босоо бичигтэн" уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулж Улиастай сумын ЕБ-ын 6-8, 9-11-р ангийн сурагчдын дунд монгол бичгийн “Хичээнгүй бичиг” уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд эхийг түргэн, чадварлаг бичих, хөрвүүлэх зэрэг хугацаатай даалгавар

өгч уралдааныг дүгнэн оролцогчдын бүтээлээр үзэсгэлэн гарган үндэсний бичгээ түгээн дэлгэрүүлж, өв соёлоо сурталчлан ажиллалаа. Уг уралдаанд 29 сургуулийн 6-12-р ангийн 66 анги бүлгийн 1527 суралцагч оролцлоо.



“Үндэсний бичиг соёл”-ын жилийн хүрээнд зохион байгуулсан “Монгол бичгийн тэргүүний уншигч” шалгаруулах улсын XVIII уралдаанд 12 сумын ЕБ-ын 15 сургуулийн нийт 46 суралцагч оролцлоо.



“Үндэсний бичиг соёл”-ын жил, “ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ”-ийн 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Төрөлх монгол хэл” уран бичлэгийн улсын IX уралдааны II шат 4-р сарын 12-ны өдөр Завхан аймгийн нийтийн номын санд амжилттай зохион байгуулагдлаа.



Хэл бичгийн ухааны доктор, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт хүүхдийн зохиолч Д.Батжаргалтай зохиолч уншигчдын уулзалт зохион байгууллаа.

Номын хэлэлцүүлэг зохиолчтой уулзах уулзалтыг Төв номын сан, ЧЭС-ийн монгол хэлний тэнхимтэй хамтран Яруу найраг хэрхэн бичих, Ардын дүрслэлийн хэл сэдвээр 2 үе шаттайгаар зохион байгуулж нийт 80 хүн хамрагдсан.



Хавар, намрын “Уншлагыг дэмжих-2024” аяны хүрээнд “Шүлэгч-анги”, “Б.Явуухулан тэмдэгтэн анги”, “Уран зохиол ба шүлгүүд”, “Англи ном орчуулга”, “Кофетой уншлага” зэрэг 5 нэр төрлийн төлөвлөгөөт арга хэмжээг удирдамжийн дагуу ЕБС-ийн 680 суралцагчид болон 80 насанд хүрэгчдийг хамруулан зохион байгууллаа.





“Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг” сэдвийн хүрээнд Ардын уран зохиолч П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” бүтээлээр Хос бичигтэн байгууллага шалгаруулах уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд 8 байгууллагын 18 албан хаагчид оролцлоо. Мөн монгол бичгээр хэвлэгдэн гардаг хүмүүн бичиг сониныг албан хаагч нарт уншуулах ажлыг зохион байгууллаа.



Тэмдэглэлт баярын өдрийн тохиолдуулан Хас банк, Нэткатипал ББСБ, Төрийн банкны ажилтнуудыг дунд асуулт хариултын хөгжөөнт “Ном хож” уралдаан, Завхан аймаг дахь МУИС, ПТК-ын оюутнуудын дунд “Алтан хонх” танин мэдэхүйн

уралдааныг тус тус зохион байгууллаа. Нийт 55 оюутан, албан хаагчид идэвхтэй оролцлоо.



Жил бүр BOOKFRIEND англи хэл дээрх ном хэвлэлийг унших, дэвтэр хөрвүүлэн орчуулах, англи хэлний шинэ үгсийн сан нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх зорилготой англи ном унших аяныг ЕБС-ын дунд, ахлах ангийн суралцагчдыг хамруулан зохион байгуулж байна. HARRY POTTER англи хэл дээр хэвлэгдэн гарсан шинэ номоор фондоо баяжуулж, уншигч хүүхдүүдэд үйлчлэн Harry potter цуврал киног англи хэлээр үзүүлж, Movie night үйл ажиллагааг зохион байгууллаа. Аянд 350 суралцагчид хамрагдлаа.



“Үндэсний бичиг соёл номын баяр арга хэмжээ-2024”

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг “Илүү их уншъя” уриатайгаар Завхан аймгийн Соёл урлагийн газар, БШУ-ны газар, Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан, Утга зохиолын нэгдэл хамтран зохион байгууллаа. Энэ үеэр Отгон сумын харьяат МЗЭ-ийн гишүүн аймгийн УЗН-ийн гишүүн Бямбаагийн Туяацэцэгийн “Цаст уулын найраг номын нээлт боллоо. Номын баярын энэ өдөр уншигчдад мэдээлэл олгох, соён гэгээрэхүйн үйл ажиллагаанд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж идэвхтэн уншигч байгууллага, хамт олон, тэргүүний уншигчдаа тодруулан урамшуулах арга хэмжээг зохион байгууллаа. Мөн Номын баяраар суралцагчдын хийсэн Номтой шүлэгтэй бага нас бүтээлийн үзэсгэлэн, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, үнэт ховор, мартагдсан номын үзэсгэлэн, Уран зургийн үзэсгэлэн, нийтэд дэлгэн үзүүлж нас насны онцлогт зориулсан номын багц бэлгийг 10 азтанд шалгарууллаа. “Номын баяр-2024” 35, 36 дахь арга хэмжээг угтан нийт 47 нэр төрлийн соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж, 3800 суралцагч уншигчид хамрагдсан байна. Нээлтийн арга хэмжээнд 1750 иргэд хүрэлцэн ирж оролцлоо.



“Соёлын бүтээлч сар” арга хэмжээ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт , Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийг энэ сарын онцлох хүнээр сонгон түүний намтар уран бүтээлийг уншигч түмэндээ сурталчлан, номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй түүний ном хэвлэлээр сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргасан. Мөн Улс тунхагласны өдрийг тохиолдуулан анги хамт олноороо “Тусгаар тогтнол” шүлгийг уран тод унших уралдаан зохион байгууллаа.



Ахлах ангийн суралцагчдад илүү ухаалаг шийдвэр гаргах, бодитой сонголт хийхэд туслах ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь суралцагч, эцэг эхэд төдийгүй Монгол улсын нийгэм, эдийн засагт чухал хувь нэмэр оруулна иймд Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн Г. Пүрэвдорж ЧЭС-ийн 11-р ангийн сурагчдад ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж хамтран ажиллаа. Нийт 43 сурагч хамрагдлаа.



Ном сэлбэн засах сургалт

Ном хэвлэл сэлбэн засах ажлын зорилго нь баримт бичигт гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, баримт гэмтэж муудаж буй шалтгааныг илрүүлэх, цаашид энэ үйл явцыг зогсоох замаар баримтыг судалгаа, лавлагаанд ашиглах нөхцөл бүрдүүлж, хадгалалтын хугацааг уртасгахад оршино. Иймд урагдаж гэмтсэн ном хэвлэлийн гэмтлийг бага дээр нь тодруулах гэмтэл үүссэн тохиолдол авах арга хэмжээний талаарх сургалтыг ЕБ-ийн 4-р сургуулийн 10а ангийн 24 суралцагчид зохион байгууллаа.



Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлж, номын тойм яриа зохион байгууллаа.

"Сайн уу? Хамгийн сайн хувилбар минь" энэхүү номонд бид өнөөдөр өчигдрөөс илүү хүн байхын төлөө өдөр бүр хичээж, өөртөө зөв хөрөнгө оруулалтыг хийж чадвал өөрийнхөө хамгийн сайн хувилбарыг бүтээж чадна гэдэг санааг зохиолч өөрийн амьдралын бодит түүх, туршлага зэрэг дээр үндэслэн уншигчдадаа хүргэхийг хичээсэн байна. Тухайн номын танилцуулга, зохиолчийн танилцуулга



хийж 1-р бүлгийг аудио хэлбэрээр сонсож дараах уншигчдын сэтгэгдлийг харилцан ярилцаж тухайн номыг унших хүсэл, сонирхол төрүүлсэн номын тоймыг Политехник коллежийн Авто инженерийн ангийн 19 суралцагчдад зохион байгуулж, 35 номоор зөөврийн ном олголоо.

Үлгэрээ сонсоцгооё чанга уншлага

Бага насны хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, үлгэрээр дамжуулан өв соёл, ёс суртахуун олгох зорилготой энэхүү чанга уншлагыг танин мэдэхүйн ном болон Монгол ардын үлгэрийн дээжсээс уншлаа. Үүнд Улиастай сумын 1, 4-р цэцэрлэгийн 262 суралцагчид хамрагдлаа. ХЖТ-ын жүжигчин Б.Батдоржтой



хамтран Д.Содномдоржийн "Норовын намтар" зохиолоор чанга уншлага хийж номын сангийн фейсбүүк хуудсаар шууд бичлэг дамжуулсан. Энэхүү үйл ажиллагаанд ЕБ-ын 4-р сургуулийн Ө.Одмаа багштай 2а ангийн 23 сурагч оролцлоо.

Ном уншихын ач тус лекц

Монголчууд “Ухаан далай номоос эхтэй” гэж үр хүүхдэдээ сургаж ирсэн билээ. Ном хүний оюун ухааныг задалж, логик сэтгэлгээг хөгжүүлдэг. Уншсан номынхоо сонин сайхан зүйлийг ухаж учрыг нь сайн ойлгох гэж хичээдэг учраас ном уншдаг сэтгэн бодох чадвар сайтай, дөлгөөн, ухаалаг, аливааг олон талаас нь бодож зөв шийдвэр гаргадаг.

Иймд хүүхэд багачуудыг багаас нь номтой нөхөрлүүлэх, ном уншихын ач тус хийгээд гэрийн номын санг бий болгох уриалга гарган цахим хэрэглээг багасгах зорилготой лекцийг ЕБ-ийн 3-р сургуулийн Нансалмаа багштай 10Б, ЕБ-ийн 4-р сургуулийн Уламбаяр багштай 10А анги, Долгорсүрэн багштай 10Б ангиудын 91 суралцагч хамрагдлаа.



Англи хэл дээрх ном уншлага: Англи хэл сурахад хамгийн амархан хэр нь сонирхолтой арга бол ном унших юм. Тухайн хэл дээр ном уншсанаар үгийн баялаг нэмэгдэж, дүрмийн алдаа засагдаж, ярианы хэллэг сайтай болдог. Тиймээс ЕБС-ийн бага бүлгийн англи хэл анхлан суралцагчдад зориулсан "Reading English Books" уншлагын дугуйлангийн үйл ажиллагааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагуудад зохион байгуулж эхэллээ. Нийт 41 суралцагч хамрагдлаа.

Зохиолч, яруу найрагч Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлэг Монгол Улсын Тусгаар тогтнолын үнэ, цэнийг тодорхой илэрхийлсэн алдартай бүтээл юм. Уг шүлгэнд "Улс гэрээ тунхагласан эх оронч өвөг дээдсийн хатан зориг, олон мянган цэрэг эрсийн халуун амь, Монголчууд биднийг сорьсон цадиг түүхийн өмнө бүтэн үлдсэн үндэсний дархлаагаа тунхаглан зарлаж, бахархан омогшиж, үр хойчдоо үеийн үед үүрд сануулан үгээр сийлсэн бүтээл билээ. Төв номын сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг энэхүү уралдаанд Аймгийн төвийн 5-н сургуулийн 6-9-р ангийн суралцагчдын дунд анги хамт олноороо уран тод зөв цээжээр уншиж эхний 3 байрт орсон анги хамт олныг шалгаруулж өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Нийт 262 суралцагчид оролцлоо.



ДӨРӨВ: КАТАЛОГ, ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Каталог, картын сангийн зохион байгуулалт:

Шинээр ирсэн 314 ширхэг номонд техник ажиллагаа хийн Электрон каталогт оруулан цаасан каталог хэвлэн байрлууллаа.

LIB4U болон Монбиблио програмын хэвийн үйл ажиллагааг ханган сумдын номын санчдад зөвлөгөө өгөн ажиллаж байна.


Номзүйн ажил:

Zotero програмд Туяа сонины 1979 оны 67 өгүүллүүдийг оруулан МҮНС-ийн нэгдсэн системд хүргүүлэн ажиллалаа.

2010-2022 оны хооронд гаргасан Санамж өгөх номзүйн бүртгэлүүдээ хавар намрын номын баяраар үзэсгэлэн гаргаж уншигчдад лавлагаа мэдээлэл өгөн ажиллаж байна.

“Завхан цахим түүх” влогт 23 сумын номын санчидтай Завхан нутгаас төрөн гарсан Зохиол, Яруу найрагчдын намтар уран бүтээл сумдын түүхийг оруулан уншигчдад мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Омега програмд оруулсан “Туяа” сонины дугааруудыг уншигчдад сурталчлах ажлыг зохион байгуулж уншигчдад тухай бүр нь лавлагаа мэдээлэл өгч байна. Тус сонины 21 нийтлэл мэдээллээр ТУВА улсын соёлын өдрүүд арга хэмжээнд үзэсгэлэн гаргаж оролцлоо.



ТАВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛ

Сумдын номын сангуудын Монбиблио програмыг онлайнд холбуулан тэдний ажлыг шууд хянах боломж бүрдэж байгаа бөгөөд хөгжүүлэлтмйн багийнхантай хамтран уг програмын тухай заавар зөвлөмжийг тухай бүр нь хүргэн ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын LIB4U програмын хэвийн ажиллах нөхцлийг ханган Волвес компанийн инженер Гантулгаас утсаар болон фэйсбүүкээр заавар зөвлөгөө аван өөрийн ажилтнуудад програмын шинэчлэлт, програмд гарсан засвар үйлчилгээний талаар мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Соёлын яамнаас олгосон Lip top зөөврийн компьютерь, laser jet олон үйлдэлт принтер, байгууллагын өөрийн хөрөнгөөр Dell optiplex tower 7020 i7-14700 маркын суурин компьютер зэргийг авч албан хэрэгцээнд хэрэглэж байна. Мөн интернэтийн хурдыг сайжруулж “Гайхмаар хурд” ХХК-тай 3 жилийн гэрээ байгуулж 4GB-ийн хурдаар интернэт авч ашиглаж байна.

ЗУРГАА: АРГА ЗҮЙН АЖИЛ

Цахим номын сангийн нэгдсэн систем коха программын сургалт

Монгол Улсын Засгийн газар, Соёлын яамны санаачилгаар аймаг, орон нутгийн номын сангуудыг олон улсын мэдээлэл солилцох стандартыг дэмждэг, номын сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, цогц үйлчилгээ үзүүлэх боломж бүхий нэгдсэн цахим системд холбох ажил эхлээд байна. Уг ажлын нэг хэсэг нь тухайн номын санд ажиллаж буй албан хаагчдыг сургах, дадлагажуулах бөгөөд үүний дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн мэргэжилтнүүд 2024 оны 06 дугаар сарын 17-18-ний өдрүүдэд Завхан аймгийн нийтийн номын санд ном зүйч Б.Цогжаргал, Т.Наранчимэг нар ажиллаж цахим системийн талаарх сургалтыг удирдан явууллаа.



БНТува улсын номын сангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага

солилцлоо

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сангийн төлөөлөл А.С.Пушкиний нэрэмжит Тува улсын Үндэсний номын сантай танилцаж, туршлага судлан цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



Сумдын номын санд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Яруу, Ургамал, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, сумдуудаар нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүлж номын сангуудын нөхцөл байдалтай танилцан мэдээллээр ханган зөвлөн туслах ажлыг зохион байгуулж цаашид авч хэрэгжүүлэх ажлын жагсаалт гарган хамтарч ажиллахаар боллоо. /Дөрвөлжин сумын номын сан/

/Ургамал сумын номын сан/

/Яруу сумын номын сан/

/Эрдэнэхайрхан сумын номын сан/




/ Зөөврийн номын сангийн үйлчилгээ, номын үзэсгэлэн/



Сумдын номын санчдад зохиулсан цуврал цахим сургалт.

“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Шинэ номын мэдээ бэлтгэх, Уншигчийн сонирхлын судалгааг цахим хэлбэрт шилжүүлэх, Влог хэрхэн хөтлөх, Canva программ дээр урилга, өргөмжлөл бэлтгэх талаарх цуврал цахим сургалтуудыг сумын номын санч нарт зохион байгууллаа. Энэ жилийн тухайд алслагдсан бүс нутагт байгаа номын санчдыг мэдээллээр хангах, ажлын байран дээр тулгамдсан асуудлуудыг шийдэхэд нь туслах зорилготойгоор танхимын болон цахим сургалтуудыг тогтмол зохион байгуулж ажиллахад илүү их анхаарч ажиллаа.





“Соёл урлагийн ажилтны өдөр”-ийн хүрээнд Аймгийн соёл урлагийн ажилтны 7-р чуулганыг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Улиастай хотод зохион байгуулсан. Энэ үйл ажиллагааг тохиолдуулан Б.Явуухулангийн нэрэмжит Аймгийн төв номын сангаас Сумын Соёлын төвийн нийтийн номын санчдад Соёл урлагийн мэдээ гаргах зөвлөмж, Номзүйн бичилтийн тухай ерөнхий ойлголт, Шинэ номын мэдээ бэлтгэх дадлага ажил, Соёл олон нийтийн ажил зохион байгуулах туршлага зэрэг сэдвээр сургалтад зохион байгууллаа. Нийт 17 номын санч хамрагдлаа. Мөн Завханмандал, Тэс сумдад шинээр орсон номын санч нарт анхан шатны мэдлэг олгох дадлагажуулах сургалтыг 7 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Сургалтад хамрагдсанаар Төлөвлөгөө тайлан боловсруулах, Анхан шатны бүртгэл хөтлөх, Каталог зохион байгуулах, Ном ангилах, ажиллах талаар анхан шатны мэдлэгтэй болж сан хөмрөгөө зохион байгуулах, уншигчтай ажиллах чадварыг эзэмшлээ.



ДОЛОО: ХҮНИЙ НӨӨЦ

Манай номын сан нь захирал, нягтлан бодогч, ном зүйч, мэдээллийн технологич, мэдээллийн ажилтан, фондчин, номын санч-3, зөөврийн номын санч, үйлчлэгч сахиул гэсэн 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээр ажилтнуудаас Мэргэжлийн номын санч-4, Номын сангийн чиглэлээр Магистр хамгаалсан ажилтан – 3 ажилтан ажиллаж байгаа бөгөөд номын санчдыг мэргэшүүлэн сургах сургалтанд хамруулж чиглэл чиглэлээр нь туршлага судлуулсан дадлага ажлуудыг холбогдох газруудад хийлгэж кредит цагийн сургалтуудад номын санчдыг хамруулах шаардлага тулгарч байгаа.

Байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг тэлэх зорилгоор тухайн жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлон улирал бүр мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

ДҮГНЭЛТ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь 2024 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 96.4%-тай хийж гүйцэтгэсэн ба ХШҮДАХ-ээс 86.6%-тай үнэлэгдсэн байна.

Уншлага үйлчилгээний хувьд: Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2501 уншигч 6688 ирэгсдэд 8293 ном олгож үйлчиллээ. Уншигч- 65.8%-тай, Ном олголт- 15.07%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна. Цаашид уншигчийн тоо нэмэгдүүлэх, ном олголтын хувийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

Номын сангийн сан хөмрөгийн хувьд: Номын сангийн сан хөмрөгийн нэр төрлийг шинэчлэн уншигчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан тасаг танхимууд дээр ирсэн татгалзлын бүртгэлийн дагуу шинэ содон ном хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан ажиллалаа.

Арга зүйн ажлын хувьд: 2024 оны төлөвлөгөөт сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллалаа. Танхимын сургалтууд болон сумдын номын санчдыг өөрийн байгууллага дээр дадлагажуулах ажлыг зохион байгуулан тодорхой үр дүнд хүрч байна. Энэ жилийн нэг онцлог нь сумын номын санд газар дээр нь очиж ажил байдалтай танилцан цаашид авч хэрэгжүүлэх ажлын жагсаалт гарган хамтран ажилласанаараа үр дүнтэй байлаа.

Соёл олон нийтийн ажлын тухайд: 2024 оны төлөвлөгөөнд орсон ажил үйлчилгээ 100% хийгдсэн ба нэмэлтээр олон төрлийн уншигч руу чиглэсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 2024 онд 57 нэр төрлийн СОНА зохион байгуулан 4300-аас дээш уншигчийг хамруулан ажилласан байна.

Техник, тоног төхөөрөмж: Энэ онд үр дүнд суурилсан санхүүжилтээр соёл олон нийтийн ажилд зайлшгүй шаардагддаг 4 ширхэг асар шинээр худалдан авсан, ажиллагсадын бичиг хэрэг хийж хадгалах зориулалтын 3 сейф, номын санчдад 7 сандал, Соёлын яамнаас олгосон Lip top зөөврийн компьютерь, laser jet олон үйлдэлт принтер, өндөр хүчин чадал бүхий суурин компьютер зэрэг 11 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

ХАВСРАЛТ

1. Ном олголт

№	Номын сан	Стандарт хэмжээ	Үйлчилсэн тоо хэмжээ
26	Улаанбаатар ХоТНС	112500	147655
25	Орхон	112500	128656
24	Дорнод	55000	114621
23	Дархан АТНС	112500	76862
22	Дархан ХНО	55000	74684
21	Ховд	55000	63688
20	Хөвсгөл	55000	62671
19	Хэнтий	55000	62330
18	Архангай	55000	57749
17	Баян-Өлгий	55000	57400
16	Өмнөговь	55000	57293
15	ХүТНС	112500	50004
14	МҮНС	130000	49469
13	Дундговь	55000	43006
12	Сэлэнгэ	55000	35589
11	Сэлэнгэ Мандал	55000	35443
10	Төв	55000	35323
9	Баянхонгор	55000	31904
8	Өвөрхангай	55000	30847
7	Увс	55000	24356
6	Говь-Сүмбэр	55000	18847
5	Булган	55000	17662
4	Сүхбаатар	55000	17615
3	Дорноговь	55000	13280
2	Говь-Алтай	55000	9481
1	Завхан	55000	8808

2. Ирц

№	Номын сан	Тоо хэмжээ
26	Дорнод	82028
25	Улаанбаатар ХотHC	70461
24	Орхон	66676
23	Дархан ХНО	61526
22	Дархан АТНС	56950
21	МҮНС	49520
20	Ховд	46532
19	Хэнтий	43644
18	Баян-Өлгий	32100
17	Хөвсгөл	31581
16	ХүТНС	29004
15	Сэлэнгэ Мандал	21558
14	Архангай	20412
13	Өвөрхангай	19897
12	Өмнөговь	19383
11	Булган	19207
10	Сэлэнгэ	15610
9	Дундговь	14049
8	Төв	13633
7	Баянхонгор	13508
6	Сүхбаатар	11786
5	Дорноговь	9760
4	Увс	9180
3	Говь-Алтай	8765
2	Говь-Сүмбэр	7117
1	Завхан	6688

3.Байнгын уншигчид эзлэх ирцийн хувь, хэмжээ

№	Номын сан	Стандарт хэмжээ	Байнгын уншигч	Ирц
26	Дорнод	3800	82028	82028
25	Улаанбаатар ХотНС	7500	25115	70461
24	Орхон	7500	61465	66676
23	Дархан ХНО	3800	4617	61526
22	Дархан АТНС	7500	5456	56950
21	МҮНС	8000	12240	49520
20	Ховд	3800	2539	46532
19	Хэнтий	3800	6216	43644
18	Баян-Өлгий	3800	18801	32100
17	Хөвсгөл	3800	18880	31581
16	ХүТНС	7500	32999	29004
15	Сэлэнгэ Мандал	3800	5001	21558
14	Архангай	3800	2840	20412
13	Өвөрхангай	3800	662	19897
12	Өмнөговь	3800	4242	19383
11	Булган	3800	2995	19207
10	Сэлэнгэ	3800	3980	15610
9	Дундговь	3800	3080	14049
8	Төв	3800	2087	13633
7	Баянхонгор	3800	2645	13508
6	Сүхбаатар	3800	2986	11786
5	Дорноговь	3800	1150	9760
4	Увс	3800	9606	9180
3	Говь-Алтай	3800	7765	8765
2	Говь-Сүмбэр	3800	785	7117
1	Завхан	3800	3014	6688

4.Сан хөмрөгийн баяжилт

№	Номын сан	Тоо хэмжээ
26	Улаанбаатар ХоТНС	5707
25	Дархан АТНС	2360
24	МҮНС	2245
23	Төв	2119
22	Сэлэнгэ Мандал	1744
21	Өмнөговь	1170
20	ХүТНС	1011
19	Увс	837
18	Дархан ХНО	749
17	Хөвсгөл	643
16	Өвөрхангай	554
15	Ховд	540
14	Сэлэнгэ	518
13	Говь-Сүмбэр	507
12	Баян-Өлгий	499
11	Сүхбаатар	481
10	Булган	461
9	Баянхонгор	452
8	Хэнтий	426
7	Дундговь	420
6	Орхон	395
5	Дорнод	367
4	Дорноговь	349
3	Завхан	322
2	Говь-Алтай	243
1	Архангай	71

5. Сан хөмрөгийн баяжилтад худалдаж авсан номын тоо

№	Номын сан	Нийт баяжилт	Худалдаж авсан
26	Улаанбаатар ХотНС	5707	1310
25	МҮНС	2245	908
24	Дархан ХНО	749	736
23	Хөвсгөл	643	518
22	Өмнөговь	1170	496
21	ХүТНС	1011	478
20	Өвөрхангай	554	413
19	Булган	461	373
18	Увс	837	361
17	Сэлэнгэ	518	344
16	Говь-Сүмбэр	507	289
15	Сүхбаатар	481	279
14	Ховд	540	252
13	Баянхонгор	452	249
12	Дорноговь	349	236
11	Баян-Өлгий	499	224
10	Орхон	395	198
9	Завхан	322	186
8	Хэнтий	426	185
7	Дундговь	420	171
6	Төв	2119	167
5	Сэлэнгэ Мандал	1744	157
4	Дархан АТНС	2360	146
3	Говь-Алтай	243	96
2	Дорнод	367	74
1	Архангай	71	71

6.Сан хөмрөгийн эргэлт

№	Номын сан	Олголт	Сан хөмрөг тоо	Эргэлтийн хувь
26	Дархан ХНО	74684	16610	450
25	Орхон	128656	36222	355
24	Дорнод	114621	73580	156
23	Хэнтий	62330	45727	136
22	Өмнөговь	57293	44871	128
21	Дархан АТНС	76862	61509	125
20	Сэлэнгэ Мандал	35443	30159	118
19	Дундговь	43006	42332	102
18	Төв	35323	36298	97
17	Баян-Өлгий	57400	60444	95
16	Хөвсгөл	62671	69188	91
15	Ховд	63688	76482	83
14	Сэлэнгэ	35589	47714	75
13	Говь-Сүмбэр	18847	13680	71
12	Баянхонгор	31904	51013	63
11	Өвөрхангай	30847	49615	62
10	ХүТНС	50004	90500	55
9	Булган	17662	36093	49
8	Архангай	57749	127199	45
7	Улаанбаатар ХоТНС	147655	390120	38
6	Сүхбаатар	17615	51924	34
5	Увс	24356	72993	33
4	Дорноговь	13280	40321	33
3	Говь-Алтай	9481	48358	20
2	Завхан	8808	56976	15
1	МҮНС	49469	2758687	2

7.Хүн амын хэдэн хувьд олголт хийсэн

№	Номын сан	Үйлчлэх хүн ам	Нийт олголт	Хүн амд эзлэх хувь
26	Архангай	20369	57749	295
25	Төв	17152	35323	218
24	Дорнод	47275	114621	210
23	Ховд	34173	63688	165
22	Орхон	106411	128656	126
21	Баян-Өлгий	45420	57400	125
20	Увс	31727	24356	123
19	Хөвсгөл	46541	63688	123
18	Дундговь	45900	43006	90
17	Булган	15357	19662	89
16	Говь-Сүмбэр	10876	18847	89
15	Сүхбаатар	20999	17615	84
14	Дархан АТНС	89130	76862	78
13	Өмнөговь	31205	57293	76
12	Хэнтий	28148	62330	75
11	Дархан ХНО	89130	74684	69
10	Завхан	16005	8808	67
9	Дорноговь	46443	13280	55
8	Говь-Алтай	18723	9481	54
7	Баянхонгор	32711	31904	48
6	Сэлэнгэ Мандал	26481	35443	43
5	Өвөрхангай	36481	30847	42
4	Сэлэнгэ	36399	35589	40
3	Улаанбаатар ХоТНС	1734848	147655	8
2	МҮНС	1734848	49469	3
1	ХҮТНС	1734848	50004	3

8.Лавлагаа

№	Номын сан	Лавлагааны тоо
26	Сүхбаатар	8678
25	Өмнөговь	5878
24	Улаанбаатар ХотНС	4203
23	Хэнтий	3386
22	Баянхонгор	1886
21	ХүТНС	1675
20	Дархан АТНС	1594
19	Дархан ХНО	1519
18	Дорнод	1048
17	Говь-Сүмбэр	820
16	Архангай	807
15	Завхан	511
14	Баян-Өлгий	451
13	Дорноговь	443
12	Хөвсгөл	401
11	Сэлэнгэ Мандал	374
10	Булган	362
9	МҮНС	328
8	Орхон	285
7	Сэлэнгэ	265
6	Увс	215
5	Төв	156
4	Ховд	135
3	Дундговь	121
2	Говь-Алтай	108
1	Өвөрхангай	32

9.Хүн амын хэдэн хувь нь байнгын уншигч

№	Номын сан	Хүн ам	Уншигч
26	Дорнод	47275	82028
25	Орхон	106411	61465
24	ХүТНС	1734848	32999
23	Улаанбаатар ХоТНС	1734848	25115
22	Хөвсгөл	46541	18880
21	Баян-Өлгий	45420	18801
20	МҮНС	1734848	12240
19	Увс	31727	9606
18	Говь-Алтай	18723	7765
17	Хэнтий	28148	6216
16	Дархан АТНС	89130	5456
15	Сэлэнгэ Мандал	26481	5001
14	Дархан ХНО	89130	4617
13	Өмнөговь	31205	4242
12	Сэлэнгэ	36399	3980
11	Дундговь	45900	3080
10	Завхан	16005	3014
9	Булган	15357	2995
8	Сүхбаатар	20999	2986
7	Архангай	20369	2840
6	Баянхонгор	32711	2645
5	Ховд	34173	2539
4	Төв	17152	2087
3	Дорноговь	46443	1150
2	Говь-Сүмбэр	10879	785
1	Өвөрхангай	36481	662

10 СОНА

№	Номын сан	Нийт
26	Улаанбаатар ХоТНС	1178
25	Дорноговь	443
24	Дархан АТНС	407
23	Сэлэнгэ	258
22	Хөвсгөл	248
21	Булган	177
20	Сэлэнгэ Мандал	168
19	Өмнөговь	162
18	Ховд	135
17	Баян-Өлгий	131
16	Хэнтий	127
15	Баянхонгор	113
14	Төв	110
13	Дархан ХНО	84
12	Орхон	84
11	Дорнод	83
10	Завхан	74
9	МҮНС	65
8	Архангай	61
7	Сүхбаатар	59
6	Дундговь	58
5	Говь-Сүмбэр	52
4	Увс	52
3	Говь-Алтай	48
2	Өвөрхангай	48
1	ХүТНС	43

11. Зөөврийн номын сан

№	Номын сан	Олгосон ном
26	Хөвсгөл	10524
25	Дархан АТНС	9455
24	ХүТНС	6340
23	Хэнтий	6270
22	Өмнөговь	4990
21	Баян-Өлгий	4949
20	Булган	4800
19	Дархан ХНО	4726
18	Сэлэнгэ	3456
17	Дорнод	3082
16	Увс	2182
15	Сүхбаатар	2163
14	Дорноговь	2132
13	Улаанбаатар ХоТНС	1912
12	Төв	1777
11	Орхон	1286
10	Ховд	1080
9	Архангай	891
8	Завхан	850
7	Дундговь	679
6	Баянхонгор	547
5	Сэлэнгэ Мандал	538
4	Өвөрхангай	478
3	МҮНС	463
2	Говь-Сүмбэр	368
1	Говь-Алтай	321

12. Номын санч сэтгүүлд өгүүлэл өгсөн байдал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	0
2	Баян-Өлгий	0
3	Баянхонгор	0
4	Булган	0
5	Говь-Алтай	0
6	Говь-Сүмбэр	0
7	Дархан АТНС	0
8	Дархан ХНО	0
9	Дорноговь	0
10	Дорнод	0
11	Дундговь	0
12	Завхан	0
13	МҮНС	0
14	Орхон	0
15	Өвөрхангай	0
16	Өмнөговь	0
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	0
19	Сэлэнгэ Мандал	0
20	Төв	0
21	Увс	0
22	Улаанбаатар ХоТНС	0
23	Ховд	0
24	Хөвсгөл	0
25	ХүТНС	0
26	Хэнтий	0

Онооны зарчим:

Өгүүлэл өгсөн аймагт 10, өгөөгүй аймагт 0 оноо.

13. Тайлангаа цагтаа өгсөн байдал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	10
2	Баян-Өлгий	10
3	Баянхонгор	10
4	Булган	10
5	Говь-Алтай	5
6	Говь-Сүмбэр	10
7	Дархан АТНС	10
8	Дархан ХНО	10
9	Дорноговь	10
10	Дорнод	10
11	Дундговь	5
12	Завхан	10
13	МҮНС	10
14	Орхон	10
15	Өвөрхангай	10
16	Өмнөговь	10
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	10
19	Сэлэнгэ Мандал	10
20	Төв	10
21	Увс	10
22	Улаанбаатар ХоТНС	5
23	Ховд	10
24	Хөвсгөл	5
25	ХүТНС	10
26	Хэнтий	10

Онооны зарчим:

Цагтаа өгсөн аймагт 10, өгөөгүй аймагт 0 оноо.

14. Коһа нэвтрүүлэлт, манлайлал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	10
2	Баян-Өлгий	5
3	Баянхонгор	5
4	Булган	10
5	Говь-Алтай	8
6	Говь-Сүмбэр	5
7	Дархан АТНС	8
8	Дархан ХНО	8
9	Дорноговь	10
10	Дорнод	5
11	Дундговь	10
12	Завхан	8
13	МҮНС	10
14	Орхон	10
15	Өвөрхангай	5
16	Өмнөговь	10
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	8
19	Сэлэнгэ Мандал	5
20	Төв	8
21	Увс	10
22	Улаанбаатар ХоТНС	10
23	Ховд	10
24	Хөвсгөл	8
25	ХүТНС	8
26	Хэнтий	10

Онооны зарчим:

Давтан сургалт авч идэвхтэй хандсан аймагт 10, идэвхтэй байгаа байгаа аймагт 8, эхний сургалтаас хойш холбогдоогүй аймагт 5 оноо.

15. Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллэгийн санд мэдээ өгсөн байдал

№	Номын сан	Олгосон ном
10	МҮНС	3774
10	Дундговь	372
10	Хөвсгөл	292
10	Орхон	289
10	Сүхбаатар	187
10	Өмнөговь	164
10	Ховд	142
10	Өвөрхангай	122
10	Дархан АТНС	117
10	Дорнод	107
10	Баянхонгор	87
10	Хэнтий	68
10	Баян-Өлгий	28
10	Увс	13
0	ХүТНС	0
0	Булган	0
0	Дархан ХНО	0
0	Сэлэнгэ	0
0	Дорноговь	0
0	Улаанбаатар ХоТНС	0
0	Төв	0
0	Архангай	0
0	Завхан	0
0	Сэлэнгэ Мандал	0
0	Говь-Сүмбэр	0
0	Говь-Алтай	0

Онооны зарчим:

Мэдээлэл ирүүлсэн аймагт 10, ирүүлээгүй аймагт 0 оноо.

Дүгнэлт

Энэхүү тайлангийн эмхэтгэл 22 дахь жилдээ эмхэтгэгдэн уншигч таны гарт хүрч байна. Энэ хугацаанд номын сангуудын тайлангаас бусад номын сангийн үйл ажиллагааны талаар нүдээр үзээд харагддаггүй зүйлсийг харж, өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийн, хэрэгжүүлэх, нэвтрүүлэх зүйлсийг олж авдаг гол хэрэгсэл болжээ.

Тийм ч учраас тайлангийн эмхэтгэлийг чамбай хийхийг бид гол зорилгоо болгон ажилладаг бөгөөд энэ зорилгын үүднээс 2021 онд *“Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүйн зөвлөмж”*-ийг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн номын сангуудын тайлан боловсруулалт, статистик дүн шинжилгээний чанарыг сайжруулахаар боловсруулан хүргүүлж, жил бүр түүнийг сануулж буй боловч аймаг, нийслэлийн номын сангууд уг зөвлөмжийн дагуу тайлан мэдээгээ ирүүлэхгүй байгаа нь тайланд дүн шинжилгээ хийх, нэгтгэхэд хүндрэл учруулж байгааг анхаарах хэрэгтэй байна.

Баримт бичигт дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа төлөвлөх нь аливаа салбарын тулгуур, чухаг аргуудын нэг бөгөөд номын сангийн салбарынхан ч мөн адил энэ аргыг эрхэмлэсээр байгаа нь бусад салбар, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхсаар буйн жишээ юм.

Мөн бичгийн тайлан болон статистик тайлангийн тоон мэдээнүүд зөрүүтэй байгаа нь тайлангийн боловсруулалт, үйл ажиллагааны үнэн бодит байдалд эргэлзэхэд хүргэж байна. Тиймээс тайлан бичих үүрэг бүхий албан хаагчдын хоорондын уялдааг хангаж, удирдлагууд уг тайланг хянаж илгээж байх нь салбарын болон улсын статистик мэдээнд үнэн бодит хувь нэмрийг оруулсан хэрэг болно.